МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ

/2017-2019 он/

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ

/2017-2019/

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

ISBN 978-9919-9062-2-1

Швейцарын хөгжлийн агентлаг болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар хооронд байгуулсан “Үндсэн хуулийн шүүхийн шинэтгэл ба ардчилал, хүний эрх” төслийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхэтгэлийг хэвлүүлэв.

Within the framework of the project “Constitutional Court Reform, Democracy, and Human Rights” implemented under the agreement between the Swiss Agency for Development and Cooperation and the Secretariat of the Constitutional Court of Mongolia, a compilation of decisions of the Constitutional Court of Mongolia has been published.

Эмхэтгэсэн:	Д.Гантуяа
	С.Алтанхуяг
	А.Ням-Оюун
	Б.Амарсайхан
Хянасан:	Р.Мухийт
	Р.Анар
Эх бэлтгэсэн:	Л.Пүрэвцэцэг
	Т.Цэнд-Аюуш
Техник редактор:	Д.Баянбилэг

© Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар, 2024.

— АГУУЛГА —

1. **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

   2017.01.18 Дугаар 01 19

   Сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

2. **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

   2017.02.22 Дугаар 02 31

   Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолын Хавсралтын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

3. **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

   2017.04.12 Дугаар 03 39

   Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

4. **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

   2017.05.03 Дугаар 04 55

   Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

5. **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

   2017.10.04 Дугаар 05 63

   Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

6. **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

   2017.10.25 Дугаар 06 71

   Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

7. **Монгол Улсын Их Хурлын тогтоол**

   2017.11.03 Дугаар 64 79

   Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 06 дугаар дүгнэлтийн тухай

8. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2017.11.29 Дугаар 07 81

Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

9. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2017.12.07 Дугаар 74 89

Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 07 дугаар дүгнэлтийн тухай

10. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол

2017.12.06 Дугаар 01 91

Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай

11. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол 101

2017.12.20 Дугаар 02

Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай

12. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол

2018.01.17 Дугаар 01 113

Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор хүчингүй болсон Шүүх байгуулах тухай хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай

13. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.01.31 Дугаар 01 119

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

14. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2018.02.08 Дугаар 18 131

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай

15. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.02.02 Дугаар 02 133

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

16. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2018.02.08 Дугаар 19 151

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 02 дугаар дүгнэлтийн тухай

17. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.02.28 Дугаар 03 153

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

18. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.04.06 Дугаар 04 169

Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамж Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

19. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2018.04.19 Дугаар 25 177

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай

20. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол

2018.06.15 Дугаар 02 179

Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамж Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

21. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.04.25 Дугаар 05 191

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

22. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.05.23 Дугаар 06 199

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

23. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.05.25 Дугаар 07 211

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хууль Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

24. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2018.06.07 Дугаар 42 219

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 07 дугаар дүгнэлтийн тухай

25. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.06.06 Дугаар 08 221

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

26. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2018.06.15 Дугаар 48 233

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 08 дугаар дүгнэлтийн тухай

27. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол

2019.01.23 Дугаар 02 235

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

28. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.06.13 Дугаар 09 249

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 9.2 дугаар зүйлийн 13 дахь хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

29. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.08.22 Дугаар 10 257

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

30. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2018.10.11 Дугаар 76 271

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийн тухай

31. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол

2018.11.30 Дугаар 03 273

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэсэн тухай

32. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.09.21 Дугаар 11 289

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

33. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.10.10 Дугаар 12 301

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

34. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2018.10.25 Дугаар 77 317

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 12 дугаар дүгнэлтийн тухай

35. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.10.24 Дугаар 13 319

Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

36. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2018.11.15 Дугаар 83 327

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 13 дугаар дүгнэлтийн тухай

37. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.11.14 Дугаар 14 329

Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

38. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2018.11.22 Дугаар 85 341

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 14 дүгээр дүгнэлтийн тухай

39. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2018.11.21 Дугаар 15 343

Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

40. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2018.12.06 Дугаар 88 359

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 15 дугаар дүгнэлтийн тухай

41. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол

2019.01.16 Дугаар 01 361

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийн зохицуулалтаар Цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болсон холбогдох хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг эцэслэн хянан шийдвэрлэсэн тухай

42. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2019.03.13 Дугаар 01 371

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

43. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2019.03.26 Дугаар 27 383

Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай

44. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2019.05.27 Дугаар 02 385

Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2018 оны 49 дүгээр тогтоол, 2019 оны 22, 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

45. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2019.06.12 Дугаар 66 415

Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 02 дугаар дүгнэлтийн тухай

46. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол

2019.10.09 Дугаар 03 417

Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 22, 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

47. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2019.06.28 Дугаар 03 435

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн зарим хэсэг, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

48. Монгол Улсын Их Хурлын тогтоол

2019.07.16 Дугаар 70 447

Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар дүгнэлтийн тухай

49. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол

2019.10.30 Дугаар 04 449

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн зарим хэсэг, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

50. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

2019.09.20 Дугаар 04 467

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

— CONTENTS —

1. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
   2017.01.18, No. 01 19
   Adjudication of the dispute concerning whether certain provisions of the Election Law violate relevant provisions of the Constitution
2. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
   2017.02.22, No. 02 31
   Adjudication of the dispute concerning whether certain provisions of the Annex to Resolution No. 12 (2016) of the State Great Hural of Mongolia are in violation of relevant provisions of the Constitution
3. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
   2017.04.12, No. 03 39
   Adjudication of the dispute concerning whether certain provisions of Section 349.1 of Article 349 of the Criminal Procedure Code violate relevant articles and paragraphs of the Constitution
4. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
   2017.05.03, No. 04 55
   Adjudication of the dispute concerning whether Sections 6.1.2 and 6.1.3 of Article 6 of the Law on the Legal Status of Judges violate the relevant provisions of the Constitution
5. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
   2017.10.04, No. 05 63
   Adjudication of the dispute concerning whether Section 18.2 of Article 18 of the Law on the Legal Status of Judges violates the relevant provisions of the Constitution
6. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
   2017.10.25 No. 06 71
   Adjudication of the dispute concerning whether Section 37.4 of Article 37 of the Law of Mongolia on the Procedures of the State Great Hural Sessions violates the relevant articles and provisions of the Constitution
7. **Resolution of the State Great Hural of Mongolia**
   2017.11.03, No. 64 79
   Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No. 06 of 2017

8. **Conclusion of the Constitutional Court of Mongolia 2017.11.29, No. 07** 81
Adjudication of the dispute over whether Article 5, paragraph 5.8 of the Law on Infringements breaches the relevant paragraphs of the Constitution

9. **Resolution of the State Great Hural of Mongolia 2017.12.07, No. 74** 89
Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No. 07 of 2017

10. **Resolution of the Constitutional Court of Mongolia 2017.12.07, No. 01** 91
Final adjudication of the dispute, through supervisory procedure, concerning the reinstatement of provisions in the Civil Code and the Law on Pledge of Immovable Property, which were invalidated by the Constitutional Court Resolution No. 11 of 2015

11. **Resolution of the Constitutional Court of Mongolia 2017.12.20, No.02** 101
Final adjudication, through supervisory procedure, concerning the reinstatement of provisions of the Law on State Great Hural, which were invalidated by the Constitutional Court Resolution No. 02 of 2012

12. **Resolution of the Constitutional Court of Mongolia 2018.01.17, No. 01** 113
Final adjudication, through supervisory procedure, of the dispute concerning whether the provisions of the Law on Establishment of the Court, which have been invalidated by the Constitutional Court Resolution, are reinstated in their substance

13. **Conclusion of the Constitutional Court of Mongolia 2018.01.31, No. 01** 119
Adjudication of the dispute concerning whether Section 12.1.5 of Article 12 of the Law of Mongolia on Defense violates the relevant provisions of the Constitution

14. **Resolution of the State Great Hural 2018.02.08, No. 18** 131
Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No. 01 of 2018

15. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
2018.02.02, No. 02 133
Adjudication of the dispute over whether Section 67.1.5 of Article 67 and certain provisions of Section 118.5 of Article 118 of the Civil Procedure Code violate the relevant provisions of the Constitution

16. **Resolution of the State Great Hural of Mongolia**
2018.02.08, No. 19 151
Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No. 02 of 2018

17. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
2018.02.28, No. 03 153
Adjudication of the dispute concerning whether the Resolution No. 23 of the State Great Hural of Mongolia (2017) violates the relevant provisions of the Constitution

18. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
2018.04.06, No. 04 169
Adjudication of the dispute concerning whether the Decree No.12 of the Prime Minister of Mongolia (2016) violates the relevant provisions of the Constitution

19. **Resolution of the State Great Hural of Mongolia**
2018.04.19, No. 25 177
Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No. 04 of 2018

20. **Resolution of the Constitutional Court of Mongolia**
2018.06.15, No. 02 179
Final adjudication of the dispute concerning whether the Decree No. 12 of the Prime Minister of Mongolia (2016) violates the relevant provisions of the Constitution

21. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
2018.04.25, No. 05 191
Adjudication of the dispute concerning whether certain provisions of Resolution No. 29 of the State Great Hural of Mongolia (2017) violate relevant provisions of the Constitution

22. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
2018.05.23, No. 06 199
Adjudication of the dispute concerning whether certain provisions of the Law on Enforcement of Court Decisions violate relevant provisions of the Constitution.

23. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
2018.05.25, No. 07 211
Adjudication of the dispute concerning whether the Law on the Annulment of certain articles of the Civil Procedure Code violated the relevant provisions of the Constitution
24. **Resolution of the State Great Hural of Mongolia**
2018.06.07, No. 42 219
Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No. 07 of 2018
25. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
2018.06.06, No. 08 221
Adjudication of the dispute concerning whether certain provisions of the Law on Enforcement of Court Decisions violate relevant provisions of the Constitution.
26. **Resolution of the State Great Hural of Mongolia**
2018.06.15, No. 48 233
Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No. 08 of 2018
27. **Resolution of the Constitutional Court of Mongolia**
2019.01.23, No. 02 235
Final adjudication of the dispute concerning whether certain provisions of Section 31.4 of Article 31 of the Law on Enforcement of Court Decisions violate relevant provisions of the Constitution
28. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
2018.06.13, No. 09 249
Adjudication of the dispute on whether Section 8 of Article 8.2 and Section 13 of Article 9.2 of the Law on Investigation of Regulatory Infringement violate the relevant provisions of the Constitution
29. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
2018.08.22, No. 10 257
Adjudication of the dispute concerning whether Resolution No. 62 of the State Great Hural of Mongolia (2018) violates the relevant provisions of the Constitution
30. **Resolution of the State Great Hural of Mongolia**
2018.10.11, No. 76 271
Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No. 10 of 2018

31. **Resolution of the Constitutional Court of Mongolia**
2018.11.30, No. 03 273
Adjudication of the dispute concerning whether Resolution No. 62 of the State Great Hural of Mongolia (2018) violated the relevant provisions of the Constitution

32. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
2018.09.21, No. 11 289
Adjudication of the dispute concerning whether certain provisions of the Law on Enforcement of Court Decisions violate the relevant provisions of the Constitution

33. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
2018.10.10, No. 12 301
Adjudication of the dispute concerning whether certain provisions of the Law on Enforcement of Court Decisions violate relevant provisions of the Constitution.

34. **Resolution of the State Great Hural of Mongolia**
2018.10.25, No. 77 317
Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No.12 of 2018

35. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
2018.10.24, No. 13 319
Adjudication of the dispute concerning whether Section 43.6 of Article 43 of the Law on Notary violated the relevant provisions of the Constitution of Mongolia

36. **Resolution of the State Great Hural of Mongolia**
2018.11.15, No. 83 327
Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No. 13 of 2018

37. **Conclusion of the Constitutional Court of Mongolia**
2018.11.14, No. 14 329
Adjudication of the dispute concerning whether Section 159.4 of Article 159 of the Election Law violated the relevant provisions of the Constitution of Mongolia

38. **Resolution of the State Great Hural of Mongolia**
2018.11.22, No. 85 341
Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No. 14 of 2018

39. Conclusion of the Constitutional Court of Mongolia
2018.11.21, No. 15 343
Adjudication of the dispute concerning whether certain provisions of the General Administrative Law and the Law on Administrative Procedure violate relevant provisions of the Constitution
40. Resolution of the State Great Hural of Mongolia
2018.12.06, No. 88 359
Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No.15 of 2018
41. Resolution of the Constitutional Court of Mongolia
2019.01.16, No. 01 361
Final adjudication of the dispute regarding whether certain provisions of the relevant law, invalidated by Constitutional Court Resolution No. 01 (2010), were reinstated in substance in accordance with Section 60.5 of Article 60 of the Election Law
42. Conclusion of the Constitutional Court of Mongolia
2019.03.13, No. 01 371
Adjudication of the dispute concerning whether certain provisions of the Criminal Procedure Code violate relevant provisions of the Constitution
43. Resolution of the State Great Hural of Mongolia
2019.03.26, No. 27 383
Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No. 01 of 2019
44. Conclusion of the Constitutional Court of Mongolia
2019.05.27, No. 02 385
Adjudication of the dispute on whether Sections 12.1 and 12.3 of Article 12 of the Election Law, the Resolution No. 49 (2018), and Resolutions No. 22 and 23 (2019) of the State Great Hural of Mongolia violate the relevant provisions of the Constitution
45. Resolution of the State Great Hural of Mongolia
2019.06.12 No. 66 415
Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No.02 of 2019
46. Resolution of the Constitutional Court of Mongolia
2019.10.09, No.03 417
Final adjudication of the dispute concerning whether Sections 12.1 and 12.3 of Article 12 of the Law on Election and Resolutions No. 22 and 23 (2019) of the State Great Hural of Mongolia violate the relevant provisions of the Constitution

47. Conclusion of the Constitutional Court of Mongolia

2019.06.28, No. 03 435

Adjudication of the dispute concerning whether certain parts and provisions of Article 47 of the Law on Minerals violate the relevant provisions of the Constitution

48. Resolution of the State Great Hural of Mongolia

2019.07.16, No. 70 447

Regarding the conclusion of the Constitutional Court of Mongolia No.03 of 2019

49. Resolution of the Constitutional Court of Mongolia

2019.10.30, No. 04 449

Final adjudication of the dispute concerning whether certain parts and provisions of Article 47 of the Law on Minerals violate relevant provisions of the Constitution

50. Conclusion of the Constitutional Court of Mongolia

2019.09.20, No. 04 467

Adjudication of the dispute concerning whether Section 17.1.9 of Article 17 and Section 18.2 of Article 18 of the Law on Administrative and Territorial Units and Their Governance of Mongolia violate the relevant provisions of the Constitution of Mongolia

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2017.01.18 Дугаар 01 Улаанбаатар хот

Сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 11.40 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Сугар, Д.Наранчимэг, Д.Одбаяр, Д.Ганзориг /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд гомдол гаргагч, иргэн О.Мөнхболд, М.Мөнхжаргал нар оролцов. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ хүрэлцэн ирээгүй болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.4, 99 дүгээр зүйлийн 99.5 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын зарим хэсэг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг; мөн хуулийн 103 дугаар зүйлийн 103.5 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын зарим хэсэг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх талаарх маргааныг хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн оршин суугч, иргэн О.Мөнхболд, Нийслэлийн Баянзүрх дүүргийн оршин суугч, иргэн М.Мөнхжаргал, Архангай аймгийн Өгийнуур сумын оршин суугч, иргэн П.Баттулга нар Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“1. Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн санал авах өдөр буюу 2016 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Архангай, Завхан, Баян-Өлгий болон Увс аймгийн зарим сумдын санал авах байруудад хүргүүлсэн саналын хуудас дуусч, саналаа өгөхөөр ирсэн сонгогчид саналаа өгч чадахгүй хүлээж эхэлсэн. Улмаар Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 180 дугаар тогтоол гарсны дагуу саналын хуудас дутсан санал авах байруудад саналын хуудсыг хэвлэж иргэд, сонгогчдын саналыг авсан. Гэтэл иргэдийн саналыг авч дууссаны дараа Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 182 дугаар тогтоол гарч, уг тогтоолоор саналын хуудас дутсан санал авах байруудаас хэвлэж иргэдийн саналыг авсан бүх саналын хуудас, түүнд тэмдэглэсэн иргэдийн саналыг бүхэлд нь хүчингүй болгосон. Ингээд дээрх санал авах байруудад нэмж хэвлэсэн саналын хуудсаар санал өгсөн бүх иргэд, сонгогчдын санал хүчингүй болсон. Сонгуулийн ерөнхий хорооны 182 дугаар тогтоол нь иргэдийн “сонгох эрх”, сонгуульд нэр дэвшсэн иргэдийн “сонгогдох эрх”-ийг шууд хязгаарласнаараа Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг ноцтой зөрчсөн шийдвэр болсон.

Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 182 дугаар тогтоол гарах болсон шалтгаан нь Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.4 дэх хэсэгт “Саналыг санал тоолох төхөөрөмжөөр тоолох бөгөөд санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудас нь тухайн хэсгийн санал хураалтын дүн байна.”, 99 дүгээр зүйлийн 99.5 дахь хэсэгт “Санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудас нь хүчинтэй саналын хуудас байна.” гэж тус тус заасантай холбоотой. Эдгээр заалт нь санал тоолох төхөөрөмжид уншигдаагүй буюу төхөөрөмжөөр тоолоогүй саналын хуудас нь хүчингүй байна гэсэн утгыг илэрхийлж байгаа ба сонгууль зохион байгуулахад гарсан алдаанаас үүдэн төхөөрөмжид уншигдахгүй саналын хуудсаар санал өгсөн иргэдийн санал шууд хүчингүй байх үр дагавар үүсгэж байна. Мөн түүнчлэн техникийн саатал гарч санал тоолох төхөөрөмж ажиллахгүй болсон тохиолдолд иргэдээс өгсөн санал ч бас хүчингүй байхаар байна. Сонгуулийн тухай хуулийн дээрх

заалтууд нь мөн Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасан “сонгох, сонгогдох эрх»-ийг зөрчиж байна.

2. Сонгуулийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.5 дахь хэсэгт “Сонгуулийн дүн гарсан бол санал хураалтыг хүчингүйд тооцохгүй.” гэж заасан. Гэтэл тус хуулийн 103, 104 дүгээр зүйлд санал хураалтыг хүчингүйд тооцох үндэслэлүүдийг дурдаж, санал хураалтыг дахин явуулах талаар зохицуулсан. Харин 133 дугаар зүйлийн 133.2 дахь хэсэгт “Сонгуулийн төв байгууллага тухайн тойрогт нэр дэвшигчдийг авсан саналын тоогоор нь дараалалд оруулан жагсаалт гаргах бөгөөд хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр шууд сонгогдсонд тооцно.” гэж сонгуулийн дүнг хэзээ гаргах талаар хуульчилсан боловч дүн гаргах хугацааг хуульд тусгайлан заагаагүй. Иймээс сонгууль явагдсаны маргааш өдөр нь сонгуулийн дүн гарах бүрэн боломжтой байгаа ба нэг өдрийн дотор санал хураалтыг хүчингүйд тооцуулах өргөдөл, нэхэмжлэл гаргаад, үүнийгээ шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болгож байгаа нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй.” гэж заасантай нийцэхгүй гэж үзэж байна.

Иймээс Сонгуулийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.5 дахь хэсэг нь санал хураалтыг хүчингүйд тооцох хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжгүй болгож, улмаар сонгуульд санал өгсөн иргэн болон сонгуульд нэр дэвшүүлсэн нам, эвсэл, нэр дэвшсэн иргэний санал хураалтыг хүчингүйд тооцуулах асуудлаар төрийн байгууллага, шүүхэд хандах эрхийг хязгаарлаж байна. Өөрөөр хэлбэл, сонгууль хуулийн дагуу явагдаагүй, сонгуульд нэр дэвшиж олонхийн санал авсан нэр дэвшигч сонгуулийн дүнг гажуудуулсан зэргээр санал хураалтыг хүчингүйд тооцох үндэслэл бүрдсэн хэдий ч шүүх Сонгуулийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.5 дахь хэсгийн заалтыг баримтлаад санал хураалтыг хүчингүйд тооцох боломжгүй нөхцөл байдал, үр дагавар үүсгэж байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.4, 99 дүгээр зүйлийн 99.5 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван

найман наснаас эдэлнэ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг; Сонгуулийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.5 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг тус тус зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү." гэсэн агуулга бүхий мэдээлэл, гомдол гаргажээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хурлын сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн санал тоолох, санал болон саналын хуудсыг хүчингүйд тооцох, сонгуулийн дүнг гаргах ажиллагаанд автоматжуулсан систем ашиглах журмыг тодорхойлсон Сонгуулийн тухай хуулийг баталсан бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно." гэж заасны дагуу Улсын Их Хурлын хууль тогтоох онцгой бүрэн эрхийн хүрээнд хамаардаг.

Сонгуулийн тухай хуулийн санал тоолох, санал болон саналын хуудсыг хүчингүйд тооцох, сонгуулийн дүнг гаргах ажиллагаанд автоматжуулсан систем ашиглах зохицуулалтууд нь сонгууль зохион байгуулахтай холбоотой хуулиар зайлшгүй зохицуулах шаардлагатай зохицуулалтууд юм.

1. ... Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.4, 99 дүгээр зүйлийн 99.5 дахь хэсэг нь сонгогч хөндлөнгийн нөлөөгүйгээр

хүсэл зоригоо илэрхийлж, саналаа нууцаар гаргаж, санал тоолох төхөөрөмжид уншуулсны дараа хэрхэн санал хураалтын дүнг гаргах, зөвхөн санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудсыг хүчинтэйд тооцохтой холбоотой заалтууд болно.

Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.4 дэх хэсэгт “Саналыг санал тоолох төхөөрөмжөөр тоолох бөгөөд санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудас нь тухайн хэсгийн санал хураалтын дүн байна.”, мөн хуулийн 99 дүгээр зүйлийн 99.5 дахь хэсэгт “Санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудас нь хүчинтэй саналын хуудас байна.” гэж заасан нь нэгэнт саналыг санал тоолох төхөөрөмжөөр тоолж байгаа тохиолдолд тухайн төхөөрөмжөөр уншигдсан саналын хуудсыг үндэслэн санал хураалтын эцсийн дүнг гаргахаар зохицуулсан бөгөөд өмнө нь явагдаж байсан сонгуулиудын саналын хуудсыг тоолох явцад хүний хүчин зүйл нөлөөлсний улмаас гардаг байсан маргааныг бууруулах боломжийг олгосон зохицуулалт болсон.

Сонгуулийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.10 дахь хэсгийн “Саналын хуудас нь тусгай нууцлалтай байх бөгөөд аймаг, дүүргийн хэмжээнд нэгдсэн дугаартай байна.”, мөн зүйлийн 84.11 дэх хэсгийн “Тухайн сонгуулийн саналын хуудасны загвар, тоог сонгуулийн төв байгууллага баталж, эрхлэн хэвлүүлнэ.”, 84.14 дэх хэсгийн “Баталсан загвараас өөр, шаардлага хангаагүй саналын хуудас хүчингүй байх бөгөөд хүчингүй саналын хуудсаар санал авах, өгөхийг хориглоно.”, 99 дүгээр зүйлийн 99.3 дахь хэсгийн “Баталсан загвар, шаардлагыг хангаагүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.” гэж заасан. Эдгээр зохицуулалт нь Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах Үндсэн хуулийн зарчмыг хангаж байна гэж үзсэн болно.

Түүнчлэн Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.5 дахь хэсэгт “Санал авах, тоолох төхөөрөмжид гэмтэл, саатал гарсан тохиолдолд тухайн төхөөрөмжид байгаа саналын хуудсыг хоёр дахь, эсхүл нөөц төхөөрөмжид уншуулж тоолох ба санал авах, тоолох төхөөрөмж байхгүй тохиолдолд сонгуулийн төв байгууллагаас баталсан журмын дагуу гар аргаар тоолно.” гэж заасан нь техникийн саатал гарч санал тоолох төхөөрөмж ажиллахгүй болсон тохиолдолд иргэдийн Монгол Улсын Үндсэн хуульд заасан сонгох, сонгогдох эрхийг хангах чухал зохицуулалт болсон.

Сонгуулийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.8 дахь хэсэгт “Сонгогч санал тэмдэглэхдээ алдаа гаргаж буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийхээс өмнө энэ тухайгаа санал авах байранд мэдэгдэж, алдаатай саналын хуудсыг хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч саналаа өгч болно.” гэж заасан нь сонгогчдын санал сонгуулийн дүнд тусаж, тэдгээрийн сонгох, сонгогдох эрх илүү хангагдаж байгаа болно.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийн иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасантай нийцүүлэн Сонгуулийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд сонгууль зохион байгуулах үйл явц, үйл ажиллагаатай холбогдуулан аливаа этгээд сонгуулийн байгууллагад өргөдөл, мэдээлэл гаргах эрхтэй, мөн сонгуулийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа / үйлдэл, эс үйлдэхүй/-ны улмаас эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзсэн аливаа этгээд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байхаар хуульчилсан байна.

Санал хураалтыг хүчингүйд тооцох нь сонгуулийг хүчингүйд тооцохоос ялгаатай асуудал бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд иргэн сонгуульд саналаа өгч оролцдог. Сонгууль хуульд заасны дагуу явагдсан нөхцөлд санал хураалтыг хүчингүйд тооцох нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан «сонгох» эрхэд халдсан зохицуулалт болно.

Сонгуулийн тухай хуулийн 103 дугаар зүйлээр сонгуулийн дүн гарахаас өмнө хууль зөрчсөн тохиолдолд зөрчил гарсан хэсгийн санал хураалтыг хүчингүйд тооцохоор зохицуулсан ба мөн хуулийн 135 дугаар зүйлээр хууль зөрчсөн тохиолдолд сонгуулийг хүчингүйд тооцож, 136 дугаар зүйлээр дахин сонгууль явуулах талаар зохицуулсан байгаа нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол

Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэсэн заалтад нийцэж байна.

3. Монгол Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд Сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Орон нутгийн сонгуулийн хуулиудыг тус тусад нь зохицуулахаар төлөвлөсөн.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.4, 99 дүгээр зүйлийн 99.5, 103 дугаар зүйлийн 103.5 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9, 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байгааг анхааран үзэж шийдвэрлэхийг Үндсэн хуулийн цэцийн эрхэм гишүүдээс хүсч байна.» гэсэн байна.

Гурав. Сонгуулийн ерөнхий хорооноос маргаан бүхий зохицуулалттай холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасан Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулах, мөн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргийн дагуу сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, ялангуяа урьд өмнө зохион байгуулагдаж ирсэн сонгуулиудын явцад сонгогчийн өгсөн саналыг будлиантуулах, санал хураалтын дүнг засварлах зэргээр сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн зөрчлийг таслан зогсоох, сонгуулийн дүнд сонгогчдын итгэх итгэл, үнэмшлийг дээшлүүлэх зорилгоор сонгуулийн үйл ажиллагаанд автоматжуулалтыг нэвтрүүлж санал авах, тоолох, сонгуулийн дүнг гаргах зэрэг ажиллагааг боловсронгуй, шуурхай болгох, сонгогчдын сонголтыг будлиулж, дүнг гажуудуулах хувь хүний аливаа субъектив сөрөг хүчин зүйлийн нөлөөг хязгаарлан хаах, арилгах хууль, эрх

зүйн орчинг бий болгох үндэслэл шаардлагад нийцүүлэн Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр “Сонгуулийн автоматжуулсан системийн тухай” хуулийг баталсан.

Сонгуулийн ерөнхий хорооны хувьд Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.4 дэх хэсэгт “Саналыг санал тоолох төхөөрөмжөөр тоолох бөгөөд санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудас нь тухайн хэсгийн санал хураалтын дүн байна.”, 99 дүгээр зүйлийн 99.5 дахь хэсэгт “Санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудас нь хүчинтэй саналын хуудас байна.” гэж тус тус заасан нь Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийг баталсан дээрх үндэслэл шаардлагад тулгуурлаж байгаа бөгөөд энэ нь сонгуулийн дүнг будлиантуулах, буруу гаргах зэрэг хууль бус үйлдлээс зайлсхийж, 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр болсон эмгэнэлт үйл явдлаас сургамж авч, тэрхүү үйл явдлыг дахин давтуулахгүй байх зорилгоор батлагдсан хуулийн зохицуулалт тул Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасан иргэний сонгох, сонгогдох эрхийг баталгаатай эдлүүлэх тухай Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд бүрэн нийцэж байна гэсэн байр суурьтай байна.

Мөн Сонгуулийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.8 дахь хэсэгт “Сонгогч санал тэмдэглэхдээ алдаа гаргаж буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийхээс өмнө энэ тухайгаа санал авах байранд мэдэгдэж, алдаатай саналын хуудсыг хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч саналаа өгч болно.” гэж, мөн зүйлийн 92.9 дэх хэсэгт “Санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг таньж уншаагүй бол сонгогч энэ тухай санал авах байранд мэдэгдэж, уг саналын хуудсыг хураалгаж, дахин саналын хуудас авч саналаа өгч болно.” гэж тус тус заасан бөгөөд санал тоолох төхөөрөмжид гэмтэл, саатал гарсан тохиолдолд мэдээллийн технологийн баг, даамал гарсан гэмтэл, саатлыг арилгах, техник хэрэгслийн ажиллагааг сэргээх, солих арга хэмжээг шуурхай зохион байгуулах чиг үүрэгтэйгээр ажилладаг болно.

Санал тоолох төхөөрөмжид зөвхөн баталсан загвар шаардлага хангасан саналын хуудас танигдаж уншигддаг бөгөөд батлагдсан загвар, шаардлага хангаагүй, эсхүл өөр төрлийн саналын хуудас санал тоолох төхөөрөмжид уншигдах техникийн болон хууль зүйн боломж байхгүй юм.

Сонгуулийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд сонгууль зохион байгуулах үйл явц, үйл ажиллагаатай холбогдуулан аливаа этгээд сонгуулийн байгууллагад өргөдөл, мэдээлэл гаргах эрхтэй, мөн сонгуулийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/-ны улмаас эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзсэн аливаа этгээд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байхаар хуульчилсан байна.

Мөн Сонгуулийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.5 дахь хэсэгт “Сонгуулийн дүн гарсан бол санал хураалтыг хүчингүйд тооцохгүй.” гэж заасан нь санал хураалтын дүнг аливаа этгээд будлиантуулах, засварлах, хүчингүй болгох хууль бус үйлдлийг хориглоход чиглэгдсэн зохицуулалт бөгөөд Сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтад “сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн болох нь тогтоогдсон” гэж сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн болохыг шүүхээс тогтоож, тухайн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон байхыг.” ойлгоно гэж, 115 дугаар зүйлийн 115.2 дахь хэсэгт “Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан сонгуулийн төв байгууллагад холбогдох энэ хуулийн 111.5-д зааснаас бусад эрх зүйн маргааныг захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж, 135 дугаар зүйлийн 135.2 дахь хэсэгт “Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн нь маргаан хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдийн шийдвэрээр тогтоогдсон бол тогтоогдсон хэмжээгээр тойрогт сонгуулийн дүн гаргасан шийдвэр хүчингүйд тооцогдоно.” гэж тус тус зааснаас үзвэл сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн эсэх, тэрхүү зөрчлөөс үүдэн санал хураалт болон сонгуулийг хүчингүйд тооцох хууль зүйн фактыг аливаа этгээд тэр дундаа сонгуулийн байгууллага дур зоргоороо шийдвэрлэж тогтоох бус гагцхүү шүүх тогтоохоор хуульчилсан болох нь Сонгуулийн тухай хуулийн дээрх заалтуудаас харагдаж байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.5 дахь хэсэгт “Сонгуулийн дүн гарсан бол санал хураалтыг хүчингүйд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасантай бүрэн нийцэж байна гэсэн байр суурьтай байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.4 дэх хэсгийн “Саналыг санал тоолох төхөөрөмжөөр тоолох бөгөөд санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудас нь тухайн хэсгийн санал хураалтын дүн байна.”, 99 дүгээр зүйлийн 99.5 дахь хэсгийн “Санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудас нь хүчинтэй саналын хуудас байна.” гэсэн нарийвчилсан зохицуулалт нь хуульд тусгах шаардлагатай хэм хэмжээ байх ба Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний сонгох, сонгогдох эрхийг хязгаарлаагүй байна.

Мөн Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.5 дахь хэсэгт “Санал авах, тоолох төхөөрөмжид гэмтэл, саатал гарсан тохиолдолд тухайн төхөөрөмжид байгаа саналын хуудсыг хоёр дахь, эсхүл нөөц төхөөрөмжид уншуулж тоолох ба санал авах, тоолох төхөөрөмж байхгүй тохиолдолд сонгуулийн төв байгууллагаас баталсан журмын дагуу гар аргаар тоолно.” хэмээн зааж санал тоолох төхөөрөмжид гэмтэл, саатал гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тусгайлан зохицуулсан байна.

Сонгууль зохион байгуулах техник ажиллагаатай холбоотой зарим тойрог, хэсгийн хороонд гарсан алдаа, зөрчил нь Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан биш юм.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.4, 99 дүгээр зүйлийн 99.5 дахь хэсэг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Сонгуулийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд сонгууль зохион байгуулах үйл явц, үйл ажиллагаатай холбогдуулан аливаа этгээд сонгуулийн байгууллагад өргөдөл, мэдээлэл гаргах; сонгуулийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/-ны улмаас эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзсэн аливаа этгээд нь шүүхэд нэхэмжлэл /гомдол/ гаргахтай холбоотой зохицуулалтыг тусгасан байна. Мөн хуулийн 112-115 дугаар зүйлд өргөдөл, мэдээлэл, нэхэмжлэлийг хэрхэн гаргах, тэдгээрийг шийдвэрлэх талаарх зохицуулалтыг тодорхой хуульчилжээ.

Сонгуулийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.5 дахь хэсгийн “Сонгуулийн дүн гарсан бол санал хураалтыг хүчингүйд тооцохгүй.” гэсэн зохицуулалтын агуулгаас үзэхэд сонгуулийн хэсгийн санал хураалтыг хүчингүйд тооцох эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай холбогдуулан өргөдөл, мэдээлэл гаргах, шүүхэд нэхэмжлэл /гомдол/ гаргах боломжийг хязгаарласан гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.5 дахь хэсэг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.4 дэх хэсэгт “Саналыг санал тоолох төхөөрөмжөөр тоолох бөгөөд санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудас нь тухайн хэсгийн санал хураалтын дүн байна.”, 99 дүгээр зүйлийн 99.5 дахь хэсэгт “Санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудас нь хүчинтэй саналын хуудас байна.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх,

эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

2. Сонгуулийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.5 дахь хэсэгт “Сонгуулийн дүн гарсан бол санал хураалтыг хүчингүйд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Н.ЖАНЦАН
ГИШҮҮД	Д.СУГАР
	Д.НАРАНЧИМЭГ
	Д.ОДБАЯР
	Д.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2017.02.22 Дугаар 02 Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолын Хавсралтын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 11.50 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Сугар даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Т.Лхагваа /илтгэгч/, Д.Солонго, Д.Одбаяр, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Г.Нацагдорж оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтын холбогдох заалтаар Оюуны өмчийн газрыг Улсын бүртгэлийн ерөнхий газартай нэгтгэн “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар” болгон тогтоосон нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны оршин суугч, иргэн Г.Нацагдорж Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээлэл, гомдлыг ирүүлжээ. Үүнд:

“1. Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцын 12 дугаар зүйлд “Холбооны гишүүн орон бүр аж үйлдвэрийн өмчийн хэрэг эрхлэх тусгай алба болон олон нийтийг патент, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болон барааны тэмдгийн патенттай танилцуулах төвлөрсөн байгууллага байгуулах үүрэг хүлээнэ.” гэж заасан байдаг. Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах Парисын конвенцод Монгол Улс 1985 онд нэгдэн оржээ. Монгол Улс нь аж үйлдвэр /оюун/-ийн өмчийн асуудлыг бие даан эрхэлдэг буюу патент, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдгийн мэдээллийг нийтэд танилцуулдаг тусдаа байгууллага байгуулах үүргийг уг конвенцод нэгдэх үедээ хүлээсэн байна. Иймд Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолын дагуу Оюуны өмчийн газрыг Улсын бүртгэлийн байгууллагатай нэгтгэж байгаа нь Парисын конвенцыг зөрчиж байна.

Монгол Улс 1997 онд нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын “Оюуны өмчийн эрхийн худалдааны асуудлаарх хэлэлцээр” /TRIPS/-ээр Монгол Улс оюуны өмчийн эрхийн зөрчилтэй тэмцэх үүрэг хүлээсэн бөгөөд дээрх байдлаар хяналтын үйл ажиллагааг нэгтгэсэн нь захиргааны арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлыг бий болгож байна. Монгол Улсын нэгдэн орсон оюуны өмчийн олон улсын гэрээ, хэлэлцээр болох Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц, Утга зохиол, уран сайхны бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц, Оюуны өмчийн эрхийн худалдааны асуудлаарх хэлэлцээр /TRIPS/-үүдээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлээгүй байна. Иймд Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн байна.

2. Аж үйлдвэрийн өмчийн объектуудад 3-аас 18 хүртэлх сарын хугацаанд хайлт, шүүлт хийх ба дараа нь бүртгэгдэх гэж байгаа объект /шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, газар зүйн заалт болон зохиогчийн эрхийн бүтээлүүд/-ын талаар олон нийтэд тодорхой хугацаанд мэдээлэл өгч, гомдол болон хүсэлт ирэх эсэхийг нягтлан шалгадаг. Иймд Оюуны өмчийн газрын үйл ажиллагаа нь олон нийтэд нээлттэй, ил тод бөгөөд харьцангуй урт хугацаа шаардлагатай байгууллага юм. Гэтэл улсын бүртгэлийн байгууллага нь үйл ажиллагаандаа Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаар “заавал биелүүлэх шинжтэй байх”,

“иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэж, нууцыг чанд хадгалах” зарчмыг баримталдаг байна. Иймд Улсын бүртгэлийн байгууллага нь гуравдагч этгээдээс хамаарахгүйгээр бүртгэл хийх ба уг бүртгэлээ хувь этгээдийн эрх ашгийг хүндэтгэх үүднээс нууцлах чиг үүрэгтэй байна. Үүнээс үзвэл чиг үүргийн хувьд хоорондоо зөрчилдөөнтэй 2 байгууллагыг нэгтгэсэн байна.

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт “Төрийн захиргааны байгууллага нь бүртгэгдсэн барааны тэмдгийн ном зүй, дүрсийг албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ.”, Патентийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Шинэ бүтээлийн ном зүй, томьёолол, бүтээгдэхүүний загварын зургийг патентийн хэвлэлд нийтэлсэн өдрөөс хойш 3 сарын дотор оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад няцаасан нотолгоо ирээгүй, маргаан гараагүй бол патент олгоно.” хэмээн нээлттэй үйл ажиллагаа явуулах талаар заасан.

Оюуны өмчийн мэдээлэл нь олон нийтэд нээлттэй мэдээлэл бөгөөд оюуны өмчийн бүтээл нь олон нийтэд мэдээлэгдсэний үр дүнд тэдгээрийг иргэд, гадаад, дотоодын аж ахуй нэгж зохих зөвшөөрлийн дагуу худалдан эсхүл лицензээр авч ашигласнаар өөрийн бизнесийн үйл ажиллагааг дэмжиж ашиг орлогыг нэмэгдүүлдэг.

Улсын бүртгэлийн байгууллага нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтад иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэж, нууцыг чанд хадгалах. гэсэн зарчмын хүрээнд зохих бүртгэлийг хийх бөгөөд мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгт Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан үрэгдэх, устгагдахаас бүрэн хамгаалагдсан байх бөгөөд улсын онцгой объектын зэрэглэлтэй байна.” гэж заасан учир Улсын бүртгэлийн газар нь улсын онцгой объект бөгөөд мэдээлэл нь хаалттай /нууц/ байхаар байна.

Гэтэл Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолоор Улсын бүртгэлийн газар, Оюуны өмчийн газрыг нэгтгэж Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрыг байгуулсан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль дээдлэх зарчимд харшилж байна. Учир нь байгууллагыг нэгтгэн нэг удирдлагатай болгосноор нэг талаас оюуны өмчийн багц хуулиуд болох Патентийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, эдгээр хуулиудад холбогдон гарсан хууль тогтоомжууд, оюуны өмчийн салбарын Монгол Улсын нэгдэн

орсон нийт 15 гэрээ хэлэлцээр, нөгөө талаас улсын бүртгэлийн хуулиуд болох Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрх, түүнтэй холбоотой бусад эрхийн улсын бүртгэлийн хууль болон эдгээр хуулиудтай холбогдон батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд саад учруулна гэж үзэж байна. Түүнчлэн оюуны өмчийн харилцааны объект, тухайн харилцаанд оролцож байгаа субъектүүд нь улсын бүртгэлийн харилцаанд оролцож байгаа объект, субъектээс эрс ялгаатай, чиглэл, зорилгын хувьд өөр бөгөөд өөр хоорондоо эрс ялгаатай олон хууль тогтоомж гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэхээр 1 удирдлагаас үйл ажиллагааг удирдан зохион байгуулах нь боломжгүй юм. Иймд Үндсэн хуульд заасан “хууль дээдлэх зарчим” зөрчигдсөн байна.

3. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 10 дугаар зүйлд зааснаар тус байгууллага нь улсын бүртгэлийн ажиллагаанд хяналт тавих буюу дотогшоо чиглэсэн хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бол оюуны өмчийн улсын хяналт нь Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Патентийн тухай хууль, Зохиогчийн эрх түүнд хамаарах эрхийн тухай хуулиудад зааснаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа нь Оюуны өмчийн олон улсын гэрээ, хэлэлцээр болон оюуны өмчийн хууль тогтоомжуудыг зөрчсөн эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчилд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэдэг. Энэ нь гадагшаа чиглэсэн үйл ажиллагаа юм. Тэгэхээр дээрх 2 байгууллага нь эрс ялгаатай хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Тусгай алба байгуулна гэдэг нь эрх зүйн харилцаанд бие даан оролцох эрхтэй гэсэн утгыг өөртөө агуулж байхад байгууллагын нэгжийг бие даасан алба хэмээн үзэх нь үндэслэлгүй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын Хавсралтын 5-д “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар” гэж заасныг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

***Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэг хариу тайлбартаа*:**

“... Монгол Улс “Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц”-д 1984 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр нэгдэн орсон бөгөөд үүнээс хойш уг конвенцыг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөж байна.

“Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц”-ийн 12 дугаар зүйлийн 1-д “Холбооны гишүүн орон бүр аж үйлдвэрийн өмчийн хэрэг эрхлэх тусгай алба болон олон нийтийг патент, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болон барааны тэмдгийн патенттай танилцуулах төвлөрсөн байгууллага байгуулах үүрэг хүлээнэ.” гэж заасны дагуу Монгол Улс 1990 онд Үндэсний хөгжлийн газрыг байгуулахдаа түүний харьяа Патент, барааны тэмдгийн газрыг байгуулж, Соёлын яамны харьяа Зохиогчийн эрхийн газрыг байгуулсан бөгөөд улмаар 1996 онд Оюуны өмчийн газар байгуулагдсан байна.

“Тусгай алба”, “төвлөрсөн байгууллага” гэдэгт ямар алба, байгууллагыг ойлгох талаар уг конвенцод нарийвчлан тодорхойлоогүй бөгөөд “тусгай алба” гэснийг заавал эрх зүйн харилцаанд бие даан оролцох бус, харин тодорхой чиг үүргийг тусгайлан хэрэгжүүлэхээр байгуулагдсан албыг, “төвлөрсөн байгууллага” гэснийг дээрх чиг үүргүүдийг олон байгууллага салбарлан хэрэгжүүлэх бус, харин нэг дор төвлөрүүлэн хэрэгжүүлэх байгууллага гэж ойлгох нь зүйтэй байна.

Патентын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Технологи дамжуулах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлэг хүлээн авч, хянан шийдвэрлэх, гэрчилгээ олгох, улсын бүртгэл хөтлөх, мэдээллийн сан байгуулах, холбогдох мэдээллийг хэвлэн нийтлэх, лавлагаа гаргах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг тусгайлан нэрлэж зааж, энэхүү чиг үүргийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн байгууллага төвлөрүүлэн гүйцэтгэхээр хуульчилсан байна.

Иймхүү “Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц”-оор Монгол Улсын хүлээсэн үүргийн биелэлтийг Монгол Улсын хэмжээнд хангах чиг үүргийг Оюуны өмчийн газар (хуучин нэрээр)-ын Аж үйлдвэрийн өмчийн хэлтэс хэрэгжүүлж байсан нь одоогийн Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газарт хэвээр хадгалагдаж, аж үйлдвэрийн өмчийн эрхийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн “Агентлагийн зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 10 дугаар тушаал болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 8

дугаар сарын 23-ны өдрийн “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” А/16 дугаар тушаалын хавсралтуудаас үзэхэд хоёр байгууллагыг нэгтгэснээр тамгын газар, мэдээллийн технологи, хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын зэрэг нийтлэг үйл ажиллагаа явуулдаг нэгжүүдийг нэгтгэсэн бөгөөд оюуны өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын онцгой чиг үүргийг хэрэгжүүлдэг Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газар, Оюуны өмчийн эрхийн газар нь өмнөх зохион байгуулалтын бүтцээрээ ажиллаж байна.

Иймд Монгол Улс “Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц”-д заасан тусгай алба, төвлөрсөн байгууллагыг байгуулах үүргээ зөрчсөн аливаа үйлдэл, шийдвэр шинээр гаргаагүй, Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газрын статусыг дордуулаагүй, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ өмнөхийн адил шударгаар сахин биелүүлж байгаа тул Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

Төрийн үйл ажиллагааны хууль дээдлэх зарчим нь эрх зүйн бүх акт, шийдвэр, хууль тогтоомж Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байхыг шаарддаг бөгөөд Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 12 дугаар тогтоол нь “Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц” болон Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нийцэж байгаа тул Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль дээдлэх зарчмыг хангаж байна.” гэсэн байна.

Гурав. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Монгол Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 12 дугаар тогтол, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 4

дүгээр тогтоолын дагуу Оюуны өмчийн газрыг татан буулгаж, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрыг өөрчлөн байгуулсан.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай А/16 дугаар тушаалаар тус газрын зохион байгуулалт, бүтцийг баталсан бөгөөд Зохиогчийн эрхийн газар, Аж үйлдвэрийн өмчийн эрхийн газар нь хэвээр хадгалагдан үлдэж үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна.

Дэлхийн 24 улсад Оюуны өмчийн газар нь бүртгэлийн байгууллагатайгаа нэгдсэн байдлаар үйл ажиллагаа нь явагддаг. Үүний 19 улс нь Аж үйлдвэрийн эрхийг хамгаалах тухай Парисын конвенцод нэгдэн орсон байна. Иймд энэхүү бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт нь Монгол Улсын хууль тогтоомж болон Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцын холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэхгүй байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисы н конвенцын 12 дугаар зүйлд “тусгай алба” гэснийг тодорхой чиг үүргийг тусгайлан, иж бүрнээр нь хариуцаж бие даан хэрэгжүүлэх, харин “төвлөрсөн байгууллага” гэснийг тодорхой төрлийн мэдээллийг нэг санд төвлөрүүлэн, нэгдсэн журмаар ашиглах гэж ойлгон гишүүн орнууд бие даасан байгууллага, агентлаг, эсхүл яам, газрын бүтцэд хэлтэс, алба, институт зэрэг хэлбэрээр зохион байгуулжээ.

2. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг тогтоох нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарч байна.

3. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 12 дугаар тогтоолын хавсралтын хэлэлцэж буй хэсэг Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 12 дугаар тогтоолын хавсралтын 5-д “Оюуны өмч, улсын бүртгэлийн газар” гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Д.СУГАР
ГИШҮҮД	Т.ЛХАГВАА
	Д.СОЛОНГО
	Д.ОДБАЯР
	Д.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2017.04.12 Дугаар 03 Улаанбаатар хот

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 11.40 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Цогтоо, Д.Сугар, Д.Наранчимэг, Д.Ганзориг /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд оролцоогүй болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсэгт “Хяналтын шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч оролцох эрхтэй ба уг этгээд энэ тухай хүсэлтээ бичгээр гаргасан бол заавал оролцоно.” гэж заасны “... шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч оролцох эрхтэй ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... өөрийгөө өмгөөлөх, ... шударга шүүхээр шүүлгэх,

хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, ... эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Монгол Улсын иргэн Ч.Лхагвасүрэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсэгт “... шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч оролцох эрхтэй ...” гэж заасан нь Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд шүүгдэгч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэр тусмаа шийтгүүлсэн этгээд болох ялтны эрх, ашиг сонирхол зөрчигдөж байна.

Учир нь дээр дурдсан Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хууль ёсны оролцогчид нь өөр өөрсдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхтэй субъектүүд бөгөөд тэр тусмаа шүүгдэгчийн (ялтны) хувьд Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрх нь ноцтойгоор зөрчигдөж байна. Ингэж үзэх үндэслэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... өөрийгөө өмгөөлөх, ... шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, ... эрхтэй. ...” гэснийг зөрчиж байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Хүнийг ... нийгмийн гарал, байдал, ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг тус тус зөрчиж байна.

Энд дурдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсэг болон Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын холбогдох хэсэг дараах эрх зүйн үр дагаврааар зөрчилдөж байна.

Нэг талаас Монгол Улсын иргэний хувьд Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу хэргээ шүүх ажиллагаанд биеэрээ оролцож, өөрийгөө өмгөөлж, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй (шударга шүүх гэдэгт гурван шатны шүүхийг ойлгож байна).

Нөгөө талаас эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч, шүүгдэгчийн (ялтны) хувьд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсэгт заасны дагуу хэргээ шүүх ажиллагаанд (шүүх хуралдаанд) оролцох, өөрийгөө шүүхийн өмнө өмгөөлөх эрхгүй

болж байна. Хуулийн энэхүү зүйл, заалт нь шүүгдэгчийг эрх зүйн байдал, ажил, албан тушаал, боловсролынх нь хувьд ялгаварлан үзэж байгаа хэрэг мөнийн хувьд өөрт холбогдох эрүүгийн хэргийг эцэслэн шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох, эрхээ хамгаалж өөрийгөө өмгөөлөх бололцоог хязгаарлаж байгаагаараа Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, мөн шүүх хуралдаанд мэтгэлцэх нэг тал болохын хувьд эрх тэгш байх Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгтэй зөрчилдөж байна.

Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэдэг бол эрх зүйн тэгш эрх гэдэг ойлголт бөгөөд шүүхийн өмнө эрх тэгш байх хуулийн баталгаа нь гагцхүү мэтгэлцэх боломжоор хангагдсан байдлаар илрэх ба үүний тулд яллах тал болох прокурорын нэгэн адил хэргээ шүүх ажиллагаанд биечлэн оролцох байдлаар хэрэгжих боломжтой, хууль, шүүх (хяналтын шатны шүүх ч мөн адил) дээр мэтгэлцэх, биечлэн оролцох хэлбэрээр шүүхийн өмнө эрх тэгш байх боломжоор хангах үүрэгтэй гэж үзэж байна.

Маргаж байгаа асуудлын талаарх өргөдөл гаргагчийн байр суурь:

Хэдийгээр хяналтын шатны шүүх хуралдаанаар эрүүгийн гэмт хэргийн үйл баримт, гэм буруугийн хэлбэр, хэмжээ, гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцөлийг тогтоодоггүй бөгөөд зөвхөн хууль хэрэглээний асуудлаар буюу Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн эсэх асуудлаар хэлэлцдэг ч шүүгдэгч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шийтгүүлсэн этгээд болох ялтан нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 320, 321 дүгээр зүйлд заасан үндэслэлээр мэтгэлцэх, өөрийгөө өмгөөлөх, хуульд заасан журмын дагуу шүүх хуралдааны дэгийг баримталж хэргээ шүүх ажиллагаанд оролцох эрх зүйн ухамсар, мэдлэг чадваргүй гэж үзэх нь хэтэрхий өрөөсгөл хэрэг болно.

Магадгүй өөрийгөө өмгөөлж эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байгаа этгээд байвал яах вэ? Эсхүл шүүгдэгч өөрөө мэргэжлийн хуульч, өмгөөлөгч байвал яах вэ? Түүнийг эрх зүйн мэдлэггүй, улсын яллагчийн үндэслэлийг няцаах чадваргүй гэж үзэж болохгүй.

Нөгөөтээгүүр, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсэг нь субъектүүдийн эрх зүйн зохицуулалт гэхээсээ илүүтэйгээр Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар, ажлын алба,

түүний бүтэц, зохион байгуулалт, шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нарын ажлын ачаалал, байр, өрөө тасалгааны нөхцөл зэрэгтэй холбоотойгоор хэргийн оролцогчдыг шүүх хуралдаанд оролцуулахгүй байхаар зохицуулсан шинжтэй. Гэтэл энэ бүхэнтэй харьцуулшгүй үнэт зүйл болох хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зэрэг илүү үнэ цэнтэй зүйлийн талаар эцсийн шатны шүүхийн шийдвэр гаргах ажиллагаанд тухайн этгээдийг өөрийг нь оролцуулж байлцуулахгүйгээр шийдвэрлэж байгаа нь шударга ёсны зарчим, хууль ёсны зарчим, шүүхийн нээлттэй байх үндсэн зарчимтай зөрчилдөж байна.

Эцэст нь тэмдэглэхэд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсгийг Үндсэн хуульд нийцүүлэн өөрчилж дээр дурдсан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хууль ёсны оролцогчдын хяналтын шатны шүүх хуралдаанд оролцох, шүүхийн өмнө эрх тэгш (прокурортой) байж өөрийгөө өмгөөлөх Үндсэн хуулиар олгогдсон эрхийг нь эдлүүлэх, эрх зүйн шинэчлэлтэй холбоотойгоор хийгдэж байгаа Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуульд ч Үндсэн хуулийн хэм хэмжээг баримтлан хууль тогтоох, ингэснээрээ олон хүний эрхийг хангах, хамгаалах болно гэж бодож байна.

Үндсэн хуулийн цэцээр шийдвэрлүүлэхээр тавьж буй шаардлага:

Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа ... шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараах наад захын баталгаагаар хангагдах эрхтэй:” гээд (d) заалтад “хэргийг нь шүүхээр хянан хэлэлцэхэд байлцах, өөрийгөө биечлэн өмгөөлөх ...” гэсэн байх ба пактын Хорин зургадугаар зүйлд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй болохыг, мөн алагчлах явдлыг хуулиар хориглох, алагчлахаас бүх хүнийг адил тэгш, үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстойг тогтоосон байна. Үүнийг Монгол Улс үндэсний хуулийн нэгэн адил, хэрэв үндэсний хуультай зөрчилдвөл дээд хүчин чадалтай үйлчлэх олон улсын эрх зүйн хэм хэмжээ болсон пактын заалтад илүү ач холбогдол өгч хэрэглэх талаарх үүргийг Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд хуульчилсан байдаг.

Мөн түүнчлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 7 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү тунхаглалд харшлах аливаа алагчлалаас болон тийнхүү алагчлахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй.” гэж, 10 дугаар зүйлд “Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх, үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.” хэмээн заажээ.

Уг нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг зохицуулж байгаа гол эрх зүйн акт болох Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад Үндсэн хуулийг удирдлага болгож, энэ хуулийг баримтална.” гээд мөн зүйлийн 2.2 дахь хэсэгт “Энэ хуулиар тогтоосон ... шүүх, ... дагаж биелүүлнэ.” гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа хууль ёсны байх зарчмыг 8.1 дэх хэсэгт “... шүүх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийн заалтыг чанд сахина.”, 8.2 дахь хэсэгт “... энэ хуулийн 8.1-ийг зөрчвөл түүний гаргасан шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүйд тооцож, ...”, 8.3 дахь хэсэгт “Шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй хуулийг хэрэглэхгүй.” хэмээн тус тус заасан байдаг.

Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй.” гэж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 7 дугаар зүйлд хууль дээдлэх, хуульд захирагдах зарчмыг, 9 дүгээр зүйлд мэтгэлцэх зарчмыг хэрхэн хангахыг хуульчилсан байна.

Энд онцгойлон тэмдэглэхэд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.4 дэх хэсэгт хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэх дэг, процессыг “Илтэгч шүүгч хэргийн байдал, тогтоол, магадлал болон гомдол, эсэргүүцлийн агуулгыг танилцуулж, дараа нь шүүгч илтгэгчид асуулт тавьж, улмаар прокурор, өмгөөлөгч тухайн хэргийн талаар санал хэлж болно.” гэжээ.

Практикт хяналтын шатны гомдол, эсэргүүцэл гаргасан этгээд эхлээд саналаа /үндэслэлээ/ хэлдэг. Тэгвэл яг энэ үед гомдол гаргасан этгээд болох шүүгдэгч нь өөрийн гомдлын үндэслэлээ хамгаалах, улсын яллагчийн гаргасан үндэслэлийг үгүйсгэх байдлаар эрх тэгш мэтгэлцэх боломжоо Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсгээр хязгаарлуулж байгаа юм.

Нөгөөтээгүүр, шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэйн хувьд өөрийн биеэр хяналтын шатны шүүх хуралдаанд оролцож байж л Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлж, мэтгэлцэх зарчим хангагдах боломжтой. Гэтэл хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд шүүгдэгчийн оролцох эрхийг хязгаарласан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсэг үйлчилсээр байна.

Тэгвэл Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан "... өөрийгөө өмгөөлөх, ... шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, ..." эрхийг Монгол Улсын иргэнд олгохдоо ямар нэг хязгаарлалт тогтоогоогүй ба шүүх хуралдаанд өөрийн биеэр оролцох шүүгдэгчийн эрх зөвхөн анхан болон давж заалдах шатны шүүхээр хязгаарлагдахгүйгээр хяналтын шатны шүүх хуралдаанд ч өөрийн биеэр оролцох эрх гэж Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 3 дахь хэсгийн (d) заалтад зааснаар ойлгож байна.

Мөн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хууль ёсны оролцогчид нь эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүх хуралдаанд оролцож өөрийн эрх, ашиг сонирхлоо хамгаалах нь Үндсэн хуулиар олгогдсон маш чухал эрх гэж үзэж байна.

Иймд миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэхийг зохих хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье." гэсэн өргөдөл гаргажээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг ... нийгмийн гарал, байдал, ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно." гэж тус тус заасныг үндэс болгон хууль тогтоогч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт "Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл

бодол, боловсролоор ялгаварлан гадуурхахгүйгээр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж Үндсэн хуулийн зарчмыг органик хуулиар баталгаажуулж хуульчилж өгсөн бөгөөд иргэний Үндсэн хуульд заасан эрх Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу дараах байдлаар хангагдана. Үүнд:

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч этгээд бүр уг ажиллагааны үе шат болгонд оролцохдоо хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээж оролцох бөгөөд анхан шатны шүүх хуралдаанд шүүгдэгчийг заавал оролцуулах ба шүүгдэгч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохоор, түүнчлэн уг ажиллагааны явцад шүүгдэгчийг байцаах, шүүгдэгчийн эцсийн үгийг сонсох зэрэг ажиллагааг явуулахаар хуульчилж өгсөн.

Анхан шатны шүүхийн шийдвэр гарсны дараа ялтан, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй бөгөөд давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд шийтгүүлсэн буюу цагаатгагдсан этгээд, хохирогч, түүнчлэн иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч оролцох эрхтэй ба тэдний шүүх хуралдаанд ирээгүй явдал нь хэрэг хэлэлцэхэд саад болохгүй байхаар, мөн шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргасан ялтныг шүүх хуралдаанд оролцуулж болохоор тус тус заасан.

Давж заалдах шатны шүүх хэргийг хэлэлцэхдээ шүүхийн тогтоол хууль ёсны ба үндэслэлтэй болсон эсэхийг хэрэгт байгаа материалыг үндэслэн хянах ба давж заалдсан гомдол, эсэргүүцэлд дурдсан зүйлээр хязгаарлахгүйгээр бусад шүүгдэгчийн талаар давж заалдах гомдол, эсэргүүцэл бичигдсэн эсэхийг харгалзахгүйгээр бүх шүүгдэгчийн хэргийг бүхэлд нь хянан үзэж, давж заалдагч гомдол, эсэргүүцлээ тайлбарлах ба дараа нь шүүх нотлох баримтыг шинжлэн судлах, хуралдаанд оролцогчийн тайлбарыг сонсох, улмаар прокурорын дүгнэлт, шийтгэгдсэн ба цагаатгагдсан этгээд, тэдний өмгөөлөгчийн нэмэлт тайлбарыг сонссоны үндсэн дээр магадлал гаргадаг.

Дээр дурдсан хоёр шатны шүүх хуралдаанд оролцогч талууд хэн аль нь шүүхэд өөрийн гэм буруу болон холбогдох бусад асуудлаар үг хэлж, хууль зүйн туслалцааг эрх бүхий этгээдээс авч, эрхээ хамгаалах талаар бүх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Давж заалдах шатны шүүх нь ял оногдуулах болон цагаатгагдсан этгээдийн гэм буруутай эсэх

асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогч болон тэдгээрийн өмгөөлөгч гомдол гаргах, харин Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.

Хяналтын шатны шүүх нь анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсэхийг хянах, өөрөөр хэлбэл, анхан болон давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэм хэмжээг хэрхэн хангаж биелүүлсэн, ял шийтгүүлсэн этгээдийн гэм буруугийн талаарх дүгнэлт эрх зүйн үндэстэй эсэх, гарсан тогтоол, магадлал, захирамж нь хуульд заасан шаардлагыг хангасан эсэхэд эрх зүйн дүгнэлт хийсний үндсэн дээр шийдвэр гаргах явдал юм.

Энэ утгаараа дээрх эрх зүйн маргаанд Монгол Улсын Үндсэн хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан өндөр шаардлага, шалгуурыг хангасан, эрх зүйн өндөр мэдлэг бүхий Улсын дээд шүүхийн шүүгчидтэй мэргэшсэн хуульч болох өмгөөлөгч оролцож хуулиар эрх олгогдсоны дагуу үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүргээ хэрэгжүүлж мэтгэлцэх нь иргэний эрхийг хаасан бус харин ч бүрэн дүүрэн хангах боломжийг бий болгоно.

Иймд хууль тогтоогч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсгээр дээрх асуудлыг зохицуулж иргэний эрхийг хамгаалж өгсөн. Нөгөөтээгүүр, хяналтын шатны шүүх хуралдаанаар нэгэнт хэргийн үйл баримт болон хавтаст хэргийн талаар хэлэлцэхгүй зөвхөн хууль хэрэглээний асуудал болон ажиллагааны явцад гарсан процессын алдааны талаар хэлэлцэх тул шүүгдэгч, хохирогч зэрэг бусад оролцогч уг ажиллагаанд оролцох шаардлагагүй гэж үзсэн. Шүүхэд хүсэлт гаргасан тохиолдолд шүүгдэгч, хохирогч санал, дүгнэлт гаргахгүйгээр шүүх хуралдаанд ажиглаж оролцох эрх нь нээлттэй.

Түүнчлэн, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасанчлан хуульчийн мэргэжлийн шалгалтанд орж тэнцсэн хуульч шүүхэд төлөөлөх эрх нээлгэхээр Улсын дээд шүүхэд бүртгүүлж, өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтад бичигдсэнээр түүний шүүхэд төлөөлөх эрх нээгдэнэ. Ийнхүү эрх нээлгэсэн өмгөөлөгч л шүүх хуралдаанд оролцоно.

Хуульч нь Монгол Улсын иргэнд Үндсэн хуулиар олгогдсон дээрх эрхийг баталгаатай эдлүүлэх үүрэгтэй. Монгол Улсын Үндсэн

хуульд заасанчлан төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцсан нийтлэг эрхийг хамгаалах үүрэг юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "... өөрийгөө өмгөөлөх, ... шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, ... эрхтэй. ..." гэсэн нь ялтан, шүүгдэгч, хохирогч нь хэргийг шүүх анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд биечлэн оролцож өөрийгөө өмгөөлж, хууль зүйн туслалцаа авах, хэргээ шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхээр бүрэн хангагдаж хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээж байгаа болно. Харин хяналтын шатны шүүх хуралд тухайн этгээдийн хэргийг шүүх ажиллагаа явагдахгүй тул дээрх заалтын "хэргээ шүүх хуралдаанд биеэр оролцох" гэснийг зөрчсөн гэж үзэхгүй байна.

Дээр дурдсаныг үндэслэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг зөрчөөгүй гэсэн тайлбарыг уламжилж байна." гэжээ.

Гурав. Монгол Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"2002 онд шинэчлэн найруулагдаж, батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт "Шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдана." гэж заасан бөгөөд уг заалтад Улсын Их Хурлаас 2014 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр "Анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны мэтгэлцэх зарчмыг хангахдаа шүүх хуралдаанд талууд, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон улсын яллагчид асуулт асуух, хариулах, нотлох баримтыг танилцуулах, өөрсдийн тайлбар өгөх, үндэслэлээ хамгаалах, үгүйсгэх боломжийг тэгш олгоно." гэсэн нэмэлтийг оруулж, мэтгэлцэх зарчим нь зөвхөн шүүн таслах үед, тэр тусмаа анхан шатны журмаар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд үйлчлэхээр хуульчлагджээ.

Шүүх эрх мэдлийн мөн чанар нь анхан шатны шүүхийн ажиллагаагаар дамжин илэрдэг тул зөвхөн энэ шатны шүүх л "Монгол Улсын нэрийн өмнөөс" шийдвэр гаргадаг билээ.

Түүнчлэн зөвхөн анхан шатны шүүх дээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны өөр ямар ч үе шаттай харьцуулшгүй Үндсэн хуулийн давхар баталгаа бүхий зарчмууд үйлчилдэг. Харин давж заалдах болон хяналтын шатны шүүхийн ажиллагаа нь Үндсэн хуулиар

баталгаажсан давж заалдах эрхийг хангах чухал хэлбэр болохоос бус заавал хэрэгжих ёстой ажиллагаа биш юм. Тийм учраас Эрүүгийн байцаан шийтгэх хуульд анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх хэмжээ, хязгаар, шүүх хуралдааны ерөнхий нөхцөл, хэрэг хэлэлцэх ажиллагааны нэршил зэргийг харилцан адилгүй байхаар хуульчилжээ. Тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн:

- 246 дугаар зүйлд анхан шатны журмаар хэрэг хэлэлцэхийг “шүүн таслах ажиллагаа” гэж нэрлэсэн бол мөн хуулийн 308, 348 дугаар зүйлд давж заалдах болон хяналтын шатны шүүхийн хувьд “хэргийг хянан шийдвэрлэнэ” гэж;

- 239-245 дугаар зүйлүүдэд анхан шатны шүүх хуралдаанд хэргийн оролцогчдыг хэрхэн оролцуулах, тэдгээр нь хүрэлцэн ирээгүй тохиолдолд хэрхэх асуудлыг оролцогч тус бүрээр тусгайлан зохицуулсан байх бөгөөд ихэнхи тохиолдолд оролцогчдын эрхийг тэгш хангах, тэдгээрийг аль болох бүрэн хамруулах зорилгоор хэрэг хэлэлцэх явдлыг хойшлуулахаар;

- 311 дүгээр зүйл болон 349 дүгээр зүйлийн 349.1, 349.2 дахь хэсгүүдэд зааснаар давж заалдах ба хяналтын шатны шүүх хуралдаанд хүсэлтээ бичгээр гаргасан прокурор, өмгөөлөгчийг заавал оролцуулах бөгөөд үүнээс бусад тохиолдолд тэдгээр нь хүрэлцэн ирээгүй явдал хэргийг хэлэлцэхэд саад болохгүй;

- 312 дугаар зүйлийн 312.1 дэх хэсэгт прокурор, өмгөөлөгчөөс бусад хэргийн оролцогчид давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох эрхтэй ба тэд шүүх хуралдаанд ирээгүй нь хэргийг хэлэлцэхэд саад болохгүй, энэ зүйлийн 312.2 дахь хэсэгт хүсэлт гаргасан ялтныг хуралдаанд оролцуулж болохоор тус тус зохицуулсан бол харин хяналтын шатны шүүх хуралдаанд дээрх субъектүүд оролцох асуудлыг хуульчлаагүй зэрэг болно.

Хууль тогтоогч хэргийн оролцогчдын гурван шатны шүүх хуралдаанд оролцох эрхийг ийнхүү хязгаартай байдлаар, өөр өөрөөр тогтоосон нь Үндсэн хууль болон процессын хуулиудаар баталгаажсан, хараат бус шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэх журмаар хэрэгждэг иргэний эрхийн шүүхийн хамгаалалттай салшгүй холбоотой гэж ойлгогдож байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 303, 342 дугаар зүйлүүдэд хэргийн оролцогчид тухайн шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхийг олгосон явдал нь анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр дэх

хууль хэрэглээний асуудлыг нягтлуулах, хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх ажиллагааг төлөвшүүлэх, хамгийн гол нь хэргийн оролцогчдын Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангах үндсэн хэрэгсэл нь болдог учиртай.

Тиймээс дээрх хуулийн 348 дугаар зүйлд зааснаар хяналтын шатны шүүх нь зөвхөн Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн (мөн хуулийн 320 дугаар зүйл), Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн (мөн хуулийн 321 дүгээр зүйл) эсэхийг хянадаг бөгөөд энэ нь тухайн хэргийг шийдвэрлэсэн доод шатны шүүхийн шийдвэрт эрх зүйн үнэлэлт өгөх зорилготой ажиллагаа билээ.

Өөрөөр хэлбэл, хяналтын шатны шүүх нь хэргийн үйл баримтыг тогтоохгүйгээр, түүний талаар шүүхээс хийсэн эрх зүйн маргааныг шийдвэрлэдэг тул хэргийн оролцогчдыг шүүх хуралдаанд биечлэн оролцуулан, мэтгэлцээний үндсэн дээр явагддаг анхан шатны шүүхийн ажиллагаатай адилтган үзэх үндэслэлгүй байна.

Иймд хэргийн оролцогчдын гурван шатны шүүхийн ажиллагаанд биечлэн оролцох эрхийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хязгаартайгаар тогтоосон нь Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтыг зөрчсөн гэж үзэх боломжгүй.” гэсэн байна.

Дөрөв. Монгол Улсын Ерөнхий прокурорын газраас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэг, 348 дугаар зүйлийн 348.1 дэх хэсэгт заасны дагуу хяналтын шатны шүүх нь эрүүгийн хэргийн үйл баримтыг тогтоохгүй, харин анхан шатны болон давж заалдах шатны шүүх эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөв хэрэглсэн эсэх, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсэхийг хянадаг. Түүнчлэн хяналтын шатны шүүх хуралдаанд мэтгэлцээн явагдахгүй, зөвхөн хууль хэрэглээний асуудлыг хянан хэлэлцэх учраас мэргэжлийн хуульч нар буюу өмгөөлөгч, прокурор оролцож, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.4 дэх хэсэгт заасны дагуу тухайн хэргийн талаарх саналаа илэрхийлж байгаа болно.

Шүүгдэгч нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 36 дугаар зүйлийн 36.3.16 дахь заалтад заасан эрхийнхээ хүрээнд анхан болон давж заалдах шатны шүүх өөрт нь холбогдох хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн гэж үзвэл өөрөө болон

өмгөөлөгчөөрөө дамжуулан хяналтын шатны шүүхэд гомдол гаргаж, шүүхийн шийдвэрийг хянуулах хуулийн зохицуулалттай байна.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдөхгүй байна.” гэжээ.

Тав. Монголын хуульчдын холбооноос Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад зааснаар Монгол Улсын иргэн нь “... Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, ... шударга шүүхээр шүүлгэх, ... хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй”.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу Монгол Улсын иргэн өөрт хамааралтай хэрэг, маргаанаа анхан шатны шүүхээр хянан шийдвэрлүүлсний дараа анхан шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, гэмт хэргийн хүнд хөнгөн ба шийтгэгдсэн этгээдийн хувийн байдалд тохироогүй ял оногдуулсан гэж үзвэл давж заалдах шатны шүүх буюу аймаг, нийслэлийн шүүхэд хохирогч, шүүгдэгч, түүний гэр бүл, өмгөөлөгч давж заалдах гомдол гаргах эрхийг хэрэгжүүлж байгаагаараа Үндсэн хуульд заасан иргэний “шударга шүүхээр шүүлгэх” эрх хангагдсан гэж үзэх хуулийн үзэл баримтлал бий.

Олон улсын жишигт мөн шударга шүүхээр шүүлгэх эрх нь анхан болон давж заалдах шатанд хангагддаг гэж үздэг ба хяналтын журмаар гомдол гаргасны дагуу үүсэх маргаан нь иргэний маргаан биш зөвхөн хууль хэрэглээний талаар өрнөдөг эрх зүйн маргаан болохыг хүлээн зөвшөөрдөг.

Ийм учраас Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн. ...”, “шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж хуульчилсан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 348 дугаар зүйлийн 348.1 дэх хэсэгт заасны дагуу хяналтын шатны шүүх нь эрүүгийн хэргийн үйл баримтыг тогтоохгүй, харин анхан болон давж заалдах шатны шүүх эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөв

хэрэглэсэн эсэх, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсэхийг хянадаг. Хяналтын шатны шүүх хуралдаанд мэтгэлцээн явагдахгүй, зөвхөн хууль хэрэглээний асуудлыг хянан үздэг бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.4 дэх хэсэгт заасны дагуу прокурор, өмгөөлөгчийн саналыг сонсдог.

Нөгөөтээгүүр, хяналтын шатны шүүх хуралдаанд шүүгдэгчийг оруулах эрхийг хангасан байлаа ч ямар нэгэн тайлбар, санал хэлэх боломжгүй, хэргийн үйл баримтыг тогтооход ач холбогдолгүй бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэгт заасны дагуу давж заалдах шатны шүүх ял оногдуулсан, эсхүл цагаатгагдсан этгээдийн гэм буруутай эсэх асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл өөрөө болон өмгөөлөгчөөрөө дамжуулан хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлаагүй юм.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Анхан шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд буюу шүүн таслах ажиллагаанд шүүгдэгчийн биеэр оролцох эрхийг заавал хангасан байхаар, харин давж заалдах шатны шүүх хуралдаанд шүүгдэгчийн хүсэлтээр оролцуулахаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгажээ.

Хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн анхан болон давж заалдах шатны шүүх эрүүгийн хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсэх тухай хууль хэрэглээний асуудлыг хянан хэлэлцдэг онцлогоос хамааран талуудын хооронд мэтгэлцээн өрнөхгүй, прокурор, өмгөөлөгч зөвхөн санал хэлэх байдлаар оролцдог утгаараа бусад оролцогчдыг оролцуулах нь эрх зүйн хувьд ач холбогдолгүй гэж хууль тогтоогчийн зүгээс тайлбарласныг үндэслэлтэй гэж үзэхээр байна.

2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд буюу хяналтын шатны шүүх хуралдаанд хэргийн оролцогчид заавал өөрийн биеэр оролцсоноор өөрийгөө өмгөөлөх эрх хэрэгжинэ гэж үзэхгүй бөгөөд энэ нь илүү өргөн хүрээг хамарсан ойлголт байна. Шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогч өөрийгөө өмгөөлөх эрхийн хүрээнд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлд заасны дагуу давж заалдах шатны шүүхийн шийдвэр дэх хууль хэрэглээний асуудлыг өөрт ашигтайгаар

тайлбарлан гомдол гаргах боломж уг хуульд нээлттэй байгаа нь өөрийгөө өмгөөлөх эрх хэрэгжих нэг нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэхээр байна.

3. Хяналтын шатны шүүх хуралдаанд зөвхөн прокурор, өмгөөлөгч оролцох эрхтэй байхаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг алдагдуулсан гэж үзэх үндэслэлгүй байна. Учир нь энэхүү зарчмын хууль зүйн агуулга нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны ямар ч үед яллах болон өмгөөлөх талуудын хэн нэгэнд давуу эрх олгодоггүй бөгөөд хяналтын шатны шүүх хуралдаанд ч яллах болон өмгөөлөх тал адил оролцох боломжтой байна.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсэгт "... шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч оролцох эрхтэй ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "... өөрийгөө өмгөөлөх, ... шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, ... эрхтэй. ..." гэснийг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсэгт "Хяналтын шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч оролцох эрхтэй ба уг этгээд энэ тухай хүсэлтээ бичгээр гаргасан бол заавал оролцоно." гэж заасны "... шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч оролцох эрхтэй ..." гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "... өөрийгөө өмгөөлөх, ... шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, ... эрхтэй. ..." гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Н.ЖАНЦАН
ГИШҮҮД	Ш.ЦОГТОО
	Д.СУГАР
	Д.НАРАНЧИМЭГ
	Д.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2017.05.03. Дугаар 04 Улаанбаатар хот

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 12.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Т.Лхагваа, Д.Сугар, Д.Одбаяр, Д.Ганзориг /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч, иргэн П.Оюунчимэг болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад “өмгөөлөгч, шүүгч, прокуророор арваас доошгүй жил ажилласан;”, 6.1.3 дахь заалтад “Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд арваас доошгүй жил багшилсан.” гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын

дээд шүүхийн шүүгчээр ... томилж болно.” гэж заасныг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3 дугаар хорооны оршин суугч, иргэн П.Оюунчимэг Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий өргөдлийг гаргасан байна. Үүнд:

“Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт Улсын дээд шүүхийн шүүгч энэ хуулийн 4 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан нэг буюу түүнээс дээш шаардлагыг хангасан байна гээд 6.1.2 дахь заалтад “өмгөөлөгч, шүүгч, прокуророор арваас доошгүй жил ажилласан;”, 6.1.3 дахь заалтад “Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд арваас доошгүй жил багшилсан.” гэсэн нөхцөл шаардлага тавьсан нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг болон Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлд “... хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох”, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... чөлөөтэй сонгох, ... хөдөлмөрлөх эрхийг хүлээн зөвшөөрч энэ эрхийг хэрэгжүүлэх ...”-ээр заасныг тус тус зөрчиж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилж болно гэжээ. Үндсэн хуулийн энэ заалт нь тухайн ажил мэргэжлийг хаших нийтлэг шалгуурыг нөхцөл болгон заасан байх бөгөөд мэргэжлээрээ ажилласан гэдэг шалгуурыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд зөвхөн “өмгөөлөгч, шүүгч, прокурор, хууль зүйн сургуульд багшаар арваас доошгүй жил багшилсан” гэж тодорхой субъектүүдийг нэр заан хуульчилсан байна.

Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиас өмнө гадаад, дотоодын их, дээд сургууль төгссөн бүх эрх зүйч, хуульчид хуулийн, захиргааны, хүний эрхийн болон төрийн байгууллагад ажиллаж байсан хуульчид энэ хуульд заасан нөхцөлийн дагуу аль ч шатны шүүхэд нэр дэвших боломжгүй болж байна.

Монгол Улсын органик болон салбар хууль нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцсэн байх ёстой ба түүнээс давсан хуулийн зохицуулалт байх ёсгүй юм.

Хэдийгээр хууль хэрэглээн дэх хуульчийн чадвар, туршлага, хариуцлага, хуульчаар ажилласан байх шаардлага зүй ёсных хэдий ч салбар хуульдаа өмгөөлөгч, шүүгч, прокурор, багш гэсэн дөрвөн субъектээс бусдыг нь өөрөөр хэлбэл, төрийн албанд арваас хорин жил мэргэжлээрээ ажиллаж байгаа бусад эрх зүйч, хуульч нар дээд шүүхийн шүүгчид өрсөлдөх боломж, ажлаа чөлөөтэй сонгох эрхийг бүрэн хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулиас давсан шаардлага болж хүний ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох сонголтод хязгаар тавьснаараа Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний үндсэн эрхийг зөрчсөн байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар тавьсан шаардлага нь зөвхөн хуульч, шүүгч, прокурор, өмгөөлөгч, багшаар ажилласан хуульчид өрсөлдөх эрхтэй болж бусад салбарт олон жил мэргэжлээрээ ажилласан эрх зүйч, хуульч нарыг мэргэжлээрээ ажиллаагүй гэж үзэж шүүгчийн шалгалтад бүртгэхээс татгалзаж байгаа нь ардчилсан ёс, тэгш байдал, хууль дээдлэх зэрэг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим алдагдахад хүргэж байна.

Иймд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад “өмгөөлөгч, шүүгч, прокуророор арваас доошгүй жил ажилласан;”, 6.1.3 дахь заалтад “Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд арваас доошгүй жил багшилсан.” гэж заасан нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр ... томилж болно.” гэж заасантай нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хариу тайлбартаа:

“... Хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, эрх зүйт төрийн баталгаа нь бие даасан шүүх, хараат бус шүүгч байдаг. Шударга ёсны мэдрэмжтэй, хууль, эрх зүйн нарийн мэдлэг, боловсролтой, шүүгчид байх сэтгэл зүйн хэв шинжийг өөртөө агуулсан, шүүгчийн ёс зүйг албаны хүрээнд болон бүхий л амьдралдаа дагаж мөрдөж чадах тийм л хүн шүүх эрх мэдлийг хараат бусаар хэрэгжүүлж, хэрэг, маргааныг хууль болон өөрийн дотоод итгэл үнэмшилд үндэслэн шийдвэрлэж чадна. Энэ шаардлага шүүгч болох хүн бүрт тавигдана.

Монгол Улсын хувьд шүүгчид тавигдах болзол, шаардлага бүрэн хангагдсан иргэнийг хуульчдаас шилж сонгон шүүгчээр томилуулах арга, ажиллагааг нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн шүүгчид тавих тусгайлсан шаардлагыг гүйцэтгэж байгаа албан үүрэгтэй нь холбогдуулан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд шинэчлэн боловсруулж тусгасан байна. ... Ингэснээр Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "... мэргэжлээрээ ажилласан ..." гэснийг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар илүү нарийвчлан тайлбарласан байна.

Анхан шатны шүүхийн шүүгчид Үндсэн хуульд заасан хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, хорин таван нас хүрсэн байх болзлыг хангасан иргэн нэрээ дэвшүүлж болно. Харин давж заалдах шатны шүүхийн шүүгчид зөвхөн шүүгч; хяналтын шатны шүүхийн шүүгчид прокурор, өмгөөлөгч, хуулийн сургуулийн багш, бусад шатны шүүгчээр ажилласан хүн тус тус нэрээ дэвшүүлэх эрхтэй байхаар тогтоосон.

Ийнхүү хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг хязгаарлаж заасан нь олон жилийн их хөдөлмөрийн үр дүнд бий болсон шүүн таслах ажлын туршлага болоод хууль, эрх зүйн мэдлэгийг хүндэтгэсэн, олон улсын жишгийг хүлээн зөвшөөрсөн алхам юм. Харин анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг хязгаарлалгүйгээр өөрийгөө хуульд заасан болзол, шаардлагыг хангасан гэж үзсэн иргэн нэрээ дэвшүүлж болохоор заасан нь Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалд нийцсэн зохицуулалт болсон.

Иймд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад "өмгөөлөгч, шүүгч, прокуророор арваас доошгүй жил ажилласан;", 6.1.3 дахь заалтад "Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд арваас доошгүй жил багшилсан." гэсэн нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр ... томилж болно." гэснийг зөрчөөгүй ..." гэж үзсэн байна.

Гурав. Монгол Улсын дээд шүүхээс уг маргаанд холбогдуулан ирүүлсэн тайлбарт:

"... Улсын дээд шүүхийн 2006 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 8 дугаар тогтоолоор Шүүхийн тухай /2002 оны/ хуулийн 33 дугаар

зүйлийн 33.3 дахь хэсэгт "... хуульч мэргэжлээрээ ажилласан хугацаа ..." гэдгийг "1.Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн "хуульч мэргэжлээрээ ажилласан хугацаа" гэдэгт эрх зүйч мэргэжлээр хууль зүйн дунд болон дээд боловсрол эзэмшсэн хүн зайлшгүй ажиллавал зохих дараах ажил, албан тушаалд ажилласан хугацааг тооцно. Үүнд:

а) Бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шийдвэр гүйцэтгэгч, өмгөөлөгч, нотариатч, арбитрч, тэдгээрийн туслах ажилтан, нарийн бичгийн дарга; ... д) Хууль зүйн их, дээд сургууль, коллеж, түүнтэй адилтгах сургалтын байгууллагын багш, хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын ажилтнууд ..." гэж тайлбарласан байна.

Харин 2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад "өмгөөлөгч, шүүгч, прокуророор арваас доошгүй жил ажилласан;", 6.1.3 дахь заалтад "Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд арваас доошгүй жил багшилсан." байхаар заажээ.

Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах бүрэн эрхийг Улсын дээд шүүх хэрэгжүүлэхээр заасан ба тайлбар гаргах журмыг нарийвчлан зохицуулсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт хүчингүй болсон, дээрх асуудалтай холбоотой хэрэг маргаан гараагүй учир Монгол Улсын дээд шүүхээс уг заалтын талаар албан ёсны тайлбар гараагүй болно." гэсэн байна.

Дөрөв. Монголын хуульчдын холбооноос уг маргаанд холбогдуулан ирүүлсэн тайлбарт:

"1. ... "мэргэжлээрээ ажилласан" гэдэг ойлголт нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан хуульчийн мэргэжлийн дадлага хийхтэй холбоотой зохицуулалт болохоос бүх шатны шүүхийн шүүгчид нэрээ дэвшүүлэх, сонгон шалгаруулахтай холбогдсон Шүүхийн тухай багц хуульд болон Үндсэн хуулийн заалттай ямар нэгэн байдлаар холбогдох үндэслэлгүй юм.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд "хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа"-г хуулийн нэр томъёоны тодорхойлолт төдийгөөр зохицуулаагүй байсан бөгөөд тус хуулийн 24 дүгээр зүйлд мэргэжлийн үйл ажиллагааны төрлийг дэлгэрэнгүй хуульчилж өгсөн нь

зөвхөн өмгөөлөгч, прокурор, шүүгчийн ажил, албан тушаал эрхлэхийг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх буюу “мэргэжлээрээ ажилласан” гэж үзэхээр хуульчлаагүй болохыг харж болно.

2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсгийн “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн үндсэн дээр хуульч нь ... шүүгчээр ажиллана.”, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан;” байх гэсэн заалтаар шүүгч нь заавал хуульч байхаар хуульчилсан.

Шүүх эрх мэдлийг хэнээс ч хараат бусаар хэрэгжүүлэх, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, гэм буруугийн асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн шударгаар шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх эрх мэдэл бүхий онцлог субъект болох шүүгчид тавьж буй тусгай шаардлага бөгөөд шүүгч нь мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар, ёс зүйтэй, шударга байх явдлыг баталгаажуулж байгаагаараа Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх хүчин зүйл болно.

3. Улсын Их Хурлаас баталсан дээрх хуулийн заалт нь Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “... Шүүхийн ерөнхий зөвлөл ... гагцхүү хуульчдаас шүүгчдийг шилж олох ...” тухай заалтыг төгөлдөржүүлсэн зохицуулалт гэж үзэж байна.

Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага бөгөөд мөн зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;” онцгой эрхийг хэрэгжүүлдэг субъект болохын хувьд шүүгчид нь хууль хэрэглээний өндөр чадвартай, шүүн таслах ажиллагааны олон жилийн туршлагатай байх шалгуурыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Гүйцэтгэж байгаа албан үүрэгтэй нь холбогдуулан шүүгчид тавих тусгайлсан шаардлагыг зөвхөн энэ хуулиар тогтооно.” гэж органик хуульд зохицуулалт хийсэн байна.

Шүүгч, өмгөөлөгч, прокурор нь хуулийг бие даан хэрэглэж шийдвэр гаргадаг бол магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд багшилж буй багш нь хууль хэрэглээний чиглэлээр онолын тасралтгүй судалгаа хийдэг байдлаараа бусад практикийн хуульчдаас ялгарах ур чадвар, мэдлэг туршлагатай. Улсын дээд шүүхийн шүүгч нь хууль хэрэглэн тайлбарлах, эцсийн шийдвэр гаргадаг утгаараа шүүн таслах

ажиллагааны өндөр мэдлэг, туршлагатай, мэргэшсэн байх нь Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэсэн зарчмыг хэрэгжүүлэх нэг баталгаа болно.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад “өмгөөлөгч, шүүгч, прокуророор арваас доошгүй жил ажилласан;” 6.1.3 дахь заалтад “Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд арваас доошгүй жил багшилсан.” гэсэн нь хуульчийн “мэргэжлээрээ ажилласан” гэсэн асуудлыг огт хөндөөгүй бөгөөд зөвхөн Улсын дээд шүүхийн шүүгчид тавих шүүн таслах ажиллагааны тусгай мэдлэг, туршлагыг илүү нарийвчлан тогтоож өгсөн зохицуулалт гэж ойлгогдохоор байгаа боловч тухайн салбарын эрдэм шинжилгээ эрхэлсэн болон тусгайлан мэргэшсэн бусад хуульчдын эрх ашгийг зөрчсөн байж болохоор байна.

Иймд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байж болзошгүй ...” гэсэн тайлбар ирүүлсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын дээд шүүх нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлд зааснаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэж шүүхийн эцсийн шийдвэрийг гаргах, Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдгийн хувьд тус шүүхийн шүүгчдийг өндөр мэдлэг, туршлага бүхий хуульчдаас бүрдүүлэхийн тулд шүүгчид тавих нийтлэг болзол, шаардлагаас гадна хуулиар нэмэлт шаардлага, шалгуур тогтоож болохоор байна.

Үүнээс үзэхэд хяналтын шатны шүүхийн шүүгч буюу Улсын дээд шүүхийн шүүгчид Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар өмгөөлөгч, шүүгч, прокуророор арваас доошгүй жил ажилласан; Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд арваас доошгүй жил багшилсан байх зэрэг нэмэлт шаардлага тогтоох нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарч байх бөгөөд ийнхүү тогтоосныг Үндсэн хуулийн зөрчил гэж үзэх үндэслэлгүй байна.

2. Иргэн П.Оюунчимэгийн Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдлийн үндэслэл, шаардлагын хүрээнд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалт Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Хууль зүйн

дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр ... томилж болно.” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Хяналтын шатны шүүхийн шүүгчид тавих шаардлагыг багасгах болон нэмэгдүүлэх хүрээнд хуульчлах асуудал нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэрлэх асуудал биш бөгөөд энэ талаарх саналаа Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хууль санаачлагчид уламжлах иргэний эрх нь нээлттэй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад “өмгөөлөгч, шүүгч, прокуророор арваас доошгүй жил ажилласан;”, 6.1.3 дахь заалтад “Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд арваас доошгүй жил багшилсан.” гэж заасан нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр ... томилж болно.” гэж заасныг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Н.ЖАНЦАН
ГИШҮҮД	Т.ЛХАГВАА
	Д.СУГАР
	Д.ОДБАЯР
	Д.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2017.10.04. Дугаар 05 Улаанбаатар хот

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 11.50 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Сугар даргалж, гишүүн Т.Лхагваа, Н.Чинбат, Д.Наранчимэг /илтгэгч/, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Б.Цолмон оролцсон болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалт, Дөчин есдүгээр зүйлийн 3, 4, Тавин нэгдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 6 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Цолмон Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээлэл ирүүлсэн байна. Үүнд:

“Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Шүүгч Хөдөлмөрийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөж болно.” гэж заажээ. Хуулийн энэхүү заалт нь дараах хоёр агуулгыг илэрхийлж байна.

Шүүгч Хөдөлмөрийн хуульд заасан насанд хүрсэн бол “нэг бол тэтгэвэрт гарах” тэтгэвэрт гарахгүй бол “Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөх”-өөр хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, заалтад харшилж байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн заалтыг дор дурдсан агуулгаар Шүүхийн ерөнхий зөвлөл ягштал хэрэгжүүлж, шүүгчийг 60 нас хүрмэгц тэтгэвэрт гаргах асуудлыг хэлэлцэж шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх санал гаргаж хэвшүүлсэн нь Үндсэн хуульд үл нийцсэн үйл ажиллагаа болж байгаа бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн шүүгчийн албан тушаалаас чөлөөлж байгаа болно.

Хуулийн агуулгаас харахад Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн заалт нь 18.3, 18.4 дэх хэсгийн заалтын “Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналд үндэслэн” гэсэн заалтын агуулгад хамаарахгүй байгаа боловч практикт ийм журам нэгэнт тогтоож хэвшүүлсэн нь буруу байна.

Харин Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүгчийг хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.” гэсэн заалтыг “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн заалт зөрчиж улмаар “шүүгчийн хүсэлтээр нь чөлөөлөх” гэдгийг орхигдуулсан байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дээрх заалтаас шалтгаалан шүүгчдийг “Хөдөлмөрийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн” гэдгээр үндэслэн түүний хүсэлтийг үл харгалзан шүүгчийн албан тушаалаас нь чөлөөлж, огцруулж байгаа нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд үл нийцсэн, улмаар Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.”,

Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд шүүгчийг огцруулахыг хориглох” заалтыг зөрчсөн гэж үзнэ.

Түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан /24.1, 24.2, 24.3/ зохицуулалтаас үзвэл төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь 65 нас байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насанд хүрснээр төрийн албанаас чөлөөлөгдөх, эсхүл насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах тухай түүний хүсэлтэд үндэслэхээр зохицуулагдсан гэж ойлгогдож байна.

Тэгвэл Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Шүүгч Хөдөлмөрийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн бол тэтгэвэрт гарах, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөх”-өөр заасан нь төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхсан, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалтын Монгол Улсын иргэн нь “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох...” “...өндөр наслах...”, үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... нас, ... эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дээр дурдсан заалтаас шалтгаалан Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана.”, Дөчин есдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийн бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ.” гэсэн заалтыг давхар зөрчигдөхөд хүргэж байгаа болно.

Эдгээр байдал нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалтад заасныг зөрчсөн, улмаар Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэгт зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн “... шүүгчийн эрх ашгийг хамгаалах” зэрэг шүүгчийн бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлэх тухай заалтад харшилж байгаа тул Үндсэн хуулийн цэцэд дүгнэлт гаргуулахаар хандаж байна.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхболд Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"... Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт "Шүүгч Хөдөлмөрийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөж болно." гэж заасан нь шүүгч Хөдөлмөрийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах нас буюу 60 насанд хүрсэн тохиолдолд өндөр насны тэтгэвэр тогтоолгон, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөхөөр байна. Энэ заалт нь мөн хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт "Шүүгчийн хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбогдсон энэ хуульд заагаагүй бусад харилцааг Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна." гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтад "шүүгчээр ажиллаж болох насны дээд хязгаарт хүрсэн бол уг насанд хүрэх сарын сүүлийн өдрөөр;" гэж, 24 дүгээр зүйлийн 24.9 дэх хэсэгт "Шүүгчийн тэтгэвэртэй холбоотой бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна." гэж заасантай тус тус харилцан хамааралтай хэрэглэгдэх юм.

Өөрөөр хэлбэл, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заагаагүй шүүгчийн хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбогдсон бусад харилцаа, шүүгчийн тэтгэвэртэй холбоотой бусад харилцааг холбогдох хууль буюу Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулахаар хуульчилсан.

Түүнчлэн хууль тогтоогч Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6, 24.7 дахь хэсэгт шүүгчийн ажил, мэргэжлийн онцлогийг харгалзан шүүгчээр нийт 25 жил ажилласан, эсхүл 55 насанд хүрсэн шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болох эрхийг шүүгчид тус тус олгосон. Харин Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт шүүгч нь Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 60 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөхөөр заасан байна.

Мэдээлэл гаргагчийн мэдээлэлд дурдсанчлан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалт, Дөчин есдүгээр зүйлийн 3, 4, Тавин нэгдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй буюу уг хуулиар шүүгчдийг эрх зүйн этгээд байхыг

үгүйсгээгүй, мөн тэдгээрийг эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаагүй, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, өндөр наслах эрхийг хязгаарлаагүй байна.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь ямар тохиолдолд шүүгчийг огцруулж болох талаар зааж, бусад тохиолдолд огцруулахыг хориглохын зэрэгцээ шүүгчийн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх эрхийг нээлттэй олгосон заалт болохоос хуульд тодорхой үндэслэл заасан байхад шүүгчийн өөрийнх нь хүсэлтийг заавал авах талаарх зохицуулалт биш гэж ойлгож байна.

Шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх, огцруулах гэсэн хууль зүйн ойлголт нь өөр, өөр эрх зүйн үр дагаврыг бий болгодог бөгөөд Үндсэн хуулийн дээрх заалт нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгтэй утга агуулгын холбоогүй байна.

Түүнчлэн мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.1 дэх заалтад “шүүгч хүсэлтээрээ чөлөөлөгдөх, өндөр насны тэтгэвэрт гарах бол уг орон тоо гарахаас нэг сарын өмнө;” гэж заасан нь шүүгч хүсэлтээрээ чөлөөлөгдөх болон өндөр насны тэтгэвэрт гарах асуудлыг салгаж буюу ялгамжтай өөр өөр нөхцөл болгож хуульчилсан байна.

Дээр дурдсаныг үндэслэн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Шүүгч Хөдөлмөрийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөж болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалт, Дөчин есдүгээр зүйлийн 3, 4, Тавин нэгдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр Танд уламжилж байна.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Шүүгч Хөдөлмөрийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөж болно.” гэсэн заалт нь мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтад зааснаар шүүгчээр ажиллаж болох насны дээд хязгаарт хүртлээ ажиллах эрхийг хязгаарласан гэж үзэхээргүй байна.

Дээрх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9 дэх хэсэгт “Шүүгчийн тэтгэвэртэй холбоотой бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.” гэсэн бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь 65 нас байна.” гэж заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагч болох шүүгч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлтээ гаргах эрх нь нээлттэй байна.

2. Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар шүүгч төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлтээ гаргасан байхад шүүгчийн бүрэн эрхийг үндэслэлгүйгээр дуусгавар болгосон гэж үзвэл Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэгт заасны дагуу шүүхэд хандах замаар тухайн шүүгч зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжтой байна.

3. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг шүүгчид эрх олгосон заалт бөгөөд Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байна.

Иймд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалт, Дөчин есдүгээр зүйлийн 3, 4, Тавин нэгдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Шүүгч Хөдөлмөрийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөж болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ...

нас, ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно.”, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ...”, 5 дахь заалтын “өндөр наслах ...”, Дөчин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана.”, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ.”, Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Д.СУГАР
ГИШҮҮД	Т.ЛХАГВАА
	Н.ЧИНБАТ
	Д.НАРАНЧИМЭГ
	Д.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2017.10.25 Дугаар 06 Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 11.50 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Цогтоо, Д.Сугар /илтгэгч/, Н.Чинбат, Д.Солонго нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, мэдээлэл гаргагч иргэн Д.Батбаатар нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч, иргэн Д.Батбаатар Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна. Үүнд:

“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн үндсэн зорилт нь “Улсын Их Хурлын нэгдсэн, Байнгын, дэд, түр хороодын хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах дэг, журамтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” хэмээн тодорхойлсон байна. Гэтэл энэ хуулийн “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох асуудлыг хэлэлцэх журам” гэсэн 37 дугаар зүйлд “37.4. Нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ.” гэсэн заалт оруулсан байгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын бүрэн эрхийг хатуу тогтоож өгсөн байдаг. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтад Улсын Их Хурал нь “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах; ...”, мөн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг “Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;” гэж маш тодорхой заасан байна.

Үндсэн хуулийн дээрх заалтуудад үндэслэн Улсын Их Хурал болон Ерөнхийлөгчийн хуулиудад тэдний бүрэн эрхийг нарийвчлан тогтоож өгсөн байдаг. Эдгээрээс харахад Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх, томилох эрх нь зөвхөн Улсын Их Хуралд байхаар зохицуулагджээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд заасан онцгой ..., бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гээд 14 дүгээр зүйлийн 14.3.4 дэх заалтад Ерөнхий сайдыг томилохоор заасан бол Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Ерөнхий сайд хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас огцорсон тохиолдолд Улсын Их Хурал түүнийг нөхөн томилохоор заажээ.

Харин Ерөнхий сайдыг томилох Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд түүнд нэр дэвшүүлэх асуудал нь улс төрийн нам, эвсэлд хадгалагдахаар хуульчлагдсан. Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлээр зохицуулагдсан харилцаанаас энэ нь тодорхой харагдах бөгөөд Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “... Засгийн газар огцорсон, Улсын Их Хурал Ерөнхий сайдыг огцруулах буюу хүсэлтээр нь чөлөөлөх тухай шийдвэр гаргасан, Ерөнхий сайд нас нөгчсөн тохиолдолд Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам буюу намуудын сонгуулийн эвсэлээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол Улсын Их Хуралд хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиоров нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч хүлээж авснаас хойш 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна.” хэмээн баталгаажсан байна. Түүнчлэн, Улс төрийн намын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтад Улсын Их Хуралд суудал бүхий нам Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан улс төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх санал тавих эрхтэй гэж тус тус зохицуулжээ.

Эдгээр зохицуулалтаас харахад Монгол Улсын Ерөнхийлөгч нь бие дааж Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх эрхгүй юм.

Гэтэл Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах дэг, журамтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсгийн “Нэр дэвшигчийг

гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ.” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;” гэснийг тус тус зөрчсөн байх тул хянан үзэж хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт “Нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ:” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг ... Улсын Их Хуралд оруулах;” гэсэн энэхүү журмаар Ерөнхий сайдад нам, эвслээс нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч түүнийг томилох саналыг Улсын Их Хуралд оруулах үйл ажиллагааг хөндөөгүй бөгөөд Ерөнхий сайдад нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүдийн олонхи нь дэмжээгүй бол хэрхэн өөр хүний нэр дэвшүүлэхийг тодруулан зааж өгсөн зохицуулалт юм. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан нэр дэвшүүлэх нөхцөл, журмыг хөндөөгүй ба өөр хүнийг нэр дэвшүүлэх саналыг оруулж ирэх хугацааг тодорхойлон зааж өгч, өмнө нь тогтоосон байсан хугацааг богиносгож, төрийн үйл ажиллагааны залгамж, чанарыг алдагдалгүй

авч явах зэрэг нөхцөлийг бүрдүүлж, 7 хоногийн дотор нэр дэвшүүлэх хугацааг зааж өгсөн болно.

Мөн үйл ажиллагааны хувьд хэрэв олонхийн саналыг авахгүй бол хэрхэн зохицуулахыг тодорхойлон зааж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан Улсын Их Хуралд олонхи суудал авсан намын эрхэд халдаагүй заалт юм. Харин Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-37.3 дахь хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасны дагуу Ерөнхий сайдад томилох саналыг хэлэлцэхээр хуульчилсан байгаа нь олонхийн санал аваагүй тохиолдолд нөхөн нэр дэвшүүлсэн тохиолдолд мөн журмаар явах зохицуулалт юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэсэн зарчмыг баримтлан Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг нэр дэвшүүлэх эрх бүхий нам, эвслийг тодорхойлсон болон санал оруулах эрх бүхий Ерөнхийлөгчийн эрхийг заасан Үндсэн хуулийн заалтыг зөрчилгүй, төрийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах зохицуулалт хийж буй заалт байна.

Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмыг баримтлан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдаар томилуулах саналыг Улсын Их Хуралд оруулж, түүнийг нь холбогдох Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, хэрэв Улсын Их Хурлын гишүүдийн олонхийн саналыг нэр дэвшигч аваагүй бол тухайн томилуулах саналыг оруулж ирсэн Ерөнхийлөгч дахин өөр хүний нэрийг дэвшүүлэхээр энэхүү Ерөнхий сайдыг томилох үйл ажиллагаа эхэлсэн үе, шат дараалларах бүцаж өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлэхээр заасан. Энэ нь нөхөн нэр дэвшүүлэх ажиллагаанд анх нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд оруулсан ямар ч үе шатыг алгасахгүйгээр, ижил журмаар явагдахаар зохицуулагдаж байгаа ба Үндсэн хуулийн энэхүү заалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заавал давхардуулан заах шаардлагагүй учир Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалттай нийцэж байгаа болно.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус зөрчөөгүй байгааг анхааран үзэж шийдвэрлэхийг Үндсэн хуулийн цэцийн эрхэм гишүүдээс хүсэж байна.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “санал оруулах” гэж томьёолсныг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт “нэр дэвшүүлнэ” гэсэн нь Үндсэн хуульд хэрэглэсэн нэр томьёоны агуулгыг өөрчилж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад зааснаар Улсын Их Хуралд суудал авсан нам, эвслээс Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх бөгөөд түүнийг томилох саналыг Ерөнхийлөгч Улсын Их Хуралд оруулах буюу уламжлах бүрэн эрхтэй байна. Гэтэл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт Ерөнхий сайдад нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч бие даан өөр хүний нэр дэвшүүлэхээр томъёолсон нь Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгоогүй бүрэн эрхийг хуульчилжээ.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг нь Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх эрхийг Ерөнхийлөгчид олгосноороо Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт “Нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл

ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт “Нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ.” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Д.ОДБАЯР
ГИШҮҮД	Ш.ЦОГТОО
	Д.СУГАР
	Н.ЧИНБАТ
	Д.СОЛОНГО

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2017.11.03 Дугаар 64 Төрийн ордон,
Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2017 оны
06 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт “Нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “… хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2017.11.29 Дугаар 07 Улаанбаатар хот

Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 11.30 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, гишүүн Ш.Цогтоо, Д.Сугар, Д.Наранчимэг /илтгэгч/, Д.Солонго нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн С.Номынбаясгалан, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нар оролцсон болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 10, 16 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Иргэн С.Номынбаясгалангаас Үндсэн хуулийн цэцэд хандан дараах мэдээллийг ирүүлжээ. Үүнд:

“Монгол Улсын Их Хурлаас 2016 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдгийг бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ гэж өргөн хүрээнд тодорхойлжээ. Энэ тодорхойлолтод тулгуурлан “хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэдэгт улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг хамааруулан үзжээ. Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний (Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйлд “Тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө.”) болон гэрээний бус (Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй”) хэм хэмжээнд тусгалаа олжээ. Гэтэл 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл сэтгэцийн өвчтэй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан, эсхүл жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татсан, эсхүл дарамт шахалт үзүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсний “... хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан ...” гэсэн нь эрх зүйн чадамжтай эсэхийг нь үл харгалзан сэтгэцийн өвчтэйгөөс бусад бүх хөгжлийн бэрхшээлтэй хүний тайван замаар жагсаал, цуглаан хийж хуран цуглах үндсэн эрхийг хязгаарлажээ. Тиймээс Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “... хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр

болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, ... -ийн өмнө эрх тэгш байна...”, 2 дахь хэсгийн “Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын “... өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс ... сайн дурааараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ...”, 16 дахь заалтын “... тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ...” гэснийг тус тус зөрчсөн байх тул хянан хэлэлцэж дүгнэлт гаргаж өгнө үү.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... нийгмийн гарал, байдал, ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх...үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтад “төрөөс хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс нь хамгаалсан нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасныг үндэс болгон хууль тогтоогч Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл сэтгэцийн өвчтэй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан, эсхүл жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татсан, эсхүл дарамт шахалт үзүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж Үндсэн хуулийн зарчмыг органик хуулиар баталгаажуулж хуульчилж өгсөн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх нь Зөрчлийн тухай хуульд заасны дагуу дараах байдлаар хангагдана. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүн шууд биш ч нийгмийн харилцаанд оролцох нөхцөл боломж дутмаг учраас хууль тогтоомжоор тэдний эрх ашгийг хамгаалж, эрхийг эдлүүлэх нь төрийн Үндсэн хуулиар хүлээсэн үүрэг юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад "хөгжлийн бэрхшээлтэй хүн" гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ гэж тодорхойлсон.

Энэ утгаараа хөгжлийн бэрхшээлтэй хүн эрхийн чадамжаа тодорхой хэмжээнд алдсан буюу хязгаарлагдмал чадамжтай байдгаас нь шалтгаалан, мөн тэдний амь нас, эрүүл мэнд, сэтгэхүйн онцлог, эрх ашгийг аливаа сөрөг нөлөөллөөс хамгаалах зорилготойгоор хууль бус жагсаал, цуглааныг санаачлагчид хариуцлага тооцохоор тусгасан заалт болно. Өөрөөр хэлбэл:

-хөгжлийн бэрхшээлтэй хүний нас, оюун ухаан, сэтгэлгээний онцлогийг төрийн болон хэсэг бүлгийн тэмцэлд ашиглуулахгүй байх;

-хууль бусаар зохион байгуулсан жагсаал, цуглааныг цагдаа, дотоодын цэргийн хүчээр албадан тараахад хөгжлийн бэрхшээлтэй хүний амь бие, эрүүл мэндийг хохироохгүй байх;

-жагсаал, цуглааны явцад нийгмийн хэв журам зөрчигдөх, эмх замбараагүй байдал бий болох магадлалтай тул тэдгээрээс гарч болох сөрөг үр дагавраас хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамгаалах;

-жагсаал, цуглааны эмх замбараагүй байдал үүсгэх шалтаг болгон ашиглуулахгүй байхад чиглэсэн эрх зүйн зохицуулалт юм.

Үндсэн хуульд заасанчлан хүн бүр тайван жагсаал, цуглаан хийх эрхтэй хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тодорхой хязгаарлагдмал оролцдогийг нь далимдуулан тэдгээрийг хууль бус жагсаал цуглаанд татан оролцуулсан этгээдэд хариуцлага тооцох асуудлыг хуульчилсан нь иргэний эрхийг хаасан бус харин ч хамгаалж, эрхийг нь эдлүүлэх боломжийг бий болгосон.

Иймд хууль тогтоогч Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгээр дээрх асуудлыг зохицуулж иргэний эрхийг хамгаалж өгсөн. Нөгөөтээгүүр хөгжлийн бэрхшээлтэй иргэн тайван замаар жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх нь нээлттэй.

Дээр дурдсаныг үндэслэн Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "... эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал цуглаанд оролцуулсан..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэсэн тайлбарыг уламжилж байна." гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улс 2009 онд нэгдэн орсон "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц"-ийн Удиртгал хэсэгт "... Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд сонголтоо чөлөөтэй хийх эрхийг оролцуулан хувийн бие даасан хараат бус байдал чухал гэдгийг хүлээн зөвшөөрч ..." гэзд мөн конвенцийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Оролцогч улсууд нь хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас бүх хэлбэрээр алагчилах явдлыг хориглох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ямарваа хэлбэрийн алагчилалд өртөхөөс хамгаалах адил тэгш, үр дүнтэй хууль зүйн хамгаалалтыг бий болгоно." гэжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь сайн дураараа эвлэлдэн нэгдэж тайван жагсаал, цуглаан хийх эрхтэй ба аливаа жагсаал цуглаанд өөрийн сонголтоор нэгдэх, оролцох эрх чөлөөтэй. Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэний сонголт хийх эрхийг хязгаарлахгүйгээр аливаа хэлбэрийн алагчилалд өртөхөөс хамгаалах адил тэгш, үр дүнтэй хамгаалалтыг бий болгох ёстой.

2. Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "... эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан..." гэсэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүний жагсаал, цуглаанд сайн дураараа нэгдэх, оролцох эрхийг хязгаарлах боломжийг бүрдүүлэхээр байх тул Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэг "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... хүн бүр хууль, ... -ийн өмнө эрх тэгш байна...", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.", Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын "... тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

3. Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "... эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан..." гэсэн нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.", Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын "... өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс … сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ..." гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл сэтгэцийн өвчтэй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан, эсхүл жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татсан, эсхүл дарамт шахалт үзүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно." гэж заасны "... эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан..." гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... хүн бүр хууль, ... -ийн өмнө эрх тэгш байна...", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.", Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын "... тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Дээрх хуулийн холбогдох заалт Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”, Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын “... өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс … сайн дурааараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ...” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

3. Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл сэтгэцийн өвчтэй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан, эсхүл жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татсан, эсхүл дарамт шахалт үзүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасны “... эсхүл хөгжлийн бэрхшээлтэй ...” гэсэн хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Д.ОДБАЯР
ГИШҮҮД	Ш.ЦОГТОО
	Д.СУГАР
	Д.НАРАНЧИМЭГ
	Д.СОЛОНГО

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2017.12.07 Дугаар 74 Төрийн ордон,
Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2017 оны
07 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл сэтгэцийн өвчтэй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан, эсхүл жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татсан, эсхүл дарамт шахалт үзүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасны “... эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, ...-ийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын “... тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль

зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ...” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2017.12.06 Дугаар 01 Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 11.30 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан, Т.Лхагваа, Ш.Цогтоо, Д.Сугар, Н.Чинбат /илтгэгч/, Д.Наранчимэг, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Ч.Жадамба, С.Номынбаясгалан болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Улсын Их Хурлаас 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын 2002 оны Иргэний хуульд нэмэлт оруулан хуульчилсан 170 дугаар зүйлийн 170.6 дахь хэсгийн “Өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх хэлцэл хийх бол үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авах үүрэгтэй.” гэсэн заалт, мөн өдөр өөрчлөн найруулсан Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай

хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “Барьцаалуулагч үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлэхдээ барьцаалагчийн зөвшөөрөл авна.” гэсэн заалт нь Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсгийн “Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна.” гэсэн заалт болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “... гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...” гэсэн заалтыг тус тус агуулгаар нь дахин сэргээсэн эсэх тухай маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн хяналтын журмаар хянан шийдвэрлэв.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Ч.Жадамба Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтаар иргэний хувийн өмчийн халдашгүй эрхийг хуульчлан баталгаажуулсан бөгөөд өмчлөх эрх нь хүний эрх, эрх чөлөөний суурь баталгаа юм.

Өмчлөх эрх нь өмчлөгчийн язгуур эрх бөгөөд хуулиар уг эрхийг позитив болон негатив байдлаар зохицуулжээ. Иймд өмчлөгч нь өөрийн материаллаг болон материаллаг бус хөрөнгөө өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах ба аливаа этгээдээс хамгаалах, хэн нэгэн өөр этгээд хөрөнгийг нь ашиглахыг таслан зогсоох эрхтэй. ...

Харин Улсын Их Хурлаас 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Иргэний хуулийн 170 дугаар зүйлд “170.6. Өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх хэлцэл хийх бол үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авах үүрэгтэй.” гэсэн хэсэг нэмсэн, мөн өдөр Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг “Барьцаалуулагч үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлэхдээ барьцаалагчийн зөвшөөрөл авна.” гэж өөрчлөн найруулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх ... эрхтэй ...” гэж заасныг илэрхий зөрчжээ.

Өмчлөгчийн эрхийг гагцхүү нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, бусдын эрхийг зөрчиж бусдад гэм хор учруулахыг хориглох, эд хөрөнгийн хязгаарлагдмал эрх бүхий этгээдэд эрхээ хэрэгжүүлэх боломж олгох зорилгын үүднээс нийтийн болон иргэний эрх зүйн хэм хэмжээгээр хязгаарладаг нийтлэг жишиг байдаг.

Ипотекийн зүйлийн өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх хөрөнгөө бусдын өмчлөлд шилжүүлэх, түрээслэх, хөлслөх, үнэ төлбөргүйгээр түр ашиглуулахаар бусдын эзэмшилд шилжүүлэх, давхар барьцаалах, барьцаалуулсан газар дээрээ барилга байгууламж барих зэргээр туйлын эрхээ хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд ингэснээрээ барьцаалагчийн эрхийг зөрчихгүй, барьцаалагчид гэм хор учруулахгүй юм.

Учир нь ипотекийн эрхээ хэрэгжүүлэх давуу эрх нь барьцаалагчид хэвээр хадгалагддаг. Мөн ипотекийн зүйлийг давхар барьцаалах нь ипотекээр хангагдах шаардлагаа тэргүүн ээлжинд хангуулах өмнөх барьцаалагчийн эрхийг хөнддөггүй.

Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэгт “Ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг ашиглахгүй, бусдын өмчлөлд шилжүүлэхгүй, өөр байдлаар гуравдагч этгээдэд эрх олгохгүй байх үүргийг өмчлөгчид хүлээлгэсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.” гэж заасан нь өмчлөгчийн туйлын эрхийг баталгаажуулсан үндсэн зохицуулалт юм.

Харин Улсын Их Хурлаас 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Иргэний хуульд оруулсан нэмэлт, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд оруулсан өөрчлөлт нь дээр дурдсан үндсэн зохицуулалттай зөрчилдөж байгаа бөгөөд өмчлөгчийн эрхийг үндэслэлгүйгээр хязгаарласан гэж үзэхээр байна.

Иймд Иргэний хуулийн 170 дугаар зүйлийн 170.6, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг тогтоож өгнө үү.” гэсэн агуулга бүхий мэдээлэл ирүүлсэн байна.

Хоёр. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн С.Номынбаясгалан Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Иргэний хуулийн 170 дугаар зүйлд “170.6. Өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхээ гуравдагч этгээдэд

шилжүүлэх хэлцэл хийх бол үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авах үүрэгтэй.” гэсэн хэсэг нэмсэн, мөн өдөр Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг “Барьцаалуулагч үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлэхдээ барьцаалагчийн зөвшөөрөл авна.” гэж өөрчлөн найруулан хуульчилсан нь барьцаалагч талд давуу байдал олгож, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын тэгш байдлын зарчим болоод Үндсэн хуулиар баталгаажуулсан өмчлөгчийн язгуур эрхэд халдсан зохицуулалтыг бий болгожээ.

Учир нь дээрх хуулиудад барьцааны зүйлийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, эрсдэлээс хамгаалах боломжийг бүрдүүлсэн атлаа барьцаалуулагч талд ийнхүү давхар үүрэг хүлээлгэх замаар иргэний үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлах нөхцөлийг бүрдүүлжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн бүтэц, агуулга талаас нь авч үзвэл өмчлөх эрх нь өмчлөгчийн язгуур эрх бөгөөд өмчлөгч нь өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах ба аливаа халдлагаас хамгаалах эрхтэй байхаар тодорхойлжээ. ...

Өмчлөгч нь үл хөдлөх хөрөнгөө бусдын өмчлөлд шилжүүлэх, түрээслэх, хөлслөх, үнэ төлбөргүйгээр түр ашиглуулахаар бусдын эзэмшилд шилжүүлэх, давхар барьцаалах зэргээр туйлын эрхээ хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд ингэснээрээ барьцаалагчийн эрхийг зөрчихгүй, барьцаалагчид гэм хор учруулахгүй юм.

Энэхүү үзэл санааг Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр тогтоолоор тайлбарласан байна.

Тиймээс Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд “170.6. Өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх хэлцэл хийх бол үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авах үүрэгтэй.” гэж заасны “... үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авах үүрэгтэй.” гэсэн хэсэг нь, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд “27.1. Барьцаалуулагч үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлэхдээ барьцаалагчийн зөвшөөрөл авна.” гэж заасны “... барьцаалагчийн зөвшөөрөл авна.” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн ... Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх ... эрхтэй. ...”

... гэж заасныг зөрчсөн тул хянан шийдвэрлэж өгнө үү.” гэсэн агуулга бүхий мэдээлэл ирүүлсэн болно.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга “Үндсэн хуулийн цэцийн гишүүний санаачилгаар Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан Иргэний хуулийн 170 дугаар зүйлийн 170.6, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг нь Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн холбогдох заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар хяналтын журмаар хянан шийдвэрлэх үндэстэй” гэж үзэж 2017 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр “Маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэх тухай” 28 дугаар тогтоол гаргасан болно.

Дөрөв. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.” гэж заасан ч өмчлөгчийн эрхийг хязгаарлаж болох зохицуулалт мөн бий.

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж тус тус заасан байдаг.

Хууль санаачлагчид энэхүү хязгаарласан зохицуулалт болон тухайн үед гацаанд орж иргэдийг хүнд байдалд оруулаад байсан ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хэвийн болгох буюу банкны зээлийн санхүүжилтээр явагдаж байсан бага хүү/8%/-тэй урт хугацаа бүхий Засгийн газрын “Орон сууцны зээлийн хөтөлбөр” зогссон байсныг үргэлжлүүлэн хэвийн явуулах үндэслэлээр Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг санаачилсан бөгөөд Улсын Их Хурал дээрх хуулийн төслүүдийг дэмжиж баталсан.

Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах аргаар баталгаажуулахыг Иргэний хуулийн 165 дугаар зүйлийн 165.1 дэх хэсэгт ипотек гэж тодорхойлсон.

Ипотекийн харилцаа нь талуудын чөлөөт хүсэл зоригт үндэслэн үүсдэг тул үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд шаардлагаа хангуулах баталгаа болж байгаа ипотекийн зүйлийн өмчлөлийн асуудалд тодорхой ашиг сонирхол байдаг бөгөөд Иргэний хуулийн дээрх заалт нь уг ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн зохицуулалт юм.

Нөгөөтээгүүр, үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авахаар заасан дээрх зохицуулалт нь иргэний өөрийн өмчлөлд байгаа ердийн өмч, хөрөнгийг захиран зарцуулах талаарх зохицуулалт бус харин банкны урт хугацааны зээлийн барьцаанд байгаа үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг бусдад шилжүүлэхтэй холбоотой асуудлыг зохицуулсан юм.

Ийнхүү үүрэг гүйцэтгэгч зөвшөөрөл авсны үндсэн дээр өмчлөх эрхийг шилжүүлэх зохицуулалт нь үүрэг гүйцэтгүүлэгчийн ипотекийн эрх хөндөгдөх, зээлүүлсэн мөнгөн хөрөнгө эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, баталгаажуулах, хамгаалах ач холбогдолтой зохицуулалт болохоос өмчлөгчийн өмчлөх эрхийг хязгаарлаагүй болно.

Өөрөөр хэлбэл, үүрэг гүйцэтгэгч нь зөвхөн зээлийн барьцаанд бариулсан үл хөдлөх эд хөрөнгөө бусдын өмчлөлд шилжүүлэх тохиолдолд л үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авсны үндсэн дээр шилжүүлэхээр заасан болохоос уг хөрөнгийг бусдад эзэмшүүлэх, ашиглуулахад /хөлслөх, түрээслэх/ зөвшөөрөл шаардаагүй бөгөөд үүрэг гүйцэтгэгч өөрийн үзэмжээр шийдвэрлэх эрх нь нээлттэй байгаа.

Түүнчлэн, Иргэний хуулийн дээрх заалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний өмчлөх эрхийг зөрчсөн бус харин ч ипотекийн урт хугацааны зээлийг ашиглан шударгаар хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө олж авах боломжийг олгож байгаа заалт гэж ойлгож байна.

Дээр дурдсаныг үндэслэн Иргэний хуулийн 170 дугаар зүйлийн 170.6 дахь хэсэгт “Өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх хэлцэл хийх бол үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авах үүрэгтэй.” гэж, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Барьцаалуулагч үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны зүйлийг

бусдын өмчлөлд шилжүүлэхдээ барьцаалагчийн зөвшөөрөл авна.” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр уламжилж байна.” гэсэн байна. Мөн Үндсэн хуулийн их цэцийн хуралдааны явцад дээрх хуулийн заалтууд нь Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн холбогдох заалтыг агуулгаар нь дахин сэргээн батлаагүй гэсэн тайлбар хийсэн болно.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн Их суудлын хуралдаанаар Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэгт “Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна.”, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Барьцаалуулагч нь Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийг баримтлан барьцааны зүйлийг гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр бусдын өмчлөлд шилжүүлэх эрхтэй.” гэж заасны “... гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...” гэсэн хэсэг нь барьцаалагч талд давуу байдал олгосноор иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын тэгш байдлын зарчим, Үндсэн хуулиар тогтоосон өмчлөгчийн язгуур эрхэд халдсан байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн гэж үзэж, Үндсэн хуулийн цэц 2015 оны 11 дүгээр тогтоолоор дээрх хуулиудын заалтыг хүчингүй болгосон байна.

2. Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлээр Иргэний хуулийн 170 дугаар зүйлд “170.6.Өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх хэлцэл хийх бол үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авах үүрэгтэй.” гэсэн хэсэг нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсгийн “Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна.” гэсэн заалттай агуулгын хувьд адил байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлээр Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг "Барьцаалуулагч үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлэхдээ барьцаалагчийн зөвшөөрөл авна." гэж өөрчлөн найруулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн "... гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ..." гэсэн заалттай агуулгын хувьд адил байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн заалтыг Улсын Их Хурал агуулгаар нь дахин сэргээсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, 4, Жаран долдугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3, 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсгийн "Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна." гэсэн заалтыг Улсын Их Хурал 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хуулиар дахин сэргээсэн байх тул Иргэний хуулийн 170 дугаар зүйлийн 170.6 дахь хэсгийн "Өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх хэлцэл хийх бол үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авах үүрэгтэй." гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн "... гагцхүү барьцаалагчийн

зөвшөөрөлтэйгээр ...” гэсэн заалтыг Улсын Их Хурал 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар дахин сэргээсэн байх тул Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “Барьцаалуулагч үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлэхдээ барьцаалагчийн зөвшөөрөл авна.” гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ Д.ОДБАЯР
ГИШҮҮД Н.ЖАНЦАН
Т.ЛХАГВАА
Ш.ЦОГТОО
Д.СУГАР
Н.ЧИНБАТ
Д.НАРАНЧИМЭГ
Д.СОЛОНГО
Д.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2017.12.20 Дугаар 02 Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан, Т.Лхагваа, Ш.Цогтоо, Д.Сугар, Н.Чинбат /илтгэгч/, Д.Наранчимэг, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн М.Ариунболд, Б.Мэргэн, Э.Хашчулуун нар оролцов.

Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй болно.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Улсын Их Хурлаас 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэгт “6.9.1. гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан.” гэсэн өөрчлөлт оруулсан нь Үндсэн хуулийн цэцийн

2012 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтын “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;” гэсэн хэсгийг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх тухай маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн хяналтын журмаар хянан шийдвэрлэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 9 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Мэргэн, Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны оршин суугч, иргэн Э.Хашчулуун, Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн М.Ариунболд нар Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш, адил байна гэдэг нь хууль тогтоогчийн болон шүүхийн зүгээс хүн бүрт эрх, үүрэг, хариуцлагыг ямар нэг ялгаваргүй тогтоох, хэрэгжүүлэх зарчим юм. Энэхүү зарчмын баталгаа болгож Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хүний эрхийн байдлыг ялгаварлан гадуурхаж болохгүй шалгууруудыг “үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол” гэж нэр заан тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, хүмүүсийг эрхэлж байгаа ажил, албан тушаал зэргээр ялгаварлаж, аль нэг хэсэгт нь давуу эрх олгох, илүү үүрэг хүлээлгэх буюу үүргээс чөлөөлөх хууль гаргаж болохгүй гэсэн үг юм.

Эрүүгийн эрх зүйд гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчим үйлчилдэг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тогтоохын тулд нотлох баримт цуглуулахаас эхлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагааг хийх шаардлагатай болно.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад гишүүнийг зөвхөн гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан тохиолдолд л Улсын ерөнхий прокурорын саналаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлнэ гээд мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.9.1-д зааснаас бусад тохиолдолд гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг

хийхийг хориглоно” гэж заасан. Энэ нь гишүүн үйлдэл дээрээ нотлох баримттайгаар баривчлагдаж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлснээс бусад тохиолдолд сэжиг бүхий үндэслэл байсан ч гэсэн түүнийг гэмт хэрэгт холбогдуулан албадан саатуулах, үзлэг, нэгжлэг хийх боломжгүй гэсэн үг юм.

Гэтэл хүн амины, дээрмийн, танхайн гэх мэт цөөн хэрэг л үйлдэл дээрээ баригддаг бөгөөд албан тушаалаа урвуулан ашигласан, эрх мэдлээ хэтрүүлэн авлига авсан гэх мэт хэргүүдийг үзлэг, нэгжлэг хийлгүйгээр илрүүлэх боломж бараг байхгүй тул гишүүдэд гэмт хэрэг үйлдсэн ч хариуцлага хүлээхгүй байж болох давуу байдлыг бий болгож байна. Харин иргэдийн хувьд заавал гэмт хэрэг үйлдэж байхдаа нотлох баримттайгаар баривчлагдсан байх шаардлагагүй, сэжиг бүхий үндэслэл байгаа тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж, гэм буруутай эсэхийг нь тогтоодог.

Хууль тогтоогч, төрийн өндөр албан тушаалтан болон шүүгчид ажил үүргээ гүйцэтгэхдээ тодорхой хэмжээний халдашгүй байдал эдлэх нь зүй ёсны асуудал гэдгийг улс орнууд хүлээн зөвшөөрч, хуульд тусгадаг.

Халдашгүй байдал нь иргэдээс сонгогдсон төлөөлөгчид хууль тогтоох байгууллагад эрүүгийн болон иргэний хуулийн дагуу хариуцлага хүлээх эрсдэлгүйгээр чөлөөтэй үг хэлэх, нэр төрийг нь аливаа гүтгэлгээс хамгаалах, тохиолдлын байдлаар албадан саатуулах, цагдан хорих, тэдний хувьд улс төрийн сэдэлтэй мөрдөх ажиллагаа явуулахаас сэргийлэх зорилготой байдаг. Тийм учраас Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. ...” гэж заасныг үндэслэн 1992 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт “Үндсэн хуулийн хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлж болно”, 1997 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт Улсын Их Хурал гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг “гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан”, “эрх бүхий байгууллага Улсын Их Хурлын гишүүнд холбогдох эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд түүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлж өгөхийг Улсын Их Хурлаас хүссэн” гэсэн

хоёр тохиолдолд хэлэлцэнэ гэж заасан байв. 2006 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд дээрх хоёр агуулга туссан байсан ч 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн өөрчлөлтөөр "гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын Их Хуралд оруулсан бол бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг хэлэлцэнэ" гэсэн заалтыг хассан юм. Ингэснээрээ зөвхөн гэмт хэрэг үйлдэж байхад нь нотлох баримттайгаар баривчлагдсан тохиолдолд л бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцэнэ гэсэн Үндсэн хуулийг хэт явцуурууллан зөрчсөн хуулийн заалт үйлчилж байна.

Эцэст нь зориуд тэмдэглэн хэлэхэд, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад "гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан бол гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ." гэж заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна гэсэн иргэн Ц.Энхжингийн мэдээллийн дагуу Үндсэн хуулийн цэц 2011 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Дунд суудлын болон 2012 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Их суудлын хуралдаанаараа хэлэлцэн Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоосон байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт "Цэцийн эцсийн шийдвэрээр Үндсэн хууль зөрчсөн гэж тогтоогдсон хууль Цэцийн тогтоол гармагц хүчингүй болно." гэж заасан ч Улсын Их Хурал холбогдох заалтыг хүчингүй болгоогүй бөгөөд харин 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр өөрчлөн найруулахдаа "гэмт үйлдлийнх нь явцад" гэснийг "гэмт хэрэг үйлдэж байхад нь", "гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж" гэснийг "хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан" гэж үгийг нь сольсон ч агуулгыг нь өөрчлөлгүй баталсан байна.

Хэдийгээр өмнөх заалттай холбогдуулан Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хууль зөрчсөн гэх дүгнэлт, тогтоол гарсан боловч Улсын Их Хурлаас Үндсэн хууль зөрчсөн алдааг зассан гэх нэрээр агуулгыг нь хэвээр баталж, Үндсэн хуульт ёсыг уландаа гишгэсэн байх тул дахин мэдээлэл гаргаж байгаа болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт нь Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн

эсэх талаар шийдвэр гаргаж өгнө үү.” гэсэн агуулга бүхий мэдээлэл ирүүлсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтыг “гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан.” гэж өөрчлөн найруулсан нь Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэцийн гишүүний санаачилгын дагуу Цэцийн их суудлын хуралдаанаар хяналтын журмаар хянан шийдвэрлэх үндэстэй гэж үзэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр “Маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэх тухай” 31 дүгээр тогтоол гаргасан болно.

Гурав. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байхаар заасан нь хууль батлах болон хууль хэрэглэхэд эрх, үүрэг, хариуцлагыг хүн бүрт аливаа ялгаваргүйгээр тогтоох, хэрэгжүүлэх зарчмыг тусгасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хүний эрхийн байдлыг ялгаварлан гадуурхаж болохгүй шалгуурыг нэр заан тодорхойлсон нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг хангах баталгаа болж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж заасан нь Улсын Их Хурлын гишүүн хувь хүнийхээ хувьд бус, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож, Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаагийн хувьд халдашгүй байх бөгөөд түүний халдашгүй байдлыг хуулиар тусгайлан тогтоож хамгаалахыг Үндсэн хуулиар баталгаажуулсан байна.

Үндсэн хуульд ийнхүү заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгааг хуульчилсан бөгөөд 34.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.9.1-д зааснаас бусад тохиолдолд гишүүнийг албадан саатуулах,

цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.” гэж, 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан ... тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулах бөгөөд Улсын Их Хурал гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэж заасанчлан Монгол Улсын Их Хурал нь парламентат ёсны онолын хувьд парламентын гишүүний императив мандатын зарчим (сонгогчид парламентын гишүүнд заавал биелүүлэх ёстой захиас, даалгавар өгөх, уг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд гишүүнийг эгүүлэн татах эрхтэй)-д бус, чөлөөт мандатын зарчим (хууль тогтоох үйл ажиллагаанд Үндсэн хууль, өөрийн итгэл үнэмшлийн үндсэн дээр үндэсний ба орон нутгийн эрх ашгийн хооронд тэнцвэржилтийг ханган ажиллах, мандат олгосон сонгогчид парламентын гишүүний мандатыг эгүүлэн татах эрхгүй)-д үндэслэн Улсын Их Хурлын гишүүнийг сонгодог. Ийнхүү чөлөөт мандатын зарчмыг баримталсан нь хууль батлах байгууллага, түүний гишүүн болон хууль батлах үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилготой бөгөөд энэ утгаараа парламентын гишүүний бүрэн эрхийн баталгаа, халдашгүй байдлыг ихэнх улс оронд хуулиар хамгаалдаг.

Нөгөө талаас Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт нь төлөөлөгчдийн байгууллагаас баталсан хууль, гаргасан бодлогыг хэрэгжүүлдэг гүйцэтгэх засаглалын байгууллагуудын зүгээс парламентын гишүүнийг хилс хэргээр эрүүгийн хариуцлагад татахаас хамгаалах зорилготой парламентын гишүүний бүрэн эрхийн баталгааны нэг хэлбэр болох иммунитетийг тогтоосон билээ. Иммунитетийг улс орнууд өөр өөрөөр тогтоодог бөгөөд хязгааргүй иммунитет тогтоосон 26, гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдлын иммунитет тогтоосон 42 /Монгол Улс хамаарна/, иргэний хариуцлагад татахыг хориглосон 10, парламентын гишүүн иммунитет эдлэхгүй 4 улс байдаг байна.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг ийнхүү хуульчилснаараа гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд иммунитет тогтоосон 42 улсад Монгол Улс хамаарч байна.

Эндээс үзэхэд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт нь Улсын Их Хурлын гишүүн болон энгийн иргэнийг албан тушаалаар ялгаварласан бус, харин институцийн хувьд төрийн эрх барих дээд байгууллага буюу Улсын Их Хурлын тогтвортой үйл ажиллагааг хангах үүднээс хууль батлах бүрэн эрхийн баталгааг хамгаалсан, тодорхой түвшинд халдашгүй байдал тогтоосон агуулгатай зохицуулалт юм.

Түүнчлэн, Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэж, хүчингүй болгосноор Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг ямар ч тохиолдолд гэмт хэрэгтэй холбогдуулж түдгэлзүүлэх боломжгүй буюу туйлын халдашгүй байдлын хэлбэрийг бий болгосон тул Улсын Их Хурлаас 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, уг хуулийн 6.9 дэх хэсгийг өөрчлөн найруулсан.

Уг хуулийн төслийг хэлэлцсэн хуралдааны тэмдэглэлээс үзэхэд Улсын Их Хурлын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх зохицуулалтыг хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх ойлголтоос ялгаатайгаар авч үзэж, Улсын Их Хурлын гишүүний хувь хүний халдашгүй байдал гэхээс илүү институцийн хувьд, Улсын Их Хурлын өөрийнх нь бүрэн эрхт, халдашгүй байдалтай шууд холбоотой гэж үзсэн байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6.9.1 дэх заалтыг ийнхүү өөрчлөн найруулсан нь Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон заалтыг агуулгаар нь дахин сэргээн баталсан асуудал биш бөгөөд харин Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал хууль батлах өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын хязгаарлалтыг тогтоосон асуудал юм.

Монгол Улсын Их Хурал бол хууль тогтоох, төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд Улсын Их Хурлын гишүүн ард түмний

элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлан ажилладаг тул түүний халдашгүй бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг алдагдуулаагүй гэж үзэж байна.

Институцийн хувьд албан тушаалтны халдашгүй байдлыг тогтоох нь зүй ёсны асуудал бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, шүүгчийн бүрэн эрхийн баталгаа, халдашгүй байдлыг холбогдох хуулиудад тогтоосон байдаг нь хувь хүнийх нь хувьд бус, эрхэлж байгаа албан тушаалынх нь хувьд халдашгүй байдлыг тогтоодог байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон чөлөөт мандатын зарчмаар сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг баталгаажуулах үүднээс гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд түүний бүрэн эрхийг хамгаалахаар халдашгүй байдлыг тогтоосон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6.9.1 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", 2 дахь хэсгийн "Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно." гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийг бүхэлд нь авч үзвэл Улсын Их Хурлын гишүүний цалин, хавсран гүйцэтгэж болох албан тушаал, халдашгүй байдлын хамгаалалт, бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах шийдвэр зэрэг Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаа, халдашгүй байдалтай холбоотой зохицуулалтыг хуульчилсан байна.

Үүнээс Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тусгайлан авч үзвэл Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг хэлэлцэх, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх шийдвэрийг гаргах болон гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол эгүүлэн татах шийдвэрийг гаргах эрх бүхий байгууллага нь зөвхөн Улсын Их Хурал байхаар заасан, харин ямар тохиолдолд "гэмт хэрэгт холбогдсон" гэж үзэх, энэ асуудлыг Улсын Их Хурал хэрхэн шийдвэрлэх талаар тусгайлан зохицуулаагүй, Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд үлдээж өгсөн байна.

Эндээс үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг нь дээр дурдсан Улсын Их Хурлын гишүүний

халдашгүй байдалтай холбогдон гарах шийдвэрийг парламент буюу Улсын Их Хурал гаргах талаар зохицуулсан бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг өөрт олгогдсон хууль батлах бүрэн эрхийнхээ хүрээнд тогтоож болохоор байна.

Үүний дагуу Улсын Их Хурлаас 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулах бөгөөд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг Улсын Их Хурал шийдвэрлэхээр өөрчлөн найруулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт нийцэж байна.

Хэрвээ Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан тохиолдолд түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, улмаар гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон бол гишүүнийг эгүүлэн татаж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд зөрчилдөх агуулга байхгүй гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.” гэж заасныг зөрчөөгүй байна.

Улсын Их Хурлын гишүүний “гэмт хэрэгт холбогдсон” байдлыг ямар хүрээнд авч үзэх талаар Монгол Улсын Үндсэн хуульд ерөнхий, эсхүл тодорхой аль нэг байдлаар заагаагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг эрхэлж байгаагийн хувьд Үндсэн хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн агуулгыг явцуурууулсан гэж үзэх үндэслэл байхгүй, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд харшилсан шинжийг агуулаагүй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус зөрчөөгүй болно.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Их суудлын хуралдаанаар 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад "гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;" гэж заасан нь Үндсэн хуулийн заалтын агуулгыг хэт явцууруулан, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх нийтлэг зарчимд харшилсан шинжийг агуулснаараа Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. ...", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ..." гэж заасныг зөрчсөн гэж үзэж, Үндсэн хуулийн цэц 2012 оны 02 дугаар тогтоолоор дээрх хуулийн заалтыг хүчингүй болгосон байна.

2. Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэгт "6.9.1. гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан." гэсэн өөрчлөлт оруулжээ.

Ийнхүү хуульчлахдаа "гэмт үйлдлийнх нь явцад" гэснийг "гэмт хэрэг үйлдэж байхад нь" гэж; "гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж" гэснийг "хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан" гэж өөрчилсөн нь эрх зүйн үр дагавар болон агуулгын хувьд адил байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн заалтыг Улсын Их Хурал агуулгаар нь төдийгүй үгийн утгын хувьд илүү явцууруулан дахин сэргээсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

3. Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор хүчингүй болсон хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээснээрээ Улсын Их Хурал өөрөө Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэснийг зөрчиж байгаа болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, 4, Жаран долдугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3, 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтын “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;” гэсэн хэсгийг Улсын Их Хурал 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар дахин сэргээсэн байх тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан.” гэж заасныг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагц хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ Д.ОДБАЯР
ГИШҮҮД Н.ЖАНЦАН
Т.ЛХАГВАА
Ш.ЦОГТОО
Д.СУГАР
Н.ЧИНБАТ
Д.НАРАНЧИМЭГ
Д.СОЛОНГО
Д.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2018.01.17 Дугаар 01 Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор хүчингүй болсон Шүүх байгуулах тухай хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 11.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан, Т.Лхагваа /илтгэгч/, Ш.Цогтоо, Д.Сугар, Н.Чинбат, Д.Наранчимэг, Д.Солонго нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн С.Номынбаясгалан оролцож, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж гадаад улсад албан ёсны айлчлалтай байсан тул оролцоогүй болно.

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдөр өөрчлөлт оруулсан Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн “Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэж, мөн “Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэж тус тус хуульчилсан нь Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор хүчингүй болсон Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх тухай маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн хяналтын журмаар хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн С.Номынбаясгалан Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна. Үүнд:

“Монгол Улсын Их Хурлаас 2016 онд оруулсан өөрчлөлтөөр Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн Нэг дэх хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэж, мөн зүйлийн Хоёр дахь хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэж тус тус хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх ...” гэсэн хэсгийг зөрчиж байна. Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоог тойргийн зарчмаар бус, харин нутаг дэвсгэрийн харьяаллын зарчмаар зохион байгуулахаар тусгасан болно.” гээд Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалтыг хүчингүй болгосон Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 02 дугаар тогтоол, 2015 оны 01 дүгээр тогтоол, 2016 оны 01 дүгээр тогтоолыг иш татан дурдаж, “Багахангай, Налайх дүүргүүдийн дунд Иргэний болон Эрүүгийн хэргийн анхан шатны нэг, нэг шүүх байгуулсан нь Үндсэн хуулийн хэм хэмжээг зөрчсөн байна.” гэжээ.

Хоёр. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

“... Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх...” гэж Улсын дээд шүүхээс бусад шүүхийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр нэрлэснийг Монгол Улсын шүүхийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр нь зохион байгуулж, аймагт аймгийн шүүх, дүүрэгт дүүргийн шүүх оршино гэж тайлбарлан хэрэглэвэл шүүхийн тогтолцоог шүүхийн харьяаллаар сольж, шүүхийн тогтолцоог гажуудуулахад

хүргэх юм. Түүнчлэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулна.” гэж заасан заалт хүчин төгөлдөр үйлчилж байгаа болно.

Дээрх хуулийн заалтын дагуу Монгол Улсын Их Хурал өөрт хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Багахангай, Налайх дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны тоо, шүүхийн ачааллыг тус тус харгалзан хоёр дүүргийн дунд нэг шүүх байгуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.’’, Дөчин долдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.’’, Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасантай нийцсэн гэж үзэж байна. Тухайлбал 2016 онд Нийслэл дэх нэг дүүргийн шүүхэд ногдох хэргийн ачаалал дунджаар Эрүүгийн 276 хэрэг, Иргэний 2899 хэрэг байсан бол Багахангай, Налайх дүүргийн анхан шатны шүүх 2016 онд Эрүүгийн 66, Иргэний 656 хэрэг шийдвэрлэсэн, үүнээс Багахангай дүүрэгт харьяалагдах Эрүүгийн 8, Иргэний 33 хэрэг хянан шийдвэрлэжээ.

Багахангай, Налайх дүүргийн шүүхийн шийдвэрлэсэн нийт 722 хэргээс Багахангай дүүрэгт харьяалагдах 41 хэрэг шийдвэрлэгдсэн байгаа нь тус шүүхийн өнгөрсөн онд шийдвэрлэсэн нийт хэргийн зөвхөн 5.6 хувийг эзэлж байна. Мөн Багахангай, Налайх дүүргийн шүүхээр 2007-2017 онд шийдвэрлэгдсэн Эрүү, Иргэний нийт 6425 хэргээс Багахангай дүүрэгт харьяалагдах 392 хэрэг байгаа нь Багахангай, Налайх дүүргийн шүүхээр сүүлийн 10 жилд шийдвэрлэсэн нийт хэргийн 6 хувь байна. Үүнээс үзвэл Багахангай дүүрэгт харьяалагдах шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн тоо нэг дүүрэгт ногдох Эрүүгийн хэргийн дундаж тооноос 34 дахин бага, Иргэний хэргийн дундаж тооноос 87 дахин бага байгаа нь тус дүүрэгт бие даасан шүүх байгуулах боломжгүй, эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тодорхой юм.

Түүнчлэн Багахангай дүүрэг нийт хүн амын тоогоор бусад дүүргээс хамгийн бага буюу 4.143 хүн амтай, нутаг дэвсгэрийн хэмжээгээр Нийслэл дэх 9 дүүргээс 7 дугаарт буюу 140.0 км^2 байна.

“Багахангай дүүргийн эдийн засаг, нийгмийн байдал”-ын 2017 оны 3 дугаар улирлын статистикийн танилцуулгад Нийслэл дэх хүн амын нягтрал 1 кв км-т ногдох хотын дундаж 298 хүн байхад Багахангай дүүрэгт хамгийн бага буюу 30 хүнтэй байна. Харин 18-аас дээш насны 10.000 хүнд ногдох гэмт хэргийн тоогоор хотын дундаж 165 хүн байхад Багахангай дүүрэгт 102 хүн байхаар тусгагджээ.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдөр өөрчлөлт оруулсан Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн “Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэж, мөн зүйлийн “Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн Шүүхийн үндсэн тогтолцооны зохицуулалт болон мөн хуулийн суурь зарчим, үзэл баримтлалыг зөрчөөгүй буюу Цэцээс шийдвэрлэсэн асуудлыг агуулгаар нь дахин сэргээгээгүй байна гэсэн тайлбарыг үүгээр уламжилж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоог Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэхээр хуульчилсан байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр “... Шүүх байгуулах тухай 1993 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн Монгол Улсын хуулиар Баганууp, Багахангай дүүргийн дунд, Баянзүрх, Гачуурт дүүргийн дунд, Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн дунд, Хан-Уул, Туул дүүргийн дунд тус бүр нэг шүүх байгуулсан нь нэрийн хувьд “дүүргийн” гэж томьёологдсон боловч үнэн хэрэг дээрээ хоёр дүүргийн дунд нэг шүүх байгуулсан агуулгыг илэрхийлж байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн дүүрэг бүр өөрийн шүүхтэй байх тухай заалтыг зөрчжээ.” гэж үзээд 05 дугаар дүгнэлтийг гаргаж, улмаар уг маргааныг эцэслэн шийдвэрлэж 02 дугаартай тогтоолыг гаргасан байна.

Мөн хууль тогтоогчоос 2013 оны Шүүх байгуулах тухай хуулийг батлахдаа шүүхийг шүүн таслах ажлын төрлөөр нь дагнан байгуулж,

тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоохдоо 2-3 аймаг дунд давж заалдах шатны нэг шүүх, 2-3 дүүргийн дунд анхан шатны нэг шүүх байхаар хуульчилсан буюу нэршлийн хувьд дэс дугаарлаж, тойргийн зарчмаар байгуулсан. Харин 2015 оны Шүүх байгуулах тухай хуулиар зөвхөн нэршлийг "аймгийн" болон "дүүргийн" гэж томьёолж, өмнөх хуультай мөн адил 2-3 аймгийн дунд нэг давж заалдах шатны шүүх, 2-3 дүүрэг дунд анхан шатны нэг шүүхтэй байхаар тус тус хуульчилж байсан нь Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн үндсэн тогтолцоог зөрчсөн гэж үзэж холбогдох заалтыг хүчингүй болгосон Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 01, 2016 оны 01 дүгээр тогтоол тус тус хүчин төгөлдөр хэвээр байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж дүүрэг тус бүр нэг шүүхтэй байхаар өөрчлөн найруулсан боловч Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн "Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх" гэсэн хэсгийн 8 дахь заалтад "Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх" гэж, мөн "Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх" гэсэн хэсгийн 8 дахь заалтад "Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх" гэж хоёр дүүргийн дунд нэг анхан шатны шүүхийг байгуулан хуульчилсан нь дээр дурдсан Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хүчингүй болсон Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн байна.

Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор удаа дараа хүчингүй болсон Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалтыг агуулгаар нь дахин сэргээснээрээ Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэснийг зөрчиж байгааг тэмдэглэх нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг; Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3, 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдөр өөрчлөлт оруулсан Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн “Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэж, мөн “Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэж тус тус хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 02, 2015 оны 01, 2016 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн байх тул хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоолын “Тогтоох” хэсгийн 1 дэх заалтыг 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ	Д.ОДБАЯР
ГИШҮҮД	Н.ЖАНЦАН
	Т.ЛХАГВАА
	Ш.ЦОГТОО
	Д.СУГАР
	Н.ЧИНБАТ
	Д.НАРАНЧИМЭГ
	Д.СОЛОНГО

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.01.31 Дугаар 01 Улаанбаатар хот

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Т.Лхагваа /илтгэгч/, Н.Чинбат, Д.Наранчимэг, Д.Солонго нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Н.Түмэнбаяр болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээс гадна дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гээд 12.1.5 дахь заалтад “дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх

бүрэн эрхийг хуулиар тогтоох;" гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална." гэж заасныг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Түмэнбаяраас Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ. Үүнд:

"Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Монгол Улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээс гадна дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:" гээд 12.1.5 дахь заалтад "дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох;" гэж заасан нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийг зөрчсөн гэж үзэж байна.

Учир нь тус хуулийн 12 дугаар зүйл агуулгын хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тодорхой 6 бүрэн эрхийг тогтоосон. Гэвч 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтад "дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох;" гэж заасан байгаа нь үгийн шууд утга болон логикийн хувьд Монгол Улсын Ерөнхийлөгч "... хуулиар тогтоох" буюу "хууль тогтоох" эрхтэй мэт ойлгогдож байна.

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-12.1.4, 12.1.6 дахь заалтад Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг "мэдүүлэх, чиглэл өгөх, дүрмүүдийг батлах, цэргийн дайчилгааг зарлах" гэж маш тодорхой буюу монгол хэлний үйлт нэрийн "х"-гээр төгсгөж заасан нь 12.1 дэх хэсэгт "...Үндсэн хуульд заасан бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:" гэсэнтэй утга агуулгын хувьд шууд уялдаж байгаа боловч 12.1.5 дахь заалтад мөн л монгол хэлний үйлт нэрийн "х"- гээр төгсгөж "... хуулиар тогтоох" гэж заасан байгаа нь утга агуулгаараа Монгол Улсын Ерөнхийлөгч өөрийнхөө бүрэн эрхийг өөрөө "хуулиар тогтоох"-оор ойлгогдож байна. Монгол Улсын хууль нь орчин цагийн монгол хэлний хэм хэмжээний дагуу найруулан бичих зүй тогтлын дүрмийг баримтлан боловсруулагдаж, энгийн шууд утгаараа Монголын ард түмэнд ойлгогдохоор хэл зүйн найруулгатай байх ёстой.

Дайны байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-13.1.8 дахь заалтад дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг туйлын тодорхой нэрлэн заасаар атал 2016 оны Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтад дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг "хуулиар тогтоох" хэмээн оруулсан нь энэхүү эрх зүйн харилцаа нь тодорхой хуулийн зохицуулалт байхгүй, эсвэл өмнө батлагдан гарсан Дайны байдлын тухай хуулиар зохицуулагдаагүй, ирээдүйд зохицуулах харилцаа мэтээр ойлгогдохоор найруулагдсан нь хууль зүйн техникийн хувьд алдаатай байна.

Хоёрдугаарт, Улс орныг батлан хамгаалах тухай хуулиуд нь үндэсний аюулгүй байдлын нэн чухал баталгаануудын нэг бөгөөд аюулгүй байдлын орчин өөрчлөгдөж, болзошгүй аюул тулгарсан нөхцөлд хуулиудын заалтууд нь хэрэгжиж эхэлдэг онцлогтой тул тухайн гэнэтийн нөхцөл байдалд иргэн бүрт хоёрдмол утгагүйгээр шууд ойлгогдохоор байх нь чухал юм. Дайны байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-13.1.8 дахь заалтад Дайны байдлын үед Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг тодорхой тогтоож өгсөн байгаа тул Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг хүчингүй болгосноор эрх зүйн хийдэл гарахгүй юм.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийг зөрчсөн Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг хүчингүй болгож өгнө үү." гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтад "дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох;" гэж заасан нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална" гэж заасныг хууль зүйн хувьд илүү бататгаж өгсөн заалт гэж үзэж байна. Учир нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад

“хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах” онцгой бүрэн эрх зөвхөн Улсын Их Хуралд хадгалагдах бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч хууль санаачлах субъект боловч хууль батлах субъект биш юм. Түүнчлэн, Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно.” гэж заасан нь Ерөнхийлөгчид ямар ч нөхцөлд зөвхөн Улсын Их Хурлаас хуулиар олгосон тодорхой бүрэн эрхээс бусад бүрэн эрхийг олгохгүй бөгөөд Ерөнхийлөгч ч өөрөө өөртөө бүрэн эрх олгох эрхгүйг тодруулсан болно.

Иймд дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд хууль тогтоох буюу батлах бүрэн эрх Улсын Их Хуралд хадгалагдах бөгөөд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд өөрөө хууль тогтоох эрх эдлэхгүй болно.

Хуулийг тайлбарлахад хууль тогтоогчийн тухайн үеийн хүсэл зоригийг харгалзан үзэх, эсхүл хуулийн нэр томьёог шууд үгийн утга, зүйгээр нь тайлбарлах зэрэг аргыг хэрэглэдэг бөгөөд Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно.” гэж заасны дагуу Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд хэрэгжүүлэх тодорхой бүрэн эрхийг нэг бүрчлэн заасан. Үүнээс үзэхэд Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтад “дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох;” гэж заасан нь хууль тогтоогчийн хүсэл зориг нь Ерөнхийлөгчид шууд хууль тогтоох эрхийг олгоогүй бөгөөд харин тухайн нөхцөл байдалд хуулиар тогтоосон болон Улсын Их Хурлаар батлах хуулиар олгосон тодорхой бүрэн эрхийг Ерөнхийлөгч хэрэгжүүлэхээр тодотгосон болно. Иймд хууль тогтоогчийн хүсэл зориг нь Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийг зөрчөөгүй гэж үзэж байна.

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг хүчингүй болгосноор хууль зүйн хийдэл үүснэ. Учир нь хууль зүй болон цэргийн нэр томьёоны хувьд дайн бүхий байдал, дайны байдал нь тус тусдаа өөр ойлголт бөгөөд Дайн бүхий байдлын тухай хуульд дайн бүхий байдал зарласан тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч буюу зэвсэгт хүчний ерөнхий

командлагчийн хэрэгжүүлэх тодорхой бүрэн эрхийг хуульчлаагүй байдаг. Харин Дайны байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгч буюу зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх тодорхой бүрэн эрхийг нэг бүрчлэн бус, тоочсон хэлбэрээр хуульчилсан. Учир нь Дайны байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт "Монгол Улсын Ерөнхийлөгч хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ." гэж заасан нь тухайн нөхцөл байдалд нийцүүлэн Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг Улсын Их Хурал хуулиар тогтоож өгөх боломжийг бий болгосон.

Үүнээс үзэхэд Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт нь Дайн бүхий байдлын тухай болон Дайны байдлын тухай хуулиудтай нягт уялдаа холбоотой бөгөөд эдгээр хуультай давхцаж, зөрчилдөөгүй байна.

Нөгөө талаар, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлтэй утга, агуулгын хувьд холбоотой бөгөөд дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох бүрэн эрх нь Үндсэн хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хуралд хэвээр хадгалагдах эрх зүйн зохицуулалтыг хөндөөгүй болно.

Өөрөөр хэлбэл, утга, агуулгын хувьд Монгол Улсын Ерөнхийлөгч дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох асуудлыг Улсын Их Хуралд хандан шийдвэрлүүлэх бүрэн эрхтэй. Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална." гэж заасан нь дайны болон дайн бүхий байдлын үед ч Улсын Их Хурал өөрийн онцгой бүрэн эрх болох хууль тогтоох бүрэн эрхийг хадгалан хэрэгжүүлэх болно.

Дээр дурдсан тайлбараас дүгнэхэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дайн бүхий болон дайны байдлын үед бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлэх тодорхой бүрэн эрхийг хуулиар тодорхой зааж өгсөн тул иргэний мэдээлэлд дурдсанчлан Ерөнхийлөгч өөрөө өөртөө хууль тогтоох гэсэн агуулгыг илэрхийлээгүй юм.

Иймд Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Монгол Улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуульд заасан

бүрэн эрхээс гадна дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:" гээд 12.1.5 дахь заалтад "дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох;" гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийг зөрчөөгүй болно." гэжээ.

Гурав. Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2017 оны 107 дугаар тогтоолын дагуу шинжээчээр томилогдсон Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, Академич Л.Болд дүгнэлтдээ:

"Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлд Ерөнхийлөгчийн бүрэн эрхүүдийн дөрвөн зүйлийг Ерөнхийлөгч өөрөө гүйцэтгэхээр тогтоожээ. Үүнд:

12.1.2 батлан хамгаалахад зайлшгүй шаардагдах нөөцийг бүрдүүлэх, зэвсэг, техникийг шинэчлэх төсвийг шийдвэрлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх;

12.1.3 батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний мэдээллийг сонсож, түүний дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газарт чиглэл өгөх;

12.1.4 цэргийн нийтлэг дүрмийг батлах.

Эдгээр заалтад дурдсан үйлийг бусдаар биш өөрөөр бүр тодруулбал, Монгол Улсын Ерөнхийлөгч өөрөө гүйцэтгэх тул үйл үгийг нь анхны хэлбэрээр нь хэрэглэсэн байна. Гэтэл 12.1.1 дэх заалтад "батлан хамгаалах бодлогын үндсийг Засгийн газартай зөвшилцөн тодорхойлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;", 12.1.5 дахь заалтад "дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох;" гэж заасан байгаа нь Ерөнхийлөгч уг үйлийг өөрөө биш харин төр Ерөнхийлөгчөөр гүйцэтгүүлэх гэсэн санаа юм. Өөрөөр хэлбэл, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт нь "дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрх"-ийг, "... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгалагдана" гэж заасны дагуу "хуулиар тогтоож" өгнө гэсэн утга тодорхой ойлгогдож байна. Эш татсан заалтад дурдсан хууль гэдэг үг нь үйлдэхийн тийн ялгалаар хувирч /хуулиар/ буй нь уг үйлийг /тогтоох/ гүйцэтгэх зэвсгийг

зааж буй бөгөөд *сүхээр мод хагалах, цээжээр тоо бодох, өөрийн унаагаар очсон* гэх мэттэй адил юм. Энэ бүх учирлалаас үндэслэн үзвэл Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад "хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах" *о*нцгой бүрэн эрх зөвхөн Улсын Их Хуралд хадгалагдах бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч хууль санаачлах субъект мөн боловч хууль батлах субъект биш юм. Түүнчлэн, Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно." гэж заасан нь Ерөнхийлөгчид ямар ч нөхцөлд зөвхөн Улсын Их Хурлаас хуулиар олгосон тодорхой бүрэн эрхээс бусад эрхийг олгохгүй бөгөөд Ерөнхийлөгч ч өөрөө өөртөө бүрэн эрх олгох эрхгүйг тодруулсан болно. Иймд Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг "дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Дайны байдлын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;" гэж засварлах боломжгүй гэж үзэж байна." гэжээ.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2017 оны 108 дугаар тогтоолын дагуу шинжээчээр томилогдсон Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн дэд захирал, доктор, профессор А.Бямбажаргал дүгнэлтдээ:

"Цэцийн гишүүний 2017 оны 108 дугаар тогтоолд дараах хоёр асуудлаар дүгнэлт гарган ирүүлэхийг хүссэн байх бөгөөд (1) Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Монгол Улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээс гадна дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гээд мөн хэсгийн 12.1.5 дахь заалтад "дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох" гэж заасан нь хууль зүйн техникийн хувьд дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох" гэж заасан нь хууль зүйн техникийн хувьд дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Ерөнхийлөгч хууль тогтоох бүрэн эрхийг хязгаартайгаар олгосон агуулгыг илэрхийлж буй эсэх; мөн (2) Парламентын засаглалтай улсын "хууль тогтоох" эрх мэдлийг Ерөнхийлөгчид шилжүүлэх боломжийн талаарх онолын үндэслэл, хязгаарлалт хэмээсэн болно. Шинжээчийн хувьд дээрх асуултуудыг тус бүрд нь дараах байдлаар дүгнэн үзэж байна.

Нэгдүгээр асуудлын хүрээнд:

1. Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль(шинэчилсэн найруулга)-ийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын дагуу дайны болон дайн бүхий байдлын үед Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувиар хууль тогтоох эрх мэдлийг бүрэн эдлэх агуулгыг илэрхийлж байна.

2. Хууль зүйн хувьд уг зохицуулалтад зэрэгцсэн хоёр гипотез буюу нөхцөл тогтоосон нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хууль тогтоох эрх нь аль аль тохиолдолд хамаарахаар болжээ. Уг заалтын дагуу нэг, дайн бүхий байдал болон хоёр, дайны байдал гэх ялгаатай нөхцөл байдалд ижил хэлбэрээр хууль тогтоох хэрэгжих боломжтой байна. Дээрх агуулгаас үзвэл Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувиар дайны болон дайн бүхий байдлын үед хуулиар өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар хууль тогтоож болох бүрэн эрхийг хуулиар шилжүүлэн авсан гэж дүгнэж болно.

3. Энэхүү зохицуулалттай холбогдох чухал заалт нь 12.1 дэх хэсэг юм. Уг зүйлд “Монгол Улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээс гадна дараах тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан. Дээрх заалтад туйлын тодорхой тусгагдсан нэгэн гипотез нь уг эрх нь Монгол Улсын Ерөнхийлөгч эдлэх бүрэн эрх бус харин зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн эдлэх бүрэн эрхийн талаарх зохицуулалт болох нь харагдаж байна.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна” хэмээн заасан. Үүнээс үзвэл манай улсын хувьд Ерөнхийлөгчөөс өөр ямар ч субъект зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн чиг үүргийг хэрэгжүүлэхгүй юм. Түүнчлэн, Үндсэн хуулийн дээрх заалтаас гадна ердийн хуулийн хүрээнд мөн зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд эдэлж болох онцгой эрхийг нарийвчлан зохицуулжээ. Тухайлбал, 1998 оны Дайны байдлын тухай Монгол Улсын хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт “Дайны байдлын үеийн онцгой нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл зарим бүрэн эрхээ Монгол Улсын Ерөнхийлөгчид шилжүүлж болно” хэмээн заасан нь дээрх зохицуулалтаас Үндсэн хуулийн заалтын утга санааг дэлгэрүүлэн зохицуулсан болохыг илтгэнэ.

Хоёрдугаар асуултын хүрээнд:

1. Эрх зүйн онолын дагуу түүний нэгэн дэд институц болох эрх шилжүүлэх (delegation of power) буюу төрийн байгууллага, албан тушаалтан хуульд заасны дагуу зарим бүрэн эрхээ хууль, гэрээний үндсэн дээр шилжүүлэх боломжтой байдаг. Үндсэн хуулийн эрх зүйн онолын ёсоор эрх шилжүүлэх боломжтой байдаг. Үндсэн хуулийн эрх зүйн онол ёсоор эрх шилжүүлэх асуудал нь аливаа субъект (албан тушаалтан болон байгууллага) өөрийн эрх хэмжээнд хамаарах бүрэн эрхийг бусад субъектэд шилжүүлэх агуулгаар ойлгогдоно. Гэвч ийнхүү эрхээ шилжүүлэх процедур нь гагцхүү хуульд заасны дараагаар хэрэгжиж хүчин төгөлдөр байх боломжтой. Өөрөөр хэлбэл, эрх шилжүүлэх хэлбэр нь хууль байж хуулиар заагаагүй аливаа бүрэн эрх шилжүүлэх үйл ажиллагаа хүчин төгөлдөр бус бөгөөд хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдөж (легитим) чадахгүйд хүрэх юм.

2. Үндсэн хуульт ёсны үүднээс эрх шилжүүлэх ойлголт төрийн эрх мэдлийн хуваарилалтын цар хүрээгээр хязгаарлагдана хэмээн үздэг. Энэ нь эрх мэдлүүд өөр хоорондоо шилжихгүй буюу хууль тогтоох эрх мэдэл гүйцэтгэх болон шүүх эрх мэдэлд шилжих боломжгүй гэх хязгаарлалт юм. Гэвч онцгой тохиолдолд уг эрх тодорхой хязгаарлалтын хүрээнд шилжих нь төрийн эрх мэдэл хуваарилалтын сонгодог зарчмыг үл хөндөнө. Өөрөөр хэлбэл, онцгой хэмээх нөхцөл нь чухам ямар байдал үүссэн байх вэ гэдгээс шууд хамаарна.

Тэгвэл эрх шилжих, түүн дотроо хууль тогтоох эрх мэдэл шилжиж болохуйц онцгой нөхцөлд тухайн улсын үндэсний аюулгүй байдал, үндсэн хуулийн байгуулалд ноцтой эрсдэл бий болсон гэх агуулгаар цөөнгүй гадаад улсуудын үндсэн хуульд заасан байна. Түүний сонгодог жишээ нь дайны байдал буюу үндэсний аюулгүй байдлын хүрээнд хойшлуулшгүй нөхцөл үүсэхэд тэрхүү орчинд тохирсон тусгай хууль батлан гаргах асуудал үүнд хамаарч байна. Өөрөөр хэлбэл, хууль батлах ердийн журам энэ тохиолдолд үл хамаарна. Энэ хүрээнд эрх зүйн харилцан адилгүй ялгаа бүхий хоёр агуулгаар уг асуудлыг гадаад улсууд шийдвэрлэсэн байна. (1) Эрх шилжүүлэх буюу дийлэнх тохиолдолд тухайн улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчид шаардлагатай бол хууль тогтоох эрх шилжиж болох арга зам (АНУ, Австрали, Польш зэрэг цөөнгүй орон үүнд хамаарна), (2) Хууль тогтоох эрх мэдлийг өргөжүүлэх буюу дайны үед төрийн удирдлага хэрэгжүүлэх субьект болох тодорхой институцийн эрхийг хууль тогтоох хэлбэрээр өргөжүүлэн зохион байгуулах

байдлаар хэрэгжиж байна. Тухайлбал: ХБНГУ-ын Үндсэн хуулийн “10 А” дугаар Үндэсний аюулгүй байдал гэх бүлэгт онцгой нөхцөл буюу үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн нөхцөл бий болсон хууль тогтоох эрх мэдэл хамтарсан хороо буюу парламентын дээд, доод танхимаас бүрдсэн институцэд шилжихээр зохицуулсан.

3. Хэдийгээр онцгой буюу улсын батлан хамгаалах хүрээнд хууль тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлэх эрх хэмжээ дан ганц парламентад бус бусад субьектэд шилжих замаар шинээр хууль батлах эрхийг хууль тогтоогчоос өөр субьект хэрэгжүүлэх тохиолдолд тэд бүхий л хуулийг дангаар батлан гаргах боломжгүй хэмээх хязгаарлалт мөн үйлчилж байна. Өөрөөр хэлбэл, улсыг батлан хамгаалах хүрээнд хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэх (delegation legislative power) болон хууль тогтоох эрх мэдлийг өргөтгөх (extend legislative power) замаар хууль тогтоох үед дараах нийтлэг хязгаарлалтууд тавигдаж байна. Үүнд:

а/ Хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэн авсан (delegation legislative power) болон хууль тогтоох эрх хэмжээ нь өргөтгөгдсөн (extend legislative power) субьект (институц)-ын хувьд аливаа хэлбэрээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон түүний үйлчлэлийг хэсэгчлэн болон бүхэлд нь зогсоох, хүчингүй болгох хууль батлахгүй байх;

б/ Иргэний Үндсэн эрх, хүний эрхэм чанарыг хязгаарласан шинжтэй хууль батлан гаргахгүй байх;

г/ Шинээр улсын хил тогтоох, өөрчлөх тухай хууль тогтоохгүй байх;

д/ Өөртөө засан тогтнох эрх олгох байдлаар улсын бүрэн бүтэн байдалд халдсан шинж бүхий хууль тогтоохгүй байх зэрэг нь нийтлэг хязгаарлалт байх бөгөөд улс орон бүр өөрийн онцлогоос хамааран Үндсэн хуулийн үл өөрчлөгдөх хэсгийг хөндөхгүй байх зэрэг тусгай хязгаарлалт тогтоож байна.

4. Гадаад орнуудын жишгээс харвал зэвсэгт хүчний ерөнхий командлагчийг (commander in cheif) засаглалын хэлбэрээр үл хамааран нийтлэг байдлаар тухайн улсын ерөнхийлөгч (АНУ, ХБНГУ, Чех, Франц, Польш, Словени зэрэг) болон засгийн газрын тэргүүн (ХБНГУ-ын холбооны канцлер, Дани, Канад, ОХУ зэрэг) хэрэгжүүлэхээр тогтоосон байна. Энэ нь дайн зэрэг онцгой нөхцөл байдалд батлан хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэйгээр зохион байгуулах, төрийн үйл ажиллагааг нэгтгэн удирдах давуу талтай байдаг хэмээн үзэж байна.

5. Манай тохиолдлын хувьд дайны болон дайн бүхий байдлын аль ч нөхцөлд Ерөнхийлөгчид хууль тогтоох эрх мэдэл шилжих боломжтой мэт зохицуулсан буйг анхаарах хэрэгтэй бөгөөд эрх зүйн үр дагаврын хувьд дээрх хоёр нөхцөл байдал ялгаатай байхаар одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд тусгасан. Тэгвэл дайн бүхий байдалд чухам уг эрх хэмжээ буюу хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэх, түүний эрхийг өргөтгөн эдлүүлэх боломж гадаад улсуудын эрх зүйн зохицуулалтад нарийвчлан зохицуулагдаагүй болох нь харьцуулсан судалгаанаас харагдаж буйг дурдах нь зүйтэй хэмээн дүгнэж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр баталсан Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээс гадна дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гээд 12.1.5 дахь заалтад “дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох;” гэж заасан байна. Уг заалт нь Монгол Улсын Ерөнхийлөгч дайн бүхий байдал, дайны байдал зарласан үед зэвсэгт хүчний ерөнхий командлагчийнхаа хувьд хэрэгжүүлэх өөрийн бүрэн эрхийн талаар хууль тогтоох эрхийг эдлэх агуулгыг илэрхийлж байна.

2. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбараас үзэхэд дээрх зохицуулалтыг хэлэлцэн баталсан хууль тогтоогчийн хүсэл зориг нь “Ерөнхийлөгчид шууд хууль тогтоох эрхийг олгоогүй бөгөөд харин тухайн нөхцөл байдалд хуулиар тогтоосон болон Улсын Их Хурлаар батлах хуулиар олгосон тодорхой бүрэн эрхийг Ерөнхийлөгч хэрэгжүүлэхээр тодотгох”-д чиглэгдсэн байжээ.

Гэтэл Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт нь хэл зүйн хувьд хууль тогтоогчийн хүсэл зоригоос өөрөөр ойлгогдохоор хуульчлагдсан нь хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална гэсэн Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийг зөрчсөн гэж үзэхэд хүргэж байна.

3. Мөн Улсын Их Хурлаас 1998 оны 5 дугаар сарын 15-ны өдөр баталсан Дайны байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт “Дайны байдлын үеийн онцгой нөхцөл байдлаас шалтгаалан

Монгол Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл зарим бүрэн эрхээ Монгол Улсын Ерөнхийлөгчид шилжүүлж болно.” хэмээн хуульчилсан зэрэгтэй уялдуулан уг зохицуулалтыг хууль тогтоогчоос боловсронгуй болгох, тодотгон хуульчлах боломжтой байгааг дурдах нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр баталсан Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтад “дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох;” гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэснийг зөрчсөн байна.

2. Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтад “дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох;” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ Д.ОДБАЯР
ГИШҮҮД Т.ЛХАГВАА
Н.ЧИНБАТ
Д.НАРАНЧИМЭГ
Д.СОЛОНГО

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2018.02.08 Дугаар 18 Төрийн ордон
Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны
01 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр баталсан Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтад “дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд бүрэн эрхийг хуулиар тогтоох;” гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэснийг зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.02.02 Дугаар 02 Улаанбаатар хот

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 12.25 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Сугар даргалж, гишүүн Н.Чинбат, Д.Наранчимэг /илтгэгч/, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд хүсэлт гаргагч Монгол Улсын дээд шүүхийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Х.Сонинбаяр, шүүгч Д.Цолмон нар оролцож, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал оролцоогүй болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлээр нэмэлт, өөрчлөлт оруулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн

67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3, 13, 17 дахь заалт, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 2, Дөчин долдугаар зүйлийн 1, Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Монгол Улсын дээд шүүх Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан хүсэлтдээ:

"... Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлээр нэмэлт, өөрчлөлт оруулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтад нийцээгүй гэж үзэн ирүүлсэн Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн саналыг Монгол Улсын дээд шүүх үндэслэлтэй гэж дүгнэн, энэ талаар Үндсэн хуулийн цэцэд 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хүсэлт мэдүүлэх тухай 02 дугаар тогтоолыг гаргасан.

Нэгдүгээрт. Монгол Улсын Их Хурал 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2017 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн №24/981/ дугаарт албан ёсоор нийтлэгдэж, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлд "67.1.5. хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийн талаар холбогдох байгууллагаас тодорхойлолт, лавлагаа авах." гэсэн заалт нэмэлтээр оруулж, уг ажиллагаа хийх үүргийг шүүгчид хүлээлгэсэн байна. ...

Дээрх 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт нь:

А/. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэснийг зөрчсөн гэж үзэхээр байна.

Эрх зүй нь нийгмийн харилцааг зохицуулагчийн хувьд өргөн ойлголт боловч тэрээр зохицуулах зүйл буюу харилцаа, зохицуулалтын

арга, зохицуулалтын зарчим зэрэг шалгуур, үндсэн шинжээр ялгагдаж, бие даасан салбар эрх зүйд хуваагддаг. Өөрөөр хэлбэл, үндсэн хуулийн эрх зүй, эрүүгийн эрх зүй, иргэний эрх зүй, захиргааны эрх зүй гэх зэргээр салбар эрх зүй нь өөр өөрийн онцлогийг тусгасан хэм хэмжээнээс бүрдэж байдаг нь ойлгомжтой.

Эрх зүйн харилцаанд оролцогч нь өөрийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзсэн тохиолдолд эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрхтэй бөгөөд шүүх нь нэн тэргүүнд "... хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх" буюу Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, түүний суурь зарчмыг хэрэгжүүлэх нь зүйн хэрэг. Мэдээж, "... хууль, шүүхийн өмнө эрх тэгш" байх ойлголт нь өргөн утга, агуулгыг илэрхийлдэг, хүний эрхийн суурь зарчим бөгөөд энэ нь хуулийн өмнө, шүүхийн өмнө гэсэн хоёр хэсэгт хуваагддаг.

Хууль тогтоогч нь эрх зүйн хэм хэмжээг тогтоохдоо салбар эрх зүйн зохицуулах зүйл, зохицуулалтын арга, зарчмаас хамааран тухайн харилцаанд оролцогчдын "эрхийн тэнцвэртэй байдлыг хангах" нь Үндсэн хуулийн "эрх тэгш" байх байдлыг хууль тогтоох аргаар тэнцвэржүүлэх үүрэгтэй.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ямар нэгэн давуу тал, эсхүл хязгаарлалт тогтоохгүй байх нь шүүхийн өмнө эрх тэгш байх гэдэг ойлголтыг тайлбарлах үндсэн шалгуур мөн төдийгүй энэ нь салбар эрх зүй буюу материаллаг эрх зүйн хэм хэмжээ, зохицуулах зүйл, зохицуулалтын арга, зарчим, түүний онцлог, үндсэн шинжээс хамааралтайгаар тухайн харилцаа нь үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох хууль зүйн факт, талуудын хүсэл зоригоос хамаарах, эсхүл хамаарахгүйгээр эрх зүйн харилцаанд оролцогчдод хууль зүйн эрх, үүрэг, хариуцлага үүсч байдаг нь тодорхой.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилтыг хуулийн 1 дүгээр зүйлд тодорхойлохдоо иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэжээ. ...

Иргэний эрх зүйн харилцааны оролцогч болох аливаа *иргэн, төр, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага* нь өөрийн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах зорилгоор шүүхэд хандах

эрхийн баталгаа, үндсэн зарчим нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан байдаг.

Иргэний эрх зүй нь өөрийн гэсэн зохицуулах зүйл, зохицуулалтын арга, зарчим, бие даасан хуультай салбар эрх зүй болохынхоо хувьд энэхүү материаллаг эрх зүйгээр хамгаалагдсан эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг нь зөрчигдсөн гэж үзсэн этгээд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах нь процессын эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл болдог нь ойлгомжтой.

Материаллаг эрх зүйн харилцаанаас үүсдэг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчим бол зохигчдын буюу "талуудын зарчим" байдаг бөгөөд шүүх энэхүү зарчмыг хангахын тулд "хөндлөнгийн байх" зарчмыг хэрэгжүүлэх нь салбар эрх зүйн онцлогтой илүүтэй холбогдоно. Өөрөөр хэлбэл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэхээс дуусгавар болох бүх процесст оролцогчдын "хүсэл зоригийн" шинжийг зайлшгүй харгалзах нь материаллаг эрх зүй буюу иргэний эрх зүйн харилцаатай холбоотой.

Өөрөөр хэлбэл, иргэний эрх зүйн харилцаа нь оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх зарчмын үндсэн дээр үүсч, өөрчлөгдөж, дуусгавар болдог үндсэн шинжээс хамааран зохигчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд "тэгш" байх явдал нь иргэний процессын эрх зүйн онцлог шинж юм.

Иймээс иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн хүсэлтийг харгалзахгүйгээр шүүх өөрийн санаачилгаар ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн хэм хэмжээг хуулиар тогтоохгүй байгаа нь Үндсэн хуулийн "... эрх тэгш" байх эрхийг хангаж байгаа явдал.

Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлтээр орсон 67.1.5 дахь заалт нь шүүгчийг "нэхэмжлэгчийн талд" үйлчлэх хуулийн тэгш бус байдлыг үүсгэж байгааг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна. Өөрөөр хэлбэл, хэрэг маргаанаа шийдвэрлүүлж буй талуудын "хүсэл зоригийг үл харгалзах" байдлаар хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийн талаарх лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулахыг

шүүгчид үүрэг болгосныг Үндсэн хуульд нийцсэн гэж үзэх боломжгүй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд нэхэмжлэлийн шаардлага, татгалзлын үндэслэлээ өөрсдөө нотлох үүргийг хүлээдэг хэдий ч зохигч "шүүхэд хүсэлт гаргах" замаар баримтыг шүүхээр бүрдүүлүүлэх, шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг авч болох тусгайлсан зохицуулалтыг хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.3., 69 дүгээр зүйл, 70 дугаар зүйлээр хэдийнээ зохицуулсан байдаг.

Тэгвэл захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчийн хүсэл зоригоос хамааралгүйгээр шүүхээс "мөрдөн шалгах" зарчмыг хэрэгжүүлж байгаа нь энэ салбар эрх зүйн онцлогтой холбоотой "тэгш байдлыг" хангах зохицуулалт юм. Энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ч салбар эрх зүйн онцлогтой холбоотойгоор сэжигтний гэм бурууг нотлох үүргийг төр хүлээдэг, эрүүгийн процессын зорилтыг хэрэгжүүлж байгаа байгууллага, эрх бүхий албан тушаалтны эрх хэмжээг тусгайлан зохицуулдаг нь мөн л Үндсэн хуулийн зарчмыг салбар эрх зүй бүрийн онцлогт тохируулан хэрэгжүүлж байгаа явдал юм.

Б/. Процессын хуульд орсон дээрх нэмэлт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... хөрөнгө чинээ, ...-ээр нь ялгаварлан гадуурхаж үл болно. ..." гэснийг зөрчсөн гэж үзэхээр байна. Үндсэн хуулийн энэ зохицуулалт нь нэн тэргүүнд ялгаварлалгүй, алагчлахгүй байхыг шаарддаг буюу энэ нь Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "... эрх тэгш байх" зарчимтай шууд хамааралтай байдаг.

Нэхэмжлэгчийн нэхэмжлэлдээ дурдсан этгээдийг "хариуцагч" гэж үздэг бөгөөд хариуцагчаар оролцох иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, олон улсын байгууллага аль нь ч байсан "хэдий хэмжээний хөрөнгө, орлоготой, эсхүл хөрөнгө орлогогүй" байхаас үл хамааран шүүх иргэний хэргийг хянан шийдвэрлэх учиртай. Гэтэл "хариуцагч" гэж үзэж буй этгээдийнхээ хөрөнгө, орлогын мэдээллийг шүүхээр гаргуулах давуу байдлыг нэхэмжлэгчид хуулиар олгож байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөрөг үр дагавар үүсгэхийг үгүйсгэхгүй бөгөөд энэ нь Үндсэн хуулийн "... хөрөнгө чинээ, ... гээр нь ялгаварлан гадуурхаж үл болно." гэж заасантай нийцэхээргүй байна.

В/. Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэж заасан байдаг. Гэтэл хэрэг үүсгэсэн шүүгч хэргийн оролцогчийн аль нэг талд буюу нэхэмжлэгчийн талд үйлчлэх зохицуулалтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлтээр оруулсан нь “шүүгчийн хараат бус, хөндлөнгийн байх” Үндсэн хуулийн зарчимтай нийцэхгүй юм. Нэхэмжлэгчээс хариуцагчаа гэж сонгосон этгээдийн хөрөнгийн талаарх лавлагаа, тодорхойлолтыг эрх бүхий байгууллагаас гаргуулах ажиллагааг шүүх зохигчдын хүсэлтээр бус харин өөрийн санаачилгаар хийх үүргийг хуульчилж байгаа нь буруу юм. Өөрөөр хэлбэл, шүүхээр гаргуулсан дээрх баримт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талуудын мэтгэлцээний зүйл буюу нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх сөрөг нөхцөл үүсч болохоор байна. Түүнчлэн, нэхэмжлэгч хариуцагчаа буруу сонгосон, хариуцагчаар татагдсан иргэн, хуулийн этгээд тухайн маргааны хариуцагч биш болох тогтоогдвол “төлбөр төлөх ёстой этгээд” гэдгийг шүүх урьдчилан тогтоож байгаатай адил үр дагаврыг бий болгож байна.

Г/. Шүүхээс үйлчилгээ авч буй талуудын эрхийг хуулиар тэнцвэржүүлэлгүйгээр, талуудын эрх тэгш байдлыг хангалгүйгээр, зөвхөн “хариуцагч”-аар татагдсан этгээдийн хуулиар хамгаалагдсан хувийн нууц, мэдээлэлд халдахыг дээрх хуулийн нэмэлтээр шүүхэд үүрэг болгож буй нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “... Иргэний хувийн ... нууц ...-ыг хуулиар хамгаална.”, мөн зүйлийн 17 дахь заалтад “... Хүний эрх, нэр төр, алдар хүнд ... хамгаалах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.”, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;” гэж заасныг тус тус зөрчсөн гэж үзэхээр байна. Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын дагуу Монгол Улс нууцын асуудлыг хуулиар тогтоосон бөгөөд “хөрөнгө” энэхүү нууцын төрөлд хамаарсан байна.

Д/. Монгол Улс “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай конвенци”- д 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан “Конвенцид нэгдэн орох тухай хууль”-иар нэгдэн орсон ба тус Конвенцийн Арван долдугаар зүйлд нийцэхгүй байгааг дурдах нь зүйтэй.

Хоёрдугаарт. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2

дугаар зүйлээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэгт өөрчлөлт оруулжээ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлд шүүхээс гарах шийдвэрийн агуулгад тавигдах, нөхцөл шаардлагыг хуулиар тогтоож өгсөн байдаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн "... Шаардлагатай бол шийдвэр гүйцэтгүүлэх арга, журам, хугацааг заана. ..." гэснийг "Энэ хуулийн 67.1.5-д заасан тодорхойлолт, лавлагааг үндэслэн төлбөр гаргуулах хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийг тодорхой тусган, шийдвэр гүйцэтгэх арга, журмыг зааж, хүний орон байр, бусад газарт нэвтрэх, төлбөр төлөгчийн бие, орон байр, бусад газар, эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, албадан барьцаалах, хураах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад шаардагдах бусад зөвшөөрөл олгоно." гэж өөрчилснийг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэхээр байна. ...

Шүүх нь Үндсэн хуулиар тогтоосон зарчим болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зарчимд захирагдаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулдаг. Үндсэн хуульд заасан "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх; шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах; хэрэг маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэх" гэсэн зарчмуудыг Үндсэн хуулийн зарчим гэх бөгөөд харин диспозитив буюу талуудын зарчим, мэтгэлцэх буюу шүүх хөндлөнгийн байх, шүүх хуралдааныг нээлттэй, тасралтгүй явуулах, монгол хэл дээр явуулах, эх хэлээрээ мэдүүлэг тайлбар өгөх, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх гэсэн зарчмуудыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зарчим гэж үздэг.

Дээрх зарчмууд нь "... хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх" Үндсэн хуулийн эрхэм зорилгод хүрэхийн тулд шүүхээс шударга ёсыг тогтооход үндсэн үзэл баримтлал нь болдог. Тиймээс шүүхийн шударга байдал нь процессын шударга байдлаар тодорхойлогддог учиртай.

Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ." гэж зааснаар шүүх нь талуудын мэтгэлцээний хүрээнд, хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурлан, маргааны нөхцөл байдалд эрх зүйн дүгнэлт

хийж, нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах эсэхийг хууль хэрэглэж шийдвэрлэдэг бүрэн эрхтэй цорын ганц байгууллага. Харин шүүх нь гаргасан шийдвэрээ "биелүүлнэ" гэсэн ойлголт байх боломжгүй бөгөөд хуульд заасан үндэслэл журмын дагуу тусгай чиг үүрэг бүхий байгууллага шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулдаг, энэ харилцаа нь бие даасан хууль тогтоомжоор зохицуулагддаг, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой гарсан гомдлыг шүүх харьяалан шийдвэрлэдэг онцлогтой. ...

Шүүх хууль хэрэглэж шийдвэр гаргадаг бол шийдвэр гүйцэтгэлийн байгууллага нь хэргийн оролцогчоос шүүхэд гаргасан хүсэлтийн үндсэн дээр шүүхээс гаргасан гүйцэтгэх хуудсаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх эрх нь үүсдэг байгууллага юм. Тодруулбал, шүүхийн шийдвэр нь эрх зүйн эх сурвалж болох боломжтой тул гүйцэтгэх засаглалын чиг үүргийг хэрэгжүүлэх буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шинжтэй ажил үүрэгт оролцох нь Үндсэн хуулиар тогтоосон эрх мэдэл хуваарилах зарчимд харшлахаар байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэгт орсон өөрчлөлт нь 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалттай холбоотой байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог нь нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын хэмжээ, хязгаарын хүрээнд хэргийг шийдвэрлэдэг бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэгт орсон өөрчлөлтөөр шүүх "нэхэмжлэлийн шаардлагад дурдаагүй, хэргийн оролцогчийн хүсэлт гаргаагүй" асуудлыг шүүх санаачилгаараа шийдвэрлэх нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "... шүүх хэрэг маргааныг ... шийдвэрлэнэ гэснийг зөрчсөн гэж үзэхээр байна. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэр бүрийн Тогтоох хэсэгт ".... төлбөр гаргуулах хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийг тодорхой тусган, шийдвэр гүйцэтгэх арга, журмыг зааж, хүний орон байр, бусад газарт нэвтрэх, төлбөр төлөгчийн бие, орон байр, бусад газар, эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, албадан барьцаалах, хураах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад шаардагдах бусад зөвшөөрөл олгоно" гэж өөрчлөлт оруулсныг алдаатай, буруу томьёолол гэж үзэж байна.

Дээрх өөрчлөлтөөр шүүхийн шийдвэрийг хариуцагч сайн дураар биелүүлэх хуулиар олгосон боломж буюу төлбөр төлөгчийн

эрхийг хязгаарлаж, харин шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг шууд албадан явуулахыг шүүхийн шийдвэр бүрийн тогтоох хэсгээр шүүх шийдвэрлэх нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.", Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад "... хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.", Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад "хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;", Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно." гэснийг тус тус зөрчсөн гэж тайлбарлахаар нөхцөл юм. Өөрөөр хэлбэл, төлбөр төлөх үүрэгтэй болсон этгээд шүүхийн шийдвэрийг сайн дурааараа биелүүлэх буюу өөрийн ямар хөрөнгийн, аль хэсгээс төлбөрөө барагдуулах тухай шийдвэр гаргах өмчлөгчийн эрхийг зөрчиж байна.

2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгатай холбогдон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн хууль гарсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар "Иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг баталгаажуулах арга хэмжээ"-нд 17 төрлийн ажиллагааг хамруулсан байх бөгөөд шийдвэр гүйцэтгэлийн байгууллага нь дээрх ажиллагааг хуулиар тогтоосон арга, журмын дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 20.5 дахь хэсэг нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэгт орсон өөрчлөлттэй шууд холбоотой бөгөөд энэ нь Үндсэн хуулийн "Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн гэж үзэхээр байгааг дурдах нь зүйтэй.

Монгол Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд хүсэлт болгох нь:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл: "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 67.1.5 дахь заалт нэмсүгэй. 67.1.5: "хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийн талаар холбогдох байгууллагаас лавлагаа авах", мөн хуулийн 2 дугаар зүйл: "Иргэний

хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн “шаардлагатай бол шийдвэр гүйцэтгүүлэх арга журмыг заана” гэснийг “Энэ хуулийн 67.1.5-д заасан тодорхойлолт лавлагааг үндэслэн төлбөр гаргуулах хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийг тодорхой тусган, шийдвэр гүйцэтгэх арга журмыг зааж, хүний орон байр, бусад газар, эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, албадан барьцаалах, хураах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад шаардагдах бусад зөвшөөрөл олгоно” гэж өөрчилсүгэй хэмээн хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3, 13, 17 дахь заалт, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 2, Дөчин долдугаар зүйлийн 1, Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... 1.Хууль тогтоогч Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... эрхтэй.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэний өмнө хариуцна.” гэж тус тус заасныг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга болон хамт өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг баталсан.

Өөрөөр хэлбэл дээрх хуулиуд нь бүхэлдээ хохирогч бүр хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирсан хохирлоо гэм буруутай, гэм хор учруулсан этгээдээр нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхээ сэргээн эдлэх тэгш эрх, боломжтой байж, уг эрхээ баталгаатай эдлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үр дүнтэй, түргэн шуурхай, бүрэн дүүрэн, хуулийн дагуу явагдах баталгааг бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээд шүүхэд хандсан үеэс буюу тухайн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанаас эхлэн шүүх нь төрөөс иргэнийхээ өмнө Үндсэн хуулиар хүлээсэн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг биелүүлэх арга хэмжээг авч ажиллах ёстой.

Ингэхийн тулд шүүхээс хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах талаарх хуулийн

зохицуулалтыг бодитой хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх, хариуцагч өөрийн хөрөнгө, орлогыг нуух, бусдад шилжүүлдэг байдлыг халах шаардлага бий болсон.

Дээр дурдсанчлан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлээр шүүх эрх мэдлийн байгууллагад шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах бүрэн эрхийг олгосон. Хуулийн дээрх зохицуулалтыг шүүхээс хэрэгжүүлэхийн тулд хариуцагч буюу төлбөр төлөгч нь хаана, ямар, хэр хэмжээний хөрөнгө, орлоготой болохыг лавлаж, тодруулан тогтоох шаардлагатай бөгөөд мөн хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалтаар шүүхэд энэ эрх буюу боломжийг хууль тогтоогч олгосон байна. Шүүх төлбөр төлөгчийн өмч хөрөнгийн байдлыг мэдэхгүйгээр дээр дурдсан хөрөнгө хамгаалах, шийдвэр баталгаажуулах арга хэмжээг авах боломж байхгүй юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалтад “хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийн талаар холбогдох байгууллагаас тодорхойлолт, лавлагаа авах.” гэж заасан нь шүүхэд аль нэг талын нэрийн өмнөөс нотлох баримт цуглуулах үүрэг хүлээлгээгүй буюу Улсын дээд шүүхийн хүсэлтэд дурдсанчлан “иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчим”-д халдсан шинж, утга агуулаагүй.

2. Шүүхээс аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа нь түүний үр дүнд гарах шийдвэрийг биелүүлэх ажиллагаатай салшгүй холбоотой байдаг. Учир нь шүүх, түүний шийдвэр нь иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэхийг тогтоодог бөгөөд харин шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн тогтоосон зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бодитоор сэргээн эдлүүлэх, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байдаг.

Шүүхээс хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах хангалттай арга хэмжээг авахгүй байгаагаас буюу гарсан шийдвэр нь биелэгдэх боломжтой эсэхэд хайхрамжгүй хандсанаар нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэхэд хүндрэл бий болох, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа хийх боломжгүй, төлбөр төлөгч хөрөнгө, орлогоо нуун далдлах, бусдад шилжүүлэх, үрэгдүүлэх нөхцөлийг үүсгэж байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн тоо баримтаас харахад шүүхээс татан буугдсан хадгаламж, зээлийн

хоршоодын 8301 хохирогчид нийт 72.4 тэрбум төгрөг олгохоор шийдвэрлэгдсэн ч 29.2 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 69.515 ширхэг хөрөнгийг төлбөрт тооцохоор шийдвэртээ заасан нь нийт хохирлын 40 хувьтай тэнцэх бөгөөд үлдсэн хувийг хэрхэн яаж төлүүлэх нь тодорхойгүй буюу шүүхийн шийдвэр биелэгдэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн байдаг. ...

Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд хүргүүлсэн хүсэлтдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд нийцээгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд тус хуулийн 69 дүгээр зүйл болон 67 дугаар зүйлийн 67.1.3 дахь заалтад зааснаар талууд шүүхэд хүсэлт гаргах замаар шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах болон нотлох баримтыг шүүхээр бүрдүүлэх зохицуулалтыг аль хэдийн бүрдүүлсэн гэжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт “Хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт нь төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой; өөр улс, орон нутагт байгаа учраас зохигч тэдгээрийг өөрөө олж авах боломжгүй; түүнчлэн туршилт, үзлэг, таньж олуулах, шинжилгээ хийлгэх, гэрчийн мэдүүлэг авах тохиолдолд нотлох баримтыг хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүх бүрдүүлнэ.” гэж заасан нь Улсын дээд шүүхийн Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хүсэлтэд дурдсан “талуудын зарчим”, “шүүх хөндлөнгийн байх” зарчмыг мөн үгүйсгэх үндэслэл болж байна. Хэрвээ Улсын дээд шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалтыг Үндсэн хуулийн зөрчлийг агуулж байна гэж үзвэл мөн хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.3 дахь заалтыг хэрхэн ойлгож, хэрэглэж ирснийг тодруулах шаардлагатай юм.

Өөрөөр хэлбэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.3 дахь заалтад “хэргийн оролцогчийн гаргасан хүсэлтийг шүүх үндэслэлтэй гэж үзвэл энэ хуулийн 38.6-д заасан ажиллагааг явуулах.” гэж заасан нь мөн хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалтаас илүүтэйгээр шүүхэд нотлох баримт цуглуулах үүрэг хүлээлгэсэн байх магадлалтай бөгөөд хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт нь мөн зүйлийн 67.1.3 дахь заалттай харьцуулахад нотлох баримт цуглуулах үүргийг шүүхэд хүлээлгээгүй, зөвхөн лавлагаа, тодорхойлолт авах, ингэхдээ “шүүхээс мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлээгүй” хэн нэгэн этгээдэд үндэслэлгүйгээр

давуу байдал бий болгох утга, санаа агуулаагүйгээрээ, түүнчлэн мөн хуулийн 69 дүгээр зүйлтэй харьцуулахад хариуцагчийн өмч хөрөнгө, өмчлөх эрхэд халдсан агуулгагүй байна.

Дээрдурдсанаасүзвэл Улсындээдшүүххуулийгялгамжтайгаар ойлгож, Үндсэн хуульд нийцэж байгаа мэтээр тайлбарлан, нэхэмжлэгч этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн зохицуулалтыг шүүхийн эрх ашигт нийцэхгүй буюу шүүхэд нэмэлт үүрэг бий болгосон, шүүхийн ачааллыг нэмсэн гэх шалтгаанаар Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж, хууль тогтоох байгууллагаас баталсан хуулийн үзэл баримтлалыг алдагдуулж болохгүй гэж үзэж байна.

Улсын дээд шүүхийн хүсэлтэд дурдсанчлан иргэний өмч, хөрөнгөтэй холбоотой мэдээ, мэдээлэл нь холбогдох хуулиар нууцад хамаарах бөгөөд эдгээр мэдээллийг зөвхөн хуулиар эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан буюу шүүх авах эрхтэй байдаг. Ийм ч учраас иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг тал болох нэхэмжлэгч нь хариуцагчийн өмч хөрөнгийн талаар мэдээлэл байхгүй, олж авах боломжгүй тул уг мэдээллийг гаргуулах талаар шүүхэд хандахад шүүх хүсэлтийг хүлээж авдаггүй, үүнээс улбаалан өмч хөрөнгийн талаар тодорхой мэдээлэл байхгүй учраас нэхэмжлэгчийн шүүхээс гаргах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тухай хүсэлтийг “битүүмжлэх дансны дугаар, эсхүл эд хөрөнгийн талаарх мэдээллийг олж ирэх үүргийг нэхэмжлэгчид өгч” шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан арга хэмжээг авдаггүй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн зохицуулалтын хүрээнд жилд 2000 гаруй шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах шүүгчийн захирамжийг албадан гүйцэтгэж байгаа нь шүүхээр шийдвэрлэж буй нийт хэрэг, маргааны тоотой харьцуулахад зөвхөн 5 хувьд энэ төрлийн арга хэмжээг шүүхээс авч байгаа нь харагдаж байна.

3. Хууль тогтоогч шүүх шийдвэртээ төлбөр төлөгчийн ямар хөрөнгө, орлого, эрхээс төлбөрийг гаргуулах талаар тодорхой заадаггүйгээс шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгчийн бүх хөрөнгөд явуулж, төлбөр төлөгчийн өмчлөх эрхэд өөрийн үзэмжээр халддаг, түүнчлэн, иргэний Үндсэн хуулиар хамгаалагдсан орон байрны халдашгүй байдалд шүүхийн шийдвэргүйгээр халдах буюу шаардлагагүй байхад орон байранд хүчээр нэвтэрч, иргэдийг айлгадаг байдлыг өөрчлөхийн тулд Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 20 дугаар зүйл болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйл, 118 дугаар зүйлүүдээр дээрх эрхийг хамгаалах зохицуулалтуудыг нарийвчлан тодорхой хуульчилсан.

Ийнхүү шүүхээс төлбөр төлөгчийн хөрөнгийн талаарх лавлагааг үндэслэн төлбөр төлөгчийн төлбөрт гаргуулах хөрөнгийг тодорхой зааж өгснөөр нэг талаас хохирсон төлбөр авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хурдан хангаж хохирлыг барагдуулах, нөгөө талаас төлбөр төлөгчийн өмчлөх эрхэд шүүхийн шийдвэргүйгээр халдах, төлбөр төлөгчийн хөрөнгийг үнэгүйдүүлэх явдлыг таслан зогсоох зэрэг төлбөр төлөгчийн эрхийг хамгаалах, түүнчлэн Монгол Улсын нэрийн өмнөөс гарсан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр бодитоор биелэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа ашиг сонирхлын зөрчилгүй, шуурхай биелэгдэх боломж бүрдсэн.

Шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгчийн төлбөрт гаргуулах хөрөнгө, орлогыг тодорхой заахын тулд төлбөр төлөгчийн нэр дээр ямар хөрөнгө, орлого хаана байгааг мэдэж байх шаардлага хууль ёсоор тавигдсан бөгөөд үүнийг шийдвэрлэхийн тулд шүүгчид холбогдох байгууллагаас лавлагаа, тодорхойлолт авах эрхийг нь хуулийн дагуу нээж өгсөн. Харин Улсын дээд шүүхийн хүсэлтэд дурдсанчлан хүний өмчлөх эрхэд халдсан, иргэний эрх зүйн суурь зарчмыг алдагдуулсан зүйл байхгүй бөгөөд хууль хоорондын уялдаа холбоог хангасан зохицуулалтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмсэн болно.

Түүнчлэн, Засгийн газраас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах шатанд Улсын дээд шүүхээс холбогдох санал авахаар хуулийн төслийг илгээж, шүүхээс “тусгайлан өгөх саналгүй” буюу хуулийн төслийг дэмжсэн саналыг өгч байсан бөгөөд хуулийн төслийг Засгийн газрын түвшинд боловсруулах болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсний дараа төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, батлуулах бэлтгэл хангах ажлын хэсэгт аль алинд нь нийслэлийн болон Улсын дээд шүүхийн төлөөлөл орж ажилласан болохыг дурдах нь зүйтэй.

Дээр дурдсаныг үндэслэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3, 13, 17 дахь заалт, Арван

долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин есдүгээр зүйлийн 1 хэсгийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр Танд уламжилж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог нь уг ажиллагаанд удирдлага болгодог тусгай зарчим болох диспозитив буюу иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг зохигчдын санаачилга, хүсэлтийн үндсэн дээр явуулах болон мэтгэлцэх зарчимд үндэслэдэг явдал юм.

Дээрх зарчмуудын агуулга нь зохигчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэх, төгсгөх асуудлаа бие даан чөлөөтэй хэрэгжүүлэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрхээ эдлэх эсэхээ өөрийн хүсэл сонирхол, санаачилгаараа шийдэх, нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлага, маргааны үйл баримт, хариуцагчийн гэм бурууг нотолж, татгалзлыг үгүйсгэх, хариуцагч нэхэмжлэгчийн шаардлагыг татгалзах, түүнийхээ үндэслэлийг нотлох үүрэгтэй байдагт оршино. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаархи нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.” хэмээн дээрх зарчмыг хуульчилсан байна.

2. Хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт нь төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой; өөр улс, орон нутагт байгаа учраас зохигч тэдгээрийг өөрөө олж авах боломжгүй; түүнчлэн туршилт, үзлэг, таньж олуулах, шинжилгээ хийлгэх, гэрчийн мэдүүлэг авах тохиолдолд нотлох баримтыг хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүх бүрдүүлдэг ба зохигч аль нэг талын хүсэлтээр эсрэг талаас нотлох баримтыг шүүх албадан гаргуулж болохоор хуульд заасан.

Харин хэргийн үйл баримтыг иргэний хэргийн шүүх өөрийн санаачилгаар тогтоохгүй бөгөөд талуудын зүгээс шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтыг хөндлөнгийн байр сууринаас шинжлэн судалж маргааныг шийдвэрлэдэг.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчид нотлох баримт гаргах, цуглуулах, тайлбараа өгөх зэргээр тэгш эрхтэй оролцдог. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг үүсгэсэн шүүгчийн заавал явуулах ажиллагаанд хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийн талаар холбогдох байгууллагаас тодорхойлолт, лавлагаа авахаар заасан нь шүүгч өөрөө нотлох баримт бүрдүүлэхийг үүрэгжүүлсэн гэж үзэхээр байна.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар өөрчлөлт оруулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн заалт нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зарчим болон зохигчдын тэгш эрхийн зарчмыг алдагдуулж байгаагаараа Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх заалтууд нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3, 13, 17 дахь заалт, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлээр нэмэлт, өөрчлөлт оруулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалтад “хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийн талаар холбогдох байгууллагаас

тодорхойлолт, лавлагаа авах.”, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэгт “... Энэ хуулийн 67.1.5-д заасан тодорхойлолт, лавлагааг үндэслэн төлбөр гаргуулах хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийг тодорхой тусган, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчсөн байна.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн холбогдох заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... хөрөнгө чинээ, …-ээр нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;”, мөн зүйлийн 13 дахь заалтад “... Иргэний хувийн ... нууц ...-ыг хуулиар хамгаална.”, мөн зүйлийн 17 дахь заалтад “... төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;”, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;”, Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. ...”, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалтад “хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийн талаар холбогдох байгууллагаас тодорхойлолт, лавлагаа авах.”, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэгт “... Энэ хуулийн 67.1.5-д заасан тодорхойлолт, лавлагааг үндэслэн төлбөр гаргуулах хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийг тодорхой тусган, ...” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 2 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ Д.СУГАР
ГИШҮҮД Н.ЧИНБАТ
Д.НАРАНЧИМЭГ
Д.СОЛОНГО
Д.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2018.02.08 Дугаар 19 Төрийн ордон,
Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны
02 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлээр нэмэлт, өөрчлөлт оруулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалтад “хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийн талаар холбогдох байгууллагаас тодорхойлолт, лавлагаа авах.”, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэгт “... Энэ хуулийн 67.1.5-д заасан тодорхойлолт, лавлагааг үндэслэн төлбөр гаргуулах хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийг тодорхой тусган, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 02 дугаар сарын 02-ний өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.02.28 Дугаар 03 Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 17.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан, Т.Лхагваа, Д.Сугар /илтгэгч/, Д.Солонго нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Ч.Жадамба, Р.Очирбал, Ж.Онон, Н.Нямжаргал болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Д.Цогтбаатар нар оролцсон болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт, Дөчин тавдугаар зүйлийн 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Ч.Жадамба, Баянгол дүүргийн 13 дугаар хорооны оршин суугч, иргэн Р.Очирбал нар Үндсэн хуулийн цэцэд хандаж дараахь агуулга бүхий мэдээлэл гаргасан байна:

“1. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолын 1 дэх заалтад “Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалт, ...-ийг зөрчиж ... төрийн давуу эрхэд хууль бусаар халдсан ...”, мөн тогтоолын 4 дэх заалтад “Хууль тогтоомж удаа дараа зөрчсөн Монголбанк, Засгийн газар, Худалдаа хөгжлийн болон Улаанбаатар хотын банкны удирдах ажилтнуудад холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахыг ... даалгасугай.” гэж тус тус заасан нь Үндсэн хууль зөрчсөн.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолын 4 дэх заалтад “Хууль тогтоомж удаа дараа зөрчсөн Монголбанк, Засгийн газар ... Худалдаа хөгжлийн болон Улаанбаатар хотын банкны удирдах ажилтнуудад холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахыг ... даалгасугай.” гэж заасан нь Банкны тухай хууль бусад хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа арилжааны банк, түүний удирдлагын хууль зөрчсөн эсэх асуудлыг Банкны тухай хуульд “шүүх эцэслэн шийдвэрлэх”-ээр тодорхой заасан байхад шүүх байгууллагын эцсийн шийдвэргүйгээр зөрчсөн эсэх асуудлыг Улсын Их Хурал тогтоож байгаа тул Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчиж байна.

2. Монгол Улсын Их Хурлын 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “... “Монголиан Коппер Корпорейшн” ХХК-д шилжсэн ... хувьцааг төрийн өмчлөлд шилжүүлэн авах асуудлыг яаралтай шийдвэрлэж, төрийн өмчит үйлдвэрийн статустайгаар ажиллуулах арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүйн байнгын хороо /Ш.Раднаасэд/, Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.” гэж заасан нь Үндсэн хуульд заасан өмчлөх эрхийг зөрчиж байна. Тодруулбал, уг заалт нь Иргэний хуулийн үндсэн зарчмыг зөрчин, бодит байдал дээр халдсан үйлдэл хийсэн эсэхээс үл хамаарч өмчлөгчийн туйлын эрхэд түүний зөвшөөрөлгүй халдах эрх зүйн үндсийг бий болгосон нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн

2 дахь хэсэгт “Төр нь ... хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... хөрөнгө ... эзэмших, өмчлөх, ... эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. ...” гэж заасныг болон Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн байна.

Улсын Их Хурал нь 2017 оны 23 дугаар тогтоолоороо Засгийн газар Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж зөрчсөн, хувийн аж ахуйн нэгж, хувь хүмүүс мөн хууль тогтоомж удаа дараа зөрчсөн, гэм буруутай болохыг хуульд заасан эрх бүхий байгууллага тогтоогоогүй байхад Үндсэн хуулийн цэц, шүүхийн эрх мэдлийг хэрэгжүүлж, хариуцлага хүлээлгэхийг даалгасан болон Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олсон өмчлөгчийн туйлын эрхэд ноцтой халдсан нь Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоож, тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

Хоёр. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Ж.Онон Үндсэн хуулийн цэцэд хандаж дараахь агуулга бүхий мэдээлэл гаргасан байна:

“Монгол Улсын Их Хурлын 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолын 2 дахь заалтын “... шилжсэн ... энгийн хувьцааг ... төрийн өмчид шилжүүлэн авах ...” гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “... хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно ...” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэж байна. Яагаад гэвэл, шударгаар олж авсан эсэхийг шударга шүүх тогтоогоогүй байхад шүүгч биш хүмүүс хууль бус гэж үзсэнийг үндэслэл болгон хувийн өмчийг төрд шилжүүлэн авах тухай шийдвэр гаргасан байна.

Энэ тогтоолын 3 дахь заалтын “... энгийн хувьцааг ... Хөгжлийн банк болон Монголбанкнаас Худалдаа хөгжлийн банкинд байршуулсан ... эх үүсвэрээс суутган тооцож төрийн өмчид авах ...” гэсэн нь харилцах дансны мөнгөн хөрөнгөөс шүүхийн шийдвэргүйгээр суутган тооцоо хийх агуулга илэрхийлж байна. Энэ нь банкны тухай хууль, журам зөрчинө.

Энэ тогтоолын 2, 3, 4 дэх заалтад “... даалгасугай.” гэж зааж нэлээдгүй даалгавруудыг холбогдох этгээдүүдэд өгчээ. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө,

тэгш байдал ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн гэж үзэж байна. Учир нь, логикийн хувьд алдаатай, холбогдох хууль, журмуудыг зөрчсөн даалгаврууд ыг албадлагын шинжтэйгээр хамаарал бүхий этгээдүүддээ өгөхийг Үндсэн хуулийн үндсэн зарчмаар хориглодог билээ.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолд туссан 1, 2, 3, 4 дэх заалтын “... давуу эрхэд хууль бусаар халдсан байх тул ...”, “... шилжсэн ... энгийн хувьцааг ... төрийн өмчид шилжүүлэн авах ...”, “... энгийн хувьцааг ... Хөгжлийн банк болон Монголбанкнаас Худалдаа хөгжлийн банкинд байршуулсан ... эх үүсвэрээс суутган тооцож төрийн өмчид авах ... ”, “... даалгасугай.” гэсэн хэсгүүд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно ...”, Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг тус тус зөрчсөн болохыг тогтоож өгнө үү.” гэжээ.

Гурав. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 16 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Нямжаргал Үндсэн хуулийн цэцэд хандаж дараахь агуулга бүхий мэдээлэл гаргасан байна:

“Монгол Улсын Их Хурал ““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолыг гаргахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг худалдаж авах төрийн давуу эрхэд хууль бусаар халдсан хэмээн тогтоолын 1 дэх заалтаар Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 330 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болгож, 2 дахь заалтаар Оросын Холбооны Улсын Засгийн газрын эзэмшлээс “Монголиан Коппер Корпорейшн” ХХК-д шилжсэн “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг төрийн өмчид шилжүүлэн авах асуудлыг яаралтай шийдвэрлэж, төрийн өмчит үйлдвэрийн газрын статустайгаар ажиллуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Ш.Раднаасэд/, Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь

хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;”, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 330 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9 дэх заалтад заасан үндсэн бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газраас гаргасан тогтоолд хамаарах учир үүнийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, соёрхон батлуулах шаардлагагүй байснаас гадна уг тогтоол нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалтыг зөрчөөгүй. Тиймээс уг тогтоолыг Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүчингүй болгох нь үндэслэлгүй юм.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааны эзэмшилд халдахын тулд хуультай байх ёстой, тэрхүү хууль нь шударга ёсонд нийцсэн байх ёстой. Гэтэл Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолд хэдийгээр хэлцэл хийх замаар хувьцааны эзэмшлийг төрийн өмчид шилжүүлнэ гэж байгаа боловч төрийн дур зоргоор өмчлөгчийн хүсэл зоригийн эсрэг, өмчийн хэлбэрийг өөрчилж, хувийн өмчийг төрийн өмчид шилжүүлж байгаа нь Үндсэн хуулиар баталгаажуулсан ардчилсан ёсны хамгийн чухал элемент, хүний үндсэн эрх, эрх чөлөөний үндэс, суурь болсон хувийн өмч, өмчлөх эрхэд халдсан явдал мөн. Хувийн өмчийг дайчлах нийгмийн зайлшгүй хэрэгцээ үүсээгүй учраас Улсын Их Хурал ямар ч үндэслэлгүйгээр хувийн өмчийг хураан авахаар шийдвэрлэсэн нь Үндсэн хуулиа зөрчиж байна.” гэжээ.

Дөрөв. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Д.Цогтбаатар нар Үндсэн хуулийн цэцэд дараахь агуулга бүхий тайлбар гаргасан байна:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд зааснаар Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн нэг болох хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаар соёрхон баталсан Оросын Холбооны Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Олон улсын гэрээний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгасан болно.

Шалгалтын явцад Засгийн газар 2016 оны “Эрдэнэт үйлдвэр” ХХК, болон “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 330 дугаар тогтоолыг батлахдаа Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдлоо:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалтад зааснаар Улсын Их Хурал Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.

2. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээг цуцлах тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

3. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын байгуулсан хэлэлцээрийн 17 дугаар зүйлийн “... Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь Үйлдвэрийн өөрийн хөрөнгө дахь хувь хөрөнгөө зохих журмын дагуу нөгөө Хэлэлцэн тохирогч талтайгаа зөвшилцсөнөөр бусад Улс, хуулийн этгээдэд худалдах, ... эсхүл хувьчилж болно. Энэ тохиолдолд нөгөө Хэлэлцэн тохирогч Тал нь худалдан авах давуу эрхтэй байна.” гэж заасан байна. Өөрөөр хэлбэл, дээрх заалтын дагуу Хэлэлцэн тохирогч Талууд буюу Оросын Холбооны Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондоо зөвшилцөхөөр байна. Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын “Ростех”

корпорациас ирүүлсэн албан бичгийг үндэслэн уг асуудлыг хэлэлцсэн нь хэлэлцээрийн холбогдох заалтад нийцэхгүй байна.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад “Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байна.”, Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт “... төрийн өмчит компанийн хувьд өмчлөгч нь төрийг төлөөлж Улсын Их Хурал ... байх бөгөөд тэдгээрийг төлөөлж хувьцаа эзэмшигч нь Засгийн газар ... байж болно.” гэж заасныг үндэслэн дээр дурдсан компаниудын хувьцааны 49 хувийг төр өөрөө эзэмших үү, хувийн хэвшлийн хуулийн этгээдэд эзэмшүүлэх үү гэдэг асуудлыг төрийн өмчийн өмчлөгчийн хувьд Улсын Их Хурал шийдэхээр байна.

5. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтад зааснаар хэлэлцэх асуудлын төсөл нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлигт нийцсэн, гүйцэд боловсрогдсон, зохих тооцоо, холбогдох яамны виз /санал/-ээр нотлогдсон байх бөгөөд мөн хэсгийн 7 дахь заалтад “хариуцсан гишүүний зөвшөөрсөн төсөл, түүний үндэслэлийг Хэрэг эрхлэх газрын дарга Ерөнхий сайдад танилцуулж, түүний зөвшөөрснөөр нийт гишүүнд уг асуудлыг хэлэлцэхээс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө гардуулсан байвал зохино.” гэж заасан. Гэтэл Засгийн газрын хуралдааны 2016 оны 33 дугаар тэмдэглэл болон Засгийн газраас шалгалтын явцад Улсын Их Хуралд ирүүлсэн албан ёсны материалаас үзэхэд Засгийн газар нь уг асуудлыг хуралдаанаараа хэлэлцэхдээ Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дээрх заалтуудыг зөрчсөн байсан болно.

6. Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 2 дахь заалтын “Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр ашиглаж байгаа Эрдэнэтийн зэс-молибдений ... ордын одоогийн ашиглаж байгаа нөхцөлийг хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзсүгэй.” гэсэн заалт мөн л хүчинтэй байхад Засгийн газар түүнийг зөрчсөн байна.

Иймд Засгийн газар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол-Оросын “Монголросцветмет” ХХК-ийн үйл ажиллагааны тухай 2007 оны хэлэлцээрийг дээр дурдсан байдлаар зөрчсөн гэж үзэж Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын

2016 оны 330 дугаар тогтоолын 1 дэх заалт Монгол Улсын хууль тогтоомжид нийцээгүй тул хүчингүй болгож, мөн Оросын Холбооны Улсын Засгийн газрын эзэмшлээс “Монголиан Коппер Корпорейшн” ХХК-д шилжсэн “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг төрийн өмчид шилжүүлэн авах асуудлыг шуурхай шийдвэрлэж, төрийн өмчит үйлдвэрийн газрын статустайгаар ажиллуулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасан болно.

Дээр дурдсаныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын ““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй.” гэсэн байна.

Мөн 2018 оны 2 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн нэмэлт тайлбартаа:

“Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааны тухай 2003 оны хэлэлцээр болон “Монголросцветмет” ХХК-ийн үйл ажиллагааны тухай 2007 оны хэлэлцээр нь Монгол Улсын Их Хурлаар батлагдсан бөгөөд эдгээр гэрээнүүдийг цуцлах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцээгүй болохыг мэдэгдье. Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар нь эдгээр гэрээний “Талууд” бөгөөд Монгол Улсын Төрийн өмчийн хороо, Оросын Холбооны Улсын “Ростех” корпораци нь тус гэрээний Талуудын “хувьцаа эзэмшигч” байхаар дээр дурдсан гэрээнүүдэд тус тус заасан.

Гэтэл Оросын Холбооны Улсын Засгийн газар гэрээний “Тал” болохын хувьд Монгол Улсын Засгийн газарт албан ёсоор хандаагүй байхад зөвхөн Оросын Холбооны Улсын хувьцааг эзэмшигч болох “Ростех” улсын корпорацийн захирал С.В.Чемезовын албан бичгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газар дээрх 49 хувийг худалдан авах давуу эрхээсээ 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдөр татгалзаж “Монголиан Коппер Корпорейшн” ХХК-д худалдахыг зөвшөөрсөн байна. Өөрөөр хэлбэл, Оросын Холбооны Улсын Засгийн газрыг төлөөлөх, Монгол Улсын Засгийн газартай харилцах эрхгүй этгээдийн саналыг үндэслэн энэхүү шийдвэрийг гаргасан байна.

Дээрх шийдвэрийг гаргасан Засгийн газрын 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанд Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирал О.Орхон, тус банкны зөвлөх Ц.Пүрэвтүвшин нар оролцож, уг асуудлаар тайлбар хэлж, асуултад хариулж байсан талаар Засгийн газрын хуралдааны протоколд тэмдэглэгдсэн байдаг.

Түүнчлэн, Оросын Холбооны Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газрын төвшинд уг асуудлаар ямар нэгэн шийдвэр гараагүй байхад буюу "Монголиан Коппер Корпорейшн" ХХК 2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр дүрмийн сангаа 12 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, Улаанбаатар хотын банк дахь данснаас 5,02 сая ам.долларыг Оросын Холбооны Улсын Альфа банкинд шилжүүлж, худалдан авах ажиллагааг эхлүүлсэн байдаг. Энэхүү 5.02 сая ам.доллар төлбөрт тооцогдсон баримт байгаа болно.

"Кью-Эс-Си", "Рийверстон", "Юнайтед энержи систем", "Канетик" компаниуд 2016 оны 6 дугаар сард тус бүрдээ Худалдаа хөгжлийн банкнаас их хэмжээний ам.долларын зээл авангуут шууд "Монголиан Коппер Корпорейшн" ХХК-д дамжуулан зээлдсэн, нөгөө талаар зээлийн гэрээ нь үг, үсгийн зөрөөгүй нэг ижил загвараар үйлдэгдсэн, ямар ч баталгаагүйгээр их хэмжээний ам.долларын зээл олгосон зэргээс үзэхэд халхавч баримт бичиг болох нь тодорхой байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл, төлбөрт шилжүүлсэн гэх дээрх 400.27 сая ам.доллар нь Д.Эрдэнэбилэг гэгч эзэнтэй Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар хотын банкнаас эдгээр банкны гол хувьцаа эзэмшигчийн, эсхүл түүний шууд удирдлагад ажилладаг хүмүүсийн нэр дээр үүсгэн байгуулсан компаниудад халхавчийн гэрээ, барьцаагүйгээр олгосон зээл байна.

Банкны хууль тогтоомжийн үндсэн зарчим, хуулийн тодорхой заалтыг Худалдаа хөгжлийн банк болон Улаанбаатар хотын банк, түүний гол хувьцаа эзэмшигчид зөрчсөн болно. Тухайлбал:

1. Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлд банкны хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээж байхаар заасан. Худалдаа хөгжлийн банк нь 745.0 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, 50.0 тэрбум төгрөгийн дүрмийн сантай, хувьцааных нь 93.1 хувийг Д.Эрдэнэбилэг эзэмшдэг. Гэтэл энэ банк зөвхөн "Эрдэнэт үйлдвэр" болон "Монголросцветмет" ХХК-ийн 49 хувийн төлбөрт тухайн үеийн ханшаар 400.27 сая ам.доллар буюу 900.2 тэрбум төгрөгийн зээл буюу гол хувьцаа эзэмшигчийн хариуцлага хүлээх хэмжээнээс давсан зээл олгосон байна.

Энэхүү 400.27 сая ам.долларын зээл олгохдоо Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн "... нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ тухайн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй ..." гэснийг зөрчөөгүй гэж харагдуулахын тулд Д.Эрдэнэбилэг болон түүний шууд удирдлагад ажилладаг ажилтнууд /Банкны тухай хуульд эдгээрийг "холбогдох этгээд" гэж тодорхойлсон/- ын нэр дээр байгуулсан компаниудад халхавч гэрээ байгуулж, 68-70 сая ам.долларын зээл олгож, эдгээр нь "Монголиан Коппер Корпорейшн" ХХК-д шилжүүлсэн байна.

2. Худалдаа хөгжлийн банк нь "Монголиан Коппер Корпорейшн" ХХК-д зээл олгохдоо Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг барьцаалж, дараа нь Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирал О.Орхон "Монголиан Коппер Корпорейшн" ХХК-ийг төлөөлж "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болсон нь Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт /холбогдох этгээд/- ыг зөрчсөн байна.

"Эрдэнэт үйлдвэр" ХХК болон "Монголросцветмет" ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг Монгол Улсын Засгийн газар худалдан авах эсэх тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн нь доор дурдсан хууль тогтоомжийг зөрчсөн байна. Үүнд, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6, 7 дахь заалт, "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын болон Оросын Холбооны Улсын Засгийн газрын хооронд байгуулсан хэлэлцээр, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын "Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" 2007 оны 27 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны "Журам шинэчлэн батлах тухай" 03 дугаар тогтоол зэрэг хууль тогтоомжийг зөрчсөн болохыг Танд үүгээр уламжилж байна." гэжээ.

Тав. Уг маргааныг шалгах явцад Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Гадаад харилцааны яам, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, "Монголиан Коппер Корпорейшн" ХХК, Оюуны

өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас холбогдох тайлбар, баримт бичиг гаргуулан авч, Монгол Улсын Их Хурлын архив дахь "Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоол"-ын хувийн хэрэгтэй танилцсан болно. Тухайлбал, Ерөнхий сайд Ч.Сайханбилэгт 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлсан хэлэлцээрийг зөвхөн хуулиар л өөрчлөх, "Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Монголросцветмет" ХХК-ийн 49 хувьтай тэнцэх хөрөнгийг хувьчлах эсвэл хувьчлах хөрөнгийн жагсаалтад оруулахыг Улсын Их Хурлаар шийдвэрлэх, Оросын Холбооны Улсын "Ростех" корпораци саналаа дипломат шугамаар ирүүлэх ёстой гэсэн зөвлөмжийг хүргүүлж байсан байна.

ШИЙДВЭРИЙН ҮНДЭСЛЭЛ:

1.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар хоорондын Монгол-Зөвлөлтийн хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийг байгуулах тухай хэлэлцээрт анх 1973 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн дарга гарын үсэг зуржээ. Энэхүү хэлэлцээрийн 20 дугаар зүйлд хэлэлцэн тохирогч хоёр этгээд Засгийн газрын төвшинд зөвшөөрснөөр тус хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан байна.

2.Монгол-Оросын "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн үйл ажиллагааны тухай 2003 оны хэлэлцээрийн 16 дугаар зүйл, Монгол-Оросын "Монголросцветмет" ХХК-ийн үйл ажиллагааны тухай 2007 оны хэлэлцээрийн 20 дугаар зүйлд хэлэлцээр хүчин төгөлдөр болоход шаардагдах өөрийн улсын дотоодын журмыг гүйцэлдүүлсний дараа бичгээр сүүлчийн мэдэгдэл хэлэлцэн тохирогч нөгөө талдаа өгснөөр хүчин төгөлдөр болохоор зааж, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудлыг мөн энэ журмаар гүйцэтгэхээр байна.

3.Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын дээрх хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын дараахь хуулиудын зохицуулалт хамаарахаар байна. Үүнд:

а)"Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Монголросцветмет" ХХК-ийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газрын хооронд байгуулсан хэлэлцээрийг Монгол Улсын Их Хурал 2004 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр, 2009 оны 01 дүгээр

сарын 16-ны өдөр тус тус хууль гарган соёрхон баталсан байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалтад Улсын Их Хурал "... Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах ..." асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ", Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээг ... цуцлах ... тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ." гэж тус тус заажээ. Иймд Монгол Улсын Засгийн газар дээрх хэлэлцээрийн нэг тал болохын хувьд хэлэлцээрийг цуцлах үр дагавартай асуудлаар урьдчилж дотоодын хууль тогтоомж буюу Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн холбогдох заалтыг биелүүлсний дараа саналаа өгөхөөр байна.

б) Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдөр баталсан "Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" 27 дугаар тогтоолын 2-т "... Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр ашиглаж байгаа Эрдэнэтийн зэс-молибдений ... ордын одоогийн ашиглаж байгаа нөхцөлийг хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзсүгэй." гэсэн заалт хүчин төгөлдөр байгаа тул уг заалтыг хүчингүй болгох эрх хэмжээ зөвхөн Улсын Их Хуралд хадгалагдаж байна.

4.Оросын Холбооны Улсын өндөр технологийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн бүтээх, үйлдвэрлэх, экспортлох ажиллагааг дэмжих "Ростех" улсын корпорацийн "Эрдэнэт үйлдвэр" ХХК болон "Монголросцветмет" ХХК-д эзэмшиж буй 49 хувийн энгийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхээ ашиглан төрийн мэдэлд авах, эсвэл өөр этгээдэд шилжүүлэх тухай шийдвэр гаргах эрх нь гагцхүү Улсын Их Хуралд байна.

5.Монгол Улсын Их Хурлаас нэгэнт соёрхон баталсан олон улсын гэрээг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэлгүй, зөвшилцөлгүйгээр өөрчилсөн Засгийн газрын 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 330 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9 дэх заалт, Олон улсын гэрээний тухай хуулийн (тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан) 18 дугаар зүйлийн 2, 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэхээр байна.

6.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт Засгийн газрын тогтоол, захирамж хууль тогтоомжид нийцээгүй

бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно гэж заасны дагуу Засгийн газрын 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 330 дугаар тогтоолыг Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолоор хүчингүй болгосон нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарч байна.

7.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад Монгол Улсын иргэн "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. ..." гэж заасан билээ. Аливаа хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг хуулийн дагуу эсвэл хууль зөрчигдсөнийг мэдээгүй, эсвэл хууль зөрчигдөж байгааг мэдэх бололцоогүй байсан нөхцөлд л шударгаар олж авсанд тооцох боломжтой. Гэтэл Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс үзэхэд "Монголиан Коппер Корпорейшн" ХХК-ийн төлөөлөл гэх Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирал О.Орхон "... хуулиар бол энэ гэрээг баталсан, энэ гэрээ нь өөрөө өөрийгөө хүчингүй болгох ийм заалттай учраас дахиж энийг оруулах, соёрхон батлуулах зөвшөөрөл шаардлагагүй гэж бид үзэж дүгнэлтээ гаргаж байгаа. ..." гэж байсан нь хуулийн шаардлагыг урьдаас мэдэж байсныг харуулж байна.

Түүнчлэн, Оросын Холбооны Улсын "Ростех" корпораци болон "Монголиан Коппер Корпорейшн" ХХК-ийн хооронд 2016 оны 6 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан "Худалдах, худалдан авах гэрээ"-нд Худалдан авагч нь урьдчилгаа төлбөрийг 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс өмнө төлсөн байхаар, мөн 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хувьцаа худалдах, худалдан авах тухай толгой гэрээг байгуулсан тухай тусгасан байгаа нь Монгол Улсын эрх бүхий байгууллага давуу эрхээсээ татгалзсан шийдвэр гаргахаас өмнө хэлцэл хийж байсныг нотолж байна.

8.Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хууль болон бусад хуулийн холбогдох заалтыг зөрчсөн шийдвэрийг үндэслэл болгон хийсэн хэлцлээр шилжүүлсэн өмчлөлийн зүйлийн хувийн өмчийн эрх холбогдох этгээдэд шударгаар үүссэн гэж үзэх, энэхүү эрхийг хамгаалах хууль зүйн хангалттай үндэслэл бүрдээгүй байна.

9.Иргэн Ч.Жадамба, Р.Очирбал, Ж.Онон, Н.Нямжаргал нарын Монгол Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1,

Дөчин долдугаар зүйлийн 1, 2, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн тухай мэдээллийн шаардлагаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс Цэцийн гишүүн 2017 оны 103 дугаар тогтоолоор татгалзсаныг дурдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын ““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь ... хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;”, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

2.“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг төрийн мэдэлд авсан тохиолдолд “Монголиан Коппер Корпорейшн” ХХК-ийн Оросын Холбооны Улсын “Ростех” корпорацид уг 49 хувийн энгийн хувьцааг авахад зарцуулсан төлбөрийг төлж барагдуулах үүрэгтэйг дурдсугай.

3.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Д.ОДБАЯР
ГИШҮҮД	Н.ЖАНЦАН
	Т.ЛХАГВАА
	Д.СУГАР
	Д.СОЛОНГО

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.04.06 Дугаар 04 Улаанбаатар хот

Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамж Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 14.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан, Т.Лхагваа /илтгэгч/, Ш.Цогтоо, Н.Чинбат нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Б.Сүхбат хүрэлцэн ирээгүй бөгөөд Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч У.Бямбасүрэн, Ч.Дондогмаа нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамж нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Дөчин

нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэж заасныг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 2 дугаар багийн оршин суугч, иргэн Б.Сүхбатаас Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ. Үүнд:

“Монгол Улсын Ерөнхий сайд асан Ж.Эрдэнэбат 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдөр “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамжаар Лхагвасүрэнгийн Ганболдыг Хөвсгөл аймгийн Засаг даргаар томилжээ. Гэвч Засаг даргаар томилогдсон Л.Ганболдын төрийн албанд ажилласан байдал нь тогтоогдохгүй байгаа бөгөөд “Лидеркашемир” ХХК болон Монгол Ардын Намын хороонд ажиллаж байсан нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйл 26.5.2 дахь заалтад Засаг даргад нэр дэвшигч нь “төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх” гэсэн хуулийн шаардлагыг хангахгүй байна.

Тодруулбал, Л.Ганболдыг төрийн албанд огт ажиллаагүй байхад, дээрх хуулийг зөрчин Ерөнхий сайд 2016 оны 12 дугаар захирамжийг гаргасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн эсэхийг тогтоож өгнө үү” гэжээ.

Хоёр. Уг мэдээллийг урьдчилан шалгах ажиллагааны явцад холбогдох тайлбар, нотлох баримтыг Монгол Улсын Ерөнхий сайд болон Төрийн албаны зөвлөлөөс гаргуулсан болно.

Гурав. ***Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 19 дүгээр захирамжаар томилогдсон Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Ариунболдоос Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд ... дөрвөн жилийн хугацаагаар томилно.” гэж заасан. Мөн Монгол

Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт "...аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын төлөөлөгч тус тус нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг Хурлын хуралдаанд оролцсон иргэд, төлөөлөгчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгоно.", мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Энэ хуулийн 26.2-т заасан журмаар нэр дэвшүүлсэн бол аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд 4 жилийн хугацаагаар томилох ..." гэж тус тус хуульчилсны дагуу Ерөнхий сайд 2016 оны 12 дугаар захирамжаараа Л.Ганболдыг Хөвсгөл аймгийн Засаг даргаар томилсон.

Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Ганболд нь 2009-2013 онд Хөвсгөл аймгийн Засаг даргын орон нутгийн бодлогын зөвлөхөөр, 2013-2016 онд Хөвсгөл аймгийн Монгол Ардын Намын хорооны даргаар ажиллаж байсан. Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.14 дэх заалтад зааснаар улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаал нь төрийн албаны улс төрийн албан тушаалд хамаардаг тул Л.Ганболдын 2009-2013 онд Хөвсгөл аймгийн Засаг даргын орон нутгийн бодлогын зөвлөхөөр ажилласан хугацаа нь төрийн алба хаасан хугацаанд хамаарч байна.

Мөн Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлд "Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан иргэн төрийн албанд шилжин ажиллавал намын байгууллагад ажилласан дээрх хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцно" гэж заасан. Засаг дарга Л.Ганболдын 2013-2016 онд Хөвсгөл аймгийн Монгол Ардын Намын хорооны даргаар ажилласан хугацаа нь дээрх хуулийн үндэслэлийн дагуу төрийн албанд ажилласан хугацаанд тооцогдож байна.

Түүнчлэн Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Л.Ганболдыг Засаг даргад нэр дэвшүүлсэн тогтоолыг Монгол Улсын Ерөнхий сайдад албан ёсоор ирүүлэхдээ Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн 2016 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 3/1495 дугаартай албан бичгийг хавсарган ирүүлсэн бөгөөд уг албан бичигт "Л.Ганболдын намын байгууллагад ажилласан жилийг 1995 оны Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн

6 дугаар зүйлд заасны дагуу төрийн албанд ажилласнаар тооцож болно” гэж дурдсан байна.

Л.Ганболдын дээр дурдсан ажилласан байдлаас үзэхэд түүний төрийн албанд ажилласан хугацаа 7 жил байх бөгөөд тэрээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсэгт заасан Засаг даргад нэр дэвшигч нь “төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх” шаардлагыг хангасан тул Ерөнхий сайд “Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай” Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 08 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд түүнийг Хөвсгөл аймгийн Засаг даргаар томилсон болно.

Дээр дурдсан нөхцөл байдал, холбогдох бичиг баримтыг үндэслэн гаргасан “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар захирамж нь хууль зүйн үндэслэлтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй болно.” гэжээ. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар захирамжаар Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Ерөнхий сайдыг төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн, референт Ч.Дондогмаа нарыг томилсон байна.

Дөрөв. Мэдээлэл гаргагч, иргэн Б.Сүхбат 2018 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Миний бие Б.Сүхбат нь Монгол Улсын Ерөнхий сайд асан Ж.Эрдэнэбатын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдөр “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамж гарган Хөвсгөл аймгийн Засаг даргаар Л.Ганболдыг томилсон нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж мэдээлэл гаргаж, уг мэдээллийн дагуу Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 13 дугаар тогтоолоор маргаан үүсгээд явж байгаа билээ.

Б.Сүхбат миний бие Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу гаргасан мэдээллийн шаардлагаасаа бүхэлд нь татгалзаж байна.” гэсэн хүсэлт ирүүлсэн болно.

ҮНДЭСЛЭЛ:

1. Иргэн Б.Сүхбат 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Хөвсгөл аймгийн Засаг даргаар Л.Ганболдыг хуулийн шаардлага хангаагүй байхад томилсон гэсэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн агуулгатай мэдээллийг Үндсэн хуулийн цэцэд хандан гаргасан болно.

Үндсэн хуулийн цэцэд уг мэдээллийн дагуу маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн шалгаад 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдөр Дунд суудлын хуралдааныг зарлан хуралдуулахад Б.Сүхбат нь уг хуралдаанд заавал биечлэн оролцох хүсэлт гарган хойшлуулсан болно. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг дахин 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр зарлан хуралдуулахад иргэн Б.Сүхбат Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээллээсээ бүхэлд нь татгалзах хүсэлт гаргаад, татгалзсан шалтгаанаа Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирж тайлбарлах байсан боловч уг хуралдаанд хүрэлцэн ирээгүй болно.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Цэц Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн заалттай харшлаагүй бусад хуулийн заалтыг удирдлага болгож болно.” гэж заасныг үндэслэн 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас батлсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хэрэг үүсгэснээс хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглоно.” гэсэн заалтыг Цэцийн дунд суудлын хуралдаан хэрэглэж болно гэж үзэн хуралдааныг үргэлжлүүлэн явуулахаар шийдвэрлэсэн болно.

2. Иргэн Л.Ганболд нь 2009-2013 оны хооронд Аймгийн Засаг даргын орон нутгийн бодлого хариуцсан зөвлөхөөр ажилласан гэх хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулаагүй буюу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2 дахь заалтад заасан “төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан” байх гэсэн шаардлагыг хангаагүй болох нь Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 506 дугаар шийдвэрээр тогтоогдсон байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 1995 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын

тухай хуулийн 7 дугаар зүйлд “Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж заасан байх ба дээрх зүйлд заасан 1994 оны Төрийн албаны тухай хууль нь 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн Төрийн албаны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиар хүчингүй болсон байна.

Л.Ганболдын 2013-2016 онуудад Хөвсгөл аймгийн Монгол Ардын Намын хорооны даргаар ажиллаж байсан хугацааг 1995 оны Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийг баримтлан төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцох хууль зүйн үндэслэлгүй болно.

4. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2 дахь заалтад заасан Засаг даргад нэр дэвшигч нь төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх гэсэн хуулийн шаардлага хангаагүй хүнийг Засаг даргаар томилсон Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Харин Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамжийн 1 дэх заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Д.ОДБАЯР
ГИШҮҮД	Н.ЖАНЦАН
	Т.ЛХАГВАА
	Ш.ЦОГТОО
	Н.ЧИНБАТ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2018.04.19 Дугаар 25 Төрийн ордон,
Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны
04 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамжийн 1 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2018.06.15 Дугаар 02 Улаанбаатар хот

Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамж Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 16.15 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Цэцийн дарга Д.Одбаяр даргалж, гишүүн Н.Чинбат, Д.Ганзориг, Ш.Цогтоо /илтгэгч/, Д.Солонго, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү, Ш.Солонго, Ц.Нанзаддорж нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар О.Мөнхзулыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан болон Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч.Дондогмаа нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамж нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан эцэслэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 25 дугаар тогтоолын үндэслэлийг хянан хэлэлцэв.

Нэг. ***Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 2 дугаар багийн оршин суугч, иргэн Б.Сүхбатаас Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ. Үүнд:***

“Монгол Улсын Ерөнхий сайд асан Ж.Эрдэнэбат 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдөр “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамжаар Лхагвасүрэнгийн Ганболдыг Хөвсгөл аймгийн Засаг даргаар томилжээ. Гэвч Засаг даргаар томилогдсон Л.Ганболдын төрийн албанд ажилласан байдал нь тогтоогдохгүй байгаа бөгөөд “Лидеркашемир” ХХК болон Монгол Ардын Намын хороонд ажиллаж байсан нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйл 26.5.2 дахь заалтад Засаг даргад нэр дэвшигч нь “төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх” гэсэн хуулийн шаардлагыг хангахгүй байна.

Тодруулбал, Л.Ганболдыг төрийн албанд огт ажиллаагүй байхад, дээрх хуулийг зөрчин Ерөнхий сайд 2016 оны 12 дугаар захирамжийг гаргасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн эсэхийг тогтоож өгнө үү.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 19 дүгээр захирамжаар томилогдсон Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд ... дөрвөн жилийн хугацаагаар томилно.” гэж заасан. Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт “... аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын төлөөлөгч тус тус нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг Хурлын хуралдаанд оролцсон иргэд, төлөөлөгчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгоно.”, мөн зүйлийн 3

дахь хэсэгт “Энэ хуулийн 26.2-т заасан журмаар нэр дэвшүүлсэн бол аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд 4 жилийн хугацаагаар томилох ...” гэж тус тус хуульчилсны дагуу Ерөнхий сайд 2016 оны 12 дугаар захирамжаараа Л.Ганболдыг Хөвсгөл аймгийн Засаг даргаар томилсон.

Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Ганболд нь 2009-2013 онд Хөвсгөл аймгийн Засаг даргын орон нутгийн бодлогын зөвлөхөөр, 2013-2016 онд Хөвсгөл аймгийн Монгол Ардын Намын хорооны даргаар ажиллаж байсан. Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.14 дэх заалтад зааснаар улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаал нь төрийн албаны улс төрийн албан тушаалд хамаардаг тул Л.Ганболдын 2009-2013 онд Хөвсгөл аймгийн Засаг даргын орон нутгийн бодлогын зөвлөхөөр ажилласан хугацаа нь төрийн алба хаасан хугацаанд хамаарч байна.

Мөн Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлд “Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан иргэн төрийн албанд шилжин ажиллавал намын байгууллагад ажилласан дээрх хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцно.” гэж заасан. Засаг дарга Л.Ганболдын 2013-2016 онд Хөвсгөл аймгийн Монгол Ардын Намын хорооны даргаар ажилласан хугацаа нь дээрх хуулийн үндэслэлийн дагуу төрийн албанд ажилласан хугацаанд тооцогдож байна.

Түүнчлэн, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Л.Ганболдыг Засаг даргад нэр дэвшүүлсэн тогтоолыг Монгол Улсын Ерөнхий сайдад албан ёсоор ирүүлэхдээ Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн 2016 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 3/1495 дугаартай албан бичгийг хавсарган ирүүлсэн бөгөөд уг албан бичигт “Л.Ганболдын намын байгууллагад ажилласан жилийг 1995 оны Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу төрийн албанд ажилласнаар тооцож болно.” гэж дурдсан байна.

Л.Ганболдын дээр дурдсан ажилласан байдлаас үзэхэд түүний төрийн албанд ажилласан хугацаа 7 жил байх бөгөөд тэрээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсэгт заасан Засаг даргад нэр дэвшигч нь “төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх”

шаардлагыг хангасан тул Ерөнхий сайд “Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай” Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 08 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд түүнийг Хөвсгөл аймгийн Засаг даргаар томилсон болно.

Дээр дурдсан нөхцөл байдал, холбогдох бичиг баримтыг үндэслэн гаргасан “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар захирамж нь хууль зүйн үндэслэлтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй болно.” гэжээ.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээрх маргааныг 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаараа хянан хэлэлцээд 04 дүгээр дүгнэлтийг гаргасан болно. Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

“1. Иргэн Б.Сүхбат 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Хөвсгөл аймгийн Засаг даргаар Л.Ганболдыг хуулийн шаардлага хангаагүй байхад томилсон гэсэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн агуулгатай мэдээллийг Үндсэн хуулийн цэцэд хандан гаргасан болно.

Үндсэн хуулийн цэцэд уг мэдээллийн дагуу маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн шалгаад 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдөр Дунд суудлын хуралдааныг зарлан хуралдуулахад Б.Сүхбат нь уг хуралдаанд заавал биечлэн оролцох хүсэлт гарган хойшлуулсан болно. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг дахин 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр зарлан хуралдуулахад иргэн Б.Сүхбат Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээллээсээ бүхэлд нь татгалзах хүсэлт гаргаад, татгалзсан шалтгаанаа Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирж тайлбарлах байсан боловч уг хуралдаанд хүрэлцэн ирээгүй болно.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Цэц Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн заалттай харшлаагүй бусад хуулийн заалтыг удирдлага болгож болно.” гэж заасныг үндэслэн 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас баталсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хэрэг үүсгэснээс

хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглоно.” гэсэн заалтыг Цэцийн дунд суудлын хуралдаан хэрэглэж болно гэж үзэн хуралдааныг үргэлжлүүлэн явуулахаар шийдвэрлэсэн болно.

2. Иргэн Л.Ганболд нь 2009-2013 оны хооронд Аймгийн Засаг даргын орон нутгийн бодлого хариуцсан зөвлөхөөр ажилласан гэх хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулаагүй буюу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2 дахь заалтад заасан “төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан” байх гэсэн шаардлагыг хангаагүй болох нь Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 506 дугаар шийдвэрээр тогтоогдсон байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 1995 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлд “Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж заасан байх ба дээрх зүйлд заасан 1994 оны Төрийн албаны тухай хууль нь 2002 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн Төрийн албаны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиар хүчингүй болсон байна.

Л.Ганболдын 2013-2016 онуудад Хөвсгөл аймгийн Монгол Ардын Намын хорооны даргаар ажиллаж байсан хугацааг 1995 оны Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийг баримтлан төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцох хууль зүйн үндэслэлгүй болно.

4. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2 дахь заалтад заасан Засаг даргад нэр дэвшигч нь төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх гэсэн хуулийн шаардлага хангаагүй хүнийг Засаг даргаар томилсон Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Харин Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Дүгнэлтийн тогтоох хэсэгт:

1. Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамжийн 1 дэх заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.” гэсэн байна.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг Улсын Их Хурал 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцээд гаргасан 25 дугаар тогтоолд:

“Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамжийн 1 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэсэн байна.

Тав. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд оролцох Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

“... Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 04 дүгээр дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн аваагүй бөгөөд ийнхүү авахгүй гэж үзэх болсон үндэслэлийг дараах байдлаар тайлбарлаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамжаар Хөвсгөл аймгийн Засаг даргаар Л.Ганболдыг томилохдоо Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2 дахь заалтад Засаг даргад нэр дэвшигч нь төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх гэсэн хуулийн шаардлага хангаагүй хүнийг томилсон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль дээдлэх зарчмыг зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэц үзжээ.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд Л.Ганболд нь 2013-2016 онуудад Хөвсгөл аймгийн Монгол Ардын Намын хорооны даргаар ажиллаж байсан бөгөөд Улсын Их Хурлаас 1995 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлд “Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан иргэн төрийн албанд шилжин ажиллавал намын байгууллагад ажилласан дээрх хугацааг 2002 оны 7 дугаар сарын 04-ний өдөр хүчингүй болгосон тул Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль мөн адил хүчингүй болсон гэж дурджээ.

Улсын Их Хурлаас 1995 онд баталсан Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчин төгөлдөр хэвээр үйлчилж байгааг нотлох дараах 5 үндэслэл байна. Үүнд:

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад зааснаар хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаардаг билээ. Улсын Их Хурлаас 1995 онд баталсан Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг 1994 оны Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдөр буюу 1995 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд 1994 оны Төрийн албаны тухай хуулийг 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр хүчингүй болсонд тооцох тухай хууль батлан хүчингүй болгосон байна. Харин 1995 онд баталсан Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болгосон аливаа хуулийг Улсын Их Хурлаас батлан гаргаагүй байна.

2/ Улсын Их Хурлаас 1995 онд баталсан Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлд “Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс

эхлэн дагаж мөрдөнө.” гэж заасан нь гагцхүү 1994 оны Төрийн албаны хууль хүчин төгөлдөр болох өдөртэй зэрэгцэн хүчин төгөлдөр болох агуулгыг илэрхийлсэн, харин энэхүү хуулийг дагаж хүчингүй болох талаарх агуулгыг багтаагаагүй байна.

3/ Монгол Улсын Үндсэн хууль, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хууль тогтоомжийн тухай хууль, энэ хууль батлагдахаас өмнө мөрдөгдөж байсан Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль болон өөр аль ч хуульд “эх” хууль хүчингүй болсноор түүнийг “дагаж мөрдөх журмын тухай” хууль хүчингүй болсонд тооцно гэсэн хэм хэмжээ байхгүй бөгөөд гагцхүү Улсын Их Хурлаас хууль батлах замаар аливаа хууль хүчингүй болдог. Иймд 1994 оны Төрийн албаны тухай хууль хүчингүй болсон тул 1995 оны Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль мөн адил хүчингүй болсон гэж үзэх үндэслэл Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд байхгүй байна.

4/ 1995 онд баталсан Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд “Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагч болсон иргэний 1990 оны 3 дугаар сарын 23-наас өмнө нам, олон нийтийн төв, орон нутгийн байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан хугацааг төрийн албан хаасан хугацаатай адилтган тооцно.” гэж заасан нь одоог хүртэл иргэд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход тэдгээрийн ажилласан жилийг тооцоход хэрэглэгдэж байгаа зохицуулалт юм ...

5/ 1995 онд баталсан Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлд “Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан иргэн төрийн албанд шилжин ажиллавал намын байгууллагад ажилласан дээрх хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцно.” гэж заахдаа ямар цаг үед намын байгууллагад ажилласан байх талаар нарийвчлан заагаагүй тул одоогийн Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байгаа иргэдэд ч мөн адил үйлчилж байх үүднээс хугацааг нарийвчлан заагаагүй гэж үзэхээр байна. Иймд 1995 онд баталсан Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчин төгөлдөр хэвээр үйлчилж байгаа тул Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамж Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг зөрчөөгүй гэж Улсын Их Хурал үзсэн болно.

Түүнчлэн, Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 04 дүгээр дүгнэлтийн “Үндэслэл” хэсэгт мэдээлэл гаргагч иргэн мэдээллээсээ бүхэлд нь татгалзах хүсэлт гаргасан хэдий ч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Цэц Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн заалттай харшлаагүй бусад хуулийн заалтыг удирдлага болгож болно.” гэж заасныг үндэслэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хэрэг үүсгэснээс хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглоно.” гэсэн заалтыг Цэцийн дунд суудлын хуралдаан хэрэглэж болно гэж үзэн хуралдааныг үргэлжлүүлэн явуулахаар шийдвэрлэсэн талаар дурджээ.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйл нь “Цэцийн шийдвэр хууль ёсны, үндэслэлтэй байх” гэсэн гарчигтай бөгөөд 2 дахь хэсгийн эхний өгүүлбэрт “Цэцийн шийдвэр ...” гэж зааснаас үзэхэд цэц шийдвэр гаргахдаа Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн заалттай харшлаагүй бусад хуулийн заалтыг удирдлага болгож болохоор заасан. Харин хуралдаан явуулах процессын ажиллагаанд бусад хуулийн заалтыг удирдлага болгохоор заагаагүй байна. Үүнийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай процессын хуулиудын “зорилт” хэсгээс тодорхой харах боломжтой байгаа нь Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 04 дүгээр дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэлд хамаарсан болохыг мөн дурдаж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамжийн 1 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчөөгүй гэж үзэж Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 04 дүгээр дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэдэг бөгөөд холбогдох хуулийн зохицуулалтыг

удирдлага болгон Дунд суудлын хуралдаанаар энэхүү маргааныг хянан шийдвэрлэсэн нь үндэслэлтэй байна.

2. Ерөнхий сайд аймгийн Засаг даргыг томилох харилцааг Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлээр зохицуулж, эрх зүйн үндсийг тогтоожээ. Үндсэн хуульд заасан уг бүрэн эрхээ хэрэгжүүлэхээр гаргасан Ерөнхий сайдын шийдвэрт холбогдох маргааныг Үндсэн хуулийн цэц хэлэлцэн шийдвэрлэж дүгнэлт гаргах бүрэн эрхтэй.

3. Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 1995 оны хуулийг батлан гаргасан зорилго, тухайн хуулиар зохицуулах харилцааны мөн чанараас үзэхэд 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөхөөс өмнөх буюу шилжилтийн үеийн цаг хугацаанд хамаарах харилцааг зохицуулахад хэрэглэхээр байна.

Түүнчлэн, 1994 оны Төрийн албаны тухай хууль батлагдахаас өмнө холбогдох албан тушаал эрхэлж байсан иргэдийн эрх зүйн байдлыг тодорхойлох, түүнийг дордуулахгүй байх зорилгоор Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 1995 оны хууль нь эдүгээ хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэж үзэхээр байна.

Иймд Л.Ганболдын 2013-2016 онд Хөвсгөл аймгийн Монгол Ардын Намын хорооны даргаар ажилласан хугацаа нь дээрх хуулийн үйлчлэлд хамаарахааргүй байх тул энэ хуулийг баримтлан төрийн албанд ажилласан хугацаанд тооцох хууль зүйн үндэслэлгүй байна.

4. Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамжийн 1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 04 дүгээр дүгнэлт үндэслэлтэй байна.

5. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "... Улсын Их Хурал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож тогтоол гаргана." гэж заажээ. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 25 дугаар тогтоолд Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа үндэслэлээ заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг; Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэсэн заалтад нийцээгүй байх тул хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай” 25 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ Д.ОДБАЯР

ГИШҮҮД Н.ЧИНБАТ
Д.ГАНЗОРИГ
Ш.ЦОГТОО
Д.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Г.ТУУЛХҮҮ
Ш.СОЛОНГО
Ц.НАНЗАДДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.04.25 Дугаар 05 Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 12.30 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Т.Лхагваа, Ш.Цогтоо, Д.Сугар, Д.Наранчимэг /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Н.Ариунболд, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа нар оролцсон болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 29 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 4, 5 дахь дэд заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт, Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Ариунболдоос Үндсэн хуулийн цэцэд хандан дараах мэдээллийг ирүүлжээ. Үүнд:

"... Монгол Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн "Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 29 дүгээр тогтоолын холбогдох заалтаар "төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахгүй байх"-ыг төрийн бүх шатны төсвийн захирагч нарт Улсын Их Хурлаас даалгажээ.

Энэхүү Улсын Их Хурлын бусад шийдвэр /тогтоол/ нь Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг болон бусад зарим заалттай үл нийцэж байна.

Нэг. Монгол Улсад төрийн алба хаах нөхцөл, журам, түүнчлэн төрийн албан хаагчийн нийгэм, эдийн засаг хууль зүйн баталгааны талаарх үндсэн зохицуулалт Төрийн албаны тухай хуулиар, Төрийн албаны тухай хуулиар зохицуулаагүй төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа Хөдөлмөрийн тухай хуулиар, тусгайлсан төрийн алба хаах нөхцөл, баталгааны талаарх харилцаа бусад салбар хуулиар зохицуулагдаж байна.

Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт зааснаар төрийн албан хаагч гэдэг нь төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээд юм. Төрийн албан хаагч нь ийнхүү төрөөс цалин авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдаж, төрийн ажлыг гүйцэтгэж, төрийн алба хашиж байгаагийнхаа төлөө Үндсэн хууль, бусад хуульд заасан зарим эрх, боломжоо хуулиар хязгаарлуулдаг билээ. Мөн төрийн албан хаагч нь эрхэлж байгаа төрийн албаны чиг үүрэгтэй холбоотойгоор тусгайлсан үүрэг хүлээж, хариуцлага алдсан тохиолдолд төрийн албан хаагчийнхаа хувьд зохих шийтгэл хүлээдэг онцлогтой этгээд юм.

... Ийнхүү төрийн албан хаагч нь хуульд заасан боломжоо хязгаарлуулж, нэмэлт хариуцлага хүлээж ажилладгийн хувьд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасан баталгаагаар хангагддаг. Тэр дундаа "цалин хөлс" авах баталгаагаар хангагддаг болно. Төрийн албан хаагчийн цалин хөлс гэдэг нь

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт зааснаар:

- улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдэл;
- төрийн захиргааны албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл;
- тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдэл;
- үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын нэмэгдэл, бусад нэмэгдлээс тус тус бүрддэг билээ.

Гэтэл төрийн албан хаагчийн баталгаа буюу төрийн албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын зэрэглэл болон бусад байдлаас хамаарч нэмэгддэг харилцааг Улсын Их Хурлаас 2017 оны байдлаар царцааж, улмаар 2017-2019 онд зогсоосон нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтад “... цалин хөлс авах ...”, Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно.” гэж заасантай нийцэхгүй байна. ...

Хоёр. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэсэн байдаг. Хэдийгээр Улсын Их Хурал нь төрийн эрх барих дээд байгууллага хэдий ч дээр дурдсаны дагуу хуулийг дээдлэх зарчимтай. Төрийн албан хаагчийн цалин хөлсний харилцаа Төрийн албаны тухай хуулиар нэгэнт зохицуулагдсан байхад хуулийн үйлчлэлийг Улсын Их Хурлын бусад шийдвэрээр зогсоосон нь хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимтай нийцэхгүй байна.

Иймд Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 29 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 4 дэх дэд заалтад “төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд

хэвээр хадгалах буюу царцаах, ...", мөн заалтын 5 дахь дэд заалтад "төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.'', Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтад "... хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах ...", Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно." гэж заасантай нийцсэн эсэхийг тогтоож өгнө үү." гэсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"... Нэг. Төрийн албан хаагч Монгол Улсын иргэний нэгэн адил Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг эдлэх эрхтэй. Харин Төрийн албан хаагчийн тангараг өргөж, нийтийн албан тушаалтан болсноор хувийн эрх зүй дэх иргэний хөдөлмөрлөх эрхээс ялгагдах онцлог харилцаа бий болдог. Тиймээс ч төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны тодорхой хэсгийг захиргааны эрх зүйгээр зохицуулдаг. Үүнд төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, хязгаарлалтууд, хариуцлага, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлууд багтана.

Төрийн албан хаагчид олгох нийгмийн баталгаа, цалин хөлс, түүнтэй холбоотой зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг тул мөнхүү зардлыг олгохтой холбоотой харилцааг төсвийн хууль тогтоомжоор зохицуулахдаа төсвийн тогтвортой байдлыг хангах зарчмыг мөн мөрдөх шаардлага үүсдэг. Улсын сан хөмрөг хангалтгүй, улсын өр, төсвийн алдагдал их хэмжээгээр өссөнөөр төсвийн зардлыг нэмэгдүүлэх боломжгүй тохиолдол нэгэнт үүссэн бол Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.", Хорин тавдугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан "...төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого..."-ыг тодорхойлох бүрэн эрхийнхээ хүрээнд тус тус зохицуулалт хийх боломж бий. Энэхүү эрх хэмжээний хүрээнд Улсын Их Хурал 2017 оны 29 дүгээр тогтоолыг батлан гаргасан.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд Улсын төсөв батлагдаагүй тохиолдол үүссэн үед санхүүжилтийн түр горимыг тогтоох, энэхүү горимын дагуу төсөв батлагдах хүртэлх хугацаанд төрийн албан хаагчийн цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр олгохоор заасан байдаг. Хэдийгээр Төсвийн тухай хуульд заасан дээрх тохиолдол бий болоогүй хэдий ч зохицуулах зүйлийн шинж байдлаараа 2017 оны 29 дүгээр тогтоол батлагдах үеийн эдийн засгийн хямралын шинжтэй нөхцөл байдал, түүнд тохируулан гаргасан шийдвэрийн зохицуулалттай ижил төсөөтэй болно.

Гадаад орнуудын туршлагаас харахад төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх мөнгөн хөрөнгө нь улсын ерөнхий эдийн засаг, санхүүгийн нөхцөл, төрөөс баримталж буй нийгмийн бодлогод нийцсэн, улсын боломжоос хэтрээгүй байх зарчим баримталдаг. АНУ-д төрийн албан хаагчдын хөдөлмөрийн хөлсний системийн нэг онцлог нь улс орны нийгэм, эдийн засгийн байдлаас хамаардаг явдал юм. Жил болгон дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, ажилгүйдлийн түвшин, төсвийн алдагдлын хэмжээ, хэрэглээний үнийн индекс зэрэг үзүүлэлтүүдээс хамаарч төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх түвшинг тогтооно, эсвэл царцаадаг байна. 2010 онд төсвийн алдагдалтай тэмцэх зорилтуудын хүрээнд төрийн албан хаагчдын цалинг 2 жилийн хугацаагаар царцаах шийдвэрийг гаргаж байжээ.

Хоёр. Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 4, 5 дахь дэд заалт нь төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтоох Үндсэн хуулийн заалтыг хөндөөгүй болно. Төрийн албан хаагчдад албан тушаалын цалин, нэмэгдлээ 2017 оны түвшинд авах эрх нь хадгалагдаж байгаа бөгөөд харин зэрэг дэв нэмэгдүүлэх, цалингийн шатлалыг ахиулах өөрчлөлттэй холбоотойгоор улсын төсвөөс гаргах нэмэлт санхүүжилтийг 2 жилийн хугацаанд түр зогсоосон. Тогтоолын дээрх заалтаар Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн цалин хөлс, бусад нийгмийн баталгааг хүчингүй болгосон, эрх зүйн байдлыг дордуулсан хууль зүйн үр дагаврыг бий болгоогүй гэж үзэж байна. Эдийн засаг сайжирч, төсвийн орлого нэмэгдэхийн хэрээр төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх, түүнчлэн мөнхүү хугацаанд аваагүй зэрэг дэвийн нэмэгдлийг нөхөн олгох шийдвэрийг Улсын Их Хурал гаргах боломж бий.

Гурав. Улс орны эдийн засаг, нийгмийн болон бусад онцгой нөхцөл байдалтай уялдаагаар хуулийн тодорхой зүйл, заалтын

үйлчлэлийг түдгэлзүүлэх, үйлчлэх хугацааг хойшлуулах зэрэг эрх хэмжээг Улсын Их Хурал хууль тогтоомж батлах өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд эдэлдэг.

Мэдээлэлд дурдсанчлан Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтын үйлчлэлийг Улсын Их Хурлын тогтоолоор зогсоосон тухай асуудлыг хуульд өөрчлөлт оруулах буюу хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлын хүрээнд шийдвэрлэх боломжтой юм.

Дээр дурдсаныг үндэслэн Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 4, 5 дахь дэд заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт, Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр Танд уламжилж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад заасан төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлогыг тодорхойлох онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд улсын эдийн засгийн өнөөгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг багасгах, төсвийн алдагдлыг бууруулах, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх, төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоохоор Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 29 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 4, 5 дахь дэд заалтад заасан нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй гэж үзэхээр байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 29 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 4 дэх дэд заалтад “төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх;”, мөн заалтын 5 дахь дэд заалтад “төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтын “... хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, ...”, Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно.” гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ Н.ЖАНЦАН
ГИШҮҮД Т.ЛХАГВАА
Ш.ЦОГТОО
Д.СУГАР
Д.НАРАНЧИМЭГ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.05.23 Дугаар 06 Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Цогтоо, Н.Чинбат /илтгэгч/, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл, гомдол гаргагч, иргэн Т.Мөнх-Эрдэнэ болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 9-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын "хөдлөх ... хөрөнгө эзэмших, өмчлөх ... эрхтэй." гэсэн хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 17 дугаар хорооны оршин суугч, иргэн Т.Мөнх-Эрдэнэ, Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн Г.Орхон нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэл, гомдолдоо:

1. “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад иргэн нь “хөдлөх ... хөрөнгө эзэмших, өмчлөх ... эрхтэй. ...” гэж үндсэн эрхийг баталгаажуулсан байна. Хөдлөх хөрөнгө гэдэг нь үл хөдлөх эд хөрөнгөөс бусад хөрөнгө мөн. Харин өмчлөх эрх гэж өмчлөгч өөрийн хөрөнгөө хуулийн хүрээнд бүрэн мэдэж эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг ойлгоно. Өөрөөр хэлбэл, тодорхой этгээд өөрт байгаа эд хөрөнгийг хуулийн хэмжээ хязгаарын хүрээнд өөрийн үзэмж, ашиг сонирхлоор буюу бусад этгээдийн нөлөөллөөс үл шалтгаалан эзэмших, ашиглах ба захиран зарцуулах эрхийг хэлнэ. Эзэмших гэж эзэмшигч эд хөрөнгийг бодитой эзэмдэж түүнд шууд нөлөөлөх боломжтой болсныг хэлнэ. Дээрх заалт нь өмчлөгчийн эрхийг Үндсэн хуулийн хүрээнд чухалчлан хамгаалсны учир нь өмчлөх эрх хувь хүний хамгаалалтын бүс үүсгэдгээрээ төрийн дур зоргоор авирлахын эсрэг хувь хүний орон зайг бий болгож, бусад эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжийг бүрдүүлдэг учраас өмчлөх эрхийг ийнхүү тусгайлан баталгаажуулжээ.

Дээрхээс үзвэл, аливаа этгээд нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх үндсэн эрхтэй байх бөгөөд тухайн шударгаар олж авсан өөрийн хөрөнгийг банкинд хадгалах, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар банкинд данс нээлгэж байршуулах, данс эзэмших эрхээр тайлбарлагдана. Энэ үндсэн эрх нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 12.1 дэх хэсэгт заасан “Иргэн, хуулийн этгээд тогтоосон журмын дагуу банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд данс нээлгэж, төлбөр тооцооны үүрэг гүйцэтгүүлэх эрхтэй.” гэж заасан агуулгаар баталгаажжээ.

Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалт нь иргэн хүний “... банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, ...” эрхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад олгосон байна.

Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны үндэс нь иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын гаргасан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд

заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийг биелүүлэх процесс билээ. Харин шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ гэдэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохистой хэрэгжүүлэхийн тулд шийдвэр гүйцэтгэгчийн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг ойлгоно. Банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоохоор байгаа нь дээрх ажиллагаанд шууд багтаж байна.

Данс гэдэг нь банкны бүртгэлийн систем буюу банкинд өөрийн хөдлөх хөрөнгийг /мөнгө/ байршуулж буй үйлчлүүлэгчийн хөрөнгийг бүртгэх бүртгэлийн систем бөгөөд банкинд байршуулж буй үйлчлүүлэгчийн хөдлөх хөрөнгийг өөртөө агуулж байгаа ойлголт юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтыг авч үзвэл хэрэв шийдвэр гүйцэтгэгч энэ арга хэмжээг авсан тохиолдолд төлбөр төлөгч аль ч банкинд данс нээх, данс эзэмших эрхгүй болж байна. Данс нээх, эзэмших эрхгүй болно гэдэг нь төлбөр төлөгч өдөр тутмын амьдралын зайлшгүй шаардлагатай төлбөр тооцоог хийж, аж ахуйн болон амины үйл ажиллагаагаа саадгүй явуулах боломжгүй болохоор байна. Тиймээс энэ нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “хөдлөх ... хөрөнгө эзэмших, өмчлөх ... эрхтэй. ...” үндсэн эрхийг хязгаарлаж буй хязгаарлалт мөн.

Гэтэл уг хязгаарлалт нь мөн л хууль ёсны бус байгаад оршиж байна. Учир нь Нэгдүгээрт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад банк, эрх бүхий хуулийн этгээд дэх төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламж харилцах дансан дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих зэрэг өөр төрлийн баталгаажуулах арга хэмжээг тусгасан байна. Мөн түүнчлэн, төлбөр төлөгчид үүрэг бүхий төлбөр төлөхөөс гадна өдөр тутамд олон төрлийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан цахим хэлбэрээр мөнгөн гуйвуулга хийх, хүүхдийн тэтгэлгийн мөнгө, хүүхдийн мөнгөн хадгаламж, тэтгэвэр, тэтгэмжийн орлого зэрэг зайлшгүй хэрэгцээт мөнгөний эх үүсвэртэй холбоотойгоор данс нээх шаардлага амьдралд тулгарч болно. Тийм учир “банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох” нь төлбөр төлөгчийн төлбөр авагчид төлбөр барагдуулах үйл явцад ач холбогдолтой нөлөө үзүүлж чадахгүй байх тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах

арга хэмжээний зорилгод нийцэхгүй байна. Хоёрдугаарт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад заасан бусад арга хэмжээнүүд нь төлбөр авагч болон шийдвэр гүйцэтгэгч хоёр талд хангалттай механизмыг бүрдүүлсэн байна гэж үзэх үндэслэлтэй. Жишээ нь, шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эзэмшиж буй эсхүл шинээр нээлгэсэн дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих бүрэн боломжийг хуульчилжээ. Тиймээс банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох нь зайлшгүй шаардлага биш болох нь үүгээр батлагдана. Гуравдугаарт, мөн Үндсэн хуулийн дагуу хөдлөх хөрөнгө эзэмших үндсэн эрхийг хуулиар хязгаарлах боломжийг тусгаж өгсөн ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад заасан хязгаарлалт нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, орлогын болон амьдралын нэн зайлшгүй эх үүсвэрийг хязгаарлахгүй байх болон төр, хүний үндсэн эрх хоёрын зохистой харьцааны Үндсэн хуулийн суурь зарчмыг зөрчөөд зогсохгүй шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарчимд ч нийцэхгүй байна.

Тиймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтын "... банк, эрх бүхий хуулийн этгээдийн данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, ..." гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын "хөдлөх ... хөрөнгө эзэмших, өмчлөх ... эрхтэй. ..." гэсэн хэсгийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж тогтоосон байдаг. Энэхүү зарчим нь төрийн аливаа хэлбэрийн үйл ажиллагаанд бодитой баримтлагдан хэрэгжих тулгуур зарчим мөн.

Дээрх зарчмын агуулгыг бэхжүүлсэн холбоо уялдаа бүхий заалт бол Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэж тодотгосон юм. Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх нь хууль тогтоох гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн бүхий л үйл ажиллагаанд баримтлах ёстой үүрэгжүүлсэн заалт мөн.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт "Барьцаалагч-төлбөр авагч" биш этгээд өөрт учирсан хохирлыг төлбөр төлөгчийн үл хөдлөх хөрөнгөөс гаргуулах гэж

дуудлага худалдаагаар оруулсан боловч тухайн үл хөдлөх хөрөнгө нь худалдан борлогдоогүй бол тухайн үл хөдлөх хөрөнгийн үнийг 50 хувь бууруулна гэсэн зарчмыг тогтоожээ. Өөрөөр хэлбэл, төлбөр авагч нь барьцаалагч байсан тохиолдолд зах зээлийн ханшаар тооцно, харин барьцаалагч биш төлбөр авагч бол дуудлага худалдаагаар борлогдоогүй үнийг 50 хувиар бууруулж төлбөр авагчид шилжүүлэхээр буюу өөр, өөр үнээр тооцож шилжүүлэхээр зохицуулсан байна.

Ингэж төлбөр авагчдын эрх зүйн байдлыг ялгамжтай үзэж, ялгавартайгаар зохицуулсан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... шударга ёс, ... тэгш байдлыг ... хангах, ... нь төрийн үйл ажиллагааны зарчим мөн", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... хүн бүр хуулийн ... өмнө эрх тэгш байна." гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.5 дах хэсэгт "Барьцаалагч-төлбөр авагчийн барьцаанд байгаа, эсхүл дундын өмчлөлийн худалдан борлогдоогүй төлбөр төлөгчид ногдох хөрөнгийг энэ хуулийн 55.3-т заасны дагуу тогтоосон үнэлгээгээр тооцож төлбөр авагчид шилжүүлнэ." гэсэн байна. Нэгдүгээрт, барьцаалагч биш төлбөр авагчийн эрхийг нь хязгаарлаж, бусад төлбөр авагчийн эрхээс дордуулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар төлбөр авагчдад тэгш бус ялгавартай ханджээ. Гэтэл барьцаалагч нь төлбөр авагч бол шинжээчээр үнэлүүлсэн тохиолдолд шинжээчийн үнэлгээгээр 50 хувь бууруулах зохицуулалт байхгүй. Хоёрдугаарт, төлбөр авагч гэж ажил үйлчилгээний үнэ хөлс, нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүний үнийг төлбөр тооцооны тодорхой хэлбэрийн бүрдүүлбэрийг хангасан баримтын дагуу нэхэмжилсэн этгээд байна. Гэтэл төлбөр авагчийг "барьцаалагч-төлбөр авагч", барьцаалагч биш төлбөр авагч гэж тусад нь ангилж хуульчилсан нь хууль зүйн дагуу үүсэх үр дагаврыг ойлгомжгүй болгосон байна. Түүнчлэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндсэн дээр өөрийн хохирлыг нөхөн төлүүлэх эрхээ эдлэх процессыг нэг ойлголт дор байгаа адил этгээдүүдэд ялгавартайгаар хуульчилсан нь үндэслэлгүй юм. Гуравдугаарт, хууль тогтоогч тухайн заалтыг ямар үндэслэл зарчмаар, ямар зорилго агуулж тогтоосон нь тодорхойгүй, ач холбогдол, эрх зүйн үр дагаврыг нь бүрэн ухамсарлаагүй харагдаж байна. Дөрөвдүгээрт, хууль тогтоогч дээрх зохицуулалтыг хийхдээ зөвхөн банкны барьцааны асуудлаар төсөөлж хийсэн нь хэт явцуурууллжээ. Тэгвэл Иргэний хуульд заасан үүргийн гүйцэтгэлийг хангах барьцааны нийтлэг шинж, зохицуулалтыг огт анхааралгүй тогтоосон байна. Иргэний хуульд заасан худалдах,

худалдан авах гэрээ, зээлээр худалдах, худалдан авах гэрээ, эд хөрөнгө хөлслөх гэрээ, орон сууц хөлслөх гэрээ, түрээсийн гэрээ, ажил гүйцэтгэх зэрэг гэрээний барьцаалагчдын хувьд тэдгээрийн эрх зүйн байдлыг дордуулж, ялгаварлал бий болгосон байна. Тавдугаарт, мөн хууль тогтоогч "... Худалдан борлогдоогүй хөрөнгийн үнэ" гэдэгт чухам ямар үнэ хамаарахыг тодорхой хуульчлаагүй нь маргаан дагуулах эх сурвалж болжээ. Үүнд тухайн худалдан борлогдоогүй хөрөнгийн зах зээлийн үнэ хамаарах уу, эсхүл хөрөнгийн үнэлгээний шинжээчийн тогтоосон үнэ хамаарах уу гэсэн маргааны нэг нөхцөл болж байна.

Тиймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно. Худалдан борлогдоогүй хөрөнгийн үнэ гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийн шаардлагаас илүү дүнтэй бол төлбөр авагч үнийн дүнгийн зөрүүг төлснөөр худалдан борлогдоогүй хөрөнгийг хүлээн авах эрх нээгдэнэ." гэж бусдын амьжиргааны эх үүсвэр болсон үл хөдлөх хөрөнгийг залгих хууль бус ажиллагааг хөхиүлэн дэмжсэн, нөгөө талаас банк зэрэг санхүүгийн ашгаар амьдардаг байгууллагын зорилгод өөр хэлбэрээр буюу бага зардлаар хүний үл хөдлөх хөрөнгийг залгих далд утгаар ашиг олох боломж бүрдүүлж байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... шударга ёс, тэгш байдлыг ... хангах, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хуулийн ... өмнө эрх тэгш байна." гэсэн хэсгийг зөрчсөн байна" гэсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд хандан ирүүлсэн тайлбартаа:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад "... банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох ..." гэж заасан нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад "хөдлөх ... хөрөнгө эзэмших, өмчлөх ... эрхтэй. ..." гэж заасныг зөрчөөгүй гэж үзэж дараах үндэслэлийг гаргаж байна:

Хууль тогтоогч шинэчлэн найруулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр

нөлөөг дээшлүүлэх, түргэн шуурхай байдлыг хангах, төлбөр авагч, төлбөр төлөгч иргэний хэн алиных нь эрх, ашиг сонирхол, тэдгээрийн Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрч, тогтоосон эрх, эрх чөлөөг хамгаалах зорилго бүхий олон шинэлэг зохицуулалтуудыг тусгасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Төр нь ... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална." гэж заасан нь өмчлөгчийн эрхэд огт халдаж болохгүй гэсэн агуулгыг агуулаагүй, уг зүйлд өмчлөгчийн эрхийг хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болох агуулга бүхий заалт бас бий. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд иргэний хэргийн талаар Монгол Улсын нэрийн өмнөөс гарсан хуулийн хүчин төгөлдөр, заавал биелэгдэх шинжтэй шүүхийн шийдвэрт заасан төлбөрийг төлбөр төлөгч биелүүлж, төлбөр авагчийн эрх, ашиг сонирхлыг хангахад чиглэсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг баталгаажуулах арга хэмжээг хуульчилсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад "... банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, ..." гэсэн зохицуулалтыг тусгасан нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүхийн шийдвэр заавал биелэгдэх, иргэнд учирсан гэм хорыг арилгах заалтын биелэлтийг хангуулах, мөн өмчлөгчийн эрхийг хуульд заасан тохиолдолд хязгаарлаж болох заалтад нийцүүлсэн болно. Өөрөөр хэлбэл, төлбөр төлөгчөөс шүүхийн шийдвэрт заасан төлбөрийг төлөхөөр шийдвэр гүйцэтгэх байгууллагад анх мэдүүлсэн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх өөрийн нэр дээрх дансаа ашиглаж орлого хийхгүй царцааж, хөрөнгө орлогоо нууж, шинээр данс нээн түүгээрээ орлого, зарлагын гүйлгээгээ хийж, төлбөр төлөх үүргээсээ зайлсхийж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан тохиолдолд төлбөр төлөгчийн шинээр данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох арга хэмжээг шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлж болохоор хуульчилсан.

Энэ нь нэг талаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэмэгц шийдвэр гүйцэтгэгчээс бүх төлбөр төлөгчид, даруй авах арга хэмжээ бус харин дээр дурдсан шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан, шүүхийн шийдвэр биелэгдэхгүй, төлбөр авагчийн эрх хангагдахгүй байх нөхцөл байдлыг бий болгосон, хууль зөрчсөн төлбөр төлөгчид л авах арга хэмжээ гэж ойлгож байна.

Төлбөр төлөгчөөс дээр дурдсан байдлыг гаргахгүй тохиолдолд өөрийн нэр дээр данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох үндэслэл үүсэхгүй. Төлбөр төлөгч хөрөнгөд орсон өөрчлөлтөө хуульд

заасны дагуу шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх үүрэг нь мөн хуулийн 46 дугаар зүйлээр нээлттэй байгаа.

Нөгөө талаас шийдвэр гүйцэтгэгч үндэслэлгүйгээр дээрх арга хэмжээг авсан гэж үзэж зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд төлбөр төлөгчид ахлах болон ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид хандаж гомдол гаргах эрхийг мөн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4, 44.5 дахь хэсгээр олгосон.

Мэдээлэл гаргагчийн мэдээлэлд дурдсанчлан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоож болохоор хуульчилсан нь төлбөр төлөгч данс ашиглан хэрэгжүүлэх амьдралын наад захын хэрэгцээ, шаардлагаа хангах боломжийг үгүйсгэсэн агуулга огт байхгүй.

Төлбөр төлөгчийн тодорхой эрхэд хязгаарлалт тогтоосон ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 87, 88, 89 дүгээр зүйлд заасанчлан төлбөрт суутгаж болохгүй, хураан авч, битүүмжилж болохгүй зайлшгүй шаардлагатай хөрөнгөө захиран зарцуулах, дансанд байршуулах эрх нь нээлттэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.13 дахь заалтын агуулга нь төлбөр төлөгчийн данс нээх, эзэмших эрхэд нь хязгаарлалт тогтоох, дансны орлого, зарлагын гүйлгээнд нь хяналт тавих утгатай бөгөөд гагцхүү төлбөр төлөгч өөрийн хөрөнгийг нуун далдлах зорилгоор олон төрлийн данс эзэмших, түүгээр дамжуулан гүйлгээ хийх явдлыг л хязгаарлах зорилготой.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно. ...” гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ... тэгш байдлыг ... хангах, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль ...-ийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчөөгүй гэж үзэж дараах үндэслэлийг гаргаж байна:

Хууль тогтоогч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлд төлбөр төлөгчийн худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгохтой холбогдсон харилцааг зохицуулсан

бөгөөд ийнхүү зохицуулахдаа 73.3 дахь хэсгээр төлбөр авагчийн барьцаанд байгаа болон дундын өмчлөлийн хөрөнгөөс төлбөр төлөгчид ногдох хөрөнгөөс бусад хөрөнгийг түүний үнэлэгдсэн үнээс 50 хувиар бууруулан төлбөр авагчид санал болгохоор, 73.5 дахь хэсгээр төлбөр авагчийн барьцаанд байгаа болон дундын өмчлөлийн хөрөнгийн төлбөр төлөгчид ногдох хэсгийг шинжээчээс тогтоосон үнээр төлбөр авагчид санал болгохоор тус тус хуульчилсан.

Иргэний хууль тогтоомжид заасанчлан барьцааны үүрэг талуудын чөлөөт хүсэл, зоригийн үндсэн дээр буюу талууд өөрсдийн эрсдэлийг тооцож, тохиролцсон үед үүсдэг.

Өөрөөр хэлбэл, барьцаалагч, барьцаалуулагч нь аливаа хөрөнгийг харилцан тохиролцсоны дагуу барьцааны зүйл байхаар сонгодог буюу барьцаалагч-төлбөр авагч үүргийн гүйцэтгэлийг хангуулах барьцааны зүйлийг өөрөө сонгож хэлцэл байгуулдаг тул барьцаалагч-төлбөр авагч сонголтынхоо эрсдэлийг өөрөө үүрэх буюу түүнд тусгайлсан зохицуулалт үйлчлэх нь гарцаагүй юм. Тодруулбал, иргэн, хуулийн этгээд зээлийн гэрээ байгуулахдаа зээлдэгч /үүрэг гүйцэтгэгч/ үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайлсан барьцааны зүйлийг үүргийн гүйцэтгэлд тооцож тэргүүн ээлжид төлбөрийн шаардлагаа хангуулах эрхээ эдлэх хүсэлтээ илэрхийлсэн байдаг тул барьцааны зүйлээр түүний үүргийн гүйцэтгэлийг хангуулан тухайн хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэх зохицуулалтыг хуульчилсан.

Ийнхүү зохицуулсан нь барьцааны зүйлээр төлбөрийн шаардлагыг бүрэн хангуулах, үүргийн гүйцэтгэлийг барьцаалагдаагүй бусад хөрөнгөөс гаргуулахгүй байж төлбөр төлөгчийн өмчлөх эрхийг хамгаалахад чиглэсэн зохицуулалт болж чадсан.

Харин энгийн төлбөр авагч буюу барьцаалагч бус төлбөр авагчийн хувьд дээр дурдсанчлан үүргийн гүйцэтгэлийг хангуулах аливаа хэлбэр, барьцааг сонгоогүй, тухайн хөрөнгийг үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар буюу төлбөртөө суутган авахаар хэлэлцэн тохиролцож гэрээ хийгээгүй байдаг. Тодруулбал, иргэн, хуулийн этгээд зээлийн гэрээ байгуулахдаа үүргийн гүйцэтгэлд аливаа эд хөрөнгө авахгүйгээр мөнгөн хэлбэрээр нь эргүүлж авна гэж тооцож хэлцэл хийсэн байдаг. Энэ тохиолдолд шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах үүднээс төлбөр төлөгчийн хоёр шатны дуудлага худалдаагаар ороод худалдан борлогдоогүй хөрөнгийн үнийг тодорхой хувиар бууруулан төлбөр авагчид санал болгохоор зохицуулсан.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан тэгш байдал, эрх тэгш байх зарчимд нийцүүлэн хууль тогтоогч өөр өөр нөхцөлөөр үүссэн харилцаанд тохирсон онцлогтой зохицуулалтыг хуульчилсан нь Үндсэн хуулийн зөрчлийг агуулахгүй гэж үзэж байна" гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Иргэн Т.Мөнх-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно. ..." гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... шударга ёс, ... тэгш байдлыг ... хангах, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль ...-ийн өмнө эрх тэгш байна." гэж заасныг зөрчсөн гэсэн мэдээллийн шаардлагаасаа татгалзсан болно.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Төр нь ... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно." хэмээн хуульчилжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад "... банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, ..." гэж зааж, хуулийн хүрээнд өмчлөх эрхийн хэрэгжилтэд хязгаарлалт тогтоосон нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарч байх ба Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад "... банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн

3 дахь заалтын “хөдлөх ... хөрөнгө эзэмших, өмчлөх ... эрхтэй. ...” гэснийг зөрчөөгүй байна.

2. Мэдээлэл гаргагч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт холбогдох мэдээллийн шаардлагаасаа татгалзсан болохыг дурдсугай.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Н.ЖАНЦАН
ГИШҮҮД	Ш.ЦОГТОО
	Н.ЧИНБАТ
	Д.СОЛОНГО
	Д.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.05.25 Дугаар 07 Улаанбаатар хот

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хууль Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 15.15 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Цогтоо, Н.Чинбат /илтгэгч/, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Н.Энхцэцэг болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 1, 2 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “иргэн шүүхэд гомдол гаргах, ... эрхтэй. ...”, Арван есдүгээр

зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ...”, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцлээ.

Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны оршин суугч иргэн Н.Энхцэцэг Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэдээлэлдээ:

“Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийг батлан гаргасан. Энэхүү хуулийн 1 дүгээр зүйлд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176[1], 177, 178 дугаар зүйлүүдийг тус тус хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2 дугаар зүйлд тус хуулийг 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосон юм.

Ийнхүү хүчингүй болсонд тооцсоноор 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан, уг хуралдаанаар хэрэг хянан шийдвэрлэх, Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар (176[1] дүгээр зүйл) хэргийг хянан шийдвэрлэх (177 дугаар зүйл), тогтоол (178 дугаар зүйл) -той холбоотой журмуудыг тус тус хүчингүй болгосон юм.

1. Дээрх хуулийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн заалттай зөрчилдөж байна.

Учир нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.10 дугаар зүйл хяналтын шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах, 40.11 дүгээр зүйл Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан, 40.12 дугаар зүйл Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдааны шийдвэр зэрэг заалтаар хяналтын шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх журмыг тодорхойлсон байдаг. Мөн түүнчлэн, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 128 дугаар зүйлд Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүхийн Захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан, 129 дүгээр зүйлд Улсын дээд шүүхийн Захиргааны хяналтын

шатны захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн нэгдсэн хуралдааны шийдвэр гэсэн зохицуулалтыг тусгаж Захиргааны хяналтын шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх журмыг тодорхойлсон байдаг.

Дээрх байдлуудыг дүгнэж үзвэл, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зохигч, гуравдагч этгээд, төлөөлөгч буюу өмгөөлөгч нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргах, нийт шүүгчдийн хуралдаанаар асуудлыг шийдвэрлүүлэх эрхгүй байгаа юм. Гэтэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хүрээнд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж асуудлаа хянан шийдвэрлүүлэх хууль зүйн боломжтой байна.

Энэ нь байцаан шийтгэх ажиллагааны нэг төрлийн оролцогчийн эрх ийнхүү хязгаарлагдаж байгаа ба Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд заасан шүүхийн өмнө эрх тэгш байх байдал нь зөрчигдөж байгааг харуулж байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан хуулийн 1 дүгээр зүйлээр иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж, Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлүүлэх хууль зүйн боломжоо алдаж байгаа нь Үндсэн хуулийн энэхүү заалтын агуулгад харшилжээ.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ...” гэж заасан.

Дээрх хуулийн 1 дүгээр зүйл нь иргэний хэргийн тухайд хяналтын журмаар гарсан шийдвэрийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хүсэлт гаргаж, нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх боломжийг хязгаарласнаараа Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх заалтын агуулгатай зөрчилдөж байна.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэж заасан.

Мөн хуулийн 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан хуулийн 1 дүгээр зүйлийн агуулгаас үзвэл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч холбогдох гомдлыг үндэстэй гэж үзвэл дүгнэлт гаргаж, уг хэргийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэй байсныг хязгаарласан байна.

Энэ нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дээд шүүхийн бүрэлдэхүүний салшгүй хэсэг байхаар тогтоосон Үндсэн хуулийн энэхүү заалтын агуулгатай бүрэн зөрчилдөж мөн Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх заалтын агуулгатай давхар зөрчилдөж хэргийн оролцогчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хохироож байна.

5. Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хууль нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “... шүүхэд гомдол гаргах, ... эрхтэй. ...” гэснийг зөрчиж байна.

Учир нь дээрх хуулиар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж нийт шүүгчдийн хуралдаанаар хэргээ шийдвэрлүүлэх хууль зүйн боломжийг хааснаараа зөвхөн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн Үндсэн хуульд заасан гомдол гаргах эрхийг хязгаарлаж байна.

Энэхүү нөхцөл байдлыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 08 дугаар дүгнэлтийн нөхцөл байдалтай харьцуулахад шинэ нөхцөл байдал илэрсэн гэж үзэхээр байна.

Иймд дээрх хуулийн 1, 2 дахь зүйл Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “... шүүхэд гомдол гаргах, ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн 2, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчиж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хуулийн 1 дүгээр зүйл, мөн хуулийн 2 дугаар зүйлийг тус тус хүчингүй болгох шийдвэр гаргаж өгнө үү.” гэсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

“Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 3, 6 дугаар дүгнэлт, 5, 7 дугаар тогтоолоор Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт, 17.2 дахь хэсгийн холбогдох заалтыг хүчингүй болгосон.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, уг хуулиудад хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн тогтоол хууль зөрчсөн, хуульд харшилсан бол Улсын дээд шүүх нийт шүүгчдийн хуралдаанаар хэргийг хянаж эцэслэн шийдвэрлэхтэй холбоотой журмыг зохицуулсан зүйл, заалтыг хүчингүй болгож, өөрчлөн найруулсан.

Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдөр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан. Дээрх хуулиудад эрүүгийн болон захиргааны эрх зүйн маргаан, хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн тогтоол хууль зөрчсөн гэх тохиолдолд зохигчид, шүүгчид, хохирогч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч Ерөнхий шүүгчид гомдол гаргах, Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичих, Ерөнхий шүүгч гомдлыг урьдчилан хянан үзээд, үндэслэлтэй гэж үзвэл Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргаа, эрүүгийн хэргийн тус тусын танхимын нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэх журмыг хуульчилсан.

Монгол Улсын Засгийн газраас хууль хоорондын уялдаа холбоо, хийдлийг арилгах зорилгоор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд холбогдох өөрчлөлтийг тусгахаар хуулийн төсөл боловсруулан ажиллаж байгааг үүгээр уламжилж байна.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 08 дугаар дүгнэлтэд “Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно.” гэсэн заалтыг хэрхэн хэрэгжүүлэх, хуульд харшилсан шийдвэрээ ямар журмаар хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулалтгүй орхиж, хуулийн хийдэл бий болгожээ “ гэж дүгнэсэн байна. Ийнхүү дүгнэсэн атал уг хийдлийг арилгаагүй байгаа нь Үндсэн хуулийн зөрчил гэж үзэхээр байна.

Мөн Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан Үндсэн хуулийн цэцэд өмнө нь ирүүлсэн тайлбар болон Цэцийн дунд суудлын хуралдааны явцад дээрх хийдлийг хүлээн зөвшөөрч холбогдох нэмэлтийг хийх талаар дурдсан болно.

2. Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийг баталж, мөн өдрөөс эхлэн дагаж мөрдсөнөөр хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн тогтоолд гомдол гаргах улмаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг хянах, мөн дүгнэлт бичиж хэргийг хянан хэлэлцүүлэх зохицуулалтгүй болсон байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 08-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль / шинэчилсэн найруулга/-ийн 40.10, 40.11 дүгээр зүйлд хяналтын шатны шүүхийн шийдвэр хууль зөрчсөн гэж үзвэл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргах, Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэргийг хянан хэлэлцэх талаар, мөн 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдөр баталсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль / шинэчилсэн найруулга/-ийн 128 дугаар зүйлд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргах, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэргийг хянан хэлэлцэх талаарх журмыг зохицуулжээ.

Дээр дурдсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын гомдлыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч урьдчилан хянаад үндэслэлтэй гэж үзвэл хэргийг Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргаа, эрүүгийн хэргийн тус тусын танхимын шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэх боломжтой байхад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 1 дүгээр зүйлийн дагуу иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын хувьд холбогдох гомдлоо Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гаргах, хэргээ хяналтын шатны хуралдаанаар дахин хянан хэлэлцүүлэх хуулийн зохицуулалтгүй болжээ. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх 3 төрлийн ажиллагааны оролцогчдод өөр өөр журмыг тогтоож, тэгш бус байдал үүсгэн, улмаар иргэний эрх тэгш байх нөхцөлийг хангах хууль зүйн баталгааг алдагдуулсан байна.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 08 дугаар дүгнэлтээр Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 1 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Тавьдугаар зүйлийн 2, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна хэмээн шийдвэрлэсэн байна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийг баталж, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийдэл үүсгэсэн нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэснийг тус тус зөрчсөн гэж үзэхээр байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн

зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176[1], 177, 178 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна.

2.Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 2 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “иргэн шүүхэд гомдол гаргах, ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ...”, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

3.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Д.ОДБАЯР
ГИШҮҮД	Ш.ЦОГТОО
	Н.ЧИНБАТ
	Д.СОЛОНГО
	Д.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2018.06.07 Дугаар 42 Төрийн ордон, Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны
07 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176[1], 177, 178 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “…хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц … хууль зүйн … баталгааг бүрдүүлэх, … үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.06.06 Дугаар 08 Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 16.15 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, гишүүн Н.Чинбат, Д.Ганзориг, Ш.Цогтоо /илтгэгч/, Б.Буяндэлгэр нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч А.Базар, П.Ундрах-Эрдэнэ болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, мөн зүйлийн 31.4 дэх хэсэг, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны оршин суугч, иргэн А.Базар, Баянгол дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч, иргэн Э.Ариунзаяа нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсгийн дагуу төлбөр авагч нь худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөрт тооцон авахаас татгалзсан нөхцөлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудсыг түүнд буцаах бөгөөд мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн дагуу гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад дахин ирүүлэхгүй буюу цаашид тухайн асуудлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэхгүй байх үр дагавартай байна.

Төлбөр авагч нь өөрийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо сэргээлгэхээр шүүхэд хандсаны дагуу шүүхийн зүгээс түүний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлж, буруутай этгээдээс төлбөр авах эрхтэй болохыг нь баталгаажуулсан шүүхийн шийдвэр гардаг. Үүний үндсэн дээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагддаг. Шүүхийн шийдвэр гарч байгаа нь төлбөр авагч буюу эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн иргэний эрхийг хууль зүйн хувьд сэргээж байгаа явдал бол нэхэмжлэгчийн зөрчигдсөн эрхийг бодитойгоор сэргээн эдлүүлэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлдэг. Иймд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох нь иргэний зөрчигдсөн эрхээ сэргээн эдлүүлэх, бодитойгоор хамгаалуулах боломжгүй байдалд хүргэж байгаа хэрэг юм.

Дуудлага худалдаа нь үнэ өрсөлдүүлэх буюу хамгийн өндөр үнэ санал болгосон этгээдэд хөрөнгийг худалдах ажиллагаа тул зах зээлийн хамгийн өндөр үнийг олох боломжтой. Иймд дуудлага худалдаанд түүний тогтоосон үнэлгээний 50 хувиар оруулахад худалдан борлогдоогүй эд хөрөнгийг зах зээлд ямар ч этгээд тийнхүү үнээр авах сонирхолгүй буюу үнэ цэнэгүй хөрөнгө гэж үзэх үндэслэлтэй юм. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн этгээд болох төлбөр төлөгчийг албадах, төлбөр авагчийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх ажиллагаа байх ёстой. Гэтэл дээрх заалт нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадлагыг зөрчигдсөн эрхээ сэргээлгэх гэж буй төлбөр авагчид чиглүүлсэн зохицуулалт байна.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтад “төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан”, 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэгт “... Хэрэв төлбөр авагч авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.”, 73.4 дэх хэсэгт “...Төлбөр авагч татгалзсан бол худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчсөн болохыг тогтоож, хүчингүй болгож өгөхийг хүсье.” гэсэн агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна.

Мөн иргэн А.Базар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “... 31.1.2 ...” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэхийг хянуулахаар мэдээллийн шаардлагын хэмжээг ихэсгэсэн болно.

Хоёр. Нийслэлийн Налайх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн П.Ундрах-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт “Иргэний шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг дараах үндэслэлээр төлбөр авагчид буцаана” гэж заасан ба 31.1.2 дахь заалтад “төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан” гэвэл мөн зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэжээ.

Өөрөөр хэлбэл, төлбөр авагч нь төлбөр төлөгчөөс хураалгасан худалдан борлогдоогүй эд хөрөнгийг заавал төлбөртөө тооцон авах ба хэрэв авахгүй бол өөрийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжгүй, шийдвэр гүйцэтгэх байгууллагад дахин хандах эрхгүй байхаар зохицуулсан нь төлбөр авагчийн эрх зүйн байдлыг дордуулж, Үндсэн

хуульд заасан “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх” иргэний үндсэн эрхийг хязгаарласан байна. Нэгэнт шүүхийн шийдвэр гарсан бол түүний зөрчигдсөн эрхийг гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн хуулийн дагуу сэргээх бөгөөд шүүхийн шийдвэр заавал биелэгдэх хүчинтэй байх ёстой юм.

Төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөртөө тооцон авахаас татгалзсан бол тухайн гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцааж болох боловч төлбөр авагч нь тухайн шийдвэрийг биелүүлэхээр шийдвэр гүйцэтгэх байгууллагад ирүүлэх эрхтэй байх ёстой. Энэ тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дахин шинээр эхлэн төлбөр төлөгчийн эд хөрөнгийг хуульд заасны дагуу эрэх олох ажиллагааг явуулж, төлбөр авагчийн төлбөрийг барагдуулна.

Ингэснээр шүүхийн шийдвэр заавал биелэгдэх, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээх хууль зүйн боломж хадгалагдан үлдэх юм.

Өмнө мөрдөгдөж байсан 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 17.1-д заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан бол түүнийг дахин гүйцэтгүүлэхээр шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлж болно.” гэж заасан байв. Өөрөөр хэлбэл өмнөх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд төлбөр төлөгчөөс гаргуулсан худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагч төлбөртөө тооцон авахаас татгалзсан нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэл болохгүй байв.

Гэтэл шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар энэ боломжийг хааж, төлбөр авагч нь төлбөр төлөгчийн худалдан борлогдоогүй хөрөнгийг заавал авах, ийнхүү аваагүй бол гүйцэтгэх баримт бичгийг дахин ирүүлэх эрхгүйгээр буцааж буй нь шүүхийн шийдвэр гарсан хэдий ч иргэн өөрийнхөө хохирлыг хэзээ ч барагдуулах боломжгүй нөхцөл байдал бий болгож байна.

Иймд Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчсөн эсэхийг тогтоож дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн агуулгатай мэдээлэл ирүүлжээ.

Гурав. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“1. Шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөр төлөгчийн хөрөнгө албадан дуудлага худалдааны журмаар худалдан борлогдоогүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангаж, төлбөр авагчийн төлбөрийг барагдуулах зорилгоор төлбөр авагчид худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөрт санал болгох шаардлага үүсэх бөгөөд энэхүү ажиллагааг дээрх хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу явуулж, үр дүнг нь мөн хуулийн 31.1.2 дахь заалтыг үндэслэн шийдвэрлэхээр хуульчилсан.

Шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх баримт бичигт заасан хөрөнгө, түүнчлэн зарим шаардлагатай тохиолдолд төлбөр төлөгчийн бүхий л хөрөнгөд ажиллагаа явуулсны үндсэн дээр санал болгосон хөрөнгийг төлбөр авагч авахаас татгалзах нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх боломжгүй болгох төдийгүй төлбөр төлөгчийн боломжийг хаах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа олон жил үргэлжлэх, мөн хугацаагаар эргээд төлбөр авагчийн хохирлыг барагдуулах, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэхгүй байх нөхцөлийг үүсгэхээр байна.

Төлбөр авагчийн хувьд хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн нь тогтоогдож, уг зөрчигдсөн эрхийг нь сэргээхээр заавал биелэгдвэл зохих хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гарсан гэдэг утгаараа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эрхийг нь хамгаалах гол оролцогч хэдий ч нөгөө талд нь Монгол Улсын Үндсэн хуулиар эрх, ашиг сонирхол нь хамгаалагдсан, албадлагын шинжтэй арга хэмжээний үйлчлэлд өртөж байгаа төлбөр төлөгчийн эрх ашиг мөн байгаа гэдгийг анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай юм.

Мэдээлэл гаргагчийн мэдээлэлд дурдсанчлан Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... эрхтэй.” гэж заасан нь төлбөр авагчид төлбөр төлөгчийн хөрөнгөөс өөрт таалагдсан, дурын хөрөнгийг сонгож төлбөрт гаргуулах эрхийг олгосон заалт гэж үзэхгүй байна.

Шийдвэр гүйцэтгэгчээс төлбөр төлөгчийн эрхийг хангаж, хохирлыг барагдуулахаар хуульд заасан бүх ажиллагааг хийж гүйцэтгэж, төлбөр төлөгчөөс өөр хөрөнгө байхгүй байгааг баталсан байхад төлбөр авагч санал болгосон хөрөнгийг авахгүй байх нь

гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид хэт давуу байдал бий болгож, зөвхөн өөртөө таалагдсан хөрөнгийг сонгож авах, энэхүү хүсэлтээ илэрхийлсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь тухайн таалагдсан хөрөнгийг нь олж санал болгох хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тасралтгүй үргэлжлэх үр дагаврыг үүсгэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомж, түүний дотор шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх талаарх зохицуулалт нь төлбөр авагчийн эрх ашигт нийцсэн байхаас гадна төлбөр төлөгчийн эрхийг мөн хамгаалах нь зүйтэй гэж үзэж байна.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтад заасан үндэслэлээр буцаасан гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгүүлэхээр хэдэн ч удаа дахин ирүүлэхээр өөрчилбөл төлбөр авагчид хэт давуу байдал бий болгож, зөвхөн өөрт таалагдсан буюу өөрт хэрэгтэй гэж үзсэн хөрөнгийг сонгож авах, энэ тухай хүсэлтээ илэрхийлсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчийн хүссэн хөрөнгийг нь олж санал болгох хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тасралтгүй үргэлжилж болох хязгааргүй байдлыг үүсгэнэ. Энэ нь төлбөр төлөгчийн эрхийг зөрчихөд хүргэж, хэн боловч ямар ч цаг хугацааны хязгааргүйгээр төлбөр төлөгч болох, хэдийд ч тэдгээрийн эрхэд халдаж болох эрсдэлтэй нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

Иргэний эрх зүйн маргааны талууд өөрсдийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, шүүхэд нэхэмжлэл гаргах, нотлох баримт цуглуулах эрх, үүргээ хэрэгжүүлэх эсэхээ өөрөө бие даан шийдэж хэрэгжүүлдэг, үүний нэгэн адил хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг албадан биелүүлсний үр дүнд бий болсон хөрөнгө, эсхүл шүүхийн шийдвэрт төлбөр авагчид шууд шилжүүлэхээр заасан хөрөнгийг хүлээн авах, эсхүл хүлээн авахаас татгалзах нь төлбөр авагчийн өөрийнх нь эрх хэмжээний асуудал гэж үзэж байна.

Тиймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт "... 31.1.2 ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын холбогдох хэсгийг зөрчөөгүй." гэсэн агуулга бүхий тайлбаруудыг гаргажээ.

Дөрөв. Монгол Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөртөө авахаас татгалзсан тохиолдолд төлбөр төлөгч уг эд хөрөнгөөс өөр эд хөрөнгө, банкинд мөнгөн хадгаламж болон харилцах дансанд мөнгөн хөрөнгө, орлогогүй болохыг шийдвэр гүйцэтгэгч холбогдох баримтаар тогтоосон бол төлбөр авагчид гүйцэтгэх баримт бичгийг буцаана гэж шүүхийн практикт тайлбарлан хэрэглэж байсан ба одоо ч энэ тайлбар ач холбогдлоо алдаагүй байна.

Төлбөр төлөгчийн борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагч авахаас татгалзсан, шийдвэр гүйцэтгэлийн байгууллага төлбөр барагдуулах боломжтой бүхий л ажиллагааг хийсэн боловч өөр хөрөнгө тогтоогдоогүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах нь төлбөр төлөгчийн тухайн үеийн эд хөрөнгийн байдалтай холбоотой бөгөөд харин шүүхийн шийдвэр биелэгдэх зарчимтай тул гүйцэтгэх баримт бичгийг буцааж авч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулах боломж нээлттэй байх ёстой.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2002 оны хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсэгт гүйцэтгэх баримт бичгийг буцаахдаа дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй гэж хуульчилсан байсныг 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болгож, тус хуулийн 17.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 17.1-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан бол түүнийг дахин гүйцэтгүүлэхээр шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлж болно.” гэж өөрчилж, Үндсэн хуульд нийцүүлсэн байна.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ийнхүү залруулж зөвтгөж байсан атлаа 2017 оны шинэчилсэн найруулгын 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 31.1.1, 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасан нь төлбөр авагчийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх үндсэн эрхэд нийцээгүй агуулгатай болсон байна.” гэсэн байна.

Тав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөрт тооцон авахаас татгалзсан тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах” эрх зүйн зохицуулалт нь 2002 оны Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх тухай хуулийн 39.8, 48.7 дахь хэсэгт тусгалаа олж, үйл ажиллагаанд 15 жилийн хугацаанд мөрдөгдөж ирсэн нь Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсэгт тус тус дээрх эрх зүйн зохицуулалтууд хэвээр хуульчлагдсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт "Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 31.1.1, 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэх" эрхгүй байхаар хуульчилсан нь төлбөр төлөгчийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа хөрөнгөд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, төлбөрийн шаардлага хангуулахаар гаргуулсан эд хөрөнгө худалдан борлогдоогүй, уг эд хөрөнгөөс өөр хөрөнгө байхгүй тохиолдолд төлбөр авагчид хөрөнгө санал болгох ажиллагааны нөхцөлийг тодорхойлсон байна.

Уг ажиллагааны зорилго нь төлбөр төлөгчийн хөрөнгийг үнэгүйдүүлэх, тэдгээрийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх, өөрт ашиг, орлого бий болгохуйц эд хөрөнгийг авах, эсхүл өндөр үнийн дүнтэй хөрөнгийг өөрийн бага төлбөрийн шаардлагад нийцүүлэн авах төлбөр авагчийн шаардлагыг хуулиар хязгаарлаж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талуудын тэгш эрхийн тэнцвэртэй байдлыг хангахад чиглэгдсэн." гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад иргэн А.Базар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 болон 73.4 дэх хэсэгт "... худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид, ..." гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тухай мэдээллийн шаардлагаасаа татгалзсан болно.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан нөхцөлд гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцааж, түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй байхаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг зөрчсөн байна.

Учир нь дээр дурдсан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан гүйцэтгэх баримт бичгийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй байх талаарх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн зохицуулалт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад төлбөр авагч хөндөгдсөн эрхээ сэргээлгэхээр дахин хандах эрх зүйн боломжийг үгүйсгэж, төлбөр авагчийн эрхийг бүрэн хязгаарласан заалт болсон гэж үзэхээр байна. Түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үр дагаврыг бий болгож, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх эрх зүйн зарчмыг зөрчсөн байна. Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасан нь төлбөр авагчийн хөндөгдсөн эрх, ашиг сонирхлоо бодитоор сэргээлгэх хууль зүйн баталгааг үгүй болгосон гэж үзэж байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсэгт төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаахаар заасан нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүрэн дуусгавар болгох эрх зүйн үр дагаврыг бий болгохооргүй байх бөгөөд иргэдийн мэдээлэлд дурдсан Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх заалтад шууд хамааралгүй гэж үзэхээр байна.

Тиймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтад “төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан;”, 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэгт “... Хэрэв төлбөр авагч авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол ... гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.”, 73.4 дэх хэсэгт “...Төлбөр авагч татгалзсан бол ... гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгохтой холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, хууль зүйн техникийн хувьд засаж залруулах шаардлага байгаа талаар дурдах нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасны “... 31.1.2 ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчөөгүй байна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтад “төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан;”, 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэгт “... Хэрэв төлбөр авагч авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол ... гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.”, 73.4 дэх хэсэгт “...Төлбөр авагч татгалзсан бол ... гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль

зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 31.1.1, 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасны “... 31.1.2 ...” гэсэн хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

6. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ Д.ОДБАЯР
ГИШҮҮД Н.ЧИНБАТ
Д.ГАНЗОРИГ
Ш.ЦОГТОО
Б.БУЯНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2018.06.15 Дугаар 48 Төрийн ордон,
Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны
08 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасны “... 31.1.2...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” Гэснийг зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 08 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2019.01.23 Дугаар 02 Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат, Д.Ганзориг, Ш.Цогтоо, Д.Солонго, Б.Буяндэлгэр, Ш.Солонго, Ц.Нанзаддорж /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал оролцож, мэдээлэл гаргагч, иргэн А.Базар, Э.Ариунзаяа, П.Ундрах-Эрдэнэ нар оролцоогүй болно.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн холбогдох заалт Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан эцэслэн шийдвэрлэж, мөн “Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 08 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолыг хянан хэлэлцлээ.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны оршин суугч, иргэн А.Базар, Баянгол дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч, иргэн Э.Ариунзаяа нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсгийн дагуу төлбөр авагч нь худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөрт тооцон авахаас татгалзсан нөхцөлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудсыг түүнд буцаах бөгөөд мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн дагуу гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад дахин ирүүлэхгүй буюу цаашид тухайн асуудлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэхгүй байх үр дагавартай байна.

Төлбөр авагч нь өөрийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо сэргээлгэхээр шүүхэд хандсаны дагуу шүүхийн зүгээс түүний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлж, буруутай этгээдээс төлбөр авах эрхтэй болохыг нь баталгаажуулсан шүүхийн шийдвэр гардаг. Үүний үндсэн дээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагддаг. Шүүхийн шийдвэр гарч байгаа нь төлбөр авагч буюу эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн иргэний эрхийг хууль зүйн хувьд сэргээж байгаа явдал бол нэхэмжлэгчийн зөрчигдсөн эрхийг бодитойгоор сэргээн эдлүүлэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлдэг. Иймд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох нь иргэний зөрчигдсөн эрхээ сэргээн эдлүүлэх, бодитойгоор хамгаалуулах боломжгүй байдалд хүргэж байгаа хэрэг юм.

Дуудлага худалдаа нь үнэ өрсөлдүүлэх буюу хамгийн өндөр үнэ санал болгосон этгээдэд хөрөнгийг худалдах ажиллагаа тул зах зээлийн хамгийн өндөр үнийг олох боломжтой. Иймд дуудлага худалдаанд түүний тогтоосон үнэлгээний 50 хувиар оруулахад худалдан борлогдоогүй эд хөрөнгийг зах зээлд ямар ч этгээд тийнхүү үнээр авах сонирхолгүй буюу үнэ цэнэгүй хөрөнгө гэж үзэх үндэслэлтэй юм. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн этгээд болох төлбөр төлөгчийг албадах, төлбөр авагчийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх ажиллагаа байх ёстой. Гэтэл дээрх заалт нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадлагыг зөрчигдсөн эрхээ сэргээлгэх гэж буй төлбөр авагчид чиглүүлсэн зохицуулалт байна.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтад “төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан”, 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэгт “... Хэрэв төлбөр авагч авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.”, 73.4 дэх хэсэгт “...Төлбөр авагч татгалзсан бол худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчсөн болохыг тогтоож, хүчингүй болгож өгөхийг хүсье.” гэсэн агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна. Мөн иргэн А.Базар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “... 31.1.2 ...” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэхийг хянуулахаар мэдээллийн шаардлагын хэмжээг ихэсгэсэн болно.” гэсэн мэдээллийг ирүүлжээ.

Хоёр. Нийслэлийн Налайх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн П.Ундрах-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт “Иргэний шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг дараах үндэслэлээр төлбөр авагчид буцаана” гэж заасан ба 31.1.2 дахь заалтад “төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан” гэзд мөн зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэжээ.

Өөрөөр хэлбэл, төлбөр авагч нь төлбөр төлөгчөөс хураалгасан худалдан борлогдоогүй эд хөрөнгийг заавал төлбөртөө тооцон авах ба хэрэв авахгүй бол өөрийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжгүй, шийдвэр гүйцэтгэх байгууллагад дахин хандах эрхгүй байхаар зохицуулсан нь төлбөр авагчийн эрх зүйн байдлыг дордуулж, Үндсэн хуульд заасан “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн

төлүүлэх” иргэний үндсэн эрхийг хязгаарласан байна. Нэгэнт шүүхийн шийдвэр гарсан бол түүний зөрчигдсөн эрхийг гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн хуулийн дагуу сэргээх бөгөөд шүүхийн шийдвэр заавал биелэгдэх хүчинтэй байх ёстой юм.

Төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөртөө тооцон авахаас татгалзсан бол тухайн гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцааж болох боловч төлбөр авагч нь тухайн шийдвэрийг биелүүлэхээр шийдвэр гүйцэтгэх байгууллагад ирүүлэх эрхтэй байх ёстой. Энэ тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дахин шинээр эхлэн төлбөр төлөгчийн эд хөрөнгийг хуульд заасны дагуу эрэх олох ажиллагааг явуулж, төлбөр авагчийн төлбөрийг барагдуулна.

Ингэснээр шүүхийн шийдвэр заавал биелэгдэх, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээх хууль зүйн боломж хадгалагдан үлдэх юм.

Өмнө мөрдөгдөж байсан 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 17.1-д заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан бол түүнийг дахин гүйцэтгүүлэхээр шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлж болно.” гэж заасан байв. Өөрөөр хэлбэл өмнөх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд төлбөр төлөгчөөс гаргуулсан худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагч төлбөртөө тооцон авахаас татгалзсан нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэл болохгүй байв.

Гэтэл шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар энэ боломжийг хааж, төлбөр авагч нь төлбөр төлөгчийн худалдан борлогдоогүй хөрөнгийг заавал авах, ийнхүү аваагүй бол гүйцэтгэх баримт бичгийг дахин ирүүлэх эрхгүйгээр буцааж буй нь шүүхийн шийдвэр гарсан хэдий ч иргэн өөрийнхөө хохирлыг хэзээ ч барагдуулах боломжгүй нөхцөл байдал бий болгож байна.

Иймд Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчсөн эсэхийг тогтоож дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн агуулгатай мэдээллийг ирүүлжээ.

Гурав. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“1. Шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөр төлөгчийн хөрөнгө албадан дуудлага худалдааны журмаар худалдан борлогдоогүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангаж, төлбөр авагчийн төлбөрийг барагдуулах зорилгоор төлбөр авагчид худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөрт санал болгох шаардлага үүсэх бөгөөд энэхүү ажиллагааг дээрх хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу явуулж, үр дүнг нь мөн хуулийн 31.1.2 дахь заалтыг үндэслэн шийдвэрлэхээр хуульчилсан.

Шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх баримт бичигт заасан хөрөнгө, түүнчлэн зарим шаардлагатай тохиолдолд төлбөр төлөгчийн бүхий л хөрөнгөд ажиллагаа явуулсны үндсэн дээр санал болгосон хөрөнгийг төлбөр авагч авахаас татгалзах нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх боломжгүй болгох төдийгүй төлбөр төлөгчийн боломжийг хаах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа олон жил үргэлжлэх, мөн хугацаагаар эргээд төлбөр авагчийн хохирлыг барагдуулах, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэхгүй байх нөхцөлийг үүсгэхээр байна.

Төлбөр авагчийн хувьд хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн нь тогтоогдож, уг зөрчигдсөн эрхийг нь сэргээхээр заавал биелэгдвэл зохих хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гарсан гэдэг утгаараа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эрхийг нь хамгаалах гол оролцогч хэдий ч нөгөө талд нь Монгол Улсын Үндсэн хуулиар эрх, ашиг сонирхол нь хамгаалагдсан, албадлагын шинжтэй арга хэмжээний үйлчлэлд өртөж байгаа төлбөр төлөгчийн эрх ашиг мөн байгаа гэдгийг анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай юм. Мэдээлэл гаргагчийн мэдээлэлд дурдсанчлан Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... эрхтэй.” гэж заасан нь төлбөр авагчид төлбөр төлөгчийн хөрөнгөөс өөрт таалагдсан, дурын хөрөнгийг сонгож төлбөрт гаргуулах эрхийг олгосон заалт гэж үзэхгүй байна.

Шийдвэр гүйцэтгэгчээс төлбөр төлөгчийн эрхийг хангаж, хохирлыг барагдуулахаар хуульд заасан бүх ажиллагааг хийж гүйцэтгэж, төлбөр төлөгчөөс өөр хөрөнгө байхгүй байгааг баталсан байхад төлбөр авагч санал болгосон хөрөнгийг авахгүй байх нь

гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид хэт давуу байдал бий болгож, зөвхөн өөртөө таалагдсан хөрөнгийг сонгож авах, энэхүү хүсэлтээ илэрхийлсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь тухайн таалагдсан хөрөнгийг нь олж санал болгох хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тасралтгүй үргэлжлэх үр дагаврыг үүсгэнэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомж, түүний дотор шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх талаарх зохицуулалт нь төлбөр авагчийн эрх ашигт нийцсэн байхаас гадна төлбөр төлөгчийн эрхийг мөн хамгаалах нь зүйтэй гэж үзэж байна. Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтад заасан үндэслэлээр буцаасан гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгүүлэхээр хэдэн ч удаа дахин ирүүлэхээр өөрчилбөл төлбөр авагчид хэт давуу байдал бий болгож, зөвхөн өөрт таалагдсан буюу өөрт хэрэгтэй гэж үзсэн хөрөнгийг сонгож авах, энэ тухай хүсэлтээ илэрхийлсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчийн хүссэн хөрөнгийг нь олж санал болгох хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тасралтгүй үргэлжилж болох хязгааргүй байдлыг үүсгэнэ. Энэ нь төлбөр төлөгчийн эрхийг зөрчихөд хүргэж, хэн боловч ямар ч цаг хугацааны хязгааргүйгээр төлбөр төлөгч болох, хэдийд ч тэдгээрийн эрхэд халдаж болох эрсдэлтэй нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

Иргэний эрх зүйн маргааны талууд өөрсдийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, шүүхэд нэхэмжлэл гаргах, нотлох баримт цуглуулах эрх, үүргээ хэрэгжүүлэх эсэхээ өөрөө бие даан шийдэж хэрэгжүүлдэг, үүний нэгэн адил хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг албадан биелүүлсний үр дүнд бий болсон хөрөнгө, эсхүл шүүхийн шийдвэрт төлбөр авагчид шууд шилжүүлэхээр заасан хөрөнгийг хүлээн авах, эсхүл хүлээн авахаас татгалзах нь төлбөр авагчийн өөрийнх нь эрх хэмжээний асуудал гэж үзэж байна. Тиймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт "... 31.1.2 ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын холбогдох хэсгийг зөрчөөгүй." гэсэн агуулга бүхий тайлбаруудыг гаргажээ.

Дөрөв. Монгол Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөртөө авахаас татгалзсан тохиолдолд төлбөр төлөгч уг эд хөрөнгөөс өөр эд хөрөнгө, банкинд мөнгөн хадгаламж болон харилцах дансанд мөнгөн хөрөнгө, орлогогүй болохыг шийдвэр гүйцэтгэгч холбогдох баримтаар тогтоосон бол төлбөр авагчид гүйцэтгэх баримт бичгийг буцаана гэж шүүхийн практикт тайлбарлан хэрэглэж байсан ба одоо ч энэ тайлбар ач холбогдлоо алдаагүй байна.

Төлбөр төлөгчийн борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагч авахаас татгалзсан, шийдвэр гүйцэтгэлийн байгууллага төлбөр барагдуулах боломжтой бүхий л ажиллагааг хийсэн боловч өөр хөрөнгө тогтоогдоогүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах нь төлбөр төлөгчийн тухайн үеийн эд хөрөнгийн байдалтай холбоотой бөгөөд харин шүүхийн шийдвэр биелэгдэх зарчимтай тул гүйцэтгэх баримт бичгийг буцааж авч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулах боломж нээлттэй байх ёстой. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2002 оны хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсэгт гүйцэтгэх баримт бичгийг буцаахдаа дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй гэж хуульчилсан байсныг 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болгож, тус хуулийн 17.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 17.1-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан бол түүнийг дахин гүйцэтгүүлэхээр шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлж болно.” гэж өөрчилж, Үндсэн хуульд нийцүүлсэн байна.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ийнхүү залруулж зөвтгөж байсан атлаа 2017 оны шинэчилсэн найруулгын 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 31.1.1, 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасан нь төлбөр авагчийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх үндсэн эрхэд нийцээгүй агуулгатай болсон байна.” гэсэн байна.

Тав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөрт тооцон авахаас татгалзсан тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах” эрх зүйн зохицуулалт нь 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 39.8, 48.7 дахь хэсэгт тусгалаа олж,

үйл ажиллагаанд 15 жилийн хугацаанд мөрдөгдөж ирсэн нь Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсэгт тус тус дээрх эрх зүйн зохицуулалтууд хэвээр хуульчлагдсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт "Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 31.1.1, 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэх" эрхгүй байхаар хуульчилсан нь төлбөр төлөгчийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа хөрөнгөд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, төлбөрийн шаардлага хангуулахаар гаргуулсан эд хөрөнгө худалдан борлогдоогүй, уг эд хөрөнгөөс өөр хөрөнгө байхгүй тохиолдолд төлбөр авагчид хөрөнгө санал болгох ажиллагааны нөхцөлийг тодорхойлсон байна.

Уг ажиллагааны зорилго нь төлбөр төлөгчийн хөрөнгийг үнэгүйдүүлэх, тэдгээрийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх, өөрт ашиг, орлого бий болгохуйц эд хөрөнгийг авах, эсхүл өндөр үнийн дүнтэй хөрөнгийг өөрийн бага төлбөрийн шаардлагад нийцүүлэн авах төлбөр авагчийн шаардлагыг хуулиар хязгаарлаж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талуудын тэгш эрхийн тэнцвэртэй байдлыг хангахад чиглэгдсэн." гэсэн байна.

Зургаа. Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн дунд суудлын хуралдаанаар энэхүү маргааныг хэлэлцэж 08 дугаар дүгнэлт гаргасан байна.

Уг дүгнэлтийн үндэслэх хэсэгт:

" 1. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад иргэн А.Базар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 болон 73.4 дэх хэсэгт "... худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид, ..." гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тухай мэдээллийн шаардлагаасаа татгалзсан болно.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан нөхцөлд гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцааж, түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй байхаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт

“Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг зөрчсөн байна. Учир нь дээр дурдсан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан гүйцэтгэх баримт бичгийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй байх талаарх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн зохицуулалт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад төлбөр авагч хөндөгдсөн эрхээ сэргээлгэхээр дахин хандах эрх зүйн боломжийг үгүйсгэж, төлбөр авагчийн эрхийг бүрэн хязгаарласан заалт болсон гэж үзэхээр байна. Түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үр дагаврыг бий болгож, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх эрх зүйн зарчмыг зөрчсөн байна. Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасан нь төлбөр авагчийн хөндөгдсөн эрх, ашиг сонирхлоо бодитоор сэргээлгэх хууль зүйн баталгааг үгүй болгосон гэж үзэж байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1, 73.4 дэх хэсэгт төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаахаар заасан нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүрэн дуусгавар болгох эрх зүйн үр дагаврыг бий болгохооргүй байх бөгөөд иргэдийн мэдээлэлд дурдсан Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх заалтад шууд хамааралгүй гэж үзэхээр байна.

Тиймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтад “төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан;”, 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэгт “... Хэрэв төлбөр авагч авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол ... гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.”, 73.4 дэх хэсэгт “...Төлбөр авагч татгалзсан бол ... гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх

үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгохтой холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, хууль зүйн техникийн хувьд засаж залруулах шаардлага байгаа талаар дурдах нь зүйтэй байна.

Дүгнэлтийн тогтоох хэсэгт:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасны “... 31.1.2 ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн ... 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчөөгүй байна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтад “төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан;”, 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэгт “... Хэрэв төлбөр авагч авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол ... гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.”, 73.4 дэх хэсэгт “...Төлбөр авагч татгалзсан бол ... гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 31.1.1, 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасны “... 31.1.2 ...” гэсэн хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

5. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.” гэжээ.

Долоо. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцээд 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 48 дугаар тогтоолыг гаргасан байна. Уг тогтоолд:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн … 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасны “… 31.1.2…” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц … хууль зүйн … баталгааг бүрдүүлэх, … хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 08 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй. ” гэсэн байна.

Найм: Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

“... Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх зорилгоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас төлбөр төлөгчийн бүхий л хөрөнгөнд ажиллагаа явуулах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх нарийн, шат дараалсан ажиллагаанууд болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын тэр дундаа төлбөр авагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, мөн шүүхийн шийдвэрийг түргэн шуурхай, бүрэн гүйцэд биелүүлэхэд чиглэгдсэн зохицуулалтыг хуульчилсан.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь илт төлбөрийн шаардлагад нийцээгүй, тохироогүй буюу төлбөр авагчийн эрх, ашиг сонирхолд нийцэхгүй шийдвэр гаргасан тохиолдолд түүний шийдвэрт гомдол гаргах, түүний шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгуулах зэрэг төлбөр авагч өөрийн эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн гэж үзвэл хуульд заасан журмын дагуу шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргаж, шийдвэрлүүлэх эрх нь уг хуулиар нээлттэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн дагуу төлбөр авагчийн хөндөгдсөн эрхийг хангах, учирсан хохирлыг барагдуулахаар хуульд заасан бүхий л арга хэмжээг авсны үндсэн дээр бий болсон хөрөнгийг санал болгож байгаа нь төлбөр авагчийн хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх хууль зүйн баталгаа болж, Үндсэн хуульд заасан эрхийг нь хангаж байгаа явдал юм.

Нөгөө талаас дээр дурдсанчлан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас төлбөр төлөгчийн бүхий л хөрөнгөнд ажиллагаа явуулсны үр дүнд бий болсон, санал болгож буй хөрөнгийг төлбөр авагч авахаас татгалзах нь шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байдалд хүргэх төдийгүй төлбөр төлөгчийн хөрөнгө, орлого, төлбөрийн чадварт нийцүүлэн төлбөрийг хэсэгчлэн төлүүлэх боломжгүй байдлыг бий болгож, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тодорхойгүй хугацаагаар үргэлжлэх, төлбөр авагчийн эрхийг мөн хугацаагаар сэргээн эдлүүлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэх юм. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн Хоёрдугаар бүлэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн явцад хүний эрх зөрчихөөс сэргийлэх, ялангуяа эд хөрөнгө албадан гаргуулахдаа өмчлөгчийн эрхийг нэгэн адил хамгаална.” гэж заасан байна.

Төлбөр авагчийн хувьд эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн, түүний зөрчигдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэхээр заавал биелэгдвэл зохих хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гарсан тул шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эрхийг нь нэн тэргүүнд хамгаалахын зэрэгцээ нөгөө талд нь төлбөр авагчийн нэгэн адил Үндсэн хуулиар эрх, ашиг сонирхол нь хамгаалагдсан, албадлагын шинжтэй арга хэмжээний үйлчлэлд өртөж, түүний улмаас эрх, ашиг сонирхол нь тодорхой хэмжээнд зөрчигдөж байгаа төлбөр төлөгчийн эрх, ашиг сонирхол байдаг бөгөөд хууль тогтоогч шүүхийн шийдвэр гүйцэтгэх

ажиллагааны талуудад эрх, ашиг сонирхлоо хамгаалах тэгш боломж, нөхцөл бүрдүүлэх буюу төлбөр төлөгч, төлбөр авагч хэн алины эрх ашгийг адил тэнцүү хамгаалах нь төрийн үндсэн үүрэг гэдгийг харгалзан үзсэн болно.

Хэрэв Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтад заасан үндэслэлээр буцаасан гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгүүлэхээр хэдэн ч удаа дахин ирүүлж болохоор зохицуулалтыг өөрчилбөл төлбөр авагчид хэт давуу байдлыг бий болгож, зөвхөн өөрт таалагдсан буюу өөрт хэрэгтэй гэж үзсэн хөрөнгийг гаргуулах, энэ тухай хүсэлтээ илэрхийлсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчийн хүссэн хөрөнгийг нь олж санал болгох хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тасралтгүй үргэлжлэх, цаашлаад төлбөр авагчид санал болгосон хөрөнгө нь төлбөр авагчид таалагдсан, ашигтай биш л бол хөрөнгийг хүлээн авахаас татгалзаж, хүссэн хөрөнгийг бий болтол ажиллагааг дахин дахин явуулах хязгааргүй байдлыг үүсгэнэ. Энэ нь төлбөр төлөгчийн эрхийг зөрчихөд хүргэж, хэн боловч ямар ч цаг хугацааны хязгаарлалтгүйгээр төлбөр төлөгч байсаар байх, хэдийд ч тэдгээрийн эрхэд халдаж болох эрсдэлтэй нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

Иймээс Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 08 дугаар дүгнэлтийг хэлэлцээд хүлээн авах боломжгүй гэж үзсэн.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

“ ... Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөрт тооцон авахаас татгалзсан нөхцөлд гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцааж, түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй байхаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 08 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн … 31.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан тохиолдолд түүнийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлэхгүй.” гэж заасны “... 31.1.2 ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц … хууль зүйн … баталгааг бүрдүүлэх, … хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн тул хүчингүй болгосугай.

2. “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 08 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ	Д.ОДБАЯР
ГИШҮҮД	Н.ЧИНБАТ
	Д.ГАНЗОРИГ
	Ш.ЦОГТОО
	Д.СОЛОНГО
	Б.БУЯНДЭЛГЭР
	Ш.СОЛОНГО
	Ц.НАНЗАДДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.06.13 Дугаар 09 Улаанбаатар хот

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 9.2 дугаар зүйлийн 13 дахь хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 14.30 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг /илтгэгч/, Ш.Цогтоо, Д.Солонго, Г.Туулхүү нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар О.Мөнхзулыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн А.Анхбаяр, Б.Батдэлгэр, О.Баясгалан, Г.Нацагдорж, С.Номынбаясгалан болон иргэн Б.Батдэлгэрийн өмгөөлөгч Л.Намнансүрэн, Д.Түмэнжаргал нар оролцов. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг болон 9.2 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна.” гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх

хэсэг, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцлээ.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн А.Дорждэрэм, түүнчлэн Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч, иргэн А.Анхбаяр нар Үндсэн хуулийн цэцэд тус тус хандаж:

“Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, мөн хуулийн 9.2 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна.” гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчиж байна.

Давж заалдах шатны шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байхаар хуульчилсан нь нэгдүгээрт Монгол Улсын дээд шүүхийн доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх бүрэн эрхэд халдаж, эрхээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан, хоёрдугаарт Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх зарчмын гол агуулгыг зөрчиж байна.” гэсэн агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна.

Хоёр. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Батдэлгэр Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.2 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ...” гэж заасныг зөрчсөн байх тул уг асуудлаар маргаан үүсгэн, хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж өгнө үү.” гэсэн мэдээллийг ирүүлжээ.

Гурав. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн С.Номынбаясгалан Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт, мөн хуулийн 9.2 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “Зөрчлийн

хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна.” гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах, ... эрхтэй. ...”, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гээд 2 дахь заалтад “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ...” гэж заасныг тус тус зөрчсөн байна. Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэрт хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй байхаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгосон иргэний гомдол гаргах эрхийг ноцтой зөрчиж байна.” гэсэн агуулгатай мэдээллийг ирүүлж, мэдээлэлдээ Үндсэн хуулийн цэцийн хэд хэдэн шийдвэрийг дурдсан байна.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд бэлтгэх ажиллагааны явцад дээрх иргэдийн мэдээлэлтэй адил агуулга бүхий мэдээллийг нийслэлийн Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны оршин суугч, иргэн О.Баясгалан, Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны оршин суугч, иргэн Г.Нацагдорж нар ирүүлснийг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж, нэгтгэн шалгасан болно.

Тав. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Хүний эрхийн түгээмэл Тунхаглалын 8 дугаар зүйлд “... эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй.” гэж, Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй гэж заасан бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй байхаар хуульчилсан байна. Түүнчлэн, “хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө

төр хариуцна.” гэж заасан нь төрийн байгууллага, тэр дундаа төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй байх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахаар заасан байна.

Иргэн захиргааны байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулах, хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд гомдлоо гаргах эрх нь Үндсэн хуулиар мөн олгогджээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, мөн хуулийн 9.2 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн “Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна.” гэж заасан нь өмнөх эрх зүйн зохицуулалт буюу 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсон Захиргааны хариуцлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Захиргааны шийтгэл ногдуулсан шийдвэрийг зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгч давж заалдах эрхтэй.” гэж зааснаар шийтгэл оногдуулсан шийдвэрийг давж заалдах эрхийг зөрчил үйлдсэн болон хохирогч аль алинд нь олгох, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны талууд давж заалдах гомдлын зохих дээд шатны эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн орон нутгийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.” гэж эцсийн шийдвэрийг шүүх гаргахаар заасныг уламжлан хуульчилсан зохицуулалт юм.

Харин Захиргааны хариуцлагын тухай хуулиар шийтгэл оногдуулсан шийдвэртэй холбоотой гомдлыг салангид байдлаар өөр өөр субьектэд гаргаж байсныг өөрчилж иргэдэд хүндрэл учруулахгүйгээр шууд шүүхэд гомдол гаргах, анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл давж заалдах эрхтэй байхаар дэлгэрүүлж заасан болно.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар эрүүгийн хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх зөрчлийн хэрэг маргаан нь эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гаргасан оролцогчийн гомдол, эсхүл тухайн шийдвэртэй холбогдуулан гаргасан прокурорын дүгнэлтээр зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахаар зохицуулсан ба мөн Зөрчлийн тухай хуульд заасан 13 төрлийн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахаар

хуульд тусгасан. Өөрөөр хэлбэл, дээрх зөрчлүүдэд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг богино хугацаанд хялбаршуулсан журмаар хэрэгжүүлэх нь чухал бөгөөд зөрчил үйлдсэнийг нотлоход гэм буруутай байх эсэх шалгуур шаардлагагүй, мөн эрх бүхий албан тушаалтан нь прокурорын хяналтын доор хуульд заасан үндэслэл, журмын дагуу нотлох ажиллагааг явуулахаар зохицуулсан.

Түүнчлэн, оролцогчдын давж заалдах эрхийг нээж, шийтгэл оногдуулсан шийдвэртэй холбоотой гомдлыг хэн нэгэн эрх бүхий албан тушаалтан бус шүүх эцэслэн шийдвэрлэх нь чухал тул шийтгэл оногдуулсантай холбоотой маргааны хувьд давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байхаар хуульд тусгасан болно.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, мөн хуулийн 9.2 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн “Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна.” гэж заасан нь Үндсэн хуулиар иргэдэд олгосон “шүүхийн шийдвэрийг давж заалдах” эрхийг зөрчөөгүй байна гэжээ.

Зургаа. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар уг маргааныг хянан шийдвэрлэхээр товлосон Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн дунд суудлын хуралдаанд орон нутагт томилолтоор ажиллах болсон тул Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг хойшлуулж өгөхийг хүссэн албан бичгийг ирүүлсэн.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн дунд суудлын хуралдаанд мөн ижил шалтгаанаар хуралдааныг хойшлуулж өгөхийг хүссэн албан бичиг дахин ирүүлсэн болно. Дээрх хүсэлтийн дагуу Цэцийн дунд суудлын хуралдааныг хойшлуулах боломжгүй гэж үзлээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг болон 9.2 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна.” гэж тус тус заасан байна.

Мөн уг хуулийн 8.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Гучин найм, Гучин есдүгээр бүлэгт заасан үндэслэл, журмыг баримтална.” гэж, харин 9.2 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт “Шүүгчийн шийтгэвэрт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Гучин найм, Гучин есдүгээр бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу оролцогч гомдол гаргаж, прокурор эсэргүүцэл бичнэ.” хэмээн хуульчилжээ.

2. Аливаа хэрэг, маргаан болон гомдлын онцлогоос хамааруулан тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх хэлбэр, үе шат, журмыг ялгамжтай байдлаар хуульчлан тогтоох боломжтой. Ийнхүү хуульчлан зохицуулахдаа хууль тогтоогч нь холбогдох хуульд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон эрх зүйн үндэслэлийг нарийвчлан тусгах ёстой бөгөөд үүний үр дүнд иргэний Үндсэн хуулиар баталгаажсан процессын эрх болон хууль зүйн тодорхой байдал, хууль дээдлэх зарчим хангагдана.

Өөрөөр хэлбэл, тухайн шийдвэрлэх хэрэг, маргааны онцлогоос хамааран тусгай журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээр зохицуулж ямар шүүх эцсийн шийдвэр гаргах (шүүхийн гурван шатыг дамжихгүйгээр)-ыг хуулиар тогтоох боломжтой юм.

Иймд зөрчлийн хэргийн мөн чанар, түүний эрүүгийн хэргээс ялгагдах онцлог болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тусгай журамтай уялдуулан хууль тогтоогчоос Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх доод шатны шүүх (ерөнхий харьяаллын шүүх)-ийн шийдвэрийг бүхэлд нь (тухайн зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэсэн ажиллагаа болон шийдвэр, холбогдох үйл баримт зэргийг) хянаж эцэслэн шийдвэрлэхээр зохицуулсан нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байна.

Тодруулбал, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг болон 9.2 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна.” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ... шүүхийн шийдвэрийг

давж заалдах, ... эрхтэй. ...", Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.", Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын Монгол Улсын дээд шүүх "давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;" гэснийг, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Хууль тогтоогч Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг батлахдаа эрүүгийн болон захиргааны эрх зүйн суурь үзэл баримтлал, ерөнхий зарчмыг алдагдуулж, тухайлбал эрүүгийн эрх зүйн харилцаанд хамаарахгүй байж болохуйц зөрчлийн хэргийг эрүүгийн хэргийн шүүхийн харьяалалд оруулах, эрүүгийн хэргийн шүүхийн хэрэглэх (баримтлах) хууль нь төрөлжсөн байх талаарх үндсэн зарчмыг зөрчиж хэд хэдэн хуулиар зохицуулсан зэрэг нь иргэдээс Үндсэн хуулийн цэцэд хандаж мэдээлэл, өргөдөл гаргах үндэс болсон гэж үзэхээр байна. Үүнээс үзэхэд зөрчлийн тухай хууль тогтоомжийг батлан мөрдүүлэхдээ салбар эрх зүйн зарчмыг хэлбэрэлтгүй сахих, төрөлжүүлэн системчлэх, хүний үндсэн эрхийг хангахуйц эрх зүйн зохицуулалтыг бий болгох зэрэг хуулийг боловсронгуй болгох шаардлага байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт "Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна." гэж, мөн хуулийн 9.2 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт "Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна." гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй. ...", Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "... Дагнасан шүүхийн үйл

ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;” гэснийг, мөн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ...” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Н.ЧИНБАТ
ГИШҮҮД	Д.ГАНЗОРИГ
	Ш.ЦОГТОО
	Д.СОЛОНГО
	Г.ТУУЛХҮҮ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.08.22 Дугаар 10 Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 15.30 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Цэцийн гишүүн Н.Чинбат, Д.Солонго /илтгэгч/, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч, иргэн С.Мөнхцэцэг, мэдээлэл гаргагч, иргэн Б.Оюу, А.Гулим болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Хэнтий аймгийн Баянхутаг сумын 2 дугаар багийн оршин суугч, иргэн С.Мөнхцэцэг Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"... Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолын 1, 2 дахь заалтаар Хэнтий аймгийн 42 дугаар тойрогт нөхөн сонгуулийг 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс товлон зарлаж, санал авах өдрийг мөн оны 10 дугаар сарын 7-ны өдрөөр тогтоосон ба мөн тогтоолын 3 дахь заалтаар тогтоолын хэрэгжих хугацааг заасан байна.

Миний бие төрийн жинхэнэ албан хаагч бөгөөд Үндсэн хуульд заасан төрийн байгууллагад сонгогдох эрхийн дагуу энэхүү нөхөн сонгуульд нэр дэвшихээр шийдээд байгаа юм. Нөхөн сонгуулийг Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "... энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлах"-аар зохицуулсан байна.

Үндсэн хууль болон Сонгуулийн тухай хуульд Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг 4 жил тутам явагдахаар цаг хугацааг нь тодорхой заасан бөгөөд иргэн хүн сонгуульд нэр дэвших эсэхээ эртнээс шийдэж, хуулиар тогтоосон шаардлагыг ханган оролцох боломжтой байдаг. Харин нөхөн сонгууль нь Сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 болон 137 дугаар зүйлийн 137.6 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдсөн, гишүүнийг эгүүлэн татсан, гишүүн нас барсан тохиолдолд орон гарсан суудлыг нөхөх зорилгоор явагдах бөгөөд нөхөн сонгууль явагдах эсэхийг урьдчилан тааж мэдэх ямар ч боломжгүй байдаг болно. Гэтэл энэ удаа нөхөн сонгууль зарлахад Сонгуулийн тухай хуульд нэгэнт товлон зарласан нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагчдыг хэрхэн оролцуулах тухай зохицуулалт огт тусгагдаагүй хийдэл үүссэн байна.

Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт "Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал нь Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ эрх бүхий этгээдэд гаргасан байх ба сонгуулийн жилийн нэгдүгээр сарын 31-ээс хойш ажил, албан үүргээ гүйцэтгээгүй байна.", Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт

“Төрийн жинхэнэ албан хаагч Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших бол тухайн ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ... төрийн албанаас чөлөөлөгдөх өргөдлөө төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд гаргана. ... Сонгуульд нэр дэвшихтэй холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагч өргөдлөө гаргаагүй нь тухайн төрийн байгууллага түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй.” гэж тус тус заасан.

Дээрх хуулиудын зохицуулалтаас үзэхэд ээлжит сонгуульд нэр дэвших төрийн жинхэнэ албан хаагч нь “... сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ...”, “... тухайн ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ...” гэж төрийн албанаас чөлөөлөгдсөн байх хугацааг тодорхой заасан байна. Гэтэл нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагчид хэзээ, хэрхэн ажлаасаа чөлөөлөгдөн оролцох зохицуулалтыг орхигдуулснаас төрийн байгууллагад ажиллаж буй төрийн жинхэнэ албан хаагчид нөхөн сонгуульд оролцохын тулд одоо ажлаасаа чөлөөлөгдөхөд дээр дурдсан хугацааны шаардлагыг хангаж чадахгүй тул сонгуульд оролцох боломжгүй болж байна. ...

Иймд төрөөс Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчдыг нөхөн сонгуульд оролцох зохицуулалтыг тодорхой болгосны үндсэн дээр тус нөхөн сонгуулийг зарлах нь Үндсэн хуульд нийцэх бөгөөд улмаар төрийн жинхэнэ албан хаагчид Үндсэн хуулиар олгогдсон сонгогдох эрхээ эдлэх хууль зүйн баталгаа бүрдэх юм.

Ийнхүү төрийн жинхэнэ албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа бүрдээгүй байхад нөхөн сонгууль болсон тохиолдолд нэр дэвших хүсэлт гаргасан боловч дээр дурдсан шаардлагыг хангаагүй үндэслэлээр сонгуульд оролцож чадаагүй төрийн албан хаагчид өргөдөл, мэдээлэл гаргасны улмаас нөхөн сонгууль бүхэлдээ хүчингүйд тооцогдож, дахин сонгууль болох улмаар үр дүнгүй их хэмжээний зардал гарч, улс орны эдийн засагт хохирол учруулах нөхцөл байдал бий болохыг үгүйсгэх аргагүй.

Энэ бүхний эцэст төрийн жинхэнэ албан хаагчид бид аливаа сонгууль болохоос өмнө хуулиар тогтоосон боломжит хугацаанд албан тушаалаасаа чөлөөлөгдөж, сонгуульд нэр дэвшиж, Үндсэн хуульд заасан сонгогдох эрхээ эдлэх хүсэлтэй байна. Тиймээс нөхөн сонгуульд төрийн албан хаагчид хэрхэн, яаж оролцохыг хуулиар

тодорхой зохицуулсны дараа нөхөн сонгуулийг зарлах нь хууль дээдлэх ёс, эрх зүйт төрийн зарчим, үндсэн хуульт ёсонд нийцнэ. Үүний зэрэгцээ Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол дараахь байдлаар Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна:

1. Төрийн албан хаагчдыг нөхөн сонгуульд оролцуулах хуулийн зохицуулалтыг орхигдуулж, хууль зүйн баталгаа хангах үүргээ төр биелүүлээгүй байхад нөхөн сонгууль зарласан нь төрийн жинхэнэ албан хаагчдыг нөхөн сонгуульд оролцох боломжгүй болгож, улмаар иргэн хүн сонгогдох эрхээ эдлэхэд тэгш бус шаардлага тавьж байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасныг зөрчиж байна.

2. Төрийн жинхэнэ албанд ажилласных нь төлөө иргэнд хуулиар биелүүлэх боломжгүй шаардлага тавьж, сонгогдох эрхийг хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулийн суурь зарчмыг үгүйсгэж, улмаар хүнийг эрхэлж буй ажил, албан тушаалынх нь хувьд шууд ялгаварлан гадуурхсан гэж үзэхээр байгаа ба энэ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ..." гэж заасныг зөрчөөд байна.

3. Сонгуулийн тухай хуульд нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагч хэрхэн оролцох талаар зохицуулалтыг тодорхой тусгаагүй орхигдуулсан ба албан тушаалаасаа чөлөөлөгдөх хуулийн шаардлага нь нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагчийг нэр дэвшүүлэх боломжгүй болгож, тэгш бус нөхцөлийг тулгаж, улмаар иргэний төрийн байгууллагад сонгогдох эрхийг ноцтойгоор зөрчиж байна. Түүнчлэн иргэний төрийн байгууллагад сонгогдох эрхийн хууль зүйн баталгааг төрөөс бүрэн хангаагүй байхад нөхөн сонгуулийг товлон зарласан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ..." гэж заасныг зөрчиж байна.

4. Улсын Их Хурлаас баталсан хууль нь Үндсэн хуульд заасан төрийн байгууллагад сонгогдох эрхийг бүрэн хангахад чиглэсэн баталгаа болохуйц байх ёстой. Хууль тогтоогчийн зүгээс Сонгуулийн тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргээ биелүүлээгүй, зохицуулалтыг орхигдуулсан буюу төрийн жинхэнэ албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа хангагдаагүй байхад Улсын Их Хурлын 62 дугаар тогтоолоор нөхөн сонгуулийн тов зарлаж, санал авах

өдрийг тогтоосон, мөн төрийн алба улс төрөөс ангид байх зарчмыг хэрэгжүүлэх зохицуулалт тодорхойгүй, ойлгомжгүй байгаа нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...” гэж заасан үүргээ зөрчсөн гэж үзэхээр байна.

5. Сонгуулийн тухай хуулиар нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагч оролцох эрхийн хууль зүйн баталгааг бүрэн хангаагүй атал Сонгуулийн ерөнхий хороо төрийн жинхэнэ албан хаагчийг нэр дэвшигчид тавигдах шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзах шийдвэр гаргах нөхцөл байдал үүсч, улмаар Үндсэн хуульд заасан хэзээ ч хязгаарлаж үл болох иргэний баталгаатай эдлэх улс төрийн эрхийг хязгаарлаж Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчсөн шийдвэр болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж тус тус заасныг зөрчсөн байх тул хянан хэлэлцэж, дүгнэлт гаргаж өгнө үү.” гээд өргөдлийн үндэслэлээ баталгаажуулан хавсарган ирүүлсэн баримтад:

Иргэн С.Мөнхцэцэгийн Сонгуулийн ерөнхий хороонд хандаж Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд (2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс товлон зарласан) нэрээ дэвшүүлэх хүсэлтэй төрийн албан хаагч эрхэлж буй ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ хэзээ гаргаж, хэзээ чөлөөлөгдсөн байх шаардлагатай талаар тодруулга хүсэхэд, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албанаас 2018 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 66 дугаар албан бичгээр “Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсгийн зохицуулалтыг тусгаад Сонгуулийн төв байгууллагын хувьд хуулийг баримтлан ажиллах бөгөөд хууль тогтоомжийг тайлбарлах эрх хэмжээ

тус байгууллагад олгогдоогүй тул тайлбар, тодруулга өгөх боломжгүй юм.” гэсэн хариуг өгсөн байна.

Хоёр. Нийслэлийн Баянгол дүүргийн 3 дугаар хороонд оршин суугч, иргэн Э.Эрдэнэцэцэг, Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороонд оршин суугч, иргэн Б.Оюу, Баянзүрх дүүргийн 25 дугаар хороонд оршин суугч, иргэн А.Гулим нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“Улсын Их Хурлаас 2018 оны 62 дугаар тогтоол гарснаар төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирлын албан тушаал эрхэлж байгаа иргэд Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох боломжгүй болоод байна. Учир нь Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт дурдсан төрийн албан хаагчид Сонгуулийн тухай хуульд заасан нэр дэвшигчид тавигдах нийтлэг шаардлагаас гадна нөхөн сонгуульд нэрээ дэвшүүлэхийн тулд сонгуулийн жил буюу 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ өгч, 1 дүгээр сарын 31-ний өдрөөс хойш албан үүргээ гүйцэтгэхгүй байх нэмэлт шаардлага тавьсан нь одоо ажлаа эрхэлж буй албан хаагч нь энэхүү шаардлагыг хангаагүй гэдэг үндэслэлээр нэр дэвшигчээр бүртгэхгүй байх улмаар Үндсэн хуульд заасан төрийн байгууллагад сонгогдох эрх зөрчигдөхөөр байна.

Нөхөн сонгууль нь Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдсөн, гишүүнийг эгүүлэн татсан, гишүүн нас барсан тохиолдолд орон гарсан суудлыг нөхөх зорилгоор явагдах бөгөөд Сонгуулийн тухай хуулиар дээр дурдсан албан хаагчийг нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгааг бүрдүүлээгүй байна. ... Ийнхүү дээр дурдсан төрийн албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа хангагдаагүй байхад Улсын Их Хурлаас 62 дугаар тогтоол гаргаж, нөхөн сонгуулийг зарлан иргэний төрийн байгууллагад сонгогдох эрх төрийн байгууллагын буруугаас зөрчигдөхөд хүргэж, улмаар төрийн албанд ажилласны төлөө нэрээ дэвшүүлэх эрхийг бүрмөсөн хязгаарлаж байгаа нь улс төрийн сонгуульд нэр дэвшигчид ижил тэнцүү нөхцөлд, шударгаар өрсөлдөх боломжийг бүрдүүлэх бус харин эсрэгээрээ Үндсэн хуулийн үндсэн зарчмыг үгүйсгэсэн Үндсэн хуулийн зөрчил юм. ...

Иймд Сонгуулийн тухай хуулиар дээр дурдсан төрийн албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа бүрэн хангагдаагүй

байхад баталсан Улсын Их Хурлын 62 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэсэн заалтыг зөрчсөн, Үндсэн хуульд нийцээгүй шийдвэр болсон гэж үзэж байна.” гэжээ.

Гурав. Уг маргаанд холбогдуулан Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцангаас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хариу тайлбартаа:

“Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоолыг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг үндэслэн баталсан. Уг тогтоол нөхөн сонгуулийг эхлэх өдөр болон санал авах ажиллагааг явуулах өдрийг тогтоосон хоёр заалттай бөгөөд тухайн сонгуульд нэр дэвшүүлэхэд тавигдах шаардлагын талаар тусгайлан зааж төрийн албан хаагчийн эрхийг хязгаарласан заалт уг тогтоолд байхгүй юм.

Иргэдийн өргөдөл, мэдээлэлд дурдсан Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт төрийн албан хаагч сонгуульд нэр дэвшүүлэхэд тавигдах шаардлагыг заахдаа “... Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ...” гэж заасан бөгөөд “сонгуулийн жил” гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна.

“Сонгуулийн жил” гэж мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад зааснаар дөрвөн жил тутам явагдах ээлжит сонгуулийн жилийг ойлгоно. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт зааснаар сонгууль нь ээлжит, ээлжит бус, нөхөн, дахин гэсэн төрлүүдтэй байх бөгөөд “Ээлжит сонгууль гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2, Гучдугаар зүйлийн 2, Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт тус тус заасны дагуу дөрвөн жил тутам явагдах сонгуулийг хэлнэ.” гэж заажээ. Одоо бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурал нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан дөрвөн жил тутам явагдах сонгуулийн үр дүнд байгуулагдсан бөгөөд 2016 онд явагдсан

энэхүү сонгууль нь Сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад заасан ээлжит сонгууль юм. Харин Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт товлон зарласан сонгууль нь Сонгуулийн тухай хуулийн мөн зүйлийн 8.1.3 дахь заалтад заасан нөхөн сонгууль билээ. Эндээс үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт заасан "сонгуулийн жил" гэдэгт дөрвөн жил тутам явагдах ээлжит сонгуулийн жилийг ойлгох бөгөөд "сонгууль явуулах тухайн жил" гэсэн ойлголтыг агуулаагүй байгаа тул төрийн албанаас чөлөөлөгдөх шаардлагад заасан хугацаа нь Улсын Их Хурлын нөхөн сонгуульд нэр дэвшүүлэхэд хамаарахгүй юм.

Түүнчлэн Сонгуулийн тухай хууль батлагдсанаар хүчингүйд тооцогдсон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт "Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна." гэж заасан нь одоогийн хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт заасантай хугацааны хувьд ижил шаардлага тавьж байсан бөгөөд уг заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг Үндсэн хуулийн цэцээс өмнө нь хянан шийдвэрлэж 2015 оны 12 дугаар дүгнэлт болон мөн оны 10 дугаар тогтоолыг баталсан байна.

Үндсэн хуулийн цэцийн дээрх шийдвэрт "...Төрийн жинхэнэ буюу мэргэшсэн алба хаагчдыг ажил, мэргэжлийн онцлог, хэрэгжүүлэх чиг үүргийг харгалзан улс төрийн үйл ажиллагаанаас ангид байлгах, төвийг сахисан байр суурийг хадгалахад чиглэсэн тусгай шаардлага, шалгуурыг тэдэнд тавьж холбогдох хуулиар зохицуулах нь хууль тогтоогчийн бүрэн эрхийн асуудал юм. ... Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... шударга ёс, ... үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын "... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ..." гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна." гэж дурдсанаас үзэхэд сонгуульд нэр дэвших төрийн албан хаагчийн төрийн албанаас чөлөөлөгдөх хугацааны шаардлагыг Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад “Улсын Их Хурал ... Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гэж, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана.” гэж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана.” гэж, мөн хуулийн 137 дугаар зүйлийн 137.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний орон гарсан бол нөхөн сонгууль явагдана.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд 2018 оны 62 дугаар тогтоолыг баталж, нөхөн сонгуулийг товлон зарласан бөгөөд уг тогтоолд төрийн албан хаагчдын сонгуульд нэр дэвших харилцаатай холбоотой аливаа зохицуулалт байхгүй болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчөөгүй болно.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурал 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан өөрийн бүрэн эрхийн хүрээнд 62 дугаар тогтоол батлан гаргаж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгууль товлон зарлаж, санал авах өдрийг тогтоосон байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” хэмээн Монгол Улсын иргэн төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хуралд сонгогдох эрхтэй болохыг нийтлэг байдлаар хуульчилсан байна. Мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг

бүрдүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хүлээхээр зааж, Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно." гэжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын дагуу Улсын Их Хурал 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн тухай хуулийг баталж, тус хуулиар Монгол Улсын Их Хурлын болон бусад байгууллагын сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорхойлж, сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах хэм хэмжээг тогтоожээ.

Сонгуулийн тухай энэхүү хуулиар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан иргэдийн өргөдөл, мэдээлэлд дурдсан нөхцөл байдал буюу нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд тухайн сонгуульд нэр дэвших, улмаар төрийн байгууллагад сонгогдох эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн боломжийг хууль тогтоогч бүрэн бүрдүүлээгүй гэж үзэхээр байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан дөрвөн жил тутам явагдах Улсын Их Хурлын ээлжит сонгуульд төрийн албанд ажиллаж буй иргэд нэрээ дэвшүүлэх, эсхүл нэр дэвших тохиолдолд Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт заасан хугацааны дотор ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ гаргахыг тодорхой заажээ.

Харин Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд нэрээ дэвшүүлэхийг хүссэн төрийн албанд ажиллаж байгаа иргэд тухайн сонгуулийн санал хураалт болох өдрөөс хэдий хугацааны өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргах, чөлөөлөгдсөн байх талаарх зохицуулалтыг Сонгуулийн тухай хуульд тусгаагүй байна.

Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлд Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийг бүртгэх талаарх нийтлэг зохицуулалтыг хуульчлахдаа тус зүйлийн 128.2.7, 128.3.6 дахь заалтад "төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлт, ажил албан тушаалаас чөлөөлөх тухай шийдвэрийн тус тус нотариатаар батлуулсан хуулбар;" зэргийг нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш гурав хоногт багтаан сонгуулийн төв байгууллагад ирүүлэхээр заасан байна. Түүнчлэн тус хуулийн 129 дүгээр зүйлийн 129.1.2 дахь заалтад "нэр

дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй;", 129.1.5 дахь заалтад "нэр дэвшигчийг бүртгүүлэхэд шаардагдах энэ хуульд заасан баримт бичиг дутуу ...;" зэрэг шаардлагыг хангаагүй бол нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзахаар зохицуулжээ.

Үүнээс үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.2.7, 128.3.6 дахь заалтад хамаарах иргэдийн хувьд нөхөн сонгуульд санал авах өдрөөс хэдий хугацааны өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байх зохицуулалтыг хуульд тусгаагүйн улмаас энэ шаардлагыг урьдчилан хангах хууль зүйн боломж бүрдээгүй байна. Ингэснээр иргэд уг сонгуульд нэрээ дэвшүүлж чадахгүйд хүрч, улмаар тэдний хувьд тэгш бус байдал буюу эрхэлсэн ажил, албан тушаалаасаа хамааран ялгаварлагдах хууль зүйн үндэслэл бий болохын хамт нөхөн сонгуульд оролцож сонгогдох эрхээ хэрэгжүүлж чадахгүй нөхцөл байдал үүсжээ. Иймд сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тулгамдсан асуудал байгааг дурдах нь зүйтэй юм.

3. Хууль тогтоогч Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг товлон зарлах шийдвэрийг гаргахдаа Үндсэн хуульт ёс, ардчилсан эрх зүйт төрийн суурь үзэл баримтлал, иргэний улс төрийн эрхийн хязгаарлалтын талаарх нийтээр хүлээн зөвшөөрсөн түгээмэл зарчимд нийцүүлэн Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийнхээ дагуу тухайн сонгуульд оролцох иргэдийн эрх зүйн байдлыг тогтоох ёстой атал иргэдэд тэгш бус байдлыг бий болгосон сонгуулийн хууль тогтоомжийн хийдлийг арилгахгүйгээр 2018 оны 62 дугаар тогтоолыг баталжээ.

Уг тогтоолыг болон Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн зардлыг хэлэлцэн баталсан Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, түүнчлэн чуулганы нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлтэй танилцахад холбогдох хуралдаан дээр нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд төрийн албанд ажиллаж буй иргэдийн сонгогдох эрх хязгаарлагдаж, тэгш бус байдал үүсэх эрх зүйн нөхцөл бүрдэж байгаа талаар яригдаж байсан нь нотлогдож байна.

Иймд Монгол Улсын Их Хурал 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай" 62 дугаар тогтоол батлан гаргаснаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг

иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчиж, улмаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэж заасан нь зөрчигдөх нөхцөл бүрдсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлан гаргасан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоолыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан

эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Д.ОДБАЯР
ГИШҮҮД	Н.ЧИНБАТ
	Д.СОЛОНГО
	Б.БУЯНДЭЛГЭР
	Г.ТУУЛХҮҮ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018.10.11 Дугаар 76 Төрийн ордон, Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталсан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ...-р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2018.11.30 Дугаар 03 Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 11.30 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат /илтгэгч/, Д.Ганзориг, Ш.Цогтоо, Д.Солонго, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү, Ц.Нанзаддорж нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Э.Эрдэнэцэцэг, Б.Оюу, А.Гулим болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлан гаргасан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан

эцэслэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийн тухай” 76 дугаар тогтоолын үндэслэлийг хянан хэлэлцэв.

Нэг. Хэнтий аймгийн Баянхутаг сумын 2 дугаар багийн оршин суугч, иргэн С.Мөнхцэцэг Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий өргөдөл гаргасан байна. Үүнд:

“Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолын 1, 2 дахь заалтаар Хэнтий аймгийн 42 дугаар тойрогт нөхөн сонгуулийг 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс товлон зарлаж, санал авах өдрийг мөн оны 10 дугаар сарын 7-ны өдрөөр тогтоосон ба мөн тогтоолын 3 дахь заалтаар тогтоолын хэрэгжих хугацааг заасан байна.

Миний бие төрийн жинхэнэ албан хаагч бөгөөд Үндсэн хуульд заасан төрийн байгууллагад сонгогдох эрхийн дагуу энэхүү нөхөн сонгуульд нэр дэвшихээр шийдээд байгаа юм. Нөхөн сонгуулийг Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “... энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана.” гэж зохицуулсан байна.

Үндсэн хууль болон Сонгуулийн тухай хуульд Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг 4 жил тутам явагдахаар цаг хугацааг нь тодорхой заасан бөгөөд иргэн хүн сонгуульд нэр дэвших эсэхээ эртнээс шийдэж, хуулиар тогтоосон шаардлагыг ханган оролцох боломжтой байдаг. Харин нөхөн сонгууль нь Сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 болон 137 дугаар зүйлийн 137.6 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдсөн, гишүүнийг эгүүлэн татсан, гишүүн нас барсан тохиолдолд орон гарсан суудлыг нөхөх зорилгоор явагдах бөгөөд нөхөн сонгууль явагдах эсэхийг урьдчилан тааж мэдэх ямар ч боломжгүй байдаг болно. Гэтэл энэ удаа нөхөн сонгууль зарлахад Сонгуулийн тухай хуульд нэгэнт товлон зарласан нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагчдыг хэрхэн оролцуулах тухай зохицуулалт огт тусгагдаагүй хийдэл үүссэн байна.

Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал нь Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс

өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ эрх бүхий этгээдэд гаргасан байх ба сонгуулийн жилийн нэгдүгээр сарын 31-ээс хойш ажил, албан үүргээ гүйцэтгээгүй байна.", Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт "Төрийн жинхэнэ албан хаагч Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших бол тухайн ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ... төрийн албанаас чөлөөлөгдөх өргөдлөө төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд гаргана. ... Сонгуульд нэр дэвшихтэй холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагч өргөдлөө гаргаагүй нь тухайн төрийн байгууллага түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй." гэж тус тус заасан. Дээрх хуулиудын зохицуулалтаас үзэхэд ээлжит сонгуульд нэр дэвших төрийн жинхэнэ албан хаагч нь "... сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ...", "... тухайн ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ..." гэж төрийн албанаас чөлөөлөгдсөн байх хугацааг тодорхой заасан байна. Гэтэл нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагчид хэзээ, хэрхэн ажлаасаа чөлөөлөгдөн оролцох зохицуулалтыг орхигдуулснаас төрийн байгууллагад ажиллаж буй төрийн жинхэнэ албан хаагчид нөхөн сонгуульд оролцохын тулд одоо ажлаасаа чөлөөлөгдөхөд дээр дурдсан хугацааны шаардлагыг хангаж чадахгүй тул сонгуульд оролцох боломжгүй болж байна. ...

Иймд төрөөс Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчдыг нөхөн сонгуульд оролцох зохицуулалтыг тодорхой болгосны үндсэн дээр тус нөхөн сонгуулийг зарлах нь Үндсэн хуульд нийцэх бөгөөд улмаар төрийн жинхэнэ албан хаагчид Үндсэн хуулиар олгогдсон сонгогдох эрхээ эдлэх хууль зүйн баталгаа бүрдэх юм.

Ийнхүү төрийн жинхэнэ албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа бүрдээгүй байхад нөхөн сонгууль болсон тохиолдолд нэр дэвших хүсэлт гаргасан боловч дээр дурдсан шаардлагыг хангаагүй үндэслэлээр сонгуульд оролцож чадаагүй төрийн албан хаагчид өргөдөл, мэдээлэл гаргасны улмаас нөхөн сонгууль бүхэлдээ хүчингүйд тооцогдож, дахин сонгууль болох улмаар үр дүнгүй их хэмжээний зардал гарч, улс орны эдийн засагт хохирол учруулах нөхцөл байдал бий болохыг үгүйсгэх аргагүй.

Энэ бүхний эцэст төрийн жинхэнэ албан хаагчид бид аливаа сонгууль болохоос өмнө хуулиар тогтоосон боломжит хугацаанд

албан тушаалаасаа чөлөөлөгдөж, сонгуульд нэр дэвшиж, Үндсэн хуульд заасан сонгогдох эрхээ эдлэх хүсэлтэй байна. Тиймээс нөхөн сонгуульд төрийн албан хаагчид хэрхэн, яаж оролцохыг хуулиар тодорхой зохицуулсны дараа нөхөн сонгуулийг зарлах нь хууль дээдлэх ёс, эрх зүйт төрийн зарчим, үндсэн хуульт ёсонд нийцнэ. Үүний зэрэгцээ Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол дараах байдлаар Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна:

1. Төрийн албан хаагчдыг нөхөн сонгуульд оролцуулах хуулийн зохицуулалтыг орхигдуулж, хууль зүйн баталгаа хангах үүргээ төр биелүүлээгүй байхад нөхөн сонгууль зарласан нь төрийн жинхэнэ албан хаагчдыг нөхөн сонгуульд оролцох боломжгүй болгож, улмаар иргэн хүн сонгогдох эрхээ эдлэхэд тэгш бус шаардлага тавьж байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасныг зөрчиж байна.

2. Төрийн жинхэнэ албанд ажилласных нь төлөө иргэнд хуулиар биелүүлэх боломжгүй шаардлага тавьж, сонгогдох эрхийг хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулийн суурь зарчмыг үгүйсгэж, улмаар хүнийг эрхэлж буй ажил, албан тушаалынх нь хувьд шууд ялгаварлан гадуурхсан гэж үзэхээр байгаа ба энэ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ..." гэж заасныг зөрчөөд байна.

3. Сонгуулийн тухай хуульд нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагч хэрхэн оролцох талаар зохицуулалтыг тодорхой тусгаагүй орхигдуулсан ба албан тушаалаасаа чөлөөлөгдөх хуулийн шаардлага нь нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагчийг нэр дэвшүүлэх боломжгүй болгож, тэгш бус нөхцөлийг тулгаж, улмаар иргэний төрийн байгууллагад сонгогдох эрхийг ноцтойгоор зөрчиж байна. Түүнчлэн иргэний төрийн байгууллагад сонгогдох эрхийн хууль зүйн баталгааг төрөөс бүрэн хангаагүй байхад нөхөн сонгуулийг товлон зарласан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ..." гэж заасныг зөрчиж байна.

4. Улсын Их Хурлаас баталсан хууль нь Үндсэн хуульд заасан төрийн байгууллагад сонгогдох эрхийг бүрэн хангахад чиглэсэн баталгаа болохуйц байх ёстой. Хууль тогтоогчийн зүгээс Сонгуулийн тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргээ биелүүлээгүй, зохицуулалтыг

орхигдуулсан буюу төрийн жинхэнэ албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа хангагдаагүй байхад Улсын Их Хурлын 62 дугаар тогтоолоор нөхөн сонгуулийн тов зарлаж, санал авах өдрийг тогтоосон, мөн төрийн алба улс төрөөс ангид байх зарчмыг хэрэгжүүлэх зохицуулалт тодорхойгүй, ойлгомжгүй байгаа нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ..." гэж заасан үүргээ зөрчсөн гэж үзэхээр байна.

5. Сонгуулийн тухай хуулиар нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагч оролцох эрхийн хууль зүйн баталгааг бүрэн хангаагүй атал Сонгуулийн ерөнхий хороо төрийн жинхэнэ албан хаагчийг нэр дэвшигчид тавигдах шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзах шийдвэр гаргах нөхцөл байдал үүсч, улмаар Үндсэн хуульд заасан хэзээ ч хязгаарлаж үл болох иргэний баталгаатай эдлэх улс төрийн эрхийг хязгаарлаж Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэж заасныг зөрчсөн шийдвэр болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...", Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэж тус тус заасныг зөрчсөн байх тул хянан хэлэлцэж, дүгнэлт гаргаж өгнө үү." гээд өргөдлийн үндэслэлээ баталгаажуулан хавсарган ирүүлсэн баримтад:

Иргэн С.Мөнхцэцэгийн Сонгуулийн ерөнхий хороонд хандаж Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд (2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс товлон зарласан) нэрээ дэвшүүлэх хүсэлтэй төрийн албан хаагч эрхэлж буй ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ хэзээ гаргаж, хэзээ чөлөөлөгдсөн байх шаардлагатай талаар тодруулга хүсэхэд, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албанаас 2018 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 66 дугаар албан бичгээр "Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсгийн

зохицуулалтыг тусгаад Сонгуулийн төв байгууллагын хувьд хуулийг баримтлан ажиллах бөгөөд хууль тогтоомжийг тайлбарлах эрх хэмжээ тус байгууллагад олгогдоогүй тул тайлбар, тодруулга өгөх боломжгүй юм.” гэсэн хариуг өгсөн байна.

Хоёр. Нийслэлийн Баянгол дүүргийн 3 дугаар хороонд оршин суугч, иргэн Э.Эрдэнэцэцэг, Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороонд оршин суугч, иргэн Б.Оюу, Баянзүрх дүүргийн 25 дугаар хороонд оршин суугч, иргэн А.Гулим нар Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээлэл гаргасан байна. Үүнд:

“Улсын Их Хурлаас 2018 оны 62 дугаар тогтоол гарснаар төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирлын албан тушаал эрхэлж байгаа иргэд Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох боломжгүй болоод байна. Учир нь Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт дурдсан төрийн албан хаагчид Сонгуулийн тухай хуульд заасан нэр дэвшигчид тавигдах нийтлэг шаардлагаас гадна нөхөн сонгуульд нэрээ дэвшүүлэхийн тулд сонгуулийн жил буюу 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ өгч, 1 дүгээр сарын 31-ний өдрөөс хойш албан үүргээ гүйцэтгэхгүй байх нэмэлт шаардлага тавьсан нь одоо ажлаа эрхэлж буй албан хаагч нь энэхүү шаардлагыг хангаагүй гэдэг үндэслэлээр нэр дэвшигчээр бүртгэхгүй байх улмаар Үндсэн хуульд заасан төрийн байгууллагад сонгогдох эрх зөрчигдөхөөр байна.

Нөхөн сонгууль нь Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдсөн, гишүүнийг эгүүлэн татсан, гишүүн нас барсан тохиолдолд орон гарсан суудлыг нөхөх зорилгоор явагдах бөгөөд Сонгуулийн тухай хуулиар дээр дурдсан албан хаагчийг нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгааг бүрдүүлээгүй байна. ... Иймхүү дээр дурдсан төрийн албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа хангагдаагүй байхад Улсын Их Хурлаас 62 дугаар тогтоол гаргаж, нөхөн сонгуулийг зарлан иргэний төрийн байгууллагад сонгогдох эрх төрийн байгууллагын буруугаас зөрчигдөхөд хүргэж, улмаар төрийн албанд ажилласны төлөө нэрээ дэвшүүлэх эрхийг хязгаарлаж байгаа нь улс төрийн сонгуульд нэр дэвшигчид ижил тэнцүү нөхцөлд, шударгаар өрсөлдөх боломжийг бүрдүүлэх бус харин эсрэгээрээ Үндсэн хуулийн үндсэн зарчмыг үгүйсгэсэн Үндсэн хуулийн зөрчил юм.

Иймд Сонгуулийн тухай хуулиар дээр дурдсан төрийн албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа бүрэн хангагдаагүй байхад баталсан Улсын Их Хурлын 62 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...", Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэсэн заалтыг зөрчсөн, Үндсэн хуульд нийцээгүй шийдвэр болсон гэж үзэж байна." гэжээ.

Гурав. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд оролцох Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан ирүүлсэн тайлбартаа:

"... Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоолыг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг үндэслэн баталсан. Уг тогтоол нөхөн сонгуулийг эхлэх өдөр болон санал авах ажиллагааг явуулах өдрийг тогтоосон хоёр заалттай бөгөөд тухайн сонгуульд нэр дэвшүүлэхэд тавигдах шаардлагын талаар тусгайлан зааж төрийн албан хаагчийн эрхийг хязгаарласан заалт уг тогтоолд байхгүй юм.

Иргэдийн өргөдөл, мэдээлэлд дурдсан Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт төрийн албан хаагч сонгуульд нэр дэвшүүлэхэд тавигдах шаардлагыг заахдаа "... Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ..." гэж заасан бөгөөд "сонгуулийн жил" гэсэн нэр томьёог хэрэглэсэн байна. "Сонгуулийн жил" гэж мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад зааснаар дөрвөн жил тутам явагдах ээлжит сонгуулийн жилийг ойлгоно. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт зааснаар сонгууль нь ээлжит, ээлжит бус, нөхөн, дахин гэсэн төрлүүдтэй байх бөгөөд "Ээлжит сонгууль гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2, Гучдугаар зүйлийн 2, Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт тус тус заасны дагуу дөрвөн жил тутам явагдах сонгуулийг хэлнэ." гэж заажээ. Одоо бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурал нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан дөрвөн

жил тутам явагдах сонгуулийн үр дүнд байгуулагдсан бөгөөд 2016 онд явагдсан энэхүү сонгууль нь Сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад заасан ээлжит сонгууль юм. Харин Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт товлон зарласан сонгууль нь Сонгуулийн тухай хуулийн мөн зүйлийн 8.1.3 дахь заалтад заасан нөхөн сонгууль билээ. Эндээс үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт заасан "сонгуулийн жил" гэдэгт дөрвөн жил тутам явагдах ээлжит сонгуулийн жилийг ойлгох бөгөөд "сонгууль явуулах тухайн жил" гэсэн ойлголтыг агуулаагүй байгаа тул төрийн албанаас чөлөөлөгдөх шаардлагад заасан хугацаа нь Улсын Их Хурлын нөхөн сонгуульд нэр дэвшүүлэхэд хамаарахгүй юм. Түүнчлэн Сонгуулийн тухай хууль батлагдсанаар хүчингүйд тооцогдсон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт "Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна." гэж заасан нь одоогийн хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт заасантай хугацааны хувьд ижил шаардлага тавьж байсан бөгөөд уг заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг Үндсэн хуулийн цэцээс өмнө нь хянан шийдвэрлэж 2015 оны 12 дугаар дүгнэлт болон мөн оны 10 дугаар тогтоолыг баталсан байна.

Үндсэн хуулийн цэцийн дээрх шийдвэрт "...Төрийн жинхэнэ буюу мэргэшсэн алба хаагчдыг ажил, мэргэжлийн онцлог, хэрэгжүүлэх чиг үүргийг харгалзан улс төрийн үйл ажиллагаанаас ангид байлгах, төвийг сахисан байр суурийг хадгалахад чиглэсэн тусгай шаардлага, шалгуурыг тэдэнд тавьж холбогдох хуулиар зохицуулах нь хууль тогтоогчийн бүрэн эрхийн асуудал юм. ... Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... шударга ёс, ... үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын "... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ..." гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна." гэж дурдсанаас үзэхэд сонгуульд нэр дэвших төрийн албан хаагчийн төрийн албанаас чөлөөлөгдөх хугацааны шаардлагыг Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад “Улсын Их Хурал ... Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гэж, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана.” гэж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана.” гэж, мөн хуулийн 137 дугаар зүйлийн 137.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний орон гарсан бол нөхөн сонгууль явагдана.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд 2018 оны 62 дугаар тогтоолыг баталж, нөхөн сонгуулийг товлон зарласан бөгөөд уг тогтоолд төрийн албан хаагчдын сонгуульд нэр дэвших харилцаатай холбоотой аливаа зохицуулалт байхгүй болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчөөгүй болно.” гэсэн байна.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаараа энэхүү маргааныг хянан хэлэлцээд 10 дугаар дүгнэлтийг гаргасан байна. Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

1. “Монгол Улсын Их Хурал 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан өөрийн бүрэн эрхийн хүрээнд 62 дугаар тогтоол батлан гаргаж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгууль товлон зарлаж, санал авах өдрийг тогтоосон байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” хэмээн Монгол Улсын иргэн төрийн эрх барих

дээд байгууллага Улсын Их Хуралд сонгогдох эрхтэй болохыг нийтлэг байдлаар хуульчилсан байна. Мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хүлээхээр зааж, Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно." гэжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын дагуу Улсын Их Хурал 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн тухай хуулийг баталж, тус хуулиар Монгол Улсын Их Хурлын болон бусад байгууллагын сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорхойлж, сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах хэм хэмжээг тогтоожээ.

Сонгуулийн тухай энэхүү хуулиар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан иргэдийн өргөдөл, мэдээлэлд дурдсан нөхцөл байдал буюу нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд тухайн сонгуульд нэр дэвших, улмаар төрийн байгууллагад сонгогдох эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн боломжийг хууль тогтоогч бүрэн бүрдүүлээгүй гэж үзэхээр байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан дөрвөн жил тутам явагдах Улсын Их Хурлын ээлжит сонгуульд төрийн албанд ажиллаж буй иргэд нэрээ дэвшүүлэх, эсхүл нэр дэвших тохиолдолд Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт заасан хугацааны дотор ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ гаргахыг тодорхой заажээ. Харин Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд нэрээ дэвшүүлэхийг хүссэн төрийн албанд ажиллаж байгаа иргэд тухайн сонгуулийн санал хураалт болох өдрөөс хэдий хугацааны өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргах, чөлөөлөгдсөн байх талаарх зохицуулалтыг Сонгуулийн тухай хуульд тусгаагүй байна.

Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлд Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийг бүртгэх талаарх нийтлэг зохицуулалтыг хуульчлахдаа тус зүйлийн 128.2.7, 128.3.6 дахь заалтад "төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлт, ажил албан тушаалаас чөлөөлөх тухай шийдвэрийн тус тус нотариатаар батлуулсан хуулбар;" зэргийг нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш гурав хоногт

багтаан сонгуулийн төв байгууллагад ирүүлэхээр заасан байна. Түүнчлэн тус хуулийн 129 дүгээр зүйлийн 129.1.2 дахь заалтад “нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй;”, 129.1.5 дахь заалтад “нэр дэвшигчийг бүртгүүлэхэд шаардагдах энэ хуульд заасан баримт бичиг дутуу ...;” зэрэг шаардлагыг хангаагүй бол нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзахаар зохицуулжээ.

Үүнээс үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.2.7, 128.3.6 дахь заалтад хамаарах иргэдийн хувьд нөхөн сонгуульд санал авах өдрөөс хэдий хугацааны өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байх зохицуулалтыг хуульд тусгаагүйн улмаас энэ шаардлагыг урьдчилан хангах хууль зүйн боломж бүрдээгүй байна. Ингэснээр иргэд уг сонгуульд нэрээ дэвшүүлж чадахгүйд хүрч, улмаар тэдний хувьд тэгш бус байдал буюу эрхэлсэн ажил, албан тушаалаасаа хамааран ялгаварлагдах хууль зүйн үндэслэл бий болохын хамт нөхөн сонгуульд оролцож сонгогдох эрхээ хэрэгжүүлж чадахгүй нөхцөл байдал үүсжээ. Иймд сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тулгамдсан асуудал байгааг дурдах нь зүйтэй юм.

3. Хууль тогтоогч Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг товлон зарлах шийдвэрийг гаргахдаа Үндсэн хуульт ёс, ардчилсан эрх зүйт төрийн суурь үзэл баримтлал, иргэний улс төрийн эрхийн хязгаарлалтын талаарх нийтээр хүлээн зөвшөөрсөн түгээмэл зарчимд нийцүүлэн Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийнхээ дагуу тухайн сонгуульд оролцох иргэдийн эрх зүйн байдлыг тогтоох ёстой атал иргэдэд тэгш бус байдлыг бий болгосон сонгуулийн хууль тогтоомжийн хийдлийг арилгахгүйгээр 2018 оны 62 дугаар тогтоолыг баталжээ.

Уг тогтоолыг болон Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн зардлыг хэлэлцэн баталсан Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, түүнчлэн чуулганы нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлтэй танилцахад холбогдох хуралдаан дээр нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд төрийн албанд ажиллаж буй иргэдийн сонгогдох эрх хязгаарлагдаж, тэгш бус байдал үүсэх эрх зүйн нөхцөл бүрдэж байгаа талаар яригдаж байсан нь нотлогдож байна.

Иймд Монгол Улсын Их Хурал 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол батлан гаргаснаар Монгол Улсын Үндсэн хуулийн

Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчиж, улмаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэж заасан нь зөрчигдөх нөхцөл бүрдсэн байна.” гэжээ.

Дүгнэлтийн тогтоох хэсэгт

1. “Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлан гаргасан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоолыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.” гэжээ.

Тав. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн "Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийн тухай" 76 дугаар тогтоолд:

"Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталсан "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал өгөх өдрийг тогтоох тухай" 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...", Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэснийг зөрчсөн байна." гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй." гэжээ.

Зургаа. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд оролцох Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тухай Цэцийн дүгнэлтийг дараах үндэслэлээр хүлээн авах боломжгүй гэж үзлээ. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоолыг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг үндэслэн баталсан. Уг тогтоол нөхөн сонгуулийг эхлэх өдөр болон санал авах ажиллагааг явуулах өдрийг тогтоосон хоёр заалттай бөгөөд тухайн сонгуульд нэр дэвшүүлэхэд тавигдах шаардлагын талаар тусгайлан зааж төрийн албан хаагчийн эрхийг хязгаарласан заалт уг тогтоолд байхгүй юм.

... Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад “Улсын Их Хурал ... Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гэж, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана.” гэж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана.” гэж, мөн хуулийн 137 дугаар зүйлийн 137.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний орон гарсан бол нөхөн сонгууль явагдана.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд 2018 оны 62 дугаар тогтоолыг баталж, нөхөн сонгуулийг товлон зарласан бөгөөд уг тогтоолд төрийн албан хаагчдын сонгуульд нэр дэвших харилцаатай холбоотой аливаа зохицуулалт байхгүй болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчөөгүй болно.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Сонгуулийн тухай хуульд төрийн албанд ажиллаж буй иргэн Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нэрээ дэвшүүлэх, эсхүл нэр дэвших тохиолдолд хэдий хугацааны өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан байх шаардлагыг тодорхой заасан боловч Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгууль зарлагдсан тохиолдолд тухайн сонгуулийн санал хураалт болох өдрөөс хэдий хугацааны өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ гаргах, чөлөөлөгдсөн байх талаарх зохицуулалтыг тусгаагүй байна. Үүний улмаас төрийн албанд ажиллаж буй иргэд Сонгуулийн тухай хуульд заасан шаардлагыг урьдчилан хангаж Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд нэрээ дэвшүүлэх боломжгүй болж, эрхэлсэн ажил, албан тушаалаасаа хамааран сонгогдох эрхээ хэрэгжүүлж чадахгүйд хүрчээ.

2. Хууль тогтоогч Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох шийдвэрийг хэлэлцэж байх үед дээр дурдсан нөхцөл байдал үүссэн нь тодорхой байсан атал иргэдэд тэгш бус байдлыг бий болгосон сонгуулийн хууль тогтоомжийн хийдлийг арилгахгүйгээр 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр 62 дугаар тогтоол гаргажээ. Тодруулбал, уг тогтоолыг болон Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн зардлыг хэлэлцэн баталсан Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлээс үзэхэд нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд төрийн албанд ажиллаж буй иргэдийн сонгогдох эрх хязгаарлагдаж, тэгш бус байдал үүсэх эрх зүйн нөхцөл бүрдэж байгаа талаар яригдаж байсан байна. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, сонгогч, сонгогдогч иргэдийн эрхийг тэгш хангаж холбогдох заалтуудыг өөрчлөх эрх нь хууль тогтоогчид байгаа юм.

Үүнээс үзэхэд, Монгол Улсын Их Хурал 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал өгөх өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол батлан гаргаснаар Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасан заалт зөрчигдөх нөхцөл бүрдсэн байна хэмээн үзсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

3. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 76 дугаар тогтоолд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн хэдий ч ийнхүү хүлээн зөвшөөрөхгүй гэж үзсэн хууль зүйн үндэслэлээ тодорхой тайлбарлаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг; Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг; Үндсэн хуулийн

цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлан гаргасан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийн тухай” 76 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ Д.ОДБАЯР

ГИШҮҮД Н.ЧИНБАТ
Д.ГАНЗОРИГ
Ш.ЦОГТОО
Д.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Г.ТУУЛХҮҮ
Ц.НАНЗАДДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.09.21 Дугаар 11 Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.30 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат даргалж, гишүүн Ш.Цогтоо /илтгэгч/, Д.Солонго, Б.Буяндэлгэр, Ц.Нанзаддорж нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Ш.Алтангадас, Ө.Эрдэнэ-Очир, Т.Мөнх-Эрдэнэ, Д.Гантөмөр нар оролцож, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг тус тус зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хорооны оршин суугч, иргэн Ө.Эрдэнэ-Очир, Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн Ш.Алтангадас нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ...” гэж заасны дагуу хууль бусаар хохирсон гэдэг нь шүүхээр тогтоогдсон бол хохирол учруулсан этгээдээс нөхөн төлүүлж зөрчигдсөн эрх, ашиг сонирхлоо нөхөн сэргээлгэх эрхийг баталгаатай эдлэхээр заажээ. Иргэний “шүүхэд гомдол гаргаж хохирлоо нөхөн төлүүлэх” эрх нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хангаж хамгаалах гол баталгаа болж байдаг билээ.

Гэтэл Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “18.1.1. энэ хуулийн 6.2.1, 6.2.2-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 4 жил; 18.1.2. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.2.3-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил; 18.1.3. энэ хуулийн 6.2.4, 6.2.5-д заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил; 18.1.4. энэ хуулийн 6.2.6-д заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 2 жил.” гэж заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дээрх зохицуулалт нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ...” гэж заасныг зөрчиж “шүүхийн шийдвэр заавал биелэх” шинж чанарыг үгүйсгэж тодорхой хугацаа өнгөрсний дараа шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байх хууль зүйн нөхцөлийг үүсгэжээ.

Шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байж болох нөхцөл боломжийг хуулиар бий болгох нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалалтгүй болгож төр Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан үүргээ зөрчсөн гэж үзэж

байгаа тул уг асуудлыг хянан шийдвэрлэж дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн агуулгатай мэдээлэл гаргажээ.

Хоёр. Нийслэлийн Баянгол дүүргийн 17 дугаар хорооны оршин суугч, иргэн Т.Мөнх-Эрдэнэ, Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн Г.Орхон нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг тодорхой хугацаа өнгөрсөн тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй байхаар тусгажээ. Энэ нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ...” гэж заасныг зөрчсөн байна.

Аливаа этгээдийг “хууль бусаар бусдад хохирол учруулсан” хэмээн шүүх тогтоосон тохиолдолд бусдад хохирол учруулсан этгээд хохирлыг сайн дурааараа нөхөн төлөх үүрэгтэй ба ийнхүү сайн дураар нөхөн төлөөгүй тохиолдолд гүйцэтгэх хуудсыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэний болон захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэж, эрх нь зөрчигдсөн этгээдийн хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааг албадан гүйцэтгэдэг журамтай.

Өөрөөр хэлбэл, нэг талаас шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр нь зөрчигдсөн эрхийг бодитоор сэргээх баталгаа, нөгөө талаас иргэнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор эрх бүхий байгууллага албадлага хэрэглэх үйл явц бөгөөд учирсан хохирлоо нөхөн төлүүлэх нь иргэний үндсэн эрх болж, ийнхүү Үндсэн хуулиар баталгаажсанд оршиж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний үндсэн эрхийг хангах зорилготой байтал тодорхой хугацаа өнгөрсний дараа эл шийдвэрийг биелүүлэхгүй байхаар хуульчилсан нь шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчим хийгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндсэн зорилгод нийцэхгүй байна. Мөн Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дээр дурдсан маргаан бүхий зүйл, заалт нь Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчсөн гэж үзэж байна.” гэсэн агуулга бүхий мэдээлэл гаргажээ.

Гурав. Нийслэлийн Баянгол дүүргийн 18 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Гантөмөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Иргэний хуулийн эрх зүйн зохицуулалтын дагуу эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, зөрчигдөхөөс өмнөх байдлыг сэргээх, хүлээсэн үүргийг гүйцэтгүүлэх, учруулсан хохирлыг арилгуулах шаардлага бүхий нэхэмжлэл, гомдлыг шүүхэд гарган шийдвэрлүүлдэг. Шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа нь түүний үр дүнд гарах шийдвэрийг биелүүлэх ажиллагаатай салшгүй холбоотой байдаг.

Энэ утгаараа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтад “хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь саад учруулсан этгээдэд хууль ёсны хариуцлага хүлээлгэнэ”, “Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлнэ”, “Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасны үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ” гэж хуульчилжээ. Дээрхээс үзэхэд, шүүхийн шийдвэр нь хуулийн адил заавал биелэгдэх ёстой.

Нөгөө талаас бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага нь төрийн албадлагаар хэрэгждэг бөгөөд заавал биелэгддэг байх ёстой. Гэвч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлд тодорхой хугацаа өнгөрсөн бол шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхгүй гэх зохицуулалтыг оруулсан нь Шүүхийн эрхэм зорилго болох “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх”-ийг үгүйсгээд зогсохгүй нийгмийн дэг журмыг зөрчиж байна.

Шүүхийн шийдвэрийн хариуцагч буюу төлбөр төлөгч нь шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх үүрэгтэй бөгөөд хэрэв биелүүлэхгүй бол хуульд заасны дагуу албадан гүйцэтгүүлэх үр дагавар үүснэ. Ийнхүү хуулиар хариуцагч, төлбөр төлөгчид шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх боломжийг олгож байгаа нь өөрийн санхүүгийн эх үүсвэрийн байдалтай уялдуулан хуваарь гарган төлбөрийг төлөх, өөрийн ямар хөрөнгийн

аль хэсгээс төлбөрийг барагдуулах тухай шийдвэрийг гаргах боломжийг олгож байгаа бөгөөд энэ нь хариуцагч, төлбөр төлөгчийн өөрийн эд хөрөнгийг өмчлөх эрхийг баталгаажуулах боломжийг олгож байдаг. Нөгөө талаас, нь авч үзвэл, төлбөр авагч болон төлбөр төлөгч нарын хооронд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон өр төлбөрийг хэрхэн төлөх, авах талаар харилцан тохиролцох боломжийг олгохын зэрэгцээ хэрэв уг тохиролцоо зөрчигдвөл төлбөр авагчид түүний хүсэлтээр шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх боломж хэзээд хадгалагдаж байх агуулгыг илэрхийлдэг. Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан зохицуулалтаар шүүхийн шийдвэрийг хүчин төгөлдөр болсноос хойш тодорхой хугацаа өнгөрвөл шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэхгүй тухай заалт нь Үндсэн хуулиар олгогдсон бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг шууд зөрчиж байна.

Нийгэмд шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх зарчим алдагдах жишиг тогтоно. Тодруулбал, нэг талд төлбөр төлөх үүрэг бүхий этгээд нь хуульд заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгүүлэхгүй байх боломжит хугацааг хүлээх, цаг хожихын тулд төрөл бүрийн худал нөхцөл байдлыг зориудаар бий болгох ингэснээр хууль, шүүхийн шийдвэрийн дагуу бусдад төлөх өр төлбөрийн үүргээс чөлөөлөгдөх, уг дүнгээр үндэслэлгүйгээр хөрөнгөжих нөгөө талд нь хууль, шүүхийн шийдвэрийн дагуу өр төлбөрийг авах эрх бүхий этгээд нь хуулийн мухардалд орно.

Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн үүднээс авч үзвэл, хүмүүс бие биенээ харилцан ойлголцож, өөр өөрийн ухамсар ойлголтын түвшнээс хамааран нийгмийн болон бусдын харилцааг ойлгож, тэдгээрт боломж ухаарал, итгэл олгох бөгөөд /зарим тохиолдолд төлбөр авагч, төлбөр төлөгч нар нь ойр дотнын ах дүү, хамаатан садан байх тохиолдол бий/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан зохицуулалтаар шүүхийн шийдвэрийг шууд албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг гаргахаас өөр сонголтыг олгохгүй байна.

Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулан Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж хуульчилжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан зохицуулалт нь тодорхой хугацаа өнгөрсөн бол иргэний хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх төрийн хүлээсэн үүргийг шууд үгүйсгэж байгаа ба уг хугацаа өнгөрсний дараа төлбөр авагч иргэн өөрийн зөрчигдсөн эрхийг хэрхэн сэргээлгэх, өр төлбөрийг хэрхэн авах талаар мухардмал байдалд оруулж байна.

Тодруулбал, тухайн асуудлаар шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй болсон, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хүсэлтийг хүлээн авахгүй, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх боломжгүй болсон иргэн өөрөө төлбөр төлөгчийн хойноос хөөцөлдөж төлбөрөө авахаас өөр сонголт үлдэхгүй байна. Төлбөр төлөгч эд хөрөнгөө нуусан, оршин суугаа газраа өөрчилсөн тохиолдолд иргэн түүнийг мэдэх, илрүүлэх боломжгүй бөгөөд энэ ажиллагааг зөвхөн эрх бүхий байгууллага тусгай журмын дагуу гүйцэтгэх эрхтэй ба үүнийг гүйцэтгэх ажиллагаа хэмээн нэрлэдэг. Иймд төлбөр төлөгчийн хойноос өөрөө хөөцөлдөж төлбөрөө гаргуулан авах гэдэг нь боломжгүй зүйл юм.

Иймд дээрх үндэслэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн агуулгатай мэдээлэл ирүүлсэн байна.

Дөрөв. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд иргэний болон захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэж болохгүй хугацааг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн төрөл, агуулгаас хамааран харилцан адилгүй тогтоосон. Хууль тогтоогч хууль заасан дээрх хугацаа өнгөрсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй байхаар хуульчлаагүй, өөрөөр хэлбэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрсөн ч хуульд /18.2-18.7, 124.2-124.4/ заасан үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах хугацааг сэргээх, шинээр тоолох тухай зохицуулалтыг тодорхой тусгасан нь төлбөр авагчид шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх хүсэлт гаргах, зөрчигдсөн эрхээ сэргээн эдлэх хангалттай боломж, нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Өөрөөр хэлбэл, төлбөр төлөгчийн буруугаас буюу төлбөр төлөгч оргон зайлсан, эсхүл эд хөрөнгөө нуун далдалсан үйлдлийн улмаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хугацаа дууссан тохиолдолд уг хууль бус үйлдэл үргэлжилсэн хугацааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хүсэлт гаргах хугацаанд оруулахгүй талаарх заалт хуульд тусгагдсан байгаа нь төлбөр төлөгчийн буруутай үйл ажиллагааны улмаас төлбөр авагчийн эрх ашиг дахин зөрчигдөхөөс урьдчилан сэргийлсэн механизм юм. Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд мөн дээрхтэй адил зохицуулалтыг нэгэн адил хуульчилж өгсөн.

Шүүхээс иргэний зөрчигдсөн эрх ашиг, сонирхлыг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах талаарх хуулийн хүчин төгөлдөр шийдвэр гарсны дараа хуульд зааснаас бусад тохиолдолд гагцхүү төлбөр авагчийн хүсэл, сонирхлыг үндэслэж буюу уг шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх хүсэлтийг төлбөр авагч шүүхэд гаргаж байж гүйцэтгэх хуудсыг шүүхээс олгосноор шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдах нөхцөл бүрддэг.

Өөрөөр хэлбэл, иргэний эрх зүйн маргааны талууд өөрсдийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх үүргийг хүлээж, нотлох баримт цуглуулах, шүүхэд нэхэмжлэл гаргах эрхээ хэрэгжүүлэх, эс хэрэгжүүлэхээ өөрөө бие даан хэрэгжүүлдгийн нэгэн адил дээр дурдсанчлан гарсан шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхээр хүсэлт гаргах эсэх нь мөн өөрсдийнх нь эрхийн асуудал тул уг эрхээ хэрэгжүүлэх хугацааг ямар нэгэн хязгааргүйгээр олгох нь төлбөр төлөгчийн эрхийг зөрчиж хугацаагүй төлбөр төлөгч байхад хүргэх бөгөөд 10 жил, 20 жилийн өмнө ч гарсан шүүхийн шийдвэрийг үндэслэн албадлагын арга хэмжээ явуулж, төлбөр төлөгчийн эрхэд халдах эрсдэлийг бий болгох сөрөг үр дагавартай юм.

Ийнхүү хугацааг зааж зохицуулж өгснөөр төлбөр төлөгч хуульд заасан хугацааны дотор буюу шийдвэр гарсан даруйд түүнийг биелүүлэх хүсэлт гаргаснаар шийдвэрийн биелэгдэх боломж нэмэгдэх, түүнчлэн хэдэн ч жилийн өмнө гарсан шийдвэрийг албадан биелүүлэхээр хүсэлт гаргах, ажиллагаа явуулах, эрх зүйн ач холбогдлоо алдсан, хугацаа алдсаны улмаас эд хөрөнгө байхгүй болсон буюу биелэгдэх боломжгүй шийдвэрийг биелүүлэхээр цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарахгүй байх нөхцөл боломж бүрдсэн. Нөгөө талаас, хугацаа заахгүй байх нь төлбөр авагчид хэт давуу байдал бий болгож ямар нэгэн цаг хугацааны хязгааргүйгээр шүүхийн шийдвэрийг

албадан гүйцэтгэх ажиллагаа үүсгэх боломж, нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэн бүрийн шүүхийн журмаар хөндөгдсөн эрхээ сэргээн эдлэх нэхэмжлэл гаргах эрхийг баталгаажуулсантай зэрэгцэн иргэн өөрт олгогдсон эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын эрхийг зөрчихгүй байх зарчмыг ч мөн адил тодорхойлсон байдаг. Үүнтэй уялдуулан хууль тогтоогч шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ иргэн бүрд төлбөр авагч, төлбөр төлөгч эсэхээс үл хамааран адил тэгш эрх, эрхээ хамгаалах механизмыг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Дээр дурдсаныг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ...", Арван ес дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.", Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ.", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль, ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэж тус тус заасныг зөрчөөгүй." гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн агуулга ёсоор хуулийн хүчин төгөлдөр болсон аливаа шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх зарчим үйлчлэх бөгөөд холбогдох этгээд шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол эрх бүхий байгууллага албадан биелүүлэх боломж, баталгааг хуулиар бүрдүүлсэн байх учиртай. Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг батлан гаргажээ.

2. Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг албадан биелүүлэх буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл нь төлбөр авагч, нэхэмжлэгч этгээдийн хүсэлтийн дагуу шүүхээс олгосон гүйцэтгэх хуудас байдаг. Өөрөөр хэлбэл, төлбөр авагч, нэхэмжлэгч этгээдийн хүсэлтийн үндсэн дээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэн явуулдаг болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй буюу түүнийг албадан гүйцэтгэхгүй байх үр дагавар бүхий зохицуулалтыг хуульчилсан байна. Гэсэн хэдий ч энэ хугацаанд төлбөр авагч болон нэхэмжлэгч нь шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх талаарх хүсэлтээ шүүхэд гаргах эрхтэй байхаас гадна уг хугацааг хэтрүүлсэн боловч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэж болох тодорхой тохиолдлуудыг мөн тусгажээ.

Тодруулбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-18.7 дахь хэсэг, 124 дүгээр зүйлийн 124.2-124.4 дэх хэсэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлсэн болон уг хугацаанд төлбөр төлөгч гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг биелүүлэхээс зайлсхийсэн, оргон зайлсан зэрэг хэд хэдэн тохиолдолд тухайн хугацааг сэргээн тоолох, шинээр тоолохоор тусгасны зэрэгцээ тоолохгүй байх үндэслэлийг мөн хуульчилсан байна.

Иймд иргэний болон захиргааны шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий байгууллагад хандах иргэний эрх, хугацаа, тухайн хугацааг сэргээлгэх үндэслэл зэргийг тус хуулийн холбогдох зохицуулалтаар тогтоосон байх тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж үзэх үндэслэлгүй байна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хугацааны талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох буюу тухайн хугацааг сэргээн тоолох, шинээр тоолох, тоолохгүй байх үндэслэлийг дэлгэрүүлэн тогтоох шаардлага байхыг үгүйсгэхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол дараахь хугацаа өнгөрсөн тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй: 18.1.1.энэ хуулийн 6.2.1, 6.2.2-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 4 жил; 18.1.2.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.2.3-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил; 18.1.3.энэ хуулийн 6.2.4, 6.2.5-д заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил; 18.1.4.энэ хуулийн 6.2.6-д заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 2 жил.”; 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол дараахь хугацаа өнгөрсөн тохиолдолд захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй: 124.1.1. энэ хуулийн 6.3.1, 6.3.3, 6.3.4-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил; 124.1.2.энэ хуулийн 6.3.2-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан.” гэж заасан нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ...”, Арван ес дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Н.ЧИНБАТ
ГИШҮҮД	Ш.ЦОГТОО
	Д.СОЛОНГО
	Б.БУЯНДЭЛГЭР
	Ц.НАНЗАДДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.10.10 Дугаар 12 Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.40 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат /илтгэгч/, Д.Солонго, Ш.Солонго, Ц.Нанзаддорж нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын дээд шүүхийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Иргэний хэргийн танхимын тэргүүн Х.Сонинбаяр, шүүгч П.Золзаяа болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтад “төлбөр гаргуулж болох хөрөнгө, орлого байхгүй бөгөөд хуульд заасан аргаар түүний хөрөнгө, орлогыг албадан гаргуулах боломжгүй бол төлбөр төлөгчийг хөрөнгөтэй болох хүртэл.” гэж заасан

нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Дөчин есдүгээр зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсгийг; мөн хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно. ..." гэж заасан нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж Улсын дээд шүүхээс дараах агуулга бүхий хүсэлт ирүүлжээ. Үүнд:

1. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтад "төлбөр гаргуулж болох хөрөнгө, орлого байхгүй бөгөөд хуульд заасан аргаар түүний хөрөнгө, орлогыг албадан гаргуулах боломжгүй бол төлбөр төлөгчийг хөрөнгөтэй болох хүртэл." гэж заасны дагуу шүүгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болно гэж заажээ. Мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэгт шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 27.1.5 дахь заалтад дурдсан үндэслэл илэрсэн бол шүүхэд мэдэгдэх бөгөөд эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэнэ гэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана." гэснийг зөрчсөн гэж үзэхээр байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг шүүгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч гэсэн хоёр субьект түдгэлзүүлдэг бөгөөд түдгэлзүүлэх үндэслэл нь зарчмын ялгаатай байдаг тул дээрх хоёр субьект нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түдгэлзүүлэхдээ процессын өөр өөр журам хэрэгжүүлдэг байна. Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хяналт тавьж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулах боломжгүйд хүргэсэн шалтгаан буюу хуульд заасан үндэслэл илэрвэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлдэг байна. Өөрөөр хэлбэл, шүүгч иргэний хэргийг хянан шийдвэрлэх явцад эрх нь зөрчигдсөн байж болзошгүй этгээдийн ашиг сонирхлын үүднээс шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түдгэлзүүлэх эсэхийг Иргэний хэрэг шүүхэд хянан

шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу шийдвэрлэдэг бол ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хяналт тавьж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу түдгэлзүүлдэг өөр өөр журамтай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтад төлбөр төлөгч нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны нэг тал бөгөөд төлбөр төлөгч хөрөнгө, орлогогүй, эсвэл хуульд заасан журмаар хөрөнгө орлогыг гаргуулах боломжгүй байдал нь угтаа шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад тогтоогддог, шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотой юм. Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн эрх хэмжээнд шийдвэрлэж байсан асуудлыг 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтын зохицуулалтаар шүүгчийн ажиллагаанд хамааруулсан шалтгаан, үндэслэл хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалд тодорхой тусгагдаагүй байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдлийн дагуу, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтад шүүгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болохыг заасан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан иргэний хэрэг үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах үндсэн зарчмыг илэрхий зөрчсөн, уг заалт нь хэрэгжиж чадахгүйд хүрснээр хууль дээдлэх зарчим зөрчигдөж байна. Иргэний эрх зүйн салбарт үүссэн аливаа хэрэг маргааныг шүүх хянан шийдвэрлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмыг баримтлахыг энэ хуулиар зохицуулсан бөгөөд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол эх сурвалж нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль юм. Энэхүү хуульд зааснаар шүүх иргэний хэрэг үүсгэснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд явуулах эрхтэй. Энэ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан “Энэ хуулийн зорилт нь ... шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн эрх зүйн баталгаагаар илэрдэг. Шүүгч иргэний эрх зүйн маргаанаас гадна иргэний эрх зүйн салбарт хамаарах бусад эрх зүйн маргааныг шийдвэрлэхдээ ч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтлах ёстой. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай

хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалт нь иргэний хэрэг үүсгэх үндэслэлийг зохицуулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан иргэний эрх зүйн маргаан, эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал, гомдлоор үүсэх хэргийн аль аль нь биш, шүүхийн үйл ажиллагаатай холбоогүй, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй зохицуулалт болсон байна. Иймд шүүгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтын үндэслэлээр шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түдгэлзүүлэх захирамж гаргах эрх зүйн үндэслэл бүрдэхгүй байгаа юм.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт шүүгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг 27.1.5 дахь заалтад заасан үндэслэлээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болно гэсэн хэдий ч шүүгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу түдгэлзүүлэх боломжгүй тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27.1.5 дахь заалтыг зайлшгүй зөрчиж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх ажиллагаа мухардалд орж, шүүгч гагцхүү хуульд захирагдана гэсэн Үндсэн хуулийн шаардлага хэрэгжих боломжгүй болно. Шүүх хуульд заасан хэм хэмжээг тодорхой бус гэсэн үндэслэлээр хэргийг хянан шийдвэрлэхээс татгалзаж болохгүй зарчимтай. Дээрх тохиолдолд шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн алийг нь хэрэглэх, эсвэл хэрэглэхгүй байх буюу сонгох асуудал тулгарч, хууль хоорондын зөрчил үүсч, аль нэг хэм хэмжээг хэрэглэхгүй, хууль зөрчих нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэж заасантай нийцэхгүй гэж үзэхээр байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй.” гэснийг зөрчсөн гэж үзэхээр байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн төрийн байгуулал гэсэн гуравдугаар бүлэгт Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газар, Шүүх эрх мэдэл гэж төрийн гурван эрх мэдлийг тусгайлан зааж, тус бүрийн эрх, үүргийг зааглан тогтоож өгсөн. Шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэх явдал нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй

нэг хэлбэр юм. Үндсэн хуулийн зохицуулалтын утга агуулгаас үзвэл шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй шүүх нь гагцхүү “хэрэг маргааныг” шийдвэрлэх чиг үүрэгтэй болохыг тогтоосон бөгөөд шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах журмыг тогтоосон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь бүхэлдээ Үндсэн хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Эрх зүйт төрийн энэхүү зарчим нь шүүх засаглалыг төрийн бусад эрх мэдлээс тусгаарлах зарчмыг тодотгож өгдөг билээ.

Харин хууль тогтоомжийн хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах үүрэг нь гүйцэтгэх эрх мэдэл буюу Засгийн газар, түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг болдог бөгөөд шүүхийн шийдвэрийг биелүүлж буй гүйцэтгэлийн шинжтэй ажил үүргийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, Засгийн газрын Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд байдаг байна. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой гарсан гомдлыг шүүх харьяалан шийдвэрлэдэг онцлогтой. Шүүх ийнхүү гомдлоор иргэний хэрэг үүсгэн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хуулийн дагуу явагдсан эсэхийг хянахдаа төлбөр төлөгч, төлбөр авагч, гуравдагч этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээхийн зэрэгцээ хуулийг тайлбарлаж нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлснээр шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг зохистой явуулах бололцоог бүрдүүлж байдаг. Өөрөөр хэлбэл шүүх нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэхийг хянах эрхтэйгээс өөрөөр шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд оролцох, өр төлбөрийг гаргуулах эрхгүй юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг болдог бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлгийн 183-188 дугаар зүйлд заасан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журмын үргэлжлэл, нарийвчилсан зохицуулалт юм. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл болох эрх зүйн акт, түүний төрөл, гүйцэтгэх хуудсын агуулга, гүйцэтгэх хуудас бичих, гүйцэтгэх хуудсыг үрэгдүүлсний хариуцлага, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх захирамж гаргах, гүйцэтгэх хуудас, шүүхийн шийдвэр, захирамжийг шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлэх журам зэрэг асуудлыг зохицуулсан бөгөөд энэ ажиллагаа нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх бүрэн эрхэд хамааралтай зохицуулалт болно. Үүнээс цааш шийдвэрийг хэн, ямар арга, журмаар биелүүлэхийг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар нарийвчлан зааж, хуулийг хэрэгжүүлэх ажиллагаа эхэлдэг.

Үүнээс үзэхэд хоорондоо харилцан уялдаа холбоотой эрх зүйн харилцааг төрийн эрх мэдлийг хуваарилах суурь зарчмын дагуу дээрх байдлаар зааглаж, хуульд ялгаатай зохицуулсан байна. Гэтэл шүүх аливаа хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулаагүй байхдаа, шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдлийн дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэхээр байгаа нь Үндсэн хуульд заасан шүүх эрх мэдлийн чиг үүрэгт нийцэхгүй ажиллагааг явуулахад хүргэжээ. Төрийн эрх мэдлийн байгууллага тэдгээрийн албан тушаалтнуудаас эрх мэдлээ хэтрүүлэн бусад эрх мэдлийн эрх, үүргийг нь хэрэгжүүлэх болон хэрэгжүүлэх боломжийг хуулиар бий болгох нь эрх мэдэл хуваарилах зарчмыг зөрчихөд хүргэх бөгөөд шүүгч шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаанд хамаарах асуудлаар шийдвэр гаргах нь гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаанд оролцсон утга агуулгатай байна.

Үндсэн хуулийн хэм хэмжээнүүд нь хүний эрх, эрх чөлөөний шүүхийн хамгаалалтын баталгаа учраас иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлдэг. Шүүхийн шийдвэр гаргах ажиллагаа Үндсэн хуульд нийцсэн байх ёстой тул шүүх эрх мэдлээс гадуур, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоогүй, шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар шүүгч эрх зүйн акт гаргах нь эрх мэдэл хуваарилах зарчимд нийцээгүй, гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаанд халдсан шинжийг агуулж байгаа нь Үндсэн хуульд нийцээгүй байх ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27.1.5 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт ”Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй.” гэснийг зөрчсөн гэж үзэхээр байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... эрхтэй. ...” гэснийг зөрчсөн гэж үзэхээр байна.

Эрхээ хамгаалуулахаар шүүхэд мэдүүлэх нь хувь хүний процессын үндсэн эрх юм. Энэ зарчим нь Үндсэн хуульд тусгагдсан байдаг бөгөөд үндсэн эрхтэй адил төрийн хамгаалалтад багтдаг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хэргийн оролцогч нь шийдвэрээс бусад эрх зүйн актын талаар тухайн шатны шүүхэд, харин эрх зүйн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн

шүүхийн шийдвэрт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах замаар эрхээ хэрэгжүүлдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтын дагуу шүүгч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түдгэлзүүлэх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй учир уг ажиллагааны талаар төлбөр авагч, гуравдагч этгээдийн шүүхэд мэдүүлэх эрхийг хязгаарлахад хүргэсэн нь иргэний үндсэн эрхийг шууд зөрчсөн, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчсөн байж болохоор байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно. ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчсөн гэж үзэхээр байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн “Иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг баталгаажуулах арга хэмжээ” заалтад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төрлийг жагсаан, нэрлэсэн байх бөгөөд шийдвэр гүйцэтгэлийн байгууллага нь дээрх ажиллагааг хуулиар тогтоосон арга, журмын дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

Албадан дуудлага худалдааны зорилго нь албадан дуудлага худалдааны ажиллагаанаас аль болох их орлогыг оруулж, тэр хэмжээгээр төлбөрийг төлүүлэх, төлбөр төлөгч төлбөрөөс чөлөөлөгдөх явдал байдаг бөгөөд төлбөр төлөгч дуудлага худалдаа явуулахаас өмнө хөрөнгийг өөрөө худалдан борлуулж чадаагүй, анхны болон хоёр дахь дуудлага худалдаагаар хөрөнгө нь худалдан борлогдоогүй бол уг борлогдоогүй хөрөнгийг төлбөртөө авахыг төлбөр авагчид санал болгоно гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэгт заажээ. Албадан дуудлага худалдаагаар борлогдоогүй хөрөнгийг төлбөртөө тооцож авахыг төлбөр авагчид санал болгох ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүлээн зөвшөөрөгдсөн аргын нэг юм. Харин ямар үнээр, хэрхэн тооцож санал болгохыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3, 73.5 дахь хэсэгт тус тус зохицуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсгийн агуулгыг тайлбарлахын тулд мөн хуулийн 73.5 дахь

хэсгийн зохицуулалтыг харьцуулах шаардлагатай байна. Хуулийн 73.5 дахь хэсэгт “Барьцаалагч-төлбөр авагчийн барьцаанд байгаа, эсхүл дундын өмчлөлийн худалдан борлогдоогүй төлбөр төлөгчид ногдох хөрөнгийг энэ хуулийн 55.3-т заасны дагуу тогтоосон үнэлгээгээр тооцож төлбөр авагчид шилжүүлнэ.” гэж заажээ. Мөн хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэгт шийдвэр гүйцэтгэгч хөрөнгийн үнэлгээг шинжээчээр тогтоолгосон бол шинжээчийн дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор талуудад мэдэгдэж, дүгнэлтийг танилцуулж, санал хүсэлтийг авч тэмдэглэл үйлдэнэ гэж заасан байна. Үүнээс үзвэл барьцааны зүйл, дундын өмчлөлийн төлбөр төлөгчид ногдох хэсгийн үнийг шинжээчээр тогтоолгох бөгөөд уг эд хөрөнгө нь дуудлага худалдаагаар борлогдоогүй бол шинжээчийн тогтоосон үнээр төлбөр авагчид санал болгож болохоор байна. Харин 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно. ...” гэж заасан нь 73.5 дахь хэсгийн шинжээчийн үнэлгээнд хамаарахгүй буюу талууд үнийг тохиролцож тогтоосон эсхүл шийдвэр гүйцэтгэгч хөрөнгийн үнэлгээг тогтоосон тохиолдол хамаарч байх ба уг үнээс Иргэний хуульд заасан дуудлага худалдааны доод үнийг тогтоож, дуудлага худалдааг явуулсан боловч хөрөнгө борлогдоогүй, улмаар борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгох тохиолдолд хөрөнгийн үнийг 50 хувь бууруулж тооцон олгоно гэж хөрөнгийн үнийг 73.5 дахь хэсэгт зааснаас өөрөөр тогтоосон нь төлбөр төлөгч, төлбөр авагчийн хуулийн өмнө тэгш байх эрх зөрчигдсөн байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 7 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй.” гэж тунхагласан байдаг билээ.

Нөгөө талаас борлогдоогүй хөрөнгийг төлбөрт тооцож шилжүүлэхдээ хөрөнгийн үнийг эд хөрөнгөө шинжээчээр үнэлүүлсэн, эсвэл талууд харилцан тохирсон, шинжээч үнэлсэн эсэхээс хамаарч өөр өөрөөр тогтоосон нь төлбөр төлөгчид эрх зүйн ижил боломж олгоогүй, хуулийн өмнө эрх тэгш байх үндсэн эрх зөрчигдсөн гэж үзэхээр байна. Төлбөрийг барагдуулах нэг зорилго байгаа хэрнээ хөрөнгийн үнийг шинжээчээр тогтоолгосон эсэхээс хамаарч төлбөрт өөр өөр үнээр тооцох болсон зохицуулалтын учир утга тодорхой бус байна. Тэгш байдлын зарчим нь нэг талаас төрийн үйл ажиллагааны зарчим, нөгөө талаас хүний үндсэн эрх болдог бөгөөд хөрөнгөө шинжээчээр үнэлүүлсэн төлбөр төлөгчийн хөрөнгө шинжээчийн

үнэлгээгээр, харин хөрөнгийн үнийг харилцан тохирсон, эсвэл шийдвэр гүйцэтгэгч үнийг тогтоосон бол хөрөнгийн үнийг 50 хувиар бууруулж төлбөрт тооцохоор болсон хуулийн хэм хэмжээ төлбөр төлөгчид тэгш хандаагүй агуулгатай байна. Хөрөнгийн талаарх шинжээчийн үнэлгээ, талуудын тохирч тогтоосон үнэ эсвэл шийдвэр гүйцэтгэгчийн үнэлгээ аль аль нь бодитой байх магадлалтай бөгөөд талуудын тохирч тогтоосон үнэ эсвэл шийдвэр гүйцэтгэгчийн үнэлгээг шинжээчийн үнэлгээнээс доогуур тавьж, үүнээс хамаарч хөрөнгөө шинжээчээр үнэлүүлсэн төлбөр төлөгч, нөгөө талаар хөрөнгийн үнийг тохирч эсвэл шийдвэр гүйцэтгэгч тогтоосон төлбөр төлөгчид ялгавартай байдлыг хуулиар бий болгосон нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд нийцэхгүй байна.

Борлогдоогүй хөрөнгийг төлбөрт нь тооцож төлбөр авагчид санал болгохдоо хөрөнгийн үнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3, 73.5 дахь хэсэгт ийнхүү хоёр өөр байдлаар тогтоосноор хөрөнгийн үнийг харилцан тогтоосон талуудын эрх, зах зээлийн үнийг тогтоосон шийдвэр гүйцэтгэгчийн ажиллагаа ач холбогдлоо алдсан байна. Нөгөө талаар хөрөнгийн үнийг 50 хувь бууруулж доод үнээс эхлэн дуудлага худалдааг явуулсан боловч хөрөнгө борлогдоогүй тул төлбөрийг барагдуулахын тулд хөрөнгийг доод үнээр нь тооцож төлбөр авагчид санал болгох зорилго байсан гэж үзэхэд хөрөнгийг шинжээчээр үнэлүүлсэн эсэхээс хамаарч өөр өөр үнээр тооцох агуулгатай байгаа нь зөрчилтэй байгаа юм.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд дараах агуулга бүхий хариу тайлбарыг гаргасан байна:

1. “Хууль тогтоогч Монгол Улсын Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тодорхой үндэслэлээр шүүгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч түдгэлзүүлэх шийдвэр гаргахаар хуульчилсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсгүүдэд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэлүүдээс харвал ахлах шийдвэр гүйцэтгэгчид олгогдсон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэлүүд нь нэгэнт тодорхой болсон, маргах шаардлагагүй үйл баримтууд буюу төлбөр төлөгч-иргэн нас барсан гэж зарлагдсан,

сураггүй алга болсонд тооцогдсон, тухайн ажиллагаатай холбогдуулан эрүүгийн, иргэний хэрэг үүсгэсэн гэх зэрэг үндэслэлүүдийг тоочин заасан байна. Харин төлбөр төлөгч эд хөрөнгөтэй эсэх, түүнийг тогтоох шаардлагатай ажиллагааг зохих ёсоор хийж гүйцэтгэсэн эсэх, төлбөр төлөгчийн хөрөнгөөс төлбөр гаргах боломжтой эсэхийг тогтоох асуудал буюу маргаж болохуйц асуудлыг шүүгч шийдвэрлэх нь зүйтэй гэж хууль тогтоогч үзсэний дагуу 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтыг шүүгчид харьяалуулан хуульчилсан.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч хөрөнгө, орлогогүй нь тогтоогдсон гэж уг ажиллагааг хэрэгжүүлэх болон түүнд хяналт тавих эрх бүхий этгээд үзэж, дангаар бие даан уг ажиллагааг түдгэлзүүлж, хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг зогсоох нь төлбөр төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшилна гэж үзсэн бөгөөд тийнхүү шийдвэр гаргах асуудлыг сонирхогч талууд буюу төлбөр төлөгч, төлбөр авагч, шийдвэр гүйцэтгэгчийн оролцоотойгоор, тэдгээрээс гаргасан мэдээлэл, баримт, сэлтэд үндэслэн хараат бус шийдвэр гаргах субьект болох шүүгч шийдвэрлэх нь төлбөр авагчийн эрх, ашиг сонирхолд нийцэх төдийгүй Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх, шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх зарчимд нийцнэ гэж үзсэн. Хууль тогтоогч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан асуудлыг хуульчлахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг үндэслэл болгож шүүгчид дээр дурдсан асуудлыг харьяалуулахаар шийдвэрлэсэн гэж үзэж байна. Мөн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журмыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн VI хэсэгт хуульчилсан байх бөгөөд иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь иргэний процессоос тусдаа бус харин түүний салшгүй нэг хэсэг байдаг.

Иймд иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх асуудал нь шүүхийн үйл ажиллагаатай холбоогүй, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу түдгэлзүүлэх боломжгүй гэсэн Улсын дээд шүүхийн хүсэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

2. Хууль тогтоогч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлд төлбөр төлөгчийн худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгохтой холбогдсон харилцааг зохицуулсан

бөгөөд ийнхүү зохицуулахдаа 73.3 дахь хэсгээр төлбөр авагчийн барьцаанд байгаа болон дундын өмчлөлийн хөрөнгөөс төлбөр төлөгчид ногдох хөрөнгөөс бусад хөрөнгийг түүний үнэлэгдсэн үнээс 50 хувиар бууруулан төлбөр авагчид санал болгохоор, 73.5 дахь хэсгээр төлбөр авагчийн барьцаанд байгаа болон дундын өмчлөлийн хөрөнгийн төлбөр төлөгчид ногдох хэсгийг шинжээчээс тогтоосон үнээр төлбөр авагчид санал болгохоор тус тус хуульчилсан. Ийнхүү зохицуулсан нь нэг талаас талуудын чөлөөт хүсэл, зоригийн үндсэн дээр буюу талууд өөрсдийн эрсдлийг тооцож, тохиролцсоны үндсэн дээр бий болсон барьцааны үүрэг, барьцааны зүйлээр төлбөрийн шаардлагыг бүрэн хангуулах, үүргийн гүйцэтгэлийг барьцаалагдаагүй бусад хөрөнгөөс гаргуулахгүй байж төлбөр төлөгчийн өмчлөх эрхийг хамгаалах, нөгөө талаас төлбөрт гаргуулах үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр төлөгчтэй дундаа хэсгээр, эсхүл хамтран өмчилж байгаа этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн зохицуулалт юм.

Энэхүү хамгаалалт төлбөр төлөгчийн өөрийн хөрөнгө нь төлбөрийн шаардлагыг биелүүлэхэд хүрэлцэхгүй тохиолдолд төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх хөрөнгийн түүнд ногдох хэсгээс төлбөрийг гаргуулахаар заасанд мөн адил хамаарч, төлбөр төлөгчтэй хөрөнгө дундаа хэсгээр өмчилж байгаа өмчлөгчийн ашиг сонирхлыг хангахад чиглэсэн агуулгатай юм.

Харин үүргийн гүйцэтгэлийг хангуулах аливаа хэлбэр, барьцааг сонгоогүй, тухайн хөрөнгийг үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар буюу төлбөртөө суутган авахаар хэлцэн тохиролцож гэрээ хийгээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах үүднээс төлбөр төлөгчийн хоёр шатны дуудлага худалдаагаар ороод худалдан борлогдоогүй хөрөнгийн үнийг тодорхой хувиар бууруулан төлбөр авагчид санал болгохоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт зохицуулсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт заасан зохицуулалт нь хоёр дахь дуудлага худалдааны дуудах анхны үнэ буюу Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн зохицуулалттай холбоотой бөгөөд хоёр дахь дуудлага худалдааны үед дээр дурдсанаар тооцсон үнээр бусдад санал болгоход дуудлага худалдаа нь амжилтгүй болсон байхад төлбөр авагчид түүнээс илүү үнээр санал болгох нь төлбөр авагчийн эрх, ашиг сонирхолд хэт сөрөг нөлөөтэй гэж үзсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.5 дахь хэсэгт төлбөрт тооцсон хөрөнгийн үнийг 50 хувиар буулгахгүйгээр тухайн хөрөнгийн анхны тогтоосон үнээр буюу 100 хувиар төлбөр авагчид санал болгох хоёр тохиолдлыг хуульчилсан.

Дээр дурдсаныг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсгийн холбогдох зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй гэсэн тайлбарыг үгээр уламжилж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтад төлбөр гаргуулж болох хөрөнгө, орлого байхгүй бөгөөд хуульд заасан аргаар түүний хөрөнгө, орлогыг албадан гаргуулах боломжгүй бол төлбөр төлөгчийг хөрөнгөтэй болох хүртэл иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүгч бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлэхээр зохицуулсан байна.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн тохиолдолд түдгэлзүүлэх тухай шийдвэр гарснаас эхлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хугацаа шинээр тоологдох үр дагавартай байдаг. Гэтэл дээр дурдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтад “... төлбөр төлөгчийг хөрөнгөтэй болох хүртэл.” гэх ойлголтоор хугацаа тодорхойлохоор тогтоосон төдийгүй, түдгэлзүүлэх үндэслэл болгон заасан байна. Мөн түүнчлэн холбогдох хуульд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэхэд ямар журмыг баримтлах, талуудын эрхийг хэрхэн хангах зэргийг холбогдох хуулиудад нарийвчлан тусгаагүй байгаа нь иргэн Үндсэн хуулиар баталгаажсан процессын эрхээ хэрэгжүүлэх, түүнчлэн шүүгчээс холбогдох асуудлыг шударга ёс, тэгш байдлын зарчмын хүрээнд шийдвэрлэх боломжгүй болгож байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна.

2. Хууль тогтоогч нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх журам болон эрх зүйн үндэслэлийг нарийвчлан хуульчлах шаардлагатай бөгөөд ингэснээр Үндсэн хуулиар баталгаажсан иргэний эрх болон шударга ёс, тэгш байдлын зарчим, хууль зүйн тодорхой байдал хангагдана.

Улсын дээд шүүхийн хүсэлтэд шүүх холбогдох ажиллагааг зөвхөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд явуулах эрхтэй, иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх дээрх асуудал нь шүүхийн үйл ажиллагаатай холбоогүй, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжих асуудал гэх үндэслэл гаргасан нь Үндсэн хуульт ёс, эрх зүйн онол, зарчимд нийцээгүй төдийгүй, үүнд тусгасан тайлбарын хүрээнд дээр дурдсан зохицуулалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх хангалттай үндэслэл болохгүй байгааг дурдах нь зүйтэй байна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 32, 33 дугаар зүйлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудад төлбөр төлөгч ба төлбөр авагч этгээдийг хамааруулахаар тодорхойлж, эрх зүйн байдал болон эрх үүргийг нийтлэг байдлаар тогтоосон байдаг. Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлд "барьцаалагч-төлбөр авагч" гэдэг нэр томьёо бий болгосон нь "барьцаалагч бус-төлбөр авагч" гэх ойлголтыг төрүүлэхээр байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт төлбөр төлөгчийн өмчлөлийн хөрөнгө худалдан борлогдоогүй тохиолдолд барьцаа болон дундын өмчлөлийн хөрөнгөөс бусад хөрөнгийг үнэлэгдсэн үнийн 50 хувиар бууруулж тооцон олгохоор заасан бол харин мөн хуулийн 73.5 дахь хэсэгт барьцаа болон дундын өмчлөлийн хөрөнгийг тухайн үнэлэгдсэн үнээр төлбөр авагчид санал болгохоор тус тус заажээ. Тодруулбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсгийн зохицуулалтын дагуу "Барьцаалагч бус-төлбөр авагч" этгээдэд учирсан хохирлыг төлбөр төлөгчийн үл хөдлөх хөрөнгөөс гаргуулахаар албадан дуудлага худалдаа зарлаад худалдан борлогдоогүй тохиолдолд тухайн эд хөрөнгийн үнийг 50 хувь бууруулан төлбөр авагчид шилжүүлэх зарчмыг тогтоосон байна. Энэ нь барьцаалагч-төлбөр авагч, барьцаалагч бус-төлбөр авагч этгээдийн хувьд албадан дуудлага худалдаагаар борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөрт тооцож шилжүүлэхдээ ялгавартай байдлаар шийдвэрлэх хууль зүйн үндэслэлийг бий болгосон зохицуулалт болжээ.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар

бууруулж тооцон олгоно. ...” гэж заасан нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг алдагдуулсан гэж үзэх үндэслэлтэй байна.

Түүнчлэн тус хуулийн 73 дугаар зүйл нь “Худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгох” талаарх хэм хэмжээг агуулахаар тусгасан атал 73.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно. ...” гэсэн императив шинжтэй хэм хэмжээг тогтоосон байна. Тодруулбал, худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгох талаарх диспозитив хэм хэмжээг зохицуулах зүйлд императив шинжтэй хэм хэмжээг тусгаж зохицуулалт хоорондын зөрчлийг үүсгэсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтад “төлбөр гаргуулж болох хөрөнгө, орлого байхгүй бөгөөд хуульд заасан аргаар түүний хөрөнгө, орлогыг албадан гаргуулах боломжгүй бол төлбөр төлөгчийг хөрөнгөтэй болох хүртэл.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ... тэгш байдал ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “... эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно. ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн байна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтад “төлбөр гаргуулж болох хөрөнгө, орлого байхгүй бөгөөд хуульд заасан аргаар түүний хөрөнгө, орлогыг албадан гаргуулах боломжгүй бол төлбөр төлөгчийг хөрөнгөтэй болох хүртэл.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.”, Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй.” гэж заасныг зөрчөөгүй байна.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтын “төлбөр гаргуулж болох хөрөнгө, орлого байхгүй бөгөөд хуульд заасан аргаар түүний хөрөнгө, орлогыг албадан гаргуулах боломжгүй бол төлбөр төлөгчийг хөрөнгөтэй болох хүртэл.” гэснийг; мөн хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно. ...” гэсэн заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

5. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Д.ОДБАЯР
ГИШҮҮД	Н.ЧИНБАТ
	Д.СОЛОНГО
	Ш.СОЛОНГО
	Ц.НАНЗАДДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2018.10.25 Дугаар 77 Төрийн ордон,
Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны
12 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтад “төлбөр гаргуулж болох хөрөнгө, орлого байхгүй бөгөөд хуульд заасан аргаар түүний хөрөнгө, орлогыг албадан гаргуулах боломжгүй бол төлбөр төлөгчийг хөрөнгөтэй болох хүртэл.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ... тэгш байдал ... нь төрийн үйл ажиллагааны үдсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “... эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй тул хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно. ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр, хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.10.24 Дугаар 13 Улаанбаатар хот

Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Цэцийн гишүүн Н.Чинбат, Д.Ганзориг, Д.Солонго /илтгэгч/, Г.Туулхүү нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Ч.Жадамба болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Нотариатын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын холбогдох хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Ч.Жадамба Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“... Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай

эдэлнэ гээд тус зүйлийн 3 дахь заалтад хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхийг хуульчлан баталгаажуулсан байна. Өмчлөгч нь өөрийн материаллаг болон материаллаг бус хөрөнгөө өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах /өв залгамжлуулах/ бөгөөд аливаа хууль бус халдлагаас хамгаалах эрхтэй. ...

Харин Нотариатын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэгт “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн байна.

Иргэний хуульд зааснаар өвлүүлэгчийн эд хөрөнгө, эрх өвлөгдөх бөгөөд өвлөгч нь өвлөн авсан өвийн хэмжээгээр өвлүүлэгчийн үүргийг хүлээдэг. Өв нээгдсэн газрын нотариатч өвлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн хуульд заасан журмын дагуу өвлөх эрхийн гэрчилгээ олгодог. Гэтэл тухайн өвлөгдөх эд хөрөнгө нь барьцаанд байгаа тохиолдолд гагцхүү барьцаалагч зөвшөөрсөн нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг олгохоор байна. Өөрөөр хэлбэл, барьцаалагч татгалзсан тохиолдолд иргэн Үндсэн хуульд заасан хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байна.

Иймд Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн эсэхийг магадлан шалгаж, хэрэв Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн бол хүчингүй болгож өгнө үү.” гэсэн мэдээлэл ирүүлсэн байна.

Хоёр. Уг маргаанд холбогдуулан Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад зааснаар Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй бөгөөд иргэний өв залгамжлуулах эрхийг хангах харилцааг Иргэний хууль, Нотариатын тухай хууль, нотариатын үйлдэл хийх заавар болон бусад холбогдох хууль, хуульчилсан актаар зохицуулсан байдаг.

Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэгт “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх үндсэн эрх, түүний хувийн эрх зүйн харилцаанд хэрэгжих үндэслэлийг тодорхойлсон заалт юм. Учир нь эд хөрөнгө барьцаалах асуудал нь Иргэний хуульд зааснаар талуудын чөлөөт хүсэл зоригт үндэслэн үүсдэг тул үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд шаардлагаа хангуулах баталгаа болсон барьцаанд байгаа эд хөрөнгийн өмчлөлийн асуудалд түүний тодорхой ашиг сонирхол хөндөгдөж байдаг.

Өөрөөр хэлбэл, өмчлөгч иргэн буюу зээлдэгч нь зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс үл маргах журмаар гаргуулахаар харилцан тохиролцсон гэрээг төрийн нэрийн өмнөөс хөндлөнгийн гэрчийн үүрэг гүйцэтгэж, эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус харилцаанд оролцож байгаа этгээдэд эрх зүйн зөвлөгөө өгөх үндсэн чиг үүрэг бүхий нотариатчаар гэрчлүүлсэн байх шаардлагыг хуульчилсан байдаг. Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлд заасны дагуу нотариатч нь үйлчлүүлэгчид эрх, үүргийг нь тайлбарлан, тухайн үйлдлийг өөрийн хүсэл зоригийн дагуу хэрэгжүүлж байгаа эсэхийг тодруулан, эрх зүйн үр дагавар, хууль зүйн ач холбогдлыг тайлбарлаж зөвлөгөө өгөх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээсээ үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй талаар, мөн хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу нотариатч уг гэрээ, хэлцлийг гэрчлэхдээ талууд тэгш эрхийн үндсэн дээр гэрээ, хэлцэл байгуулсан эсэх, бусдын дарамт, шахалт болон бусад хүчин зүйлсийн нөлөөлөлд автсан эсэх, гэрээний агуулга нь талуудын хүсэл зоригийг бүрэн илэрхийлж чадсан эсэх, үүсэх үр дагавар, үр дүнд бодитой хандаж чадсан эсэх, гэрээний агуулга, гарах үр дагавар, үүргээ биелүүлээгүй нөхцөлд хүлээх хариуцлага зэргийг бүрэн гүйцэд ойлгосон эсэхийг талуудаас тодруулж, эдгээр нөхцөл байдлын аль нэг нь зөрчигдсөн бол нотариатч гэрээг гэрчлэхээс татгалзах үүрэгтэй, мөн Иргэний хуулийн 515 дугаар зүйлийн 515.2 дахь хэсэгт “Өвлөгч өвлөн авсан өвийн хэмжээгээр өвлүүлэгчийн үүргийг хүлээнэ.” гэж заасантай нийцүүлэн Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсгийг хуульчилсан.

Дээрх хуулийн зохицуулалт нь өвлөгчийн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх, түүнчлэн өв залгамжлуулах эрхийг хязгаарласан заалт

биш юм. Энэ нь үүрэг гүйцэтгэгч, гүйцэтгүүлэгчийн хооронд гэрээний үндсэн дээр байгуулагдсан барьцаалбарын асуудал хөндөгдсөн үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаалагчийн ашиг сонирхолтой холбоотой хэрэглэгдэх зохицуулалт болохоос биш өвлөгчийн өмчлөх эрхийг хязгаарлах утгаар хэрэглэгдэхгүй болно.

Нотариатын тухай хуульд зааснаар өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгох асуудал нь нотариатчийн эрхлэх үйлдлийн нэг төрөл бөгөөд өвлөх эрхийг баталгаажуулах үйлдэл юм. Хуульд зааснаар нотариатчаас гадна өвлөх эрхийн гэрчилгээг нотариатын үүрэг гүйцэтгэгч болох нотариатын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хавсран эрхэлж байгаа сумын Засаг даргын Тамгын газрын дарга болон Монгол Улсын дипломат төлөөлөгч, консулын газар олгож болдог.

Иймд Нотариатын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсгийн “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэж заасан нь Үндсэн хуулиар иргэдэд олгосон хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрхийг зөрчөөгүй гэсэн тайлбарыг уламжилж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Өмчлөх эрх нь өмчлөгчийн язгуур эрх учир иргэний өмчлөх, өв залгамжлуулах эд хөрөнгөд өмчлөгчийн хүсэл зоригийн эсрэг хөндлөнгөөс халдаж болохгүй. Энэхүү үзэл баримтлалын хүрээнд иргэний өмчлөх эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтаар хуульчлан баталгаажуулсан болно.

2. Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалахаар зааж, эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль зэргээр нарийвчлан зохицуулж байна.

Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.1, 156.3 дахь хэсэгт зааснаар барьцааны гэрээг бичгээр байгуулах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байхаар зохицуулж, мөн хуулийн

154 дүгээр зүйлийн 154.1, 154.2 дахь хэсэгт зааснаар өмчлөгч өөрийн өмчлөлийн хөрөнгийг хэд хэдэн этгээдэд давхар барьцаалж болох бөгөөд энэ нөхцөлд барьцаалагч буюу үүрэг гүйцэтгүүлэгч нар нь барьцааны гэрээг байгуулсан дарааллын дагуу өөрсдийн шаардлагаа хангуулах эрхтэй байхаар хуульчилжээ. Мөн уг хуулийн 515 дугаар зүйлийн 515.2 дахь хэсэг, 535 дугаар зүйлд зааснаар өв хүлээн авсан өвлөгчид эсхүл холбогдох журмын дагуу өвийг шилжүүлэн авсан төрийн байгууллага нь өвлүүлэгчийн гүйцэтгэвэл зохих үүргийг өвлөн авсан өвийн хэмжээгээр хувь тэнцүүлэн хариуцахаар зохицуулсан байна. Үүнээс үзэхэд өвлөгдөх эд хөрөнгө буюу өв барьцаанд байгаа нөхцөлд тухайн өвийг өвлөгч хүлээн авсан, эсхүл татгалзсан, улмаар өвлөх эрхийн гэрчилгээг өвлөгчид олгосон, холбогдох төрийн байгууллага өвийг шилжүүлэн авсан зэргээс үл хамааран барьцаалагч этгээд өөрийн шаардлагаа өвлөгчийн өвлөн авсан өвөөс хангуулах эрхийг хөндөхөөргүй байна.

Гэтэл Нотариатын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэгт “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэж зааж өвлөгдөх эд хөрөнгө буюу өв нь барьцаанд байгаа нөхцөлд өв хүлээн авагчид өвлөх эрхийн гэрчилгээг олгохдоо тухайн эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрөл авахаар хуульчилсан байна.

Үүнээс үзэхэд Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг нь өмчлөгчийн хүсэл зоригийн дагуу бусдаас хараат бусаар хэрэгжих өмчлөх, өв залгамжлуулах эрх, нөгөө талаас хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг гэрээслэл болон хуулийн дагуу өв залгамжлах эрхэд хязгаарлалт тогтоосноороо Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн гэж үзэхээр байна.

Түүнчлэн уг зохицуулалт нь иргэний эрх зүйн тэгш эрхийн зарчмыг алдагдуулж, өвлөгдөх эд хөрөнгийг барьцаалсан байгууллагад давуу байдал бий болгосон байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн өмчлөгч өөрийн өмчлөлийн барьцаанд байгаа үл хөдлөх хөрөнгийг бусдын эзэмшил, өмчлөлд шилжүүлэхдээ үүрэг гүйцэтгүүлэгч, барьцаалагчийн зөвшөөрөл авсан байхыг шаардсан агуулга бүхий зохицуулалтын талаарх маргааныг хянан хэлэлцээд Монгол Улсын Үндсэн хуулийн

холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэж 2015 оны 11, 2017 оны 01 дүгээр тогтоолоор уг зохицуулалтыг хүчингүй болгосон байна.

Тухайлбал, Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр тогтоолын үндэслэх хэсэгт “Ипотекийн зүйлийн өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх хөрөнгөө бусдын өмчлөлд шилжүүлэх, түрээслэх, хөлслөх, үнэ төлбөргүйгээр түр ашиглуулахаар бусдын эзэмшилд шилжүүлэх, давхар барьцаалах, барьцаалуулсан газар дээрээ барилга байгууламж барих зэргээр туйлын эрхээ хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд ингэснээрээ барьцаалагчийн эрхийг зөрчихгүй, барьцаалагчид гэм хор учруулахгүй юм. Учир нь ипотекийн зүйлийн өмчлөл, эзэмшил хэнд шилжсэнээс үл хамааран барьцааны зүйлийг дагалдан ипотекийн эрхээ хэрэгжүүлэх давуу эрх нь барьцаалагчид хэвээр хадгалагддаг. Мөн ипотекийн зүйлийг давхар барьцаалах нь ипотекаар хангагдах шаардлагаа тэргүүн ээлжинд хангуулах өмнөх барьцаалагчийн эрхийг хөнддөггүй. Монгол Улсын Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэгт “Ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг ашиглахгүй, бусдын өмчлөлд шилжүүлэхгүй, өөр байдлаар гуравдагч этгээдэд эрх олгохгүй байх үүргийг өмчлөгчид хүлээлгэсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.” гэж заасан нь өмчлөгчийн туйлын эрхийг баталгаажуулсан үндсэн зохицуулалт юм.” гээд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн Их суудлын хуралдаанаар Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэгт “Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна.”, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Барьцаалуулагч нь Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийг баримтлан барьцааны зүйлийг гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр бусдын өмчлөлд шилжүүлэх эрхтэй.” гэж заасны “... гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...” гэсэн хэсэг нь барьцаалагч талд давуу байдал олгосноор иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын тэгш байдлын зарчим, Үндсэн хуулиар тогтоосон өмчлөгчийн язгуур эрхэд халдсан байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн гэж үзэж, Үндсэн хуулийн цэц 2015 оны 11 дүгээр тогтоолоор дээрх хуулиудын заалтыг хүчингүй болгосон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт,

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан Нотариатын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэгт “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. ...” гэснийг зөрчсөн байна.

2. Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсгийн “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэсэн заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Д.ОДБАЯР
ГИШҮҮД	Н.ЧИНБАТ
	Д.ГАНЗОРИГ
	Д.СОЛОНГО
	Г.ТУУЛХҮҮ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2018.11.15 Дугаар 83 Төрийн ордон,
Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны
13 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“ Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан Нотариатын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэгт “Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө … өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. …” гэснийг зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 13 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.11.14 Дугаар 14 Улаанбаатар хот

Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 15.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг, Б.Буяндэлгэр /илтгэгч/, Г.Туулхүү, Ц.Нанзаддорж нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормаа оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Н.Наранбаяр, Г.Бямбажаргал болон, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн

Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Наранбаяр, Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны оршин суугч, иргэн Г.Бямбажаргал нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

1. “Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай Сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заажээ.

Энэхүү заалтаас үзвэл иргэдийн Төлөөлөгчийг “нэр дэвшигчийн” хувьд гэсэн онол, арга зүйн огт байхгүй ойлголтыг бий болгосон байдаг. Үндсэн хуулийн эрх зүйн хувьд нэр дэвшигч сонгуулийн хууль тогтоомжийн шаардлагын дагуу сонгогдсон нөхцөлд иргэдийн Төлөөлөгч гэсэн субъект болдог. Иргэдийн Төлөөлөгч хэмээх субъект буцаж нэр дэвшигч болох тухай хууль зүйн зохицуулалт байж хэрхэвч болохгүй. Сонгуулийн эрх зүйн хувьд нэр дэвшигчийн талаарх эрх зүйн зохицуулалт, иргэдийн Төлөөлөгчийн талаарх эрх зүйн зохицуулалт тус тусдаа байх ёстой. Энэхүү нөхцөл байдал нь сонгуулийн үр дүнд иргэдийн Төлөөлөгчөөр сонгогдож бүрэн эрх нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталгаажиж, мандат авсан иргэдийн Төлөөлөгчийн бүрэн эрхэд нэр дэвшигчтэй адил халдах байдлыг үгүйсгэж байгаагаараа түүний Үндсэн хуулийн хүрээн дэх эрх зүйн байдлыг дордуулсан зохицуулалт болсон гэж үзэж байна.

Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.1 дэх хэсэгт сонгуулийн байгууллага нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасахаар зохицуулсан байдаг. Энэ зүйлийн агуулгаас үзвэл иргэдийн Төлөөлөгчийн мандатыг сонгуулийн байгууллага хүчингүй болгож, бүрэн эрхийг дуусгавар болгож байх юм. Гэтэл Үндсэн хуулийн эрх

зүйн хүрээнд Сонгуулийн байгууллага нь сонгуулийг зохион байгуулж явуулах үндсэн чиг үүрэг бүхий этгээд юм. Үндсэн хуулийн эрх зүйн агуулгаар бол сонгуулийн харилцаанд нэр дэвшигч ялалт байгуулж ард түмний төлөөлөгчөөр буюу иргэдийн Төлөөлөгчөөр сонгогдож, бүрэн эрх нь баталгаажсан тэрхүү эрх зүйн механизмаар буюу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Төлөөлөгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох эсэх асуудлыг шийдвэрлэж байх ёстой.

Сонгуулийн тухай хуулийн дээрх зохицуулалт нэг талаасаа сонгогчдын сонгох эрх, иргэдийн Төлөөлөгчдийн сонгогдох эрхэд Үндсэн хуулийн агуулгад нийцээгүй байдлаар халдаж байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ..." хэмээн хуульчилсан заалтын агуулгатай дээрх зохицуулалт зөрчилдөж байна.

2. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт "Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай Сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж бүрэн эрх нь дуусгавар болно." гэж заажээ. Гэтэл орон нутгийн хурлын сонгуулиас бусад төрлийн сонгуульд энэ заалттай төсөөтэй буюу ижил зохицуулалт байхгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн харилцаанд Улсын Их Хурлын гишүүн болон Ерөнхийлөгчийн тухайд "нэр дэвшигчийнх" нь хувьд гэдэг ойлголт, зохицуулалт байдаггүй. Энэ нөхцөл байдал нь сонгуулийн харилцаанд эрх тэгш байдлыг алдагдуулж байгаа зохицуулалт гэж үзэх үндэслэлийг бий болгож байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэсэн заалттай Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг бүрэн нийцэхгүй байгаа юм.

3. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг "Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх нь хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай Сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж бүрэн эрх нь дуусгавар болно." гэж заажээ. Энэ зүйлийн зохицуулалт нь өнгөцхөн харахад хууль тогтоомжийн зохицуулалтын алдаа мэт харагдах хэдий ч хэрэгжиж байгаа мөн чанар нь ард түмний

засгийн эрх мэдэлд халдсан шинжтэй байгаа юм. Бодит амьдрал дээр сонгуулийн байгууллага иргэдийн Төлөөлөгчдийн бүрэн эрхийг дуусгавар болгож, мандатыг нь хүчингүй болгож байгаа практик байгааг дурдах нь зүйтэй. Цаашид энэхүү байдал үргэлжлэх нь Монгол Улсын иргэдийн Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлээр тодорхойлогдсон эрхэнд ноцтой халдаж байх нөхцөл бүрдүүлж байгаа билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ." хэмээн заасан юм. Сонгуулийн тухай хуулийн дээр дурдсан зохицуулалт нь агуулгын хувьд Үндсэн хуулийн энэхүү заалттай бүрэн харшилж байна. Учир нь ард түмэн сонгосон төлөөлөгчдийн байгууллагын тухайд түүнийг төлөвшүүлэн бүрдүүлсэн эрх зүйн механизмаар уг байгууллагыг бүрдүүлж буй иргэдийн Төлөөлөгчийн бүрэн эрхийг хязгаарлах хууль зүйн зохицуулалтыг тодорхойлох ёстой. Гэтэл энэ асуудлыг сонгуулийн байгууллага шийдвэрлэх эрх мэдэлтэй байхаар Сонгуулийн хуулиар хуульчилсан юм. Иймд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчийн мандатыг хүчингүй болгож, бүрэн эрхийг нь дуусгавар болгох талаарх Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг нь дээр дурдсан агуулгатай бүрэн нийцэхгүй байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт "Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх нь хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай Сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж бүрэн эрх нь дуусгавар болно." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг тус тус зөрчсөн болохыг тогтоож өгнө үү." гэсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

1. "Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт "Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөөгчийг нэр дэвшигчийнх нь хувьд нэрийн жагсаалтаас хасах

тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэснийг зөрчөөгүй талаар:

Монгол Улсын Үндсэн хуулиар засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх зарчмыг хуульчилсан нь төрийн засаглах эрх мэдлийн эх сурвалж нь ард түмэн гэснийг нотолж байгаа хэлбэр бөгөөд засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэдэг нь ардчиллын зарчмын хэрэгжилтийг хангах засаглалын оновчтой механизм юм. Иймд төлөөлөх ардчилал нь ард түмний сонгон байгуулсан төрийн байгууллагаараа дамжуулж төрийн засаглах эрх мэдлийг хэрэгжүүлдэг удирдлагын арга бөгөөд Сонгуулийн тухай хуулийн холбогдох заалт Монгол Улсын засгийн бүх эрх мэдлийг ард түмний мэдэлд байх зарчмыг зөрчөөгүй ба ард түмэн төрийн хэрэгт шууд оролцох боломжийг нь ямар нэг байдлаар хөндөөгүй болно.

Үндсэн хуулийн зарим төрлийн эрхэд зөвшөөрөх журам тогтоосон байдаг. Холбогдох төрийн байгууллага эсвэл нутгийн удирдлагын байгууллагаас зөвшөөрөл авсны дараа зөвхөн тэдгээр нь хэрэгжих боломжтой болно. Гэхдээ хүн өөрийн Үндсэн хуулийн эрхийг чөлөөтэй эдэлж болох боловч эрхээ буруугаар ашигласан, хууль зөрчсөн нөхцөлд хариуцлага хүлээлгэх механизм бүрддэг. Сонгуулийн тухай хуульд аливаа сонгуульд нэр дэвшихдээ хориглох үйлдэл болон түүний улмаас нэрийн жагсаалтаас хасах зохицуулалтыг нарийвчлан хуульчилсан. Тиймээс орон нутгийн төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн хэдий ч тухайн сонгуульд нэр дэвшихдээ хууль зөрчиж төлөөлөгчөөр сонгогдсон бол сонгуулийн хорооны шийдвэрээр тухайн төлөөлөгчийн мандатыг хүчингүй болгож, бүрэн эрх нь дуусгавар болгоно. Учир нь ард түмэн төрийн үйл хэрэгт оролцох эрхээ хэрэгжүүлснээр сонгож байгуулсан орон нутгийн Хурлын төлөөлөгч нь сонгогдохдоо хуульд заасан хориглох хэм хэмжээг зөрчин сонгогдсон нь ард түмний сонгох эрхийг зөрчсөн үйлдэл болох тул орон нутгийн төлөөлөгчийн хувьд шинээр илэрсэн нөхцөл байдлыг нь харгалзан тухайн төлөөлөгчийн мандатыг нь хүчингүй болгож, бүрэн эрхийг нь дуусгавар болгох үндэслэл болно.

Сонгуулийн тухай хуулийн 151 дүгээр зүйлийн 151.1 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын сонгууль нь нутгийн өөрөө удирдах байгууллагыг орон нутгийн иргэд өөрсдийн төлөөлөгчдөөр бүрдүүлэх үндсэн арга мөн.” гэж заасан үндэслэлээр сонгогчид төрийн үйл ажиллагаанд шууд оролцож, сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан эрхээ эдэлж байгааг нь зөрчөөгүй бөгөөд Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг нь орон нутгийн хурлын төлөөлөгчийг сонгох журмыг тогтоосон заалт бөгөөд энэ нь ард түмний засаглах бүрэн эрхийг үл хөндсөн болно.

2. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчөөгүй талаар:

Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим нь аливаа этгээдэд адил шударга, хүндэтгэлтэй хандаж, хуулийг чанд, нэг мөр хэрэглэх агуулгыг илэрхийлдэг бөгөөд хуулийн өмнө тэгш байх ерөнхий эрхийн хүрээнд тэгш сонгогдох эрх хамгаалагдсан болохыг илэрхийлдэг. Гэхдээ тодорхой тохиолдолд буюу зөрчил үйлдсэн этгээдэд түүний зан үйлээс шалтгаалан үйлдэл, үйл ажиллагаанд хуулийн нэг зохицуулалт ялгаатай байдлаар бус харин хуулийн өөр зохицуулалт үйлчлэх нь хуулийн өмнө эрх тэгш байх зарчмыг хөндөхгүй байх бөгөөд энэ нь шударга ёсны зарчимд илүү нийцнэ гэж үзэж байна. Үндсэн хууль зөвхөн тэгш эрхийг хангаж, өөрөөр хэлбэл бүх хүнд нэгэн адил хууль зүйн ижил боломж олгодог, ижил тэгш үүрэг хүлээлгэдэг. Тиймээс хуулийн өмнө тэгш байна гэдэг нь албан тушаал, нийгмийн байдал, хувь хүний бусад шинж чанараас үл хамааран хууль бүгдэд нь адил үйлчилж, хууль зөрчсөн нөхцөлд бүх хүн адилхан хариуцлага хүлээх ёстой гэсэн үг юм.

Сонгуулийн тухай хуульд Монгол Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигчдэд тавигдах шаардлага, эрх үүрэг, баталгаа, хориглох үйлдэл, үйл ажиллагаа, захиргааны зөрчлийн хэлбэр, хариуцлага зэргийг нийтлэг байдлаар хуульчилсан. Сонгуулийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.2 дахь хэсэг, 159 дүгээр зүйлийн 159.2 дахь хэсэгт нэр дэвшигч Сонгуулийн тухай хуулийн 52, 67.3, 70.1, 70.5.1-70.5.10, 70.5.13-70.5.16 дахь заалтад заасан үндэслэл тогтоогдвол уг нэр дэвшигчийг бүртгэсэн сонгуулийн байгууллага нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасч, нийтэд мэдээлэх талаар адил зохицуулалттай. Тиймээс Сонгуулийн тухай хуулийн холбогдох зүйлд

нэр дэвшигч нь Сонгуулийн тухай хуулийн хамаарах хэсэгт заасан үндэслэл тогтоогдсон тохиолдолд орон нутгийн Хурлын төлөөлөгчөөр хүлээн зөвшөөрөгдсөн ч нэр дэвшигчийн хувьд нэрийн жагсаалтаас хасаж төлөөлөгчийн мандат хүчингүй болно.

Төрийн үйл ажиллагааны эрх чөлөө, тэгш байдлын зарчим нь шударга ёсны зарчмаас эх үүсвэртэй бөгөөд сонгуулийн тухай хуулийн үндсэн зорилго болох аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн зарчим, журам, сонгууль зохион байгуулахтай холбоотой харилцааг бусад эрх бүхий этгээдийн сонгуультай адил зохицуулсан нь шударга ёсны зарчмыг хангаж байгаа тул төрийн үйл ажиллагаанд эрх чөлөө, тэгш байдлын зарчим зөрчигдөөгүй гэж үзэж байна.

3. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг зөрчөөгүй талаар:

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу иргэн нь шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох, төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй гэж заасан бөгөөд төрийн зохих байгууллага, албан тушаалд тавигдах шаардлагыг харгалзан хуулиар тусгайлан тогтоож болохоор заасны дагуу Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд заасан өөрийн онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт нэр дэвшигчид хүлээлгэх хариуцлагыг хуульчилжээ.

Сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад “нэр дэвшигч” гэж энэ хуульд заасан журмын дагуу тухайн сонгуульд нэр дэвшиж бүртгүүлсэн, нэр дэвшигчийн үнэмлэх авсан иргэнийг хэлнэ гэж заажээ. Орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигчийн эрх зүйн байдлыг адил тодорхойлсон бөгөөд нэр дэвшигч сонгуулийн тухай хуулийн хориглох заалтыг зөрчиж иргэдийн Төлөөлөгчөөр сонгогдож бүрэн эрх нь баталгаажсан ч түүний эрх зүйн байдал нь хэрхэн тодорхойлогдсон байсан нь үл хамааран бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно.

Энэхүү зохицуулалт нь Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангаж, төр хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх

чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах Үндсэн хуулийн зарчмыг хангаж байна гэж үзсэн болно.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасныг тус тус зөрчөөгүй болно.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн тухай хуулийг батлан гаргаж Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч болон орон нутгийн хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорхойлж, эдгээр сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Сонгуулийн тухай хуульд Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуулийн үеийн зөрчлийн хэлбэр, нэр дэвшигчийн жагсаалтаас хасах үндэслэл зэргийг нийтлэг байдлаар хуульчилсан байна. Тухайлбал, Сонгуулийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.2, 159 дүгээр зүйлийн 159.2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигчдийг ижил үндэслэлээр нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасч, нийтэд мэдээлэхээр нэгэн адил зохицуулжээ.

Гэтэл тус хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж хуульчилсан боловч Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшиж сонгогдсон гишүүн тангараг өргөн бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсний дараа сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэл нь тогтоогдвол ямар нэгэн хариуцлага тооцох талаар Сонгуулийн тухай хуульд тусгаагүй байна.

Иймхүү сонгуулийн дүнд байгуулагддаг Улсын Их Хурал болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд нь хүлээлгэх хариуцлагыг илтэд ялгавартайгаар, тухайлбал Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшин сонгогдож тангараг өргөн, бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн Улсын Их Хурлын гишүүнд хүлээлгэх энэ

төрлийн хариуцлагыг хуульчлаагүй нь Үндсэн хуулиар баталгаажсан шударга ёс, тэгш байдлын зарчмыг алдагдуулсан, Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэхээр байна.

2. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт заасны дагуу иргэдийн Төлөөлөгчөөр сонгогдож бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн мандатыг хүчингүй болгох, бүрэн эрхийг дуусгавар болгох үр дагавар бүхий шийдвэрийг орон нутгийн сонгуулийн хороо гаргахаар хуульчилсан нь нутгийн өөрөө удирдах байгууллагын Үндсэн хуулиар тодорхойлогдсон эрх хэмжээнд тухайн сонгуулийг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй байгууллага халдах боломж олгосон зохицуулалт болжээ.

Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсгийн найруулга, хууль зүйн томъёолол боловсронгуй бус, хууль зүйн техникийн хувьд алдаатай, мөн түүнчлэн хуулийн системчлэлийн хувьд уг хуулийн уялдаа холбоо бүхий зүйл, заалтад болон бусад холбогдох хуульд энэ талаарх зохицуулалт, журмыг тодорхой тусгаагүй байна.

3. Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх зарчимд нийцүүлэн сонгуулийн аль ч үе шатанд сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн болох нь тогтоогдсон бол тангараг өргөсөн Улсын Их Хурлын гишүүн, бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч хэн боловч сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээдэг байхаар холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага байгааг хууль тогтоогч анхаарвал зохино.

4. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын Монгол Улсын иргэн “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын Монгол Улсын иргэн “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. …” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэсэн заалтын үйлчлэлийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай

хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Н.ЧИНБАТ
ГИШҮҮД	Д.ГАНЗОРИГ
	Б.БУЯНДЭЛГЭР
	Г.ТУУЛХҮҮ
	Ц.НАНЗАДДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2018.11.22 Дугаар 85 Төрийн ордон,
Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны
14 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 14 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018.11.21 Дугаар 15 Улаанбаатар хот

Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 16.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг /илтгэгч/, Ш.Цогтоо, Д.Солонго, Ш.Солонго нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын дээд шүүхийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн М.Батсуурь, шүүгч Г.Банзрагч болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн холбогдох заалт, түүнчлэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын холбогдох хэсэг, 7 дугаар зүйлийн

7.3, 112 дугаар зүйлийн 112.9 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын Монгол Улсын иргэн “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Монгол Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан хүсэлтдээ:

“... Монгол Улсад Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдаж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт орсон юм. Үүнд:

Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.” гэсэн захиргааны актыг үндсэн шинжээр нь тодорхойлсон хууль зүйн ойлголтод “захиргааны байгууллагаас” гэсний дараа “зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад” гэсэн ангиллыг оруулж өгснөөр зөрчилд оногдуулах захиргааны хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг захиргааны актад хамруулахгүй болгосон. Тодруулбал, өмнө нь захиргааны хяналт шалгалт нь захиргааны үйл ажиллагааны нэг бие даасан төрөлд тооцогдож, хяналт шалгалтыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, дуусгах, шалгалтын явцад зөрчлийг тогтоох, түүнд захиргааны хариуцлага хүлээлгэх зэрэг харилцаа нь бүхэлдээ захиргааны эрх зүйгээр зохицуулагдаж /Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хуулиудаар/, захиргааны хариуцлага хүлээлгэсэн шийдвэр /шийтгэл/ нь захиргааны актад хамаарч байсан.

Гэтэл дээрх хуулийн өөрчлөлт орсноор захиргааны зөрчилд хүлээлгэх шийтгэлийг захиргааны акт биш гэж үзсэн, иймээс Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын

“гэмт хэрэг мөрдөн байцаах ажиллагаа” гэснийг “хууль сахиулах, гэмт хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа” гэж өөрчилсөн. Үүний улмаас Захиргааны ерөнхий хуулийн нийтлэг шаардлага болох захиргааны акт нь зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, үндэслэл бүхий байх зэрэг шаардлага нь зөрчилд хүлээлгэсэн шийтгэлд /захиргааны актад/ хамаарахгүй болсон.

Нэгэнт зөрчлийн шийтгэлийг захиргааны акт биш гэж үзсэн тул захиргааны хэргийн шүүх зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэлээр үүсэх захиргааны хэргээс өөрөөр буюу “гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны журмаар эрүүгийн хэргийн шүүхийн нэгэн адил зарчмаар шийдвэрлэх ёстой гэсэн үзэл баримтлалаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11. ““гомдол” гэж хуульд тусгайлан зааснаар эрх бүхий этгээдийн шийдвэрийг хянуулахаар захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдөл, ... Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргасан прокурорын дүгнэлтийг”; 7 дугаар зүйлийн 7.3. “Энэ зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан зарчим нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй.”; 112 дугаар зүйлийн 112.9. “Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй.” гэсэн зохицуулалтыг нэмсэн байна.

Гэтэл эдгээр хуулийн нэмэлт, өөрчлөлтийн улмаас иргэд захиргааны акттай холбоотой маргааны хувьд нэг хэсэг нь захиргааны хэргийн шүүхэд захиргааны журмаар буюу “нэхэмжлэгч”-ийн хувиар маргах бол, харин нөгөө хэсэг нь зөрчилд “холбогдогч”-ийн хувиар гомдол гаргах болсон. Үүний ялгаа нь хүн, хуулийн этгээдээс захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэгчийн хувиар захиргааны акттай холбогдуулан маргах тохиолдолд шүүх “нотлох зарчим”-ыг хэрэгжүүлэн тухайн захиргааны акт хууль ёсны эсэхийг Захиргааны ерөнхий хууль болон бусад тусгай хуулийн хүрээнд агуулга буюу хууль хэрэглээний хувьд нь, хэлбэр буюу шийдвэр гаргах ажиллагааны журмыг баримталсан эсэхэд нь хяналт тавина.

Харин зөрчлийн хэргийн тухайд захиргааны хэргийн шүүх нь захиргааны байгууллагын актыг биш зөрчилд холбогдогчийн /гомдол гаргагчийн/ үйлдлийг буюу холбогдогч гэм буруутай эсэхийг шүүх нотлох зарчмыг хэрэгжүүлэхгүйгээр зөвхөн шийтгэл оногдуулж буй албан тушаалтны бүрдүүлсэн хэргийн материалын хүрээнд хянахад хүрч байгаа юм. Ийнхүү захиргааны хэргийн шүүх нь захиргааны маргааныг хоёр өөр журмаар /зарчмаар/ шийдвэрлэж байгаа нь

“хууль тогтоогчийн зүгээс хүн бүрт эрх, үүрэг, хариуцлагыг ямар нэг ялгаваргүйгээр тогтоох, хүн бүр шүүхээр адилхан хамгаалуулах” агуулга бүхий Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчим зөрчигдөж байна.

Мөн Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах” төрийн үүрэг нь юуны түрүүнд хүний үндсэн эрх, эрх чөлөө, бусад хуулиар хамгаалагдсан хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын буюу төрийн өөрийнх нь хууль бус үйл ажиллагаанаас хамгаалахад чиглэгддэг. Ийм ч учир Монгол Улс захиргааны байгууллагын үйл ажиллагаа хууль ёсны эсэх, түүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эсэхийг хөндлөнгийн байр сууриас хянан шийдвэрлэдэг захиргааны хэргийн шүүхийг байгуулсан нь Үндсэн хуулийн уг зүйл, заалт бодитойгоор хэрэгжих, улмаар эрх зүйт төрийг бэхжүүлэхэд нэг том алхам болсон.

Захиргааны хэргийн шүүх энэхүү хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх гол арга зам нь “шүүх нотлох зарчим”, түүний үндсэн дээр хэрэгжих талуудын тэгш мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх явдал юм. Тодруулбал, захиргааны хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог болох “шүүх нотлох зарчим”-ын үндсэн зорилго нь нэг талд эрх мэдэлгүй хүн, хуулийн этгээд нөгөө талд хуулиар давуу эрх олгогдсон “захиргаа” гэсэн хүч тэнцвэргүй талуудын эрх зүйн байдлыг тэнцвэржүүлснээр /захиргаанаас давуу эрхээ хэтрүүлэхийг нь хязгаарласнаар/ хэргийн бодит үнэнийг тогтооход чиглэгддэг бөгөөд үүгээрээ эрх тэгш талуудын өөрсдийнх нь цуглуулсан нотлох баримтын хүрээнд маргааныг хянан шийдвэрлэдэг иргэний хэргийн шүүхийн процессоос, шүүгдэгчийн гэм бурууг нотлох прокурорын яллах дүгнэлт болон түүнийг няцаах өмгөөлөгчийн тайлбарын хүрээнд хэргийг хянан шийдвэрлэдэг эрүүгийн хэргийн шүүхийн процессоос ялгаатай. Нэг үгээр хэлбэл, захиргааны хэргийн шүүх нотлох зарчмыг хэрэгжүүлснээр хэргийн оролцогчдын тэгш байдлыг хангадаг.

Гэтэл захиргааны хэргийн шүүх зөрчлийн хэргийн тухайд “шүүх нотлох зарчим”-ыг хэрэгжүүлэх боломжгүй болсноор үнэн чанартаа Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн

эрхийг сэргээн эдлүүлэх” төрийн үүрэг биеллээ олохгүй болж байгаа нь Үндсэн хуулийн зөрчилд хүргэж байна.

Түүнчлэн, хэрэв Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах хүний үндсэн эрхийн агуулгыг зөвхөн “шүүхэд хандах эрх”-ээр хязгаарлахгүйгээр зөрчигдсөн эрх нь “бодитойгоор хамгаалагдах эрх”-ийн агуулгаар авч үзвэл, өмнө нь хүн, хуулийн этгээдийн зүгээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд мэдүүлэх эрхээ эдэлдэг байсан бол, харин одоо эсрэгээрээ захиргааны байгууллагын зүгээс хүн, хуулийн этгээдийг буруутгаж зөрчилд холбогдуулсны улмаас “хэрэгт холбогдогч”-ийн хувиар “гэм буруугүйгээ нотлох” болсноороо зөрчилдөж байна.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн уг зүйлд заасан хүний “шүүхэд мэдүүлэх, шударга шүүхээр шүүлгэх эрх” нь захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас эрх нь зөрчигдсөн гэж үзэж буй этгээд нь шүүхэд нэхэмжлэгчийн хувиар шаардлага гаргах, маргаж буй асуудлыг үндэслэх, няцаах нотлох баримтыг заах, гаргах, тайлбарлах, мэргэжлийн байгууллагаар шинжлүүлэх, үзлэг, туршилт хийлгүүлэх зэргээр мэтгэлцэх, нотлох ажиллагаа хийлгүүлэх боломжтой байх, захиргааны хэргийн шүүх нь зөрчилд холбогдогчийн гэм буруутай эсэхийг тогтоохын тулд бус харин нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь захиргааны шийдвэр, үйл ажиллагаанаас зөрчигдсөн эсэхийг тогтоогчийн хувьд хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах хууль зүйн зохицуулалт бүрдсэн үед бодитойгоор хэрэгжих учиртай. Гэтэл эдгээр зарчмууд алдагдсанаар Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан хүний үндсэн эрх бодит байдал дээр хэрэгжих, хамгаалагдах боломжгүй болсон гэдэг утгаараа зөрчил гэж үзэхэд хүрч байна.

Иймд Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлд “Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “захиргааны байгууллагаас” гэсний дараа “зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад” гэж нэмсүгэй.”, мөн хуулийн 2 дугаар зүйлд “Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “гэмт хэрэг мөрдөн байцаах ажиллагаа” гэснийг “хууль сахиулах, гэмт хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх

ажиллагаа” гэж өөрчилсүгэй.” гэж; мөн өдөр баталсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй: 1/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт: “3.1.11. “гомдол” гэж ... Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргасан прокурорын дүгнэлтийг.”; 2/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг: “7.3.Энэ зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан зарчим нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй.”; 5/112 дугаар зүйлийн ... 112.9 дэх хэсэг: ... 112.9.Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй.” гэж тус тус хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасныг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

Нэг. “Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “захиргааны байгууллагаас” гэсний дараа “зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад” гэж нэмсүгэй.”, мөн хуулийн 2 дугаар зүйлд “Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “гэмт хэрэг мөрдөн байцаах ажиллагаа” гэснийг “хууль сахиулах, гэмт хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа” гэж өөрчилсүгэй.” гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй талаар:

1.1 Захиргааны ерөнхий хуулийн 3.1.4 дэх заалт, 37.1 дэх хэсэгт оруулсан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь захиргааны ерөнхий хуулийн үйлчлэлд хамаарахгүй байх, зөрчил шалган шийдвэрлэхэд гаргасан акт нь захиргааны актад хамаарахгүй байх агуулгатай нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлаас Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталсантай холбогдуулан түүнд нийцүүлэн оруулсан.

2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Зөрчлийн тухай хуулиар зөрчлийг гэмт хэргээс зааглан тогтоож, 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил

гэнэ” гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон захиргааны хэм хэмжээний актыг санаатай болон болгоомжгүй байдлаар зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь зөрчил болно.

Иймд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой үүсэх аливаа харилцаа нь Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд үүсэх харилцаанаас ялгаатай тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зохицуулах нь зүйтэй гэж хууль тогтоогч үзсэн.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн “Хуулийн үйлчлэх хүрээ” гэсэн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь зөрчил хаана гарсныг үл харгалзан энэ хуулийн дагуу явагдана.”, 1.4 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад ““зөрчил шалган шийдвэрлэх” гэж зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих прокурорын хяналт, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг;” ойлгохоор тус тус хуульчилсан. Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулах үндэслэлтэй бөгөөд тухайн зөрчлийг шалган тогтоох, бүрэн бүтэн этгээдэд шийтгэл оногдуулах эсэхийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчим нь аливаа этгээдэд адил шударга, хүндэтгэлтэй хандаж, хуулийг чанд, нэг мөр хэрэглэх агуулгыг илэрхийлдэг. Гэхдээ тодорхой тохиолдолд буюу зөрчил үйлдсэн этгээдэд түүний зан үйлээс шалтгаалан үйлдэл, үйл ажиллагаанд хуулийн нэг зохицуулалт ялгаатай байдлаар бус харин хуулийн өөр зохицуулалт үйлчлэх нь “хуулийн өмнө эрх тэгш байх” зарчмыг хөндөхгүй бөгөөд энэ нь шударга ёсны зарчимд илүү нийцнэ гэж үзэж байна.

Иймээс тухайн актыг захиргааны байгууллага, албан тушаалтан гаргаснаас үл хамааран акт гаргах үндэслэл, зохицуулсан харилцаанаас шалтгаалан түүнд хамаарах хуулийг ялгамжтай байдлаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчөөгүй гэж үзэж байна.

1.2. Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдахаас өмнө зөрчил хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлж байсан байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны үндэслэл, журмыг Захиргааны хариуцлагын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Өрсөлдөөний тухай зэрэг салбарын хуулиар зохицуулж байсан. Энэ нь зөрчил шалган тогтоох болон шийтгэл оногдуулах ажиллагааг харилцан адилгүй, тэнцвэргүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байсан. Өөрөөр хэлбэл, тус хуулиар эрх бүхий албан тушаалтнаас хэрэгжүүлдэг хоёр өөр зорилго бүхий чиг үүргийг / төрийн хяналт шалгалт болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа/ нэгтгэн салбарын онцлог нэрийн дор салбар бүрд зөрчлийг шалган шийдвэрлэх өөр өөр стандарт тогтоож байсныг өөрчилсөн.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь зөрчил үйлдсэн этгээдийг олж тогтоох, шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэхэд чиглэгдэх бөгөөд энэхүү ажиллагаанд прокурор хуульд заасан чиг үүргийнхээ дагуу хяналт тавьж, шийтгэл оногдуулсантай холбоотой гомдлыг шүүх эцэслэн шийдвэрлэхээр хуульчилсан. Энэ дагуу улсын байцаагч нь хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хоёр ялгаатай ажиллагааг хэрэгжүүлж, шийдвэр гаргана.

Тодруулбал, Төрийн болон салбарын хяналт шалгалтын хүрээнд захиргааны акт /Захиргааны ерөнхий хуулийн дагуу/, Зөрчил шалган шийдвэрлэх чиг үүргийн хүрээнд /Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн дагуу/ шийтгэл оногдуулах, эсхүл шийтгэлээс чөлөөлөх, зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргана.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар улсын байцаагч нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг тус хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах бөгөөд бүхий л нөхцөлд оролцогчийн буюу хохирогч, холбогдогчийн эрхийг хангах үүрэгтэй. Ийнхүү улсын байцаагчийн хэрэгжүүлэх зөрчил үйлдсэн этгээдэд шийтгэл оногдуулах эсэх болон хяналт шалгалттай холбоотой шийдвэр гаргах ажиллагаа нь зорилгоос гадна шийдвэр гаргах процесс ажиллагааны үндэслэл, журмын хувьд эрс ялгаатай тул онцлогийг нь харгалзан хууль зүйн ялгаатай зохицуулалтыг хуульчилсан.

Нөгөө талаар дээр дурдсан ялгаатай хоёр шийдвэрийг нэг субьект /улсын байцаагч/ гаргаж байгаа гэдгээр нэгтгэн бүгдийг нь захиргааны акт хэмээн үзэх нь учир дутагдалтай. Учир нь улсын байцаагчийн дээрх зарчмын ялгаатай ажиллагааны улмаас гаргасан

эрх зүйн ялгаатай үр дагавар бүхий шийдвэртэй холбоотой гомдол, маргааныг шүүхээр шийдвэрлэхэд ч ялгаатай зарчим үйлчлэх шаардлагатай. Ингэснээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хуулийн нарийн зохицуулалт, журам үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж, "хуулийн өмнө эрх тэгш байх" зарчмыг илүү хангасан зохицуулалт болсон гэж үзэж байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар бүлэг, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн 6-9 дүгээр бүлэгт эрх нь зөрчигдсөн хүн, хуулийн этгээд дараагийн шатны шүүхэд хандаж гомдол гаргах, хяналт тавих, зөрчигдсөн эрхээ хангуулах, зөрчлийн улмаас учирсан хохирлыг арилгуулах асуудлыг зохицуулсан бөгөөд эрх нь зөрчигдсөн этгээдэд ялгавартай байхаар, эсхүл гомдол гаргах эрхийг хязгаарласан заалт холбогдох хуулиудад тусгагдаагүй тул Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх" гэснийг зөрчөөгүй гэж үзэж байна.

Хоёр. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй: 1/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт: "3.1.11. "гомдол" гэж ... Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргасан прокурорын дүгнэлтийг."; 2/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг: "7.3. Энэ зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан зарчим нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй."; 5/112 дугаар зүйлийн ... 112.9 дэх хэсэг: ... 112.9. Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх талаар дараахь тайлбарыг гаргаж байна:

2.1. Улсын дээд шүүхийн хүсэлтэд иргэд захиргааны хэргийн шүүхэд зарим хэсэг нь нэхэмжлэгчийн хувиар, зарим хэсэг нь гомдол гаргаж оролцож байгаа нь захиргааны хэргийн шүүх захиргааны маргааныг хоёр өөр журмаар шийдвэрлэж байгаа нь "хууль шүүхийн өмнө эрх тэгш байх" зарчим зөрчигдөж байгаа талаар дурджээ.

Хууль зөрчсөн тодорхой үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх, эсхүл зөрчилд хамааруулах нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарах асуудал бөгөөд нэгэнт гэмт хэргээс ялгаатай үзэж зөрчилд хамруулсан хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй хийсэн этгээдийг хууль зөрчөөгүй

боловч захиргаанаас эрх ашгийг нь хохироосон иргэнээс ялгаатай авч үзэх нь “хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчмыг хөндөхгүй гэж үзэж байна.

Энэ нь харин ч шударга ёсны зарчимд нийцэх бөгөөд эрх зүйн байдлын хувьд ялгаатай нөхцөлд ялгаатай хуулийн зохицуулалт хэрэглэхээр шийдвэрлэсэн нь “хуулийн өмнө эрх тэгш байх” нөхцөлийг хангасан төдийгүй, хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарах асуудал юм.

Харин эсрэгээрээ, захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэгчийн болон гомдол гаргагчийн хувиар оролцож байгаа этгээдүүдэд ижил хуулийн зохицуулалт үйлчилснээр “хууль, шүүхийн өмнө эрх, тэгш байх” зарчим хангагдана гэж үзвэл, “эрх нь зөрчигдсөн иргэн” болон “хууль зөрчиж, зөрчил гаргасан иргэн” гэсэн хоёр тохиолдолтой холбоотой захиргааны маргааныг ижил процессын дагуу шалган шийдвэрлэх нь “шударга ёсны” зарчимд нийцэхгүй юм.

2.2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Захиргааны хэргийн шүүх хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй ...” гэсний дагуу нэхэмжлэлээр үүсэх захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүргийг Захиргааны хэргийн шүүх өөрөө гүйцэтгэдэг.

Хуулиар захиргааны хэргийн шүүх нотлох баримт цуглуулах үүрэг хүлээсэн хэдий ч хууль тогтоогч “хууль, шүүхийн өмнө эрх, тэгш байх” зарчмыг хангах үүднээс гомдлоор үүсэх зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхэд цугларсан нотлох баримтын хүрээнд шийдвэрлэхээр хуульчилсан.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нэг онцлог нь хэрэг бүртгэлтийн ажиллагаа буюу нотлох баримтыг цуглуулах, оролцогчийн нотлох баримт гаргаж өгөх, тодорхой шалгах ажиллагаатай холбоотой хүсэлт, гомдлыг шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмаар шүүхээс өмнөх шатанд хэрэгжүүлэх юм. Зөрчил шалгах ажиллагааны явцад гаргах шийдвэр бүхэн, түүний дотор зөрчлийг шалгаж шийдвэрлэх, холбогдогчид шийтгэл оногдуулах ажиллагаа нь зөвхөн нотлох баримтад үндэслэсэн байх ёстой.

Нэгэнт зөрчлийн хэрэг үүсгэн, прокурорын хяналт дор хуулийн дагуу нотлох баримт бүрдүүлсэн тул түүнд үндэслэн шүүх талуудын эрх

тэгш байдал, мэтгэлцэх зарчмын үндсэн дээр асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж хууль тогтоогч үзсэн байна.

Иймд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй: 1/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт: "3.1.11 ."гомдол" гэж ... Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргасан прокурорын дүгнэлтийг.", 2/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг: "7.3.Энэ зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан зарчим нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй.", 5/112 дугаар зүйлийн ... 112.9 дэх хэсэг: ... 112.9.Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна." гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Их Хурал Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг батлан гаргасантай холбогдуулан 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

1. Дээр дурдсан Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлээр Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн "захиргааны байгууллагаас" гэсний дараа "зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад" гэсэн заалтыг нэмсэн, мөн хуулийн 2 дугаар зүйлээр Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын "гэмт хэрэг мөрдөн байцаах ажиллагаа" гэснийг "хууль сахиулах, гэмт хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа" гэж өөрчилжээ.

Монгол Улсын Үндсэн хуулиар ардчилсан эрх зүйт төрийн зарчмыг үндэс болгон тогтоож, хүний болон иргэний эрх, эрх чөлөөний баталгаа, Үндсэн хуульт ёсыг баталгаажуулан, төрийн эрх мэдлийн хуваарилалтыг тодорхойлсон. Хууль тогтоогчоос батлан гаргасан хууль тогтоомжийн биелэлтийг хангах, түүнийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, бусад нийтийн захиргааны байгууллагын аливаа шийдвэр, үйл ажиллагаа дээр дурдсан Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд үндэслэсэн байхын зэрэгцээ, иргэний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн байх учиргүй.

Энэ үүднээс хууль тогтоогч хуулиар “захиргааны акт” гэх нийтийн эрх зүйн үндсэн ойлголтыг тодорхойлохдоо тухайн салбар эрх зүйн болон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үзэл баримтлал, чиг хандлага, өөрийн орны Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд нийцүүлэх шаардлагатай юм.

Нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар захиргааны байгууллагаас гаргасан эрх зүйн шууд үр дагавар бий болгосон, гадагш чиглэсэн аливаа захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг захиргааны актад хамааруулах бөгөөд энэхүү шинж нь захиргааны актыг сонгодог утгаар нь илэрхийлдэг.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд дээрх шинжийг бүрэн агуулсан шийдвэрийг гаргах боломжтой бөгөөд энэ тохиолдолд тухайн шийдвэр нь захиргааны актад хамаарах учиртай.

Гэтэл хууль тогтоогч дээр дурдсан Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлээр тус хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг болон 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж захиргааны акт гэх ойлголтод зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд холбогдох шийдвэр, үйл ажиллагааг хамаарахгүй болгон өөр хуулийн хүрээнд хамааруулан зохицуулсан нь захиргааны актад холбогдох эрх зүйн маргааныг хоёр өөр журмаар шийдвэрлэхэд хүргэж, шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрх бодитоор хэрэгжих нөхцөлийг хязгаарлаж, иргэний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг дордуулж, хөндөгдсөн эрхээ сэргээлгэх боломжийг алдагдуулсан байна. Энэ талаарх Улсын дээд шүүхийн хүсэлт үндэслэлтэй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн холбогдох заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын дагуу тус хуулийн “Шүүх нотлох зарчим” гэсэн 7 дугаар зүйлд “Энэ зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан зарчим нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй.” гэсэн 7.3 дахь хэсэг; мөн зүйлийн 5 дахь заалтын дагуу 112 дугаар зүйлд “Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй.” гэсэн 112.9 дэх хэсгийг тус тус нэмжээ.

Захиргааны хэргийн шүүх нь захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагаанаас иргэдийн субъектив эрхийг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд энэ чиг үүргийн хүрээнд захиргааны хэргийн оролцогчдын тэгш бус байдлыг тэнцвэржүүлэх зорилгоор хэргийн нөхцөл байдлыг тодруулах үүргийг талууд бус захиргааны хэргийн шүүх хүлээх бөгөөд үүгээрээ захиргааны хэргийн шүүхийн үндсэн мөн чанар, онцлог тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүх шийдвэрээ хэргийн оролцогчдын тодорхойлсон нөхцөл байдал, нотолгооны хүрээнд гаргадаггүй, нотлох баримтыг захиргааны хэргийн шүүх өөрөө цуглуулж, талуудын тэгш байдлыг хангадаг.

Гэтэл дээр дурдсан хуулийн нэмэлтээр захиргааны хэргийн шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх нотлох зарчмыг хэрэгжүүлэх боломжгүй болж, захиргааны хэргийн оролцогчдын эрх зүйн байдлыг дордуулан шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрхээ бодитоор хэрэгжүүлэх нөхцөлийг хязгаарлаж, хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх төрийн үүрэг хангагдахгүйд хүргэсэн байна.

Иймд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 112 дугаар зүйлийн 112.9 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

3. Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлд ""гомдол" гэж хуульд тусгайлан зааснаар эрх бүхий этгээдийн шийдвэрийг хянуулахаар захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдөл, шүүгчийн захирамж, тогтоол, анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хянуулахаар гаргасан өргөдөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргасан прокурорын дүгнэлтийг." ойлгох талаарх 3.1.11 дэх заалт нэмсэн байна.

Улсын дээд шүүхээс ирүүлсэн хүсэлтэд хууль тогтоогчоос Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлд 3.1.11 дэх заалтаар тухайн хуулийн үйлчлэлийн хүрээнд хамаарагдах "гомдол" хэмээх нэр томьёог тодорхойлсны "… Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргасан прокурорын

дүгнэлтийг.” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж тусгасан боловч уг шаардлагынхаа үндэслэл, уялдаа холбоо, шалтгааныг тусгайлан тайлбарлаагүй байх тул Үндсэн хуулийн цэцээс уг асуудалд холбогдуулан дүгнэлт хийх боломжгүй байна. Уг асуудлын хүрээнд дээрх шаардлагыг ханган дахин хандаж хүсэлт гаргах эрх нь нээлттэй болно.

4. Зөрчлийн тухай хууль тогтоомжийн хүрээнд Үндсэн хуулийн нэр томьёог хэрэглэх, Үндсэн хуульд заасан эрх зүйн суурь ухагдахууныг гүнзгийрүүлэн зохицуулах, салбар эрх зүйн зарчим, үндсэн үзэл баримтлалыг чанд сахих, түүнд уялдуулан төрөлжүүлж системчлэх, хүний үндсэн эрхийг хангахуйц эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага байгааг дурдах нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад “хууль сахиулах, гэмт хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, ...” гэж заасны “хууль сахиулах, … зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа …”, мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.” гэж заасны “... зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын Монгол Улсын иргэн “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан зарчим нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй.”, мөн хуулийн 112 дугаар зүйлийн 112.9 дэх хэсэгт “Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй.” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын Монгол Улсын иргэн “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад “хууль сахиулах, гэмт хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, …” гэж заасны “хууль сахиулах, … зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа …”, мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.” гэж заасны “... зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчөөгүй байна.

4. Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад “хууль сахиулах, гэмт хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;” гэж заасны “хууль сахиулах, … зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа …”, мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.” гэж заасны “... зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад ...” гэсэн хэсгийг; Захиргааны хэрэг

шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан зарчим нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй.”, мөн хуулийн 112 дугаар зүйлийн 112.9 дэх хэсэгт “Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй.” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

5. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Н.ЧИНБАТ
ГИШҮҮД	Д.ГАНЗОРИГ
	Ш.ЦОГТОО
	Д.СОЛОНГО
	Ш.СОЛОНГО

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018.12.06 Дугаар 88 Төрийн ордон, Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 15 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад “хууль сахиулах, гэмт хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, ...” гэж заасны “хууль сахиулах, … зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа …” гэсэн хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.” гэж заасны “… зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад …” гэсэн хэсэг, мөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан зарчим нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй.”, 112 дугаар зүйлийн 112.9 дэх хэсэгт “Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын Монгол Улсын иргэн “Монгол улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд

гомдол гаргах, … шударга шүүхээр шүүлгэх … эрхтэй. …” гэсэн заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц … хууль зүйн … баталгааг бүрдүүлэх, … хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн заалтыг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан зарчим нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй.”, 112 дугаар зүйлийн 112.9 дэх хэсэгт “Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 15 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2019.01.16 Дугаар 01 Улаанбаатар хот

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийн зохицуулалтаар Цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болсон холбогдох хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг эцэслэн хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 14.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат, Д.Ганзориг, Ш.Цогтоо, Д.Солонго /илтгэгч/, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү, Ш.Солонго нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Б.Амартүвшин, Я.Баярсайхан болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэж зааснаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон 2005 оны

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх тухай маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн хяналтын журмаар хянан шийдвэрлэв.

Нэг. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Амартүвшин Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн мэдээлэлдээ:

"Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт "Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...", мөн зүйлийн 10 дахь заалтад "... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. ...", мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэсэн хэм хэмжээг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтыг хүчингүй болгосон боловч Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуульд дахин оруулж ирсэн нь нам, эвсэл, иргэнийг зардлын тайлангаа гаргаж өгөөгүй, эсвэл хуульд заасан хугацаанаас хоцроосон алдаатай үйлдлийнхээ төлөө Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.7 дахь хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 21-26 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл хүлээж байгаа боловч нэг удаагийн алдаатай үйлдлийнхээ төлөө дахин сонгуульд оролцох эрхээ хасуулж байгаа нь хууль зүйн шинжлэх ухааны нэг алдаанд нэг шийтгэл ногдуулах зарчмыг алдагдуулж байна.

Аль нэг нам, эвсэл хариуцлагагүй ажилтны гаргасан алдаа, эсхүл санаатайгаар өрсөлдөгчөө намнах хуйвалдаанаас болж гаргасан зөрчлийн улмаас бусад гишүүд, дэмжигчдийн сонгогдох эрхийг хязгаарлаж байгаа нь Үндсэн хуульд харшилж байна гэж

үзэж байгаа тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хяналтын журмаар шийдвэрлэж, уг заалтыг хүчингүй болгож өгнө үү.” гэсэн байна.

Хоёр. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн Я.Баярсайхан Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болсон 2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтыг агуулгын хувьд шууд сэргээн хэрэглэсэн гэж үзэж байна.

Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолын тогтоох хэсэгт “2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтын “... Аль нэгэн нам, ... гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. ...” гэснийг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэснийг хүчингүй болгосугай. ...**”** гэж дурдсан.

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэсэн заалт нь Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Монгол Улсын Их Хурлаас 2005 онд баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Дараахь тохиолдолд нам, эвслийг бүртгэхээс татгалзана:” гээд 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол.” гэсэн заалтыг шууд агуулгаар нь дахин сэргээн хэрэглэсэн байна. Энэ нь Монгол Улсын иргэний болон намын гишүүд, дэмжигчдийн ардчиллын үнэт зүйлс болсон сонгох, сонгогдох эрхийг хязгаарласан үйлдэл юм.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны шийдвэрээр хүчингүй болсон, Монгол Улсын иргэний эрхэд халдсан, Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийг хүчингүй болгож өгнө үү." гэсэн агуулгатай мэдээлэл ирүүлсэн байна.

Гурав. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

"... Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор "2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...", мөн зүйлийн 10 дахь заалтын "... Аль нэгэн нам, ... гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. ..." гэснийг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" гэснийг хүчингүй болгосугай." хэмээн шийдвэрлэсэн нь зөвхөн тухайн үед үйлчилж байсан хуульд хамаарч байгаа бөгөөд 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай уг хуулийг 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

Хүчингүй болсон дээрх хуульд "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" гэж заасан 26 дугаар зүйлийн гарчиг нь "Сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх" гэж байсан бөгөөд үүгээр зөвхөн нам, эвслийг бүртгэхтэй холбоотой явцуу харилцааг зохицуулж байсан юм. Үндсэн хуулийн цэцийн энэ талаар гаргасан дээрх шийдвэр ч зөвхөн бүртгэх үйл ажиллагаанд хамаарах агуулгатай гарсан гэж ойлгогдохоор байна.

Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар зүйлийн 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн гарчиг нь "Сонгуулийн зардлын тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдал" гэж байгаа бөгөөд тус зүйлийн 60.5 дахь хэсэгт "Хуульд заасан

хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэсэн заалтад бүртгэхгүй байх үндэслэлийг: нэгдүгээрт, сонгуулийн зардлаа тайлагнах тухай хуулийн заалтыг биелүүлээгүйгээр хууль зөрчсөн эс үйлдэл, хоёрдугаарт, сонгуулийн ажиллагаа хууль ёсоор, шударга явагдаж байгаа эсэхэд иргэд, сонирхогч талууд бүрэн хяналт тавих, энэ талаар үнэн бодитой мэдээлэл авах бололцоог алдагдуулсан хууль бус үйлдэлд хамааруулсан ба бүртгэхгүй байж болох субъектэд нэр дэвшигч иргэн нэмэгдэж тусгагдсан. Хууль тогтоогчийн зүгээс энэ хуульд зөвхөн бүртгэхгүй байх үйлдлийг биш түүний үндэслэлийг гол болгож авч үзэж тусгасан болохыг онцлон тэмдэглэж байна. Үүгээрээ 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтаас агуулгын хувьд ялгаатай.

Хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдлийнхээ эрх зүйн үр дагаврыг нэр дэвшигч иргэн, нам, эвсэл хэн боловч гарцаагүй хариуцаж байх нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэсэн заалтын шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх зарчмын агуулгад бүрэн дүүрэн нийцнэ гэж үзэж байна. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн эсэх тухай асуудлыг авч үзэхдээ Үндсэн хуулийн үндсэн зарчим алдагдахгүй байх нөхцөлийг заавал тооцож үзэх ёстой гэдгийг Улсын Их Хурал хууль тогтоох үзэл баримтлалдаа удирдлага болгодог. Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэсэн заалтаар хуулиар хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлсэн иргэн, нам, эвслийг улс төрийн сонгуульд оролцох эрх ашиг, эрх чөлөөг ямар ч байдлаар хязгаарлаагүй. Хуульд заасан үүргээ биелүүлээгүй зөрчсөн этгээд, хуулийг ёсчлон биелүүлдэг этгээд адил тэгш байдалтай сонгуульд оролцох нь сонгуулийн бодит байдалд сөрөг нөлөө үзүүлэх үр дагавар үүсгэх өндөр магадлалтайгаас гадна шударга ёс, хууль дээдлэх ёсны үндсэн зарчмыг зөрчиж байгаа Үндсэн хуулийн хамгийн ноцтой хэлбэр гэдгийг анхааран үзэхийг зориуд хүсэлт болгож байна.

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийн заалт нь зөвхөн нэр дэвшигчийн бүртгэлээс өргөн агуулгатай бөгөөд

тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан хууль дээдлэх, 5.1.2 дахь заалтад заасан ил тод байдлыг хангах, 5.1.3 дахь заалтад заасан шударга ёсыг сахих зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тухайн хуульд тусгагдан хэрэгжиж байгаа тул үүгээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" гэж заасан байсныг агуулгаар нь дахин сэргээгээгүй бөгөөд Монгол Улсын Их Хурал энэ хуулийг тогтоохдоо түүнээс зарчмын ялгаатай үзэл баримтлалыг эш үндэс болгосон болно." гэжээ.

Дөрөв. Сонгуулийн ерөнхий хорооны даргын "Мэдээлэл хүргүүлэх тухай" 2018 оны 70 дугаар албан бичигт:

"Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцохоор Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн 12 нам, 3 эвсэл, 498 нэр дэвшигчдээс 1 нам (Иргэний зориг ногоон нам), 1 эвсэл, 104 нэр дэвшигч нь хуульд заасан хугацаанд зардлын тайлангаа ирүүлээгүй болно.

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт "Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй." гэж заасан бөгөөд зардлын тайлангаа ирүүлээгүй дээр дурдсан нам, эвсэл, нэр дэвшигчтэй холбоотой өргөдөл, гомдол тус хороонд ирээгүй бөгөөд шүүхэд хандаж шийдвэрлүүлсэн мэдээлэл байхгүй байна." гээд сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй нам, эвсэл, нэр дэвшигчдийн судалгааг хавсралтаар ирүүлсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурал сонгуулийн тухай хуулийг шинэчлэн 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталжээ. Ийнхүү батлахдаа сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийг бүртгэх, бүртгэхээс татгалзах талаарх зохицуулалтад өөрчлөлт оруулсан байна. Харин сонгуулийн сурталчилгааны эдийн засгийн үндсийг зохицуулсан хэм хэмжээг тусгай бүлэг болгон хуульчилж, "Сонгуулийн зардлын хяналт" гэсэн дэд бүлэгт холбогдох зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх Үндсэн хуулийн эрх зүйн болон захиргааны эрх зүйн хариуцлагын төрлийг тусгасан байна.

Энэ хүрээнд Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт "Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа

ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэж сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлээгүй нам, эвсэл, нэр дэвшигчид хүлээлгэх хариуцлагыг хуульчилжээ.

2. Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийн зорилго, мөн чанар, эрх зүйн үр дагавар нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон хуулийн зохицуулалтаас өөр байна.

Тодруулбал, Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон 2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн “Нам, эвсэл сонгуульд оролцох” хэмээх Тавдугаар бүлгийн “Сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх” гэсэн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” нам, эвслийг сонгуульд бүртгэхээс татгалзахаар хуульчилсан байсан нь хэм хэмжээний зорилгын хувьд зөвхөн нам, эвслийг сонгуульд бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулж байсан ба сонгуульд оролцсон нам, эвсэл сонгуулийн зардлын тайлангаа Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол дараа дараагийн хэдэн ч удаагийн сонгуульд оролцуулахгүй байж болох тодорхой бус үргэлжилсэн үр дагаврыг үүсгэж тухайн намын гишүүд, дэмжигчдийнх нь сонгох, сонгогдох эрх хугацаагүйгээр хязгаарлагдахаар байжээ.

Харин 2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулийн “Сонгуулийн зардлын хяналт” хэмээх Зургадугаар дэд бүлгийн “Сонгуулийн зардлын тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдал” гэсэн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэж заасан нь зорилгын хувьд сонгуулийн хуулийн хэрэгжилтийг хангах, сонгуулийн сурталчилгаа төдийгүй сонгуулийн үйл ажиллагаа хууль ёсоор, шударга явагдаж байгаа эсэхэд хяналт тавих, энэ талаар бодит мэдээллийг гаргуулахын тулд хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй байж дараагийн сонгуульд оролцуулахгүй байх хууль зүйн тодорхой хариуцлага тогтоожээ. Өөрөөр хэлбэл, уг зохицуулалтаар сонгуулийн зардлын хяналт, нээлттэй, ил тод байдлын үндсийг тогтоон сонгуулийн санхүүжилтийн болон зардлын тайлан гаргахыг шаардаж Үндсэн хуулийн эрх зүйн субъект болох улс төрийн намын

санхүүгийн үйл ажиллагааг хөндлөнгийн хяналттай, хариуцлагатай болгож, сонгуулийн тэгш, шударга байдлыг баталгаажуулах, иргэний улс төрийн эрхийг хангах хууль зүйн баталгааг бүрдүүлсэн гэж үзэхээр байна.

Үүнээс үзэхэд 2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулийн дээрх зохицуулалт Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтын зохицуулалтаас агуулгын хувьд ялгаатай байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, үндсэн хуулийн эрх зүйн болон сонгуулийн эрх зүйн суурь онол, зарчим, нийтлэг хандлага, Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 04 дүгээр дүгнэлт, 2010 оны 01 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн маргааны архивын баримт, энэхүү маргааныг Их суудлын хуралдаанд бэлтгэх явцад цугларсан баримт, маргагч талуудыг тайлбараас үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийн зохицуулалтаар Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон холбогдох хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж заасан бөгөөд уг зохицуулалтаар ард түмнээс засгийн эрхээ хэрэгжүүлэхдээ төрийн үйл хэрэгт шууд буюу сонгож байгуулсан төлөөллийн байгууллагаар уламжлан оролцох үзэл баримтлалын үндсийг тогтоожээ.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “... Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. ...”, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад Монгол Улсын иргэн “Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;” үндсэн үүрэгтэй болохыг хуульчилсан байдаг.

Үүнээс үзэхэд хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй байх агуулга бүхий хууль зүйн хариуцлага тогтоосон нь дээр дурдсан үзэл баримтлал, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах

болон тухайн намын дотоод хяналтыг сайжруулах, намын гишүүдийг хариуцлагажуулах, хууль дээдлэх зарчмыг хангах, Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн зохицуулалт хэмээн үзэх үндэслэлтэй байна.

Харин Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны явцад гаргасан маргагч талуудын тайлбар, хуралдаанд бэлтгэх ажиллагааны явцад цугларсан бусад баримт судалгааг үзэхэд улс төрийн сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн санхүүжилт, зардлын тайлангаа хуульд заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хоцроох зэрэгтэй холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байгааг тэмдэглэх нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, Жаран зургадугаар зүйлийн 1, 4, Жаран долдугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3, 31 дүгээр зүйлийн 1, 32 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэсэн зохицуулалтаар Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон 2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтыг агуулгаар нь дахин сэргээн батлаагүй байна гэж үзсүгэй.

2.Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагц хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ	Д.ОДБАЯР
ГИШҮҮД	Н.ЧИНБАТ
	Д.ГАНЗОРИГ
	Ш.ЦОГТОО
	Д.СОЛОНГО
	Б.БУЯНДЭЛГЭР
	Г.ТУУЛХҮҮ
	Ш.СОЛОНГО

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2019.03.13 Дугаар 01 Улаанбаатар хот

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 14.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат /илтгэгч/, Д.Ганзориг, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн А.Ариунболд, Б.Мөнхтөр болон түүний өмгөөлөгч Б.Батбаяр нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтын холбогдох хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Налайх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн П.Ундрах-Эрдэнэ, Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч, иргэн А.Ариунболд нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.1 дүгээр зүйлийн 1, 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасны дагуу шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, тэдгээрийн өмгөөлөгч, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч шүүхийн шийдвэрт гомдол гаргаж байгаа нь нэг талаас Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасны дагуу шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх, нөгөө талаас шударга шүүхийг эрэлхийлэх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, шүүхийн алдаа зөрчлийг хянуулах, өөрийн гэм бурууг эцэслэн тогтоолгохоор зорьж буй хэрэг юм.

Гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад шүүгдэгч, түүний өмгөөлөгч шүүхийн шийдвэрт гомдол гаргасан тохиолдолд шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулж, ялыг хүндрүүлэх боломжтой байдлаар хуульчилсан нь шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн гомдол гаргах эрх, өөрийгөө өмгөөлөх эрх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хязгаарлажээ. Өөрөөр хэлбэл давж заалдах, хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан шүүгдэгчийн эрх зүйн байдлыг анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд зааснаас дордуулах, гомдол гаргагчийн ялыг хүндрүүлэх зохицуулалтыг хуульчилсан шүүгдэгч өөрийн ялыг хүндрүүлэхээс эмээж, шударга шүүхийг эрэлхийлэх зоригийг мохоож, дарамт, айдас бий болгож, шүүхэд гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг хянуулахаас татгалзах үр дагаврыг үүсгэж байна.

Иймд шүүгдэгч гомдол гаргасан байхад шүүх шүүгдэгчийн гомдлыг авч хэлэлцээд, шүүгдэгчийн ялыг хүндрүүлж болохоор заасан нь шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрх, өөрийгөө өмгөөлөх эрхийг хязгаарлаж байх тул Үндсэн хуулийн холбогдох заалтыг хэрэгжихгүйд хүргэж байна.

Шүүгдэгчийн өмгөөлөгч нь шүүгдэгчид хууль зүйн туслалцаа үзүүлж, үйлчлүүлэгчийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалан давж

заалдах, хяналтын шатны шүүхэд гомдол гаргахад давж заалдах, хяналтын шатны шүүх гомдол гаргасан өмгөөлөгчийн үйлчлүүлэгч буюу шүүгдэгчийн ялыг хүндрүүлж болохоор заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан хууль зүйн туслалцаа авах, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэх заалтыг зөрчигдөхөд хүргэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр батлан 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдүүлж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "... шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... хүндрүүлж болно." гэсэн хэсэг, мөн хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах." гэсэн хэсэг, мөн хуулийн 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;" гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэхийг тогтоож, дүгнэлт гаргаж өгнө үү." гэсэн байна.

Хоёр. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Мөнхтөр Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

"Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэж заасан ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид нь Монгол Улсын иргэний хувьд шүүхийн шийдвэрт давж заалдах, Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл, журмыг тодорхойлон заасан байдаг. Гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлж, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, хүндрүүлж болно.” гэж, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;” гэж тус тус заасан нь хэргийн оролцогч нарын шударга шүүхээр шүүлгэх, давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхийг хязгаарлаж байна.

Тухайлбал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчдын эрхийг хязгаарласан байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, үндэслэл, журмыг ноцтой зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн, хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй асуудлаар мөрдөн байцаах, прокурор, шүүхийн үйл ажиллагаатай холбогдуулан хэргийн оролцогч давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргахад шүүгдэгчийн ялыг хүндрүүлэн өөрчлөх боломжийг давж заалдах, хяналтын шатны шүүхэд олгосон нь Монгол Улсын Үндсэн хуулийн зөрчил юм. Жишээлбэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн асуудлаар шүүгдэгчийн өмгөөлөгчийн гаргасан гомдлыг дээд шатны шүүхээс хянан үзээд, хэргийн бодит байдал, зөв бурууг хуульд зааснаар хянаж шударга шийдвэр гаргахын оронд шүүгдэгчид оногдуулсан ялыг шууд хүндрүүлж, дээрх хуулийн заалтуудыг хэргийн оролцогч нарыг гомдол гаргуулахгүй болгох арга болгон ашиглаж байна. Сүүлийн үед давж заалдах болон хяналтын шатны шүүх хэргийн оролцогч нарын гомдлоор хэргийг шийдвэрлэхдээ ял шийтгэлийн асуудлыг шүүх хуралдаан дээр хэлэлцэгдээгүй байхад, прокурорын саналаас давсан ялыг тодорхой үндэслэлгүйгээр хүндрүүлэн нэмдэг боллоо.

Хэргийн оролцогч Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэн шүүхийн гаргасан хуулийн зөрчлийг засуулахаар дээд шатны шүүхэд хандсан байхад давж заалдах болон хяналтын шатны шүүхээс ялыг нь хүндрүүлж байгаа нь хүмүүнлэг, энэрэнгүй байх Монгол Улсын Үндсэн хуулийн үнэт чанарыг эс хэрэгссэн, хүний эрхийн ноцтой зөрчил юм.

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.” гэж, 26 дугаар зүйлд “Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчилах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчилахаас бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой.” гэж, мөн Пактын 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Ямар нэг гэмт хэрэгт шийтгүүлж ял заагдсан хүн бүр шийтгэгдсэнээ болон оноосон ялыг эргэж хянуулахаар хуулийн дагуу дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй.” гэж тус тус заасан үүргийг Монгол Улс хүлээсэн байтал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдыг давж заалдах гомдол гаргах эрхийг нь хязгаарлаж байна. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчиж байна.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтын холбогдох хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ..., өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах ..., эрхтэй.” гэж заасныг зөрчсөн тухай дүгнэлт гаргана уу.” гэсэн байна.

Гурав. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Үндсэн хуулийн цэцэд хандан ирүүлсэн тайлбартаа:

1. “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн

... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан бөгөөд үүний хүрээнд холбогдох бусад хууль, хууль тогтоомжийн актаар иргэний эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлдэг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино.” гэж хуульчилсан. Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.” гэж заасан. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн зорилт болон ялын бодлого нь хэн нэгэн этгээд бусдын хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөг зөрчсөн бол түүндээ тохирсон хариуцлагыг зайлшгүй хүлээх үзэл санаа, үр дагавартай байдаг.

Эрүүгийн хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэж байгаа шүүгч, шүүх бүрэлдэхүүн нь ямар нэг байдлаар нөлөөнд автаж, шүүгдэгчид түүний үйлдсэн гэмт хэрэг, гэм буруугийн хэлбэрт нийцээгүй буюу гэмт хэрэгт тухайн зүйлчлэлээр оногдуулж болох ялын төрлөөс хамгийн хөнгөнийг сонгох боломжтой бөгөөд энэ тохиолдолд Эрүүгийн хуульд заасан шударга ёсны зарчим алдагдахад хүрэх учраас уг сөрөг үр дагаврыг засах боломжийг дээд шатны шүүхэд олгох үүднээс дээрх заалтыг хуульчилсан.

Хэн нэгэн этгээд өөрийгөө гэм буруугүй, эрх бүхий байгууллага, албан тушаалтан эрх хэмжээгээ хэтрүүлэн ял оноосон, буруу зүйлчилсэн гэж үзэн дээд шатны шүүхэд хандан эрх, эрх чөлөөгөө хамгаалдаг. Ийм учраас хууль тогтоогч Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг баталгаатай эдлүүлдэг. Түүнчлэн Эрүүгийн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөнөөр хохирогч бий болж байдаг бөгөөд Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргагч иргэдийн дурдаад байгаа заалт нь хэн нэгэнд ял завших боломж олгохоос сэргийлэх, хохирогчийн эрх ашгийг хамгаалах давхар баталгаа болж байдаг.

Мэдээлэл гаргагчийн мэдээлэлд дурдсанчлан Үндсэн хуульд шүүгдэгч шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг тусгаснаас гадна эрх, эрх чөлөө нь хөндөгдсөн хохирогч шүүхэд гомдол гаргах асуудал мөн ижил хамгаалагдсаныг дурдах нь зүйтэй.

2. Хууль тогтоогч өмнө үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хуульд заасан үндэслэл байвал хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт, анхан шатны болон шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцааж хугацаа алддаг, оролцогчдод чирэгдэл үүсгэдэг, хэрэг замхрах нөхцөл байдлыг бий болгодог байсан зохицуулалтыг халж, зөвхөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатнаас л хэргийг буцааж, шүүхийн бусад шатнаас хэргийг буцаадаггүй болгож хуульчилсантай холбоотойгоор давж заалдах болон хяналтын шатны шүүхээс шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр оногдуулсан ял хөнгөдсөн талаар дүгнэлтэд хүрсэн тохиолдолд ялыг хүндрүүлж болох эрх хэмжээг олгосон.

Энэхүү эрх хэмжээг олгосон бас нэг үндэслэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж заасантай нийцүүлэх, энэхүү үзэл баримтлалыг хэрэг хянан шийдвэрлэх хуульд бодитоор тусгаж, хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх явдал байсан.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хуулиар Улсын дээд шүүхэд дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрийг хянах бүрэн эрхийг олгосон бөгөөд нэгэнт хянах эрх нь байгаа тохиолдолд анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн /ял хөнгөдсөн/ шийдвэрийг зөвтгөх, буруу шийдвэрийг засах арга зам, тодорхой шийдвэр гаргах эрх нь зайлшгүй байх ёстой гэж үзсэний үндсэн дээр хяналтын шатны шүүхийн эрх хэмжээг дээрх байдлаар хуульчилсан.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар гомдол, эсэргүүцлийн дагуу эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээс гарсан шийдвэрийг хяналтын шатны шүүх бүхэлд нь хянан үзсэний үндсэн дээр гэмт хэргийн зүйлчлэл болоод бусад бүх асуудал нь зөв, хуулийн дагуу байгаад гагцхүү оногдуулсан

ял нь илтэд хөнгөдсөн талаарх дүгнэлтээ үндэслээд ялыг хүндрүүлж болохоор зохицуулсан.

Дээр дурдсаныг үндэслэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "... шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... хүндрүүлж болно." гэж, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ..., эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах." гэж, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ..., эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;" гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй." гэсэн байна.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад мэдээлэл гаргагч иргэн А.Ариунболд, Б.Мөнхтөр нар нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэлэлцэж буй заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын Монгол Улсын иргэн "... шударга шүүхээр шүүлгэх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ..., эрхтэй.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг зөрчсөн гэсэн мэдээллийн шаардлагаа дэмжиж, бусад шаардлагаас татгалзсан болно.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлан гаргахдаа 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлж, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, хүндрүүлж болно.", 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Давж заалдах шатны шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:" гээд 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;", 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хяналтын шатны шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:" гээд 1.4 дэх заалтад "шүүгдэгчид

холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;" гэсэн зохицуулалтыг тусгаж хэргийн оролцогчдын гаргасан гомдлын дагуу шүүхийн шийдвэрийг холбогдох шатны шүүх хянаад шүүхээс оногдуулсан ялыг хүндрүүлж болохоор хуульчилсан байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн удиртгал хэсэгт хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгон тунхагласан бөгөөд Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахаар хуульчлан тогтоосон. Мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг давж заалдах үндсэн эрхтэй болохыг бататган хуульчилсан юм.

Түүнчлэн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 5 дахь хэсэгт "Ямар нэг гэмт хэрэгт шийтгүүлж ял заагдсан хүн бүр ... дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй." гэж бататган тогтоосон байдаг.

3. Монгол Улсын Шүүхийн тухай хуульд анхан шатны шүүх хуулиар харьяалуулсан эрүүгийн хэргийг анхан шатны журмаар, давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг талуудын гаргасан гомдол, прокурорын эсэргүүцлийн үндсэн дээр давж заалдах журмаар, Дээд шүүх нь давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хэргийн магадлалтай холбогдуулан гаргасан эрх зүйн маргааныг талуудын гомдол, Улсын ерөнхий прокурор, эсхүл түүний эрх олгосон прокурорын эсэргүүцлийн үндсэн дээр хяналтын журмаар тус тус хянан шийдвэрлэх эрх хэмжээтэй байхаар хуульчилсан. Үүнээс үзэхэд анхан шатны шүүхийн шийдвэрээс шалтгаалж давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхийн ажиллагаа эхэлдэг. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч дээд шатны шүүхэд ханддаг бөгөөд гомдол, эсэргүүцлийн үндсэн дээр анхан шатны шүүх болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүснэ. Иймд давж заалдах болон хяналтын шатны шүүхийн үйл ажиллагаа нь анхан шатны шүүхийн шийдвэрийн хүрээнд асуудлыг шүүгдэгчид ашигтайгаар буюу хэргийн бодит байдлыг тогтоон хүний эрхийг хангаж, анхан шатны шүүхийн шийдвэрийг

эс зөвшөөрч дээд шатны шүүхэд гаргасан үндэслэл бүхий гомдлыг шийдвэрлэх ёстой. Гэтэл давж заалдах болон хяналтын шатны шүүх шүүгдэгчид холбогдох эрүүгийн хэргийг гомдлоор хянан хэлэлцэхэд гомдолд дурдаагүй асуудал, тухайлбал ялын асуудлыг хөндөж анхан шатны шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг хүндрүүлэх боломжийг бий болгох зэргээр шүүгдэгч (бусад шүүгдэгч)-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулах хууль зүйн үндэслэлийг бүрдүүлсэн байна.

Үүнээс үзэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх ... шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... хүндрүүлж болно.”, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;”, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;” гэж хуульчлан анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч дээд шатны шүүхэд хандсанаар шүүгдэгчид илүү хүнд ял оноох, эрх зүйн байдлыг дордуулж болохоор зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгын агуулгад нийцэхгүй байхаас гадна хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхийн шийдвэрийг давж заалдах иргэний үндсэн эрхийг хөндөж, Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлж, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, хүндрүүлж болно” гэж, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн

нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;" гэж, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;" гэж тус тус заасны "... хүндрүүлж ...", "... эсхүл хүндрүүлж ..." гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын Монгол Улсын иргэн "... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Давж заалдах шатны шүүх ... шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... хүндрүүлж болно.", 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;", 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг ... эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын Монгол Улсын иргэн "... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх ..." гэснийг тус тус зөрчөөгүй байна.

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлж, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, хүндрүүлж болно." гэж заасны "... хүндрүүлж ..." гэснийг, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;" гэж заасны "... эсхүл хүндрүүлж ..." гэснийг, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;" гэж заасны "... эсхүл хүндрүүлж ..." гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх

хэсэгт заасны дагуу 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн тус тус түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Д.ОДБАЯР
ГИШҮҮД	Н.ЧИНБАТ
	Д.ГАНЗОРИГ
	Б.БУЯНДЭЛГЭР
	Г.ТУУЛХҮҮ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2019.03.26 Дугаар 27 Төрийн ордон,
Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2019 оны
01 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлж, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж хүндрүүлж болно” гэж, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;” гэж, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;” гэж тус тус заасны “... хүндрүүлж ...”, “... эсхүл хүндрүүлж ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын Монгол Улсын иргэн “... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2019.05.27 Дугаар 02 Улаанбаатар хот

Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2018 оны 49 дүгээр тогтоол, 2019 оны 22, 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 17.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, гишүүн Н.Чинбат, Д.Солонго /илтгэгч/, Б.Буяндэлгэр, Ц.Нанзаддорж нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд иргэн Г.Нацагдорж, Д.Отгонбат, А.Кадирбек, Д.Ганхуяг, Б.Ууганбаяр нар болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Я.Санжмятав нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар:

- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн “Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай” 49 дүгээр тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Хорин нэгдүгээр зүйлийн 1, 2, Хорин гуравдугаар зүйлийн 1, 2, Хорин есдүгээр зүйлийн 2, 3, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим зохицуулалтыг;

- Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг болон Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9, 10 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг;

- Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны оршин суугч, иргэн Г.Нацагдорж, Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Отгонбат нар Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“... Улсын Их Хурлын гишүүн Д.Гантулгын “чөлөөлөгдөх хүсэлт”-ийг Улсын Их Хурал 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдөр хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай 49 дүгээр тогтоолыг баталжээ. Уг тогтоолыг дараах үндэслэлээр Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзэж байна:

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3 дахь заалт нь “өөр ажилд шилжих”, “хүндэтгэн үзэх бусад шалтгаан” гэсэн хоёр нөхцөлийг шаардаж байна. Гэтэл Д.Гантулга гишүүн нь өөр ажилд шилжих болсон талаар хүсэлтдээ дурдаагүй, дараа нь томилогдоогүй. Мөн түүний чөлөөлөгдөхийг хүссэн өргөдөлд “хүндэтгэн үзэх шалтгаан”-ы талаар огт дурдаагүйгээс гадна нотлох баримт хавсаргаагүй тул хүндэтгэн үзэх ямар нэг шалтгаан бүрдээгүй байна. ... Тэгэхээр хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй байхад түүнийг чөлөөлсөн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн юм.

2. Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэсэн нь Улсын Их Хурлын гишүүн хувийн ашиг сонирхлоор үүргээ биелүүлэхээс татгалзахгүй, хүссэн үедээ өргөдлөө өгөөд чөлөөлөгдөхгүй гэсэн үг.

Парламентат ёсны дархлааг авч үлдэхийн тулд парламент өөрөө болон ард түмний элч болох парламентын гишүүн нь хараат бус, бие даасан байна. Нөгөө талаараа Улсын Их Хурлын гишүүн нь бусдын дарамт, шахалт, барьцаанд орж өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргах боломжгүй байхыг уг хараат бус, бие даасан байх зарчим хангана.

3. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь хуульд заасан үндэслэл журмын дагуу бус харин Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу "дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болох"-оор байна. Үүнээс бусад тохиолдолд бүрэн эрхийг дуусгавар болгох нь Үндсэн хуулийн эрх зүйн зөрчил юм. ...

4. ... Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурал нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч, төрийн эрх барих дээд байгууллагын хувьд хууль дээдлэх ёс буюу хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах зарчмыг чанд баримтлан, зөвхөн хуулиар тодорхойлсон, хуульд заасан хүрээ хязгаарын дотор, гагцхүү хуульд үндэслэсэн шийдвэр гаргах ёстой. ... Өөрөөр хэлбэл ард түмний элч, нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталж ажиллах Улсын Их Хурлын гишүүнийг хуульд заасан үндэслэлээр бус, харин бусдын дарамт шахалтын улмаас ямар ч шалтгаан нөхцөл заахгүйгээр гаргасан хүсэлтийг нь үндэслэн, хуулийг буруу тайлбарлан хэрэглэж, чөлөөлсөн Монгол Улсын Их Хурлын 2018 оны 49 дүгээр тогтоолыг хүчингүй болгож өгнө үү." гэсэн агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ.

Хоёр. Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын 3 дугаар багийн оршин суугч, иргэн А.Кадирбек Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

"... Монгол Улсын Их Хурал нь 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Д.Гантулгын хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөхдөө Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасан Монгол Улсын иргэний төрийг удирдах хэрэгт оролцох эрх, төрийн байгууллагад сонгох эрхийг ноцтой зөрчиж, Үндсэн хуулиар баталгаатай эдлүүлэхээр олгосон ард түмний эрхийг үгүй хийж, дан ганц Улсын Их Хурлын гишүүний өөрийнх нь хүсэлтийг үндэслэж шийдвэр гаргасан нь Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална." гэсэн үүргийг зөрчсөн шийдвэр болсон.

Түүнчлэн Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж Монгол Улсын Их Хурлын гишүүний хууль зүйн баталгааг тусгажээ. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд Улсын Их Хурлын гишүүн нь гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсоноос бусад тохиолдолд түүнийг Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхээс эгүүлэн татах, чөлөөлөх, түдгэлзүүлэхийг хориглосон нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Хорин нэгдүгээр зүйлийн 2, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтад заасан Монгол Улсын иргэний эрхийг төр баталгаатай эдлүүлэх Үндсэн хуулийн баталгаа юм.

Үүнээс гадна Монгол Улсын иргэдийн хүсэл зоригоор сонгогддог Улсын Их Хурлын гишүүн нь Үндсэн хуульд зааснаас бусад тохиолдолд ард түмнийг төлөөлж төрийн үйл хэрэгт оролцох үндсэн үүргээсээ өөрийн эрх ашгийн үүднээс татгалзаж, Улсын Их Хурал тухайн гишүүний саналыг үндэслэж түүнийг чөлөөлсөн Улсын Их Хурлын шийдвэр нь Үндсэн хуулийн үзэл баримтлал, парламент ёсыг үгүй хийсэн, Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. ...” гэсэнд нийцээгүй, Монгол Улсын нийт ард иргэдийн эрх ашгийг зөрчсөн шийдвэр болсон байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 49 дүгээр тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:” гээд 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн

хугацаагаар сонгоно.", Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.", Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.", мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна." гэж хуульчилсныг тус тус зөрчсөнийг тогтоож өгнө үү." гэжээ.

Гурав. Нийслэлийн Баянгол дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Ганхуяг Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээлэл гаргасан байна. Үүнд:

"... Улсын Их Хурлын гишүүн нь нийт ард түмнээсээ сонгогдсон төлөөлөл, ард түмний элч болж, нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталж ажиллахаар төр, ард түмнийхээ өмнө тангараг өргөсөн төрийн улс төрийн албан хаагч болохынхоо хувьд зөвхөн хуульд заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд л үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх бөгөөд энгийн төрийн албан хаагчийн нэгэн адил хүссэн үедээ ямар нэгэн шалтаг, шалтгаанаар үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргах боломжгүй байдаг онцлогтой. ...

Д.Гантулга нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3 дахь заалтад "гишүүн өөр ажилд шилжих болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан;" гэж заасан үндэслэлээр чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан бөгөөд хүсэлтдээ чухам ямар хүндэтгэн үзэх шалтгаантай болохоо тодорхой дурдаагүй, баримт хавсаргаагүй байна. Мөн түүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа гэдэг боловч тэрээр гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор эцэслэн шийдэгдээгүй байгаа. ...

Хуулийн зохицуулалтаас үзвэл гишүүн хүндэтгэн үзэх тодорхой шалтгаангүйгээр чөлөөлөгдөх хүсэлт гаргах эрх зүйн үндэслэл байхгүй байх бөгөөд Улсын Их Хурлын зүгээс хүсэлтийг хүлээн авахдаа хүндэтгэн үзэх шалтгаан буюу ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон онцгой нөхцөл байдал байсан эсэхийг тодруулж, тогтоосны үндсэн дээр шийдвэр гаргах ёстой атал энэ талаар тодруулалгүй, хуульд заасан үндэслэлгүй, хүлээж авах ёсгүй хүсэлтийг шууд хүлээн авч тогтоол гаргасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь

хэсэгт "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэж заасныг тус тус зөрчсөн байна. ...

Улсын Их Хурлын энэ шийдвэр нь дараа дараагийн зарчмын хувьд буруу шийдвэр гарах нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, Хэнтий аймгийн 42 дугаар тойрогт энэ оны 6 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын нөхөн сонгууль хийхээр товлож, 287 сая гаруй төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас, үнэн хэрэг дээрээ ард түмний халааснаас гаргахаар шийдвэрлэсэн нь дээр дурдсан буруу шийдвэрээс үүдэлтэй шууд хор хохирол юм. Хууль зөрчин зарласан энэ сонгуульд 11 нам оролцохоор бүртгүүлсэн ба намын болон нэр дэвшигчдээс нэмж гаргах зардлыг тооцвол эл шийдвэр эрүүл ухааны аливаа хэм хэмжээнээс хэтрэн гарсан байна. Хэнтийн нөхөн сонгууль нь Улсын Их Хурлын дурын гишүүнийг дарамтлан өргөдлийг нь өгүүлж, Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх гарц, боломжийг нээн өгч зарчмын хувьд буруу, үр дагаврын хувьд туйлын хортой жишиг тогтоож байна.

Иймхүү Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц … хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...", Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурал ... далан зургаан гишүүнтэй байна.", Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.", мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.", Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэж тус тус заасныг зөрчсөн эсэхийг магадлан хянаж, дүгнэлт гаргаж өгнө үү." гээд уг ***мэдээллийн шаардлагаа 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдөр дараах байдлаар нэмэгдүүлж ирүүлсэн байна. Үүнд:***

"... Төрийн эрх барих дээд байгууллага болох Монгол Улсын Их Хурлаас хуульд заасан үндэслэл бүрдээгүй байхад 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай хууль бус тогтоол гаргасан. Уг хууль бус тогтоолдоо үндэслэн гаргасан Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн "Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай" 22 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх … үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг шууд зөрчсөн байна. ...

Төр нь улс орноо хөгжүүлэх, ард түмнээ элбэг хангалуун, амар жимэр амьдруулах зорилгоор буюу нийгмийн хөгжлийг хангахын тулд эдийн засгийг удирдах учиртай. Гэтэл Үндсэн хуульд нийцээгүй шийдвэр гаргаж түүнийгээ хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олон зуун сая төгрөг зарцуулахаар төсөвлөж байгаа нь эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх эрхэм зорилгод нийцэхгүй байна. ... Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын төлөөллийн тухай ухагдахуун бол "нэг хүн"-д хамаарах хууль зүй, улс төрийн шинжлэх ухааны ойлголт биш харин тогтолцоо, зохион байгуулалт буюу "төлөөлөгчдийн байгууллага" болох Улсын Их Хуралд шууд хамаарах ойлголт болохыг учирлан тайлбарлаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 22 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Төр нь ... хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэж тус тус заасныг зөрчсөн эсэхийг магадлан хянаж, өмнө нь гаргасан мэдээлэлтэй хамтад нь хэлэлцэн дүгнэлт гаргуулахаар мэдээллийн шаардлагаа ихэсгэж байна." гэжээ.

Дөрөв. Нийслэлийн Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Уганбаяр Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн мэдээлэлдээ:

"... Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг Улсын Их Хурал товлон зарлахаар хуульчилсны дагуу Монгол Улсын Их Хурлын 2019 оны 22 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг 2019 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн товлон зарлаж, Улсын Их Хурлын нөхөн сонгуулийн санал авах өдрийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байхаар тогтоосон байна. ...

Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэгт зааснаар Улсын дээд шүүхэд бүртгүүлснээр улс төрийн нам нь үйл ажиллагаа явуулах эрхтэй болдог. Гэтэл Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт Улсын Их Хурлын сонгуульд "Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй." гэж хуульчилсан нь санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлээгүй нам нь бусад улс төрийн намуудтай ижил тэгш эрхтэйгээр Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах сонгуульд оролцох эрхийг хязгаарлаж байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ..." гэж хуульчилсан ба Сонгуулийн тухай хуульд зааснаар санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлээгүй нам Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуульд оролцох нэр дэвшүүлэх, сонгогдох эрхийг энэхүү органик хуулиар хязгаарлаж буй нь Үндсэн хуулийн ноцтой зөрчил юм. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.", мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно." гэж хуульчилсан ба тухайн намаас дээрх Үндсэн хуульд заасан шаардлагыг хангасан хүнийг Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах нөхөн

сонгуульд нэр дэвшүүлэхээр байтал Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангаагүй гэх үндэслэлээр Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцуулахгүй байх, нэр дэвшүүлэхээс татгалзах нөхцөл байдал үүсч байна.

Энэ нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасан иргэний төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг, мөн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, төрийн бүхий л үйл хэрэгт ард түмний оролцоог хангах, иргэнийг нам, улс төрийн үзэл баримтлалаар ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш боломжийг бүрдүүлэх Үндсэн хуулийн суурь зарчим, Үндсэн хуулиар бий болгосон иргэний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчсөн байна.

... Мөн Монгол Улсын Их Хурал нь Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах нөхөн сонгуулийг товлон зарлахдаа уг нөхөн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, бие даагчийн Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг нэгдүгээрт, органик хуулиар хязгаарлаж, хоёрдугаарт, улс төрийн нам, эвсэл байгуулах, сонгуульд оролцох эрхийн хууль зүйн болон бусад баталгааг хангаагүй нь Үндсэн хуулийн ноцтой зөрчил болно. Тухайлбал, Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэж хуульчилжээ.

Монгол Улсын Их Хурлаас Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг 2019 оны 2 дугаар сарын 10-ны өдөр товлон зарласан ба санал авах өдрийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байхаар тогтоосон билээ. Гэтэл энэхүү 2 дугаар сарын 10-ны өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийн хооронд 140 хоног болж байгаа ба нам, эвсэл нь Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцохын тулд 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлага Сонгуулийн хуулиар тавигдсан юм.

Монгол Улсын Их Хурал энэхүү Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг товлон зарлахдаа улс төрийн нам, эвсэлд хуулиар биелэх боломжгүй шийдвэрийг гаргаж, улмаар Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох эрхийг Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгээр хязгаарлаж буй нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “нийгмийн болон өөрсдийн ашиг

сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дурааараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг болон Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай" 22 дугаар тогтоол тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан заалтуудыг зөрчсөн болохыг тогтоож өгнө үү." гэжээ.

Тав. Уг маргаанд холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хариу тайлбартаа:

"... Аль ч орны парламентын гишүүн нь хууль тогтоомж болон олон улсын зарчмаар хүлээн зөвшөөрөгдсөн ардчилсан парламентын гол шинж болох халдашгүй байдал, бүрэн эрхийн баталгааг эдлэх боловч үндсэн эрхийн тодорхой хэм хэмжээ, хязгаарлалт, хууль тогтоомжид захирагдах нь хүний эрх, хууль дээдэлсэн, ардчилсан хүмүүнлэг иргэний нийгмийн зүй ёсны шаардлага юм. ...

Парламентын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, бүрэн эрхээсээ татгалзах, чөлөөлөгдөх, эгүүлэн татах асуудалд улс орнууд болгоомжтой ханддаг бөгөөд парламентын гишүүнийхээ мандатын шинж байдлыг ихэнх тохиолдолд Үндсэн хуулиар "өөрөөр нь тодорхойлуулдаг" гэж үздэг.

Монгол Улс ч мөн 1992 онд энэ жишгийг дагаж Улсын Их Хурлын гишүүний мандатын хэв шинжийг Үндсэн хуулиараа тогтоосон. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална." гэж заасан нь Монгол Улсын Их Хурлын гишүүн нь императив бус чөлөөт мандаттайг харуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн "Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай" 49 дүгээр

тогтоолоор Монгол Улсын Их Хурлын гишүүн өөрийн хүсэлтээр Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх асуудлыг шийдвэрлэсэн анхны тохиолдол биш юм. Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурлын гишүүний өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүнээс хэд хэдэн гишүүнийг чөлөөлж байсан.

Улсын Их Хурлын гишүүн хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох тухай асуудал 1992 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Дараах тохиолдолд Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх буюу эгүүлэн татна: ... 2) эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос чөлөөлж өгөхийг хүсэж өргөдөл гаргасан.” гэж, 1997 оны 2 дугаар сарын 06-ны өдөр баталсан Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Дараахь тохиолдолд Төрийн байгуулалтын байнгын хорооны санал дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлнө: ... 2/биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос чөлөөлж өгөхийг хүсэж гишүүн өөрөө өргөдөл гаргасан” гэж тус тус зохицуулагдаж ирсэн.

Улсын Их Хурлын гишүүн асан Д.Гантулгын хувьд Улсын ерөнхий прокуророос гэмт хэрэгт холбогдуулан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх хүсэлт ирүүлсний дагуу уг асуудлыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.2 дахь заалт, мөн зүйлийн 6.13 дахь хэсэгт тус тус зааснаар 2018 оны 6 дугаар сарын 08-ны өдөр хэлэлцэн Д.Гантулгын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх шаардлагагүй гэж үзээд Улсын Их Хурал тогтоол гаргасан болно.

Улсын Их Хурлын тогтоол баталсны дараа Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн зүгээс хэвлэлийн бага хурал хийсэн. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгаас 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Д.Гантулгын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 47 дугаар тогтоолд хориг тавьж, тодорхой үндэслэлээ тусгасан байсан. ...

Улсын Их Хурлын гишүүн асан Д.Гантулгын зүгээс Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн мэдээлэл, Монгол Улсын

Ерөнхийлөгчийн хориг зэргийг харгалзан улс төрийн шийдвэрээ гарган хууль, шүүхийн байгууллагаар гэм буруугийн асуудлаа хуулийн дагуу шийдвэрлүүлэхээр шийдэж Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдөр гаргасан. Уг хүсэлтийг Монгол Улсын Их Хурал авч хэлэлцэхдээ "хүндэтгэн үзэх бусад шалтгаан" гэдгийг үүсээд байсан нөхцөл байдлыг шийдвэрлэх, ингэхдээ гишүүний зүгээс гадны хүчин зүйлийн нөлөөгүйгээр өөрийн итгэл үнэмшлээр улс төрийн шийдвэр гаргасан гэж үзэн хүсэлтийг хүлээн авч олонхын саналаар шийдвэрлэсэн болно. Иймд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн "Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай" 49 дүгээр тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй, харин эдгээр зарчмыг баримтлан бэхжүүлэхэд чиглэгдсэн гэж үзэж байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна.", Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.", мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно." гэсэн зохицуулалт нь Улсын Их Хурлын бүрэлдэхүүний суурь үндсийг тогтоож байгаа бөгөөд Монгол Улсын Их Хурлын бүрэлдэхүүн, түүнтэй холбогдох бусад асуудал тухайлбал, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, бүрэн эрхээс чөлөөлөх зэргийг Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиудаар тусгайлан зохицуулсан байдаг. Иймд Үндсэн хуулийн эдгээр зарчмыг мөн зөрчсөн гэж үзэх боломжгүй байна." гээд ***Улсын Их Хурлаас 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдөр ирүүлсэн нэмэлт тайлбартаа:***

"Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад Монгол Улсын иргэн нь "шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. ..." гэж заасан байдаг. Гэтэл Хэнтий аймгийн 42 дугаар тойргийн 17450 иргэд, сонгогчид төрийн эрх барих дээд байгууллагад 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрөөс өнөөдрийг хүртэл төлөөлөлгүй байна. Иймд Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг

сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Сонгуулийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний орон гарсан бол нөхөн сонгууль явагдана.” гэж заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн санал авах өдрийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байхаар тогтоосон болно.

Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад Улсын Их Хурал нь “... Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах;” асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана.”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд 2019 оны 22 дугаар тогтоолыг баталж, нөхөн сонгуулийг товлон зарласан бөгөөд уг тогтоолд улс төрийн нам сонгуульд оролцохтой холбоотой аливаа зохицуулалт байхгүй болно.

Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, мөн зүйлийн 12.3 дахь хэсэгт “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэж тус тус заасан. Энэ зохицуулалт нь нам сонгуульд оролцохоос өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх тодорхой хугацааг заасан шалгуурыг анх удаа тогтоосон асуудал биш бөгөөд өмнө нь үйлчилж байсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиудад Улсын Их Хурлын сонгууль зарлахаас өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй байхаар зохицуулж байсан. ...

Ардчилсан нийгэмд нэг талаас иргэд улс төрийн намд зөвхөн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх; нөгөө талаас иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг төр хангах, хамгаалах үүрэг хүлээх нь зайлшгүй шаардлага байдаг бөгөөд сонгуулийн үр дүнгээр төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагыг улс төрийн намууд хүлээдэг.

Венецийн комиссын 2010 оны 10 дугаар сарын 15, 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Улс төрийн намын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтад удирдлага болгох зарчмууд”-ыг хэлэлцэн батлсан бөгөөд энэ баримт бичигт улс төрийн нам гэдэг нь чөлөөт, ардчилсан сонгуульд нэр дэвшүүлэх, төрийн үйл хэргийг удирдахад оролцох замаар иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлэхийг нэг зорилтоо болгосон иргэдийн сайн дурын нэгдэл мөн гэж тодорхойлжээ. Энэ тодорхойлолт нь бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх, эсхүл өөрийн гишүүдийг төрийн эрх барих байгууллагад сонгуульд оролцуулах замаар улс төрийн салбарт засаглах бүрэн эрхийг хэрэгжүүлэхийг зорьсон иргэдийн сайн дурын аливаа нэгдэлд хамаарна гэсэн байна. Мөнхүү баримт бичигт дурдсанаар улс төрийн намыг бүртгүүлэхэд зарим нэг шаардлага тавих нь эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөнд тооцогдохгүй гэж Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрүүдэд заасан байна.

Төрийн үйл хэргийг удирдахад оролцох, төрийн бодлогыг тодорхойлох, улмаар зарим давуу байдлыг олж авдгийн хувьд улс төрийн нам төрийн сонгуульд оролцох хүсэлтээ илэрхийлэх нь санамсаргүй, гэнэтийн, тохиолдлын зүйл байх ёсгүй буюу зөвхөн тухайн нэг сонгуульд аливаа зорилгоор оролцохын тулд улс төрийн намыг хэлбэрийн төдий байгуулах, дотооддоо бэхжиж, үйл ажиллагаа нь тогтворжоогүй, бодлого, үзэл баримтлалаа тодорхойлоогүй улс төрийн намыг төрийн сонгуульд оролцуулах нь өөрөө сөрөг үр дагаврыг бий болгох эрсдэлтэй гэж үздэг.

Эдгээр үндэслэлүүдээр Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэгт тавьсан шаардлага нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ...” гэж тус тус заасныг баталгаажуулан бэхжүүлсэн, иргэдийн эрхийг баталгаатай хангах нөхцөлийг хамгаалсан зохицуулалт болсон гэж үзэж байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн “Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай” 49 дүгээр тогтоол, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн

сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ... -ыг хориглоно.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.” гэжээ.

Зургаа. Уг маргаанд холбогдуулан Улсын ерөнхий прокуророос 2019 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 1/2411 тоотоор ирүүлсэн албан бичигт:

“... Нийслэлийн прокурорын газраас Улсын Их Хурлын гишүүн асан Г-д ... холбогдуулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдөр яллах дүгнэлт үйлдэж, хэргийг хянан шийдвэрлүүлэхээр шүүхэд шилжүүлсэн байна.

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдаанаар хэргийг хянан хэлэлцээд мөрдөн шалгах нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаасан бөгөөд энэ шийдвэрийг эс зөвшөөрч бичсэн прокурорын эсэргүүцлийн дагуу Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хэргийг хэлэлцээд, анхан шатны шүүгчийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад яллагдагч Г ... гэмт хэрэгт дахин холбогдож, энэ үйлдэлд нь 2019 оны 1 дүгээр сарын

14-ний өдөр Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар ... дугаартай эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, өмнөх ... дугаартай хэрэгт нэгтгэж мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.” гэжээ.

Долоо. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд бэлтгэх явцад хийсэн ажиллагааны тухайд:

Иргэдийн мэдээлэлд дурдсан асуудалтай холбогдох Цэцийн шийдвэрийн лавлагааг гарган, “хүндэтгэн үзэх шалтгаан”, “нөхөн сонгууль” зэрэг нэр томъёо, парламентын гишүүнийг чөлөөлөх, огцруулах талаарх зарим орны эрх зүйн зохицуулалт, парламентын гишүүний халдашгүй байдлыг цуцлах, бүрэн эрхийг түдгэлзүүлэх талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтын (Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төв) судалгаа, Монгол Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд өөрийн хүсэлтээр Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж шийдвэрлүүлсэн тохиолдлууд, Улсын Их Хурлын гишүүнийг гишүүнээс нь чөлөөлөх талаарх Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох заалт, Улс төрийн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцох, нэр дэвшүүлэх эрхийн тухай болон Улсын Их Хурлын гишүүнийг нөхөн сонгох талаарх сонгуулийн холбогдох хуулийн заалтын түүхчилсэн, харьцуулсан зэрэг шаардлагатай бусад судалгааг Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төвтэй хамтран гүйцэтгэж, Европын хүний эрхийн шүүхийн зарим шийдвэрийг судлан үзлээ.

Мөн Монгол Улсын Их Хурлаас Улсын Их Хурлын нэр бүхий гишүүний “Хүсэлт гаргах тухай” 2018.06.11-ний 6853 дугаар албан бичиг (Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх тухай), уг асуудлыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар 2018.06.13-ны өдөр, чуулганы нэгдсэн хуралдаанаар 2018.06.14-ний өдөр тус тус хэлэлцсэн тэмдэглэл, Монгол Улсын Их Хурлын 2018.06.14-ний өдрийн “Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай” 49 дүгээр тогтоол, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийг анх хэлэлцсэн Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2005.12.27, 2006.01.17-ны өдрийн, чуулганы нэгдсэн хуралдааны 2006.01.05, 19, 26-ны өдрийн тэмдэглэл, Монгол Улсын Их Хурлын 2019.02.02-ны “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол, уг 22 дугаар

тогтоолын төслийг хэлэлцсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны 2019.01.29-ний өдрийн, чуулганы нэгдсэн хуралдааны 2019.02.02-ны өдрийн тэмдэглэл, Сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцсэн Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2015.11.17, 25, 2015.12.23, 24, 25-ны өдрийн, чуулганы нэгдсэн хуралдааны 2015.11.20, 2015.12.25-ны өдрийн тэмдэглэл, бусад холбогдох баримт болон Улсын дээд шүүхээс Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намын жагсаалт зэргийг гаргуулан авч танилцав.

Найм. Дээрх маргааныг хянан хэлэлцэх Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад:

Иргэн Б.Ууганбаяр нь өөрийн мэдээллийн үндэслэлд тусгасан Монгол Улсын Их Хурлын 2019 оны 22 дугаар тогтоол Сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн, улмаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт нийцээгүй гэсэн шаардлагаа тодруулаа. Тухайлбал, 2019 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийн хооронд 140 хоног болж байгаа тул Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийг Улсын Их Хурал зөрчиж дээрх тогтоолыг гаргасан гэсэн үндэслэлээ хэд хэдэн удаа давтан тайлбарлав.

Мөн иргэн Д.Ганхуяг “Улсын Их Хурлын 2019 оны 22 дугаар тогтоол нь дараа дараагийн зарчмын хувьд буруу шийдвэр гарах нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, Хэнтий аймгийн 42 дугаар тойрогт энэ оны 6 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын нөхөн сонгууль хийхээр товлож, 287 сая гаруй төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас, үнэн хэрэг дээрээ ард түмний халааснаас гаргахаар шийдвэрлэсэн нь дээр дурдсан буруу шийдвэрээс үүдэлтэй шууд хор хохирол юм.” гэсэн мэдээллийнхээ үндэслэлийг тодруулан, Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолыг холбогдох хуульд нийцүүлэн гаргаагүйгээс Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль дээдлэх зарчмыг зөрчсөн гэсэн үндэслэл, тайлбарыг хийлээ.

Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Я.Санжмятав нар иргэн Б.Ууганбаяр, Д.Ганхуяг нарын дээрх шаардлагад холбогдуулан няцаах тайлбар, үндэслэл гаргаж, Сонгуулийн тухай хуулийн хүрээнд тодруулбал, 16 дугаар зүйлийн 16.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурал уг 22 дугаар тогтоолыг гаргасан;

холбогдох төсвийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон нэгэнт хэвшин тогтсон практикийн дагуу Засгийн газрын нөөц сангаас гаргахаар 23 дугаар тогтоолд тусгасан гэсэн болно. Мөн түүнчлэн Сонгуулийн тухай хуулийн сонгуулийн тов зарлах болон санал авах өдрийг тодорхойлох тухай зохицуулалттай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооноос лавлагаа авч байсан талаар дурдаж байв.

ҮНДЭСЛЭЛ:

Нэг. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн "Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай" 49 дүгээр тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааны тухайд:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Гантулга 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх тухай хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын даргад хандаж гаргажээ. Уг хүсэлтийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3 дахь заалт, мөн зүйлийн 6.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцүүлж, гаргасан дүгнэлтийг 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд нууцаар санал хурааж, хуралдаанд оролцсон нийт 60 гишүүний 75 хувь нь Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх хүсэлтийг дэмжсэн байна. Иймхүү Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 49 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Дорждугарын Гантулгыг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсөн байна.

2. Улсын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, мөн зүйлийн 4 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр баталжээ.

Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт "Дор дурдсан тохиолдолд гишүүний бүрэн эрх энэ хуулийн 6.3-т заасан хугацаанаас өмнө дуусгавар болно:" гээд 6.6.3 дахь заалтад "гишүүн өөр ажилд шилжих болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан;", мөн зүйлийн 6.7 дахь хэсэгт "Энэ хуулийн 6.6.3, 6.6.4-т заасан тохиолдолд гишүүнийг чөлөөлөх ...", 6.8 дахь хэсэгт "Гишүүнийг чөлөөлөх ... асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн

саналаар, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.” гэж хуульчилжээ. Харин Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх үйл явцыг журамласан зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэзэд Улсын Их Хурлын гишүүн нь өөрийн сонгогдсон тойргийн төлөө хүчин зүтгэдэг императив буюу захирагдмал мандаттай бус, харин нийт иргэн, улсын ашиг сонирхлыг хангахын тулд ажиллаж, түүний төлөө хариуцлага хүлээдэг чөлөөт мандаттай болохыг тогтоосон бөгөөд уг үзэл баримтлалын хүрээнд аль ч тойргийн сонгогч Улсын Их Хурлын гишүүдийг өөрийн төлөөлөл гэж үзэх үндэслэл бүрдсэн болно. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын гишүүн тойргоос сонгогддог хэдий ч нийт иргэдийн төлөөлөл болдог учиртай. Түүнчлэн Үндсэн хуулийн уг заалтын үзэл баримтлалын хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Ээлжит сонгуулийн дараа нийт гишүүний дөрөвний гурав буюу 57-оос доошгүй гишүүн сонгогдож, Улсын Их Хурлын гишүүний тангараг өргөсөн бол Улсын Их Хурлыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.” хэмээн хуульчилжээ.

Үүнээс үзэхэд Монгол Улсын Их Хурал эдүгээ үйлчилж буй эрх зүйн зохицуулалтын дагуу, өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд “Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх тухай” дээр дурдсан хүсэлтийг шийдвэрлэж 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн “Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай” 49 дүгээр тогтоол гаргасан байх тул уг шийдвэр Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Хорин нэгдүгээр зүйлийн 1, 2, Хорин гуравдугаар зүйлийн 1, 2, Хорин есдүгээр зүйлийн 2, 3, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар

хамгаална.” гэсэн заалтын биелэлтийг хангах болон Үндсэн хуульт ёс, тэр дундаа парламентат ёсыг бэхжүүлэх, төрийн болон эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, улс төр дэх авлига, дарамт шахалтаас урьдчилан сэргийлэх үүднээс ард түмний элч болж нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталж бүрэн эрхээ хэрэгжүүлдэг Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх үндэслэлийг тодорхой болгох, мөн чөлөөлөх үйл явцыг нарийвчлан хуульчлах, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3 дахь заалтад заасан “хүндэтгэн үзэх бусад шалтгаан” гэх ойлголтын агуулга, хүрээ, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, халдашгүй байдлын талаарх эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох замаар боловсронгуй болгох бүрэн эрх хууль тогтоогчид байгаа болохыг тэмдэглэж байна.

Хоёр. Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22, “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааны тухайд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дурааараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, мөн зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” хэмээн зааж Монгол Улсад засгийн бүх эрх ард түмнээс эхтэй болохыг тодорхойлон Монгол Улсын иргэн улс төрийн намд эвлэлдэн нэгдэж, төрийн эрх барих байгууллага болох Улсын Их Хуралд сонгогдох, түүний гишүүнийг сонгох эрхээ хэрэгжүүлэх боломжтойг баталгаажуулан тогтоосон болно.

Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дурааараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл бөгөөд төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагыг өөрсдийн төлөөлөлтэйгөөр байгуулах, улмаар өөрсдийн дэвшүүлж буй бодлого, үзэл баримтлал, хөтөлбөрийн дагуу түүнийг удирдах зорилготой байдаг. Энэ хүрээнд иргэд сонгуульд өөрсдийн байгуулсан, нэгдэн орсон эсхүл үзэл баримтлал, үйл ажиллагааг дэмждэг нам, эвслээс нэр дэвших, нэр дэвшигчийг сонгох замаар улс төрийн эрхээ хэрэгжүүлдэг. Үүнээс үзэхэд аливаа улс төрийн нам, эвсэл төрийн эрх барих байгууллагын сонгуульд оролцох, нэр дэвшүүлэх асуудал бол иргэн хүний улс төрийн эрх болон Үндсэн хуулиар баталгаажсан ардчилсан ёс, засгийн бүх эрх ард түмнээс эхтэй байх үзэл санаатай нягт уялдаатай юм.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.” гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын дагуу Улсын Их Хурал 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн тухай хуулийг баталж, тус хуулиар Монгол Улсын Их Хурлын болон бусад байгууллагын сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорхойлж, сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах хэм хэмжээг тогтоожээ.

Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлд Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуульд нэр дэвшүүлэх эрхийн талаарх зохицуулалтыг хуульчлахдаа тус зүйлийн 12.1 дэх хэсэгт “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, 12.3 дахь хэсэгт “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэжээ. Түүнчлэн, тус хуулийн 124 дүгээр зүйлийн 124.3.1 дэх заалтад “санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангаагүй;” бол нам, эвслийг сонгуульд оролцуулахаар бүртгэхээс татгалзахаар нийтлэг байдлаар зохицуулсан байна.

Гэтэл Улс төрийн намын тухай хуульд зааснаар 801 ба түүнээс олон иргэн сайн дурааараа нэгдэж нам байгуулан, хөтөлбөр, дүрмээ баталж, Улсын дээд шүүхэд хянуулж бүртгүүлснээр гэрчилгээ авч үйл ажиллагаа явуулах эрхтэй болдог.

Үүнээс үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсгийн зохицуулалт нь 180-аас доош хоногийн өмнө нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд хуульд зааснаар сонгууль товлон зарласан өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн улс төрийн нам дангаараа болон бусад нам, улс төрийн хүчинтэй эвсэж уг сонгуульд оролцох, нэр дэвшүүлэх боломжгүй болгожээ. Өөрөөр хэлбэл, тухайн намын гишүүд, дэмжигч иргэд төрийн байгууллагад сонгогдох, сонгох эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн боломжийг хууль тогтоогч Сонгуулийн тухай хуулиар бүрэн бүрдүүлээгүй буюу Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан иргэн Б.Уганбаярын мэдээлэлд дурдсан нөхцөл байдлыг бий болгосон байна.

Ингэснээр хугацааны шалгууруар иргэд аль нэгэн намд эвлэлдэн нэгдсэний төлөө буюу гишүүнийхээ хувьд ялгаварлагдах хууль зүйн үндэслэл бий болж, улмаар тэдний хувьд тэгш бус байдлыг үүсгэжээ.

Үүний зэрэгцээ Сонгуулийн тухай хуулийн дээрх заалтууд нь зөвхөн Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн хүрээнд төдийгүй Улсын Их Хурлын бусад аль ч төрлийн сонгуульд улс төрийн нам оролцоход хугацаанаас хамаарч ялгавартай байдлаар хандах боломжийг бүрдүүлсэн нь иргэдийн улс төрийн эрхийг хөндсөн, ардчилсан ёсны зарчмыг алдагдуулсан байна. Тодруулбал, сонгуульд оролцох улс төрийн намд тодорхой шалгуурыг хуулийн хүрээнд тогтоож болох боловч уг шалгуур нь үндэслэлтэй бөгөөд хариуцлага, санхүүжилт, илт тод байдал гэх зэрэг хуулийн бусад зохицуулалттай уялдсан, иргэний улс төрийн эрхийн хязгаарлалтын талаарх нийтээр хүлээн зөвшөөрсөн түгээмэл зарчимд нийцсэн байх учиртай юм. Гэтэл дээрх заалтуудад тусгасан “180-аас доошгүй хоног”-ийн хугацааны шалгуур нь эдгээрт хамаарахгүй байна. Улсын Их Хурлаас ирүүлсэн хариу тайлбарт “улс төрийн намыг бүртгүүлэхэд зарим нэг шаардлага тавих нь эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөнд тооцогдохгүй гэж Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрүүдэд заасан байна.” гэсэн боловч нотолгоог тодорхой дурдаагүй байна. Мөн өнөөдрийн хэлэлцэж буй маргаан нь улс төрийн намыг бүртгэх тухай бус нэгэнт бүртгэгдсэн намыг сонгуульд оролцохтой холбоотой асуудал байгаа болно. Харин Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хамгаалж, баталгаажуулсан шийдвэрүүд зонхилж байх ба эдгээр нь Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 22 болон Хүний эрхийн тухай Европын конвенцийн 11 дүгээр зүйлийг үндэслэж, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг зөвхөн

үндэсний болон нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуульд зааснаар хязгаарлалт тавьж болно; үүнээс өөр хязгаарлалтыг зөвхөн гарцаагүй бөгөөд үндэслэлтэй учир шалтгаан байгаа тохиолдолд хэрэглэнэ; уг хязгаарлалт нь тавьж буй хууль ёсны зорилгод дүйцэхүйц байхаас гадна нөхцөл байдалд нийцсэн, энэ талаарх нотолгоотой байх хэрэгтэй талаар тусгасан байна.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн түүхчилсэн судалгаанаас үзэхэд өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулиудад улс төрийн нам, эвсэл сонгуульд оролцох тохиолдолд ийнхүү тухайлан хагас жилээс доошгүй хугацааны өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх тухай зохицуулалтыг тусгаагүй байх ба 1992 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд “Нам сонгуульд оролцохоо санал авах өдрөөс 65 хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр илэрхийлж, албан ёсоор бүртгүүлнэ. 2005, 2011 оны хуульд сонгууль товлон зарласан өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй байхаар заасан байсныг дурдах нь зүйтэй байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр гаргасан дүгнэлт, мөн оны 11 дүгээр сарын 30-ны өдөр гаргасан 03 дугаар тогтоолдоо “Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд тухайн сонгуульд нэр дэвших, улмаар төрийн байгууллагад сонгогдох эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн боломжийг хууль тогтоогч бүрэн бүрдүүлээгүй” гэж, “сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тулгамдсан асуудал байгааг дурдах нь зүйтэй” гэж, мөн “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, сонгогч, сонгогдогч иргэдийн эрхийг тэгш хангаж холбогдох заалтыг өөрчлөх эрх нь хууль тогтоогчид байгаа” талаар тус тус тухайлан тусгаж Улсын Их Хуралд уламжилж байсан болно.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хүлээж байгаа юм.

Гэтэл Монгол Улсын Их Хурал нь Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг товлон зарлах шийдвэрийг 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдөр гаргахдаа Үндсэн хуульт ёс, ардчилсан эрх зүйт төрийн суурь үзэл баримтлалд нийцүүлэн Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх

үүргийнхээ дагуу тухайн сонгуульд оролцох улс төрийн намын тэгш байдлыг хангах ёстой атал тэгш бус байдлыг бий болгосон, сонгогч, сонгогдогч иргэдэд үндэслэлгүй ялгаварлал бий болгосон сонгуулийн хуулийн хийдэл, дутагдлыг арилгахгүйгээр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоолыг батлан гаргажээ.

Дээр дурдсан үндэслэл, нөхцөл байдлаас үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, түүнчлэн Монгол Улсын Их Хурал 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол батлан гаргаснаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчиж, улмаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэж заасныг зөрчигдөх нөхцөл бүрдүүлсэн байна.

4. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт “Ээлжит сонгуулийн санал авах өдрийг санал авах өдрөөс 150-иас доошгүй хоногийн өмнө тогтооно.” гэж хуульчилжээ. Харин тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана.” хэмээн заасан боловч Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн санал авах өдрийг зарлах шийдвэрийг хэзээ гаргах талаар уг хуульд тусгайлан хуульчлаагүй байна. Гэтэл сонгуулийн эрх зүй нь Үндсэн хуулийн эрх зүйн бусад институттэй харьцуулахад процессын хэм хэмжээ ихээр агуулдаг онцлогтой бөгөөд сонгуулийн үйл явцын үе шат бүрийн эхлэх, дуусгавар болох хугацааг нарийвчлан тогтоосон байхыг шаарддаг. Ийнхүү тогтоогоогүй тохиолдолд нийтийн эрх зүйн зарчмын дагуу ерөнхий зохицуулалтыг удирдлага болгох

учиртай. Иймд уг зарчмын хүрээнд Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн санал авах өдрийг санал авах өдрөөс 150-иас доошгүй хоногийн өмнө тогтоохоор байна.

Үүнээс үзэхэд Монгол Улсын Их Хурал нь Сонгуулийн тухай хуулийн дээр дурдсан зохицуулалтыг зөрчиж, 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдөр 22 дугаар тогтоол гарган 148 хоногийн өмнө Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгуулийн санал авах өдрийг тогтоосон байна. Иймхүү Улсын Их Хурлын 2019 оны 22 дугаар тогтоол нь холбогдох хуулийн заалтад үл нийцсэн байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

5. Монгол Улсын Их Хурал 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарласан бөгөөд үүнтэй уялдуулан мөн өдрийн 23 дугаар тогтоолоороо тус сонгуулийг зохион байгуулахтай холбоотой зардлын хэмжээг тогтоож, уг зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан байна.

Харин Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.14 дэх заалтад Улсын Их Хурлын нөхөн сонгуулийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр хуульчилжээ. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд "Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийн орлогыг Засгийн газрын тусгай сан…" гэж тодорхойлоод, тус хуулийн 8 дугаар зүйлд "Засгийн газрын нөөц сан"-аас төсөв батлахаас өмнө урьдчилан харах боломжгүй тодорхой хэдэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр зохицуулжээ. Харин Сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт "Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана." гэж заасан ба мөн Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуультай холбоотой Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр гарсан зэргээс үзэхэд уг нөхөн сонгуулийг 2019 онд явуулах нь тодорхой байсан юм. Үүнээс үзэхэд Монгол Улсын Их Хурлын 2019 оны 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад "Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын

нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай" гэсэн нь дээрх хуулиудын зохицуулалтад үл нийцжээ. Улмаар Улсын Их Хурлын 23 дугаар тогтоолын 2 дахь заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасныг зөрчсөн байна.

6. Ээлжит сонгуультай харьцуулахад нөхөн сонгууль нь баримтлах зарчмын хувьд ижил боловч сонгуулийн үйл явцын хугацаа болон холбогдох процедурын хувьд онцлог, ялгаатай. Гэтэл энэхүү онцлог байдлыг хууль тогтоогч харгалзан үзэхгүйгээр 2015 онд Сонгуулийн тухай хуулийг баталсан байна. Тодруулбал, уг хуульд нөхөн сонгуультай холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй, хийдэлтэй, эсхүл нийтлэг байдлаар хуульчилсан нь иргэдээс Үндсэн хуулийн цэцэд удаа дараа хандах, улмаар сонгуулийн талаарх хэм хэмжээ, шийдвэрүүд хүчингүй болох үр дагаврыг бий болгож байна. Иймд сонгуулийн тухай хууль тогтоомжийг батлан гаргахдаа нөхөн сонгуульд холбогдох зохицуулалтыг нарийвчлан хуульчлах нь Үндсэн хуулийн үнэт зүйл болон ардчилал, парламентат ёсыг бэхжүүлэх, улмаар Үндсэн хуульт ёсыг хамгаалах, Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

Мөн энэхүү дүгнэлтийн тэмдэглэх хэсэгт дурдсан судалгаа, үндсэн хуулийн болон сонгуулийн эрх зүйн онол, номлолоос үзэхэд аливаа нөхөн сонгуулийн талаарх зохицуулалтыг хуульчлах болон нөхөн сонгууль товлон зарлах шийдвэр гаргахдаа тухайн улсын төрийн байгууламж, мандатын хэв шинж (императив, эсхүл чөлөөт), парламентын оронгарсан гишүүний бүрэн эрхийн хугацаа, парламентын өөрийнх нь бүрэн эрхээ хэрэгжүүлж болохуйц бүрэлдэхүүний тоо зэргийг үндэслэж, улс орны эдийн засгийн болон төрийн тогтвортой байдал, улс төр дэх авлига, дарамт шахалтаас ангид байх асуудал гэх мэт хүчин зүйлийг харгалздаг байна. Тухайлбал, өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиудад (1992, 2005, 2011 он) орон гарсан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахад нэг жил хүрэхгүй хугацаа үлдсэн бол нөхөн сонгууль явуулахгүй байхаар нарийвчлан тусгасан байжээ. Харин Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуульд энэ талаарх зохицуулалтыг орхигдуулан хуульчилсан байна. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлд Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс болохыг тогтоож, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын гишүүн бол ард

түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэж зааж Улсын Их Хурлын гишүүн нь императив бус чөлөөт мандаттай болохыг тодорхойлсон.

Үүний зэрэгцээ тус хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд Улсын Их Хурлын гишүүн нас барсан, хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдсөн, эсхүл бүрэн эрхийг нь түдгэлзүүлсэн, эгүүлэн татсаны улмаас орон гарсан боловч нөхөн сонгууль явагдаагүй тохиолдолд Улсын Их Хурлын 57-оос доошгүй гишүүний бүрэн эрх хүчинтэй байвал Улсын Их Хурлыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.” хэмээн заасанд нийцүүлэх нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, 12.3 дахь хэсгийн “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэсэн заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:” гэзд мөн зүйлийн

9 дэх заалтад "... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...", мөн зүйлийн 10 дахь заалтад "... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар 02-ны өдрийн "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай" 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад "Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасныг зөрчсөн байна.

3. Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 22, 23 дугаар тогтоол тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийг зөрчөөгүй байна.

4. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн "Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай" 49 дүгээр тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Хорин нэгдүгээр зүйлийн 1, 2, Хорин гуравдугаар зүйлийн 1, 2, Хорин есдүгээр зүйлийн 2, 3, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.-

5. Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн "Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.", 12.3 дахь хэсгийн "Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна." гэсэн заалтыг болон Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 22, 23 дугаар тогтоолыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан

шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн тус тус түдгэлзүүлсүгэй.

6. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Д.ОДБАЯР
ГИШҮҮД	Н.ЧИНБАТ
	Д.СОЛОНГО
	Б.БУЯНДЭЛГЭР
	Ц.НАНЗАДДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2019.06.12 Дугаар 66 Төрийн ордон, Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 02 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан “Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, 12.3 дахь хэсгийн “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэсэн заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:” гэзд мөн зүйлийн 9 дэх заалтад “... төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...”, 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх

хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.“Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2019.10.09 Дугаар 03 Улаанбаатар хот

Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 22, 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 11.45 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат, Ш.Цогтоо, Д.Солонго, Б.Буяндэлгэр, Ш.Солонго, Г.Туулхүү, Ц.Нанзаддорж /илтгэгч/, Г.Баясгалан нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормаа оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Б.Ууганбаяр болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Я.Санжмятав нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 02 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурал хүлээн авч хэлэлцээд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 22, 23 дугаар тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох

заалтыг зөрчсөн гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 66 дугаар тогтоолыг гарган ирүүлсэн тул уг маргааныг Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар дахин хянан эцэслэн шийдвэрлэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Ганхуяг Үндсэн хуулийн цэцэд хандаж:

"... Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тогтоол нь дараа дараагийн зарчмын хувьд буруу шийдвэр гарах нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, Хэнтий аймгийн 42 дугаар тойрогт энэ оны 6 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын нөхөн сонгууль хийхээр товлож, 287 сая гаруй төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас, үнэн хэрэг дээрээ ард түмний халааснаас гаргахаар шийдвэрлэсэн нь дээр дурдсан буруу шийдвэрээс үүдэлтэй шууд хор хохирол юм. Хууль зөрчин зарласан энэ сонгуульд 11 нам оролцохоор бүртгүүлсэн ба намын болон нэр дэвшигчдээс нэмж гаргах зардлыг тооцвол уг шийдвэр эрүүл ухааны аливаа хэм хэмжээнээс хэтрэн гарсан байна.

... Дээрх хууль бус тогтоолдоо үндэслэн гаргасан Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн "Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай" 22 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх … үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг шууд зөрчсөн байна. ...Төр нь улс орноо хөгжүүлэх, ард түмнээ элбэг хангалуун, амар жимэр амьдруулах зорилгоор буюу нийгмийн хөгжлийг хангахын тулд эдийн засгийг удирдах учиртай. Гэтэл Үндсэн хуульд нийцээгүй шийдвэр гаргаж түүнийгээ хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олон зуун сая төгрөг зарцуулахаар төсөвлөж байгаа нь эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх эрхэм зорилгод нийцэхгүй байна. ... Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын төлөөллийн тухай ухагдахуун бол "нэг хүн"-д хамаарах хууль зүй, улс төрийн шинжлэх ухааны ойлголт биш харин тогтолцоо, зохион байгуулалт буюу "төлөөлөгчдийн байгууллага" болох Улсын Их Хуралд шууд хамаарах ойлголт болохыг учирлан тайлбарлаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 22 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн

2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь ... хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж тус тус заасныг зөрчсөн.” гэсэн агуулга бүхий мэдээлэл ирүүлсэн байна. ***Мөн Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан дээр:*** “Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолыг холбогдох хуульд нийцүүлэн гаргаагүйгээс Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль дээдлэх зарчмыг зөрчсөн” гэсэн нэмэгдүүлсэн шаардлага гаргаж холбогдох тайлбарыг хийжээ.

Хоёр. Нийслэлийн Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Уганбаяр Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн мэдээлэлдээ:

“... Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг Улсын Их Хурал товлон зарлахаар хуульчилсны дагуу Монгол Улсын Их Хурлын 2019 оны 22 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг 2019 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн товлон зарлаж, Улсын Их Хурлын нөхөн сонгуулийн санал авах өдрийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байхаар тогтоосон байна. ...

Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэгт зааснаар Улсын дээд шүүхэд бүртгүүлснээр улс төрийн нам нь үйл ажиллагаа явуулах эрхтэй болдог. Гэтэл Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт Улсын Их Хурлын сонгуульд “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.” гэж хуульчилсан нь санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлээгүй нам нь бусад улс төрийн намуудтай ижил тэгш эрхтэйгээр Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах сонгуульд оролцох эрхийг хязгаарлаж байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ..." гэж хуульчилсан ба Сонгуулийн тухай хуульд зааснаар санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлээгүй нам Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуульд оролцох нэр дэвшүүлэх, сонгогдох эрхийг энэхүү органик хуулиар хязгаарлаж буй нь Үндсэн хуулийн ноцтой зөрчил юм. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.", мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно." гэж хуульчилсан ба тухайн намаас дээрх Үндсэн хуульд заасан шаардлагыг хангасан хүнийг Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах нөхөн сонгуульд нэр дэвшүүлэхээр байтал Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангаагүй гэх үндэслэлээр Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцуулахгүй байх, нэр дэвшүүлэхээс татгалзах нөхцөл байдал үүсч байна.

Энэ нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасан иргэний төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг, мөн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, төрийн бүхий л үйл хэрэгт ард түмний оролцоог хангах, иргэнийг нам, улс төрийн үзэл баримтлалаар ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш боломжийг бүрдүүлэх Үндсэн хуулийн суурь зарчим, Үндсэн хуулиар бий болгосон иргэний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчсөн байна.

... Мөн Монгол Улсын Их Хурал нь Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах нөхөн сонгуулийг товлон зарлахдаа уг нөхөн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, бие даагчийн Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг нэгдүгээрт, органик хуулиар хязгаарлаж, хоёрдугаарт, улс төрийн нам, эвсэл байгуулах, сонгуульд оролцох эрхийн хууль зүйн болон бусад баталгааг хангаагүй нь Үндсэн хуулийн ноцтой зөрчил болно. Тухайлбал, Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт "Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна." гэж хуульчилжээ.

Монгол Улсын Их Хурлаас Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг 2019 оны 2 дугаар сарын 10-ны өдөр товлон зарласан ба санал авах өдрийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байхаар тогтоосон билээ. Гэтэл энэхүү 2 дугаар сарын 10-ны өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийн хооронд 140 хоног болж байгаа ба нам, эвсэл нь Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцохын тулд 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлага Сонгуулийн хуулиар тавигдсан юм.

Монгол Улсын Их Хурал энэхүү Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг товлон зарлахдаа улс төрийн нам, эвсэлд хуулиар биелэх боломжгүй шийдвэрийг гаргаж, улмаар Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох эрхийг Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгээр хязгаарлаж буй нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад "нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг болон Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай" 22 дугаар тогтоол тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан заалтуудыг зөрчсөн болохыг тогтоож өгнө үү." гэжээ.

Гурав. Уг маргаанд холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирүүлсэн хариу тайлбарт:

"... Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад Монгол Улсын иргэн нь "шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. ..." гэж заасан байдаг. Гэтэл Хэнтий аймгийн 42 дугаар тойргийн 17450 иргэд, сонгогчид төрийн эрх барих дээд байгууллагад 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрөөс өнөөдрийг хүртэл төлөөлөлгүй байна. Иймд

Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Сонгуулийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний орон гарсан бол нөхөн сонгууль явагдана.” гэж заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн санал авах өдрийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байхаар тогтоосон болно.

Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад Улсын Их Хурал нь “... Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах;” асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана.”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд 2019 оны 22 дугаар тогтоолыг баталж, нөхөн сонгуулийг товлон зарласан бөгөөд уг тогтоолд улс төрийн нам сонгуульд оролцохтой холбоотой аливаа зохицуулалт байхгүй болно.

Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, мөн зүйлийн 12.3 дахь хэсэгт “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэж тус тус заасан. Энэ зохицуулалт нь нам сонгуульд оролцохоос өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх тодорхой хугацааг заасан шалгуурыг анх удаа тогтоосон асуудал биш бөгөөд өмнө нь үйлчилж байсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиудад Улсын Их Хурлын сонгууль зарлахаас өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй байхаар зохицуулж байсан. ...

Венецийн комиссын 2010 оны 10 дугаар сарын 15, 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Улс төрийн намын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтад удирдлага болгох зарчмууд”-ыг хэлэлцэн батлсан бөгөөд энэ баримт бичигт улс төрийн нам гэдэг нь чөлөөт, ардчилсан сонгуульд нэр дэвшүүлэх, төрийн үйл хэргийг удирдахад оролцох замаар иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлэхийг нэг зорилтоо болгосон иргэдийн сайн дурын нэгдэл мөн гэж тодорхойлжээ. Энэ тодорхойлолт нь бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх, эсхүл өөрийн гишүүдийг төрийн эрх барих байгууллагад сонгуульд оролцуулах замаар улс төрийн салбарт засаглах бүрэн эрхийг хэрэгжүүлэхийг зорьсон иргэдийн сайн дурын аливаа нэгдэлд хамаарна гэсэн байна. Мөнхүү баримт бичигт дурдсанаар улс төрийн намыг бүртгүүлэхэд зарим нэг шаардлага тавих нь эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөнд тооцогдохгүй гэж Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрүүдэд заасан байна.

Төрийн үйл хэргийг удирдахад оролцох, төрийн бодлогыг тодорхойлох, улмаар зарим давуу байдлыг олж авдгийн хувьд улс төрийн нам төрийн сонгуульд оролцох хүсэлтээ илэрхийлэх нь санамсаргүй, гэнэтийн, тохиолдлын зүйл байх ёсгүй буюу зөвхөн тухайн нэг сонгуульд аливаа зорилгоор оролцохын тулд улс төрийн намыг хэлбэрийн төдий байгуулах, дотооддоо бэхжиж, үйл ажиллагаа нь тогтворжоогүй, бодлого, үзэл баримтлалаа тодорхойлоогүй улс төрийн намыг төрийн сонгуульд оролцуулах нь өөрөө сөрөг үр дагаврыг бий болгох эрсдэлтэй гэж үздэг.

Эдгээр үндэслэлүүдээр Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэгт тавьсан шаардлага нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ...” гэж тус тус заасныг баталгаажуулан бэхжүүлсэн, иргэдийн эрхийг баталгаатай хангах нөхцөлийг хамгаалсан зохицуулалт болсон гэж үзэж байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн “Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай” 49 дүгээр тогтоол, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн

сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ... –ыг хориглоно.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.” гэжээ.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаар энэхүү маргааныг хэлэлцэж 02 дугаар дүгнэлт гаргасан байна. Уг дүгнэлтийн үндэслэх хэсгийн “Хоёр”-т:

“... 2. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.” гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын дагуу Улсын Их Хурал 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн тухай хуулийг баталж, тус хуулиар Монгол Улсын Их Хурлын болон бусад байгууллагын сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорхойлж, сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах хэм хэмжээг тогтоожээ.

Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлд Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуульд нэр дэвшүүлэх эрхийн талаарх зохицуулалтыг хуульчлахдаа тус зүйлийн 12.1 дэх хэсэгт “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, 12.3 дахь хэсэгт “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх

шаардлагыг хангасан байна.” гэжээ. Түүнчлэн, тус хуулийн 124 дүгээр зүйлийн 124.3.1 дэх заалтад “санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангаагүй;” бол нам, эвслийг сонгуульд оролцуулахаар бүртгэхээс татгалзахаар нийтлэг байдлаар зохицуулсан байна.

Гэтэл Улс төрийн намын тухай хуульд зааснаар 801 ба түүнээс олон иргэн сайн дурааараа нэгдэж нам байгуулан, хөтөлбөр, дүрмээ баталж, Улсын дээд шүүхэд хянуулж бүртгүүлснээр гэрчилгээ авч үйл ажиллагаа явуулах эрхтэй болдог.

Үүнээс үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсгийн зохицуулалт нь 180-аас доош хоногийн өмнө нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд хуульд зааснаар сонгууль товлон зарласан өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн улс төрийн нам дангаараа болон бусад нам, улс төрийн хүчинтэй эвсэж уг сонгуульд оролцох, нэр дэвшүүлэх боломжгүй болгожээ. Өөрөөр хэлбэл, тухайн намын гишүүд, дэмжигч иргэд төрийн байгууллагад сонгогдох, сонгох эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн боломжийг хууль тогтоогч Сонгуулийн тухай хуулиар бүрэн бүрдүүлээгүй буюу Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан иргэн Б.Уганбаярын мэдээлэлд дурдсан нөхцөл байдлыг бий болгосон байна.

Ингэснээр хугацааны шалгуураар иргэд аль нэгэн намд эвлэлдэн нэгдсэний төлөө буюу гишүүнийхээ хувьд ялгаварлагдах хууль зүйн үндэслэл бий болж, улмаар тэдний хувьд тэгш бус байдлыг үүсгэжээ.

Үүний зэрэгцээ Сонгуулийн тухай хуулийн дээрх заалтууд нь зөвхөн Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн хүрээнд төдийгүй Улсын Их Хурлын бусад аль ч төрлийн сонгуульд улс төрийн нам оролцоход хугацаанаас хамаарч ялгавартай байдлаар хандах боломжийг бүрдүүлсэн нь иргэдийн улс төрийн эрхийг хөндсөн, ардчилсан ёсны зарчмыг алдагдуулсан байна. Тодруулбал, сонгуульд оролцох улс төрийн намд тодорхой шалгуурыг хуулийн хүрээнд тогтоож болох боловч уг шалгуур нь үндэслэлтэй бөгөөд хариуцлага, санхүүжилт, илт тод байдал гэх зэрэг хуулийн бусад зохицуулалттай уялдсан, иргэний улс төрийн эрхийн хязгаарлалтын талаарх нийтээр хүлээн зөвшөөрсөн түгээмэл зарчимд нийцсэн байх учиртай юм.

Гэтэл дээрх заалтуудад тусгасан “180-аас доошгүй хоног”-ийн хугацааны шалгуур нь эдгээрт хамаарахгүй байна. Улсын Их Хурлаас

ирүүлсэн хариу тайлбарт “улс төрийн намыг бүртгүүлэхэд зарим нэг шаардлага тавих нь эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөнд тооцогдохгүй гэж Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрүүдэд заасан байна.” гэсэн боловч нотолгоог тодорхой дурдаагүй байна. Мөн өнөөдрийн хэлэлцэж буй маргаан нь улс төрийн намыг бүртгэх тухай бус нэгэнт бүртгэгдсэн намыг сонгуульд оролцохтой холбоотой асуудал байгаа болно. Харин Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хамгаалж, баталгаажуулсан шийдвэрүүд зонхилж байх ба эдгээр нь Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 22 болон Хүний эрхийн тухай Европын конвенцийн 11 дүгээр зүйлийг үндэслэж, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг зөвхөн үндэсний болон нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуульд зааснаар хязгаарлалт тавьж болно; үүнээс өөр хязгаарлалтыг зөвхөн гарцаагүй бөгөөд үндэслэлтэй учир шалтгаан байгаа тохиолдолд хэрэглэнэ; уг хязгаарлалт нь тавьж буй хууль ёсны зорилгод дүйцэхүйц байхаас гадна нөхцөл байдалд нийцсэн, энэ талаарх нотолгоотой байх хэрэгтэй талаар тусгасан байна.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн түүхчилсэн судалгаанаас үзэхэд өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулиудад улс төрийн нам, эвсэл сонгуульд оролцох тохиолдолд ийнхүү тухайлан хагас жилээс доошгүй хугацааны өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх тухай зохицуулалтыг тусгаагүй байх ба 1992 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд “Нам сонгуульд оролцохоо санал авах өдрөөс 65 хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр илэрхийлж, албан ёсоор бүртгүүлнэ. 2005, 2011 оны хуульд сонгууль товлон зарласан өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй байхаар заасан байсныг дурдах нь зүйтэй байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр гаргасан дүгнэлт, мөн оны 11 дүгээр сарын 30-ны өдөр гаргасан 03 дугаар тогтоолдоо “Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд тухайн сонгуульд нэр дэвших, улмаар төрийн байгууллагад сонгогдох эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн боломжийг хууль тогтоогч бүрэн бүрдүүлээгүй” гэж, “сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тулгамдсан асуудал байгааг дурдах нь зүйтэй” гэж, мөн “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, сонгогч, сонгогдогч иргэдийн эрхийг тэгш хангаж холбогдох заалтыг өөрчлөх

эрх нь хууль тогтоогчид байгаа” талаар тус тус тухайлан тусгаж Улсын Их Хуралд уламжилж байсан болно.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хүлээж байгаа юм.

Гэтэл Монгол Улсын Их Хурал нь Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг товлон зарлах шийдвэрийг 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдөр гаргахдаа Үндсэн хуульт ёс, ардчилсан эрх зүйт төрийн суурь үзэл баримтлалд нийцүүлэн Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийнхээ дагуу тухайн сонгуульд оролцох улс төрийн намын тэгш байдлыг хангах ёстой атал тэгш бус байдлыг бий болгосон, сонгогч, сонгогдогч иргэдэд үндэслэлгүй ялгаварлал бий болгосон сонгуулийн хуулийн хийдэл, дутагдлыг арилгахгүйгээр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоолыг батлан гаргажээ.

Дээр дурдсан үндэслэл, нөхцөл байдлаас үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, түүнчлэн Монгол Улсын Их Хурал 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол батлан гаргаснаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчиж, улмаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэж заасныг зөрчигдөх нөхцөл бүрдүүлсэн байна.

4. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт “Ээлжит сонгуулийн санал авах өдрийг санал авах өдрөөс

150-иас доошгүй хоногийн өмнө тогтооно.” гэж хуульчилжээ. Харин тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана.” хэмээн заасан боловч Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн санал авах өдрийг зарлах шийдвэрийг хэзээ гаргах талаар уг хуульд тусгайлан хуульчлаагүй байна. Гэтэл сонгуулийн эрх зүй нь Үндсэн хуулийн эрх зүйн бусад институттэй харьцуулахад процессын хэм хэмжээ ихээр агуулдаг онцлогтой бөгөөд сонгуулийн үйл явцын үе шат бүрийн эхлэх, дуусгавар болох хугацааг нарийвчлан тогтоосон байхыг шаарддаг. Ийнхүү тогтоогоогүй тохиолдолд нийтийн эрх зүйн зарчмын дагуу ерөнхий зохицуулалтыг удирдлага болгох учиртай. Иймд уг зарчмын хүрээнд Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн санал авах өдрийг санал авах өдрөөс 150-иас доошгүй хоногийн өмнө тогтоохоор байна.

Үүнээс үзэхэд Монгол Улсын Их Хурал нь Сонгуулийн тухай хуулийн дээр дурдсан зохицуулалтыг зөрчиж, 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдөр 22 дугаар тогтоол гарган 148 хоногийн өмнө Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгуулийн санал авах өдрийг тогтоосон байна. Ийнхүү Улсын Их Хурлын 2019 оны 22 дугаар тогтоол нь холбогдох хуулийн заалтад үл нийцсэн байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

5. Монгол Улсын Их Хурал 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарласан бөгөөд үүнтэй уялдуулан мөн өдрийн 23 дугаар тогтоолоороо тус сонгуулийг зохион байгуулахтай холбоотой зардлын хэмжээг тогтоож, уг зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан байна.

Харин Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.14 дэх заалтад Улсын Их Хурлын нөхөн сонгуулийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр хуульчилжээ. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд “Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийн орлогыг Засгийн газрын тусгай сан…” гэж тодорхойлоод, тус хуулийн 8 дугаар зүйлд “Засгийн газрын нөөц

сан”-аас төсөв батлахаас өмнө урьдчилан харах боломжгүй тодорхой хэдэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр зохицуулжээ. Харин Сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана.” гэж заасан ба мөн Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуультай холбоотой Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр гарсан зэргээс үзэхэд уг нөхөн сонгуулийг 2019 онд явуулах нь тодорхой байсан юм. Үүнээс үзэхэд Монгол Улсын Их Хурлын 2019 оны 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай” гэсэн нь дээрх хуулиудын зохицуулалтад үл нийцжээ. Улмаар Улсын Их Хурлын 23 дугаар тогтоолын 2 дахь заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна. ...” гээд Тогтоох хэсэгт “Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, 12.3 дахь хэсгийн “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэсэн заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:” гээд мөн зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний

үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг; мөн өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна.” гэж дүгнэн, 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн тус тус түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Тав. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” 66 дугаар тогтоолд:

“1. “Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, 12.3 дахь хэсгийн “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэсэн заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:” гээд мөн зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. “Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэсэн байна.

Зургаа. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Я.Санжмятав нар Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:

“… Сонгуулийн тухай хуулийн 16.3-т заасны дагуу санал авах өдрийг тогтоох тухай 150 хоног нь ээлжит сонгуульд хамаарах бөгөөд хэзээ, ямар нөхөн сонгууль болох нь урьдчилан тооцох боломжгүй тул энэхүү хугацаа нь нөхөн сонгуулийн санал авах өдрийг товлон зарлахад хамаарахгүй юм.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай” гэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.1.2-т заасны дагуу Засгийн газрын нөөц сан нь 100 хувь эх үүсвэрийг нь төсвийн хөрөнгөөр бүрдүүлдэг сангийн ангилалд хамаардаг бөгөөд уг сангаас төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардлыг санхүүжүүлж байхаар хуульчилсан тул нөхөн сонгуулийн зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргах нь хууль зөрчөөгүй болно

Иймд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол, “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн

нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоол тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.” мөн зүйлийн 10 дахь заалтын “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...”, Далдугаар дугаар зүйлийн 1 дэх хэсэг “... Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино...” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, 12.3 дахь хэсгийн “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэсэн заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, … тэгш байдал ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:” гээд мөн зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр,

нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг; мөн өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 02 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1.Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, 12.3 дахь хэсгийн “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, … тэгш байдал ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:” гээд мөн зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн тул хүчингүй болгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн тул хүчингүй болгосугай.

3.Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн тул хүчингүй болгосугай.

4.“Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 66 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

5.Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ Д.ОДБАЯР

ГИШҮҮД Н.ЧИНБАТ
Ш.ЦОГТОО
Д.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Ш.СОЛОНГО
Г.ТУУЛХҮҮ
Ц.НАНЗАДДОРЖ
Г.БАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2019.06.28 Дугаар 03 Улаанбаатар хот

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн зарим хэсэг, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 14.40 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Ш.Цогтоо, Д.Солонго, Ш.Солонго, Ц.Нанзаддорж /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн С.Баярмаа болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 4, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч иргэн С.Баярмаа Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ. Үүнд:

“2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр өөрчлөн найруулсан Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.”, 47.3 дахь хэсэгт “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дараахь хэмжээтэй байна:” гээд 47.3.1 дэх заалтад “дотоодод борлуулж байгаа нүүрсний нөөц ашигласны төлбөр тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү,”, 47.3.2 дахь заалтад “Энэ хуулийн 47.1.3-т зааснаас бусад төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн доод хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5,0 хувь, Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд тушаасан алтанд ногдох энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү.”, 47.4 дэх хэсэгт “Тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч энэ хуулийн 47.3.2-т заасан хувь дээр мөн хуулийн 47.5-д заасан хувийг нэмсэн дүнгээр тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулна.”, 47.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 47.4-т заасан нэмэлт төлбөрийн хувийг дараахь байдлаар тодорхойлно:” гээд 47.5 дахь хэсгийн 47.5.11 дэх заалтад “Боловсруулаагүй нүүрс Зах зээлийн үнийн түвшин 0-25 ам доллар хүртэл бол хүдэрт 0.00 хувь, 25-50 ам.доллар хүртэл бол хүдэрт 1.00 хувь, 50-75 ам.доллар хүртэл бол хүдэрт 2.00 хувь, 75-100 ам.доллар хүртэл бол хүдэрт 3.00 хувь, 100-125 ам.доллар хүртэл бол хүдэрт 4.00 хувь, 125 ам.доллар ба түүнээс дээш бол хүдэрт 5.00 хувиар,”, 47.5.12 дахь заалтад “Баяжуулсан нүүрс (хуурай болон нойтон аргаар технологийн боловсруулалт хийсэн) Зах зээлийн үнийн түвшин 0-100 ам.доллар хүртэл бол баяжмалд 0.00 хувь, 100-130 ам.доллар бол баяжмалд 1.00 хувь, 130-160 ам.доллар хүртэл бол баяжмалд 1.50 хувь, 160-190 ам.доллар хүртэл бол баяжмалд 2.00 хувь, 190-210 ам.доллар хүртэл бол баяжмалд 2.50 хувь, 210 ам.доллар ба түүнээс дээш бол баяжмалд 3.00 хувиар,”, 47.5.13 дахь заалтад “Эцсийн бүтээгдэхүүн

(хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн) Зах зээлийн үнийн түвшин 0-160 ам.доллар хүртэл бол бүтээгдэхүүнд 0.00 хувь, 160-190 ам.доллар хүртэл бол бүтээгдэхүүнд 0.50 хувь, 190-210 ам.доллар хүртэл бол бүтээгдэхүүнд 1.00 хувь, 210-240 ам.доллар хүртэл бол бүтээгдэхүүнд 1.50 хувь, 240-270 ам.доллар хүртэл бол бүтээгдэхүүнд 2.00 хувь, 270 ам.доллар ба түүнээс дээш бол бүтээгдэхүүнд 2.50 хувиар" гэж тус тус заасан байна.

Ашигт малтмалын тухай хуульд орсон дээрх өөрчлөлтүүд нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцээгүй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын эдийн засагт дарамт учруулсан, давхар татвар ногдуулсан, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг хаасан, нийгмийн эдийн засгийн хөгжилд саад учруулсан зэрэг сөрөг үр дагаврыг бий болгох бодит нөхцөлийг үүсгээд байна.

Мөн маргаж буй зүйлүүд нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөд зогсохгүй Татварын ерөнхий хуультай зөрчилдөж байгаа тул хуулийг нэг мөр, зөв ойлгон хэрэглэх үүднээс уг зүйлүүд нь Үндсэн хуульд нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргуулж иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг хуулийн төөрөгдөлд орох, давхар татвар төлөх эрсдэлээс сэргийлэх зүй ёсны хэрэгцээ шаардлага үүсч байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Төр нь, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж зааснаас үзвэл төр нь эдийн засгийн зөв бодлого баримталж нийгмийн хөгжлийг хангах, аж ахуй нэгж байгууллагыг үйл ажиллагаа явуулахад нь эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх бодлого баримталж, эх орондоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бүтээн байгуулалтыг дэмжиж өгөх ёстой гэсэн утга санааг илэрхийлсэн. Гэтэл Ашигт малтмалын тухай хуульд орсон маргаж буй нэмэлт, өөрчлөлтүүд нь Үндсэн хуулийн дээрх заалтуудыг бүхэлд нь зөрчиж иргэд, аж ахуй нэгжийг давхар татварын дарамтанд оруулж, нэг бүтээгдэхүүнд хэд хэдэн татвар ногдуулж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хөгжих боломжийг хааж эдийн засгийн алдагдалд оруулах бодит нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн хүчингүй болсон өмнөх заалтад Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй этгээд нь олборлосон бүтээгдэхүүндээ ашигт малтмал ашигласны төлбөр төлдөг байсан бол хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээдүүд бүгд тухайн бүтээгдэхүүний хувьд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байхаар тусгасан нь хуулийн алдааг бий болгосон.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллага нь шинээр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3, 7.3.6 дахь заалтад заасан хоёр төрлийн татварыг давхар төлөх бодит нөхцөл байдал бий болоод зогсохгүй худалдахаар ачуулсан гэсэн үндэслэлээр дахин нэмж татвар төлөхөөр болсон. Татварын ерөнхий хуульд зааснаар Монгол Улсын татвар нь албан татвар, хураамж, төлбөрөөс бүрдэнэ гэж зааснаас үзвэл татвар, төлбөр гэдэг нь хоёулаа татвар юм. Иймд нэг бүтээгдэхүүнээс улс үндсэндээ дөрвөн татварыг авч байна.

Байгалийн баялгийг олборлосон аж ахуйн нэгжээс ашигт малтмал ашигласны төлбөр аваад түүнийг нь боловсруулсан, ашигласан аж ахуй нэгжээс мөн ашигт малтмал ашигласны төлбөр авч худалдахаар ачуулсан этгээд дахин нэмж ашигт малтмал ашигласны төлбөр төлөхөөр болж байгаа нь нэг бүтээгдэхүүнээс гурван хэлбэрээр төлбөр авч мөн дээрээс нь нэмэгдсэн өртгийн албан татвар гээд нийт дөрвөн төрлийн татварыг авч байна. Үүнээс үзэхэд ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан аж ахуйн нэгжүүд нь нэмэгдсэн өртгийн албан татварыг төлөөд зогсохгүй ашигласан, худалдахаар ачуулсан гэсэн гурван төрлийн төлбөрийг төлөх нөхцөлийг бүрдүүлж байгаа нь хэт шударга бус байна.

Тэгэхээр Монгол Улсад байгалийн баялгийг боловсруулж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн бий болгох нэг ч аж ахуй нэгж байхгүй болж уул уурхайн салбар хөгжихгүй байгалийн баялаг эх орондоо үлдэхгүй, эдийн засгийн ямар ч үр өгөөжгүйгээр түүхийгээр хямд өртгөөр экспортод гарсан хэвээр байх дүр зураг харагдаж байна.

Монгол Улс нь байгалийн баялаг ихтэй эдийн засаг нь уул уурхайн салбартай салшгүй холбоотой учир дээрх Үндсэн хууль зөрчсөн зөрчлийг арилгахгүйгээр уул уурхайн салбарыг хөгжүүлэх, дотооддоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ямар ч боломжгүй гэж үзэж байна.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"... Энэ өөрчлөлт нь алтны ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид олборлосон алтаа хувь хүн, бичил уурхайн нэр дээр банканд тушааж ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс зайлсхийдэг зөрчлийг арилгах зорилготой юм.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 220 дугаар тогтоолоор нүүрсэнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг зөвхөн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс авахаар зохицуулсан байгаа.

Мэдээлэл гаргагч мэдээлэлдээ "Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3, 7.3.6-д заасан хоёр төрлийн татварыг давхар төлөх бодит нөхцөл байдал бий болсон" тухай дурджээ. Давхар татварын тухай асуудал нь нэг этгээдэд нэг татварыг дахин ногдуулахгүй тухай ойлголт бөгөөд бодит байдал дээр олон улс хооронд үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, хувь хүнд тулгардаг асуудал юм. Тухайлбал, аль нэг улсад үйл ажиллагаа эрхлэн олсон орлогодоо татвар төлсөн этгээд өөрийн харьяалал бүхий улс оронд дахин тус татварыг төлөх асуудал үүсдэг. Иймээс тухайн этгээдийн эдийн засгийн эрх, эрх чөлөөг хангах, өөрийн улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих зэрэг олон шалтгааны улмаас тодорхой улс орнууд хоорондоо Давхар татварын асуудлыг зохицуулах тухай олон улсын гэрээ байгуулдаг.

Харин орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, нэмэгдсэн өртгийн албан татвар зэрэг нь давхар татварын асуудал биш бөгөөд татварын бүтцэд багтдаг төрөл бүрийн төлбөрүүдийн нэг хэсэг юм. Татварыг дотор нь ингэж төрөлжүүлэн салгахын гол ач холбогдол нь төрөөс эдийн засгийн аливаа харилцааг зохицуулах, хянах зорилгоо татварын бодлогоор дамжуулан хэрэгжүүлэх явдал. Жишээлбэл, Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.", 2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн." гэж заасан байдаг. Эрдэс баялгийнхаа ашиглалтаас ард түмэндээ хүртээх асуудлыг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэн

нийгмийн үйлчилгээнд зарцуулах байдлаар хэрэгжүүлдэг. Харин нэмэгдсэн өртгийн албан татвар бол аливаа бараа, ажил, үйлчилгээний эцсийн хэрэглээнд татвар оноох буюу шууд бус татваруудын үр ашгийг сайжруулах зорилготой бөгөөд татварын бодлогын хэрэгжилтийг хянах зорилготой төрийн зохицуулалтын нэг арга хэрэгсэл юм.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4, 47.5-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийн хувь хэмжээ бол тухайн ашигт малтмалд оноож байгаа давхар татвар биш бөгөөд тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг нэмэх буюу бууруулах тухай асуудал юм.” гэжээ.

Гурав. Мэдээлэл гаргагч С.Баярмаа Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээллийнхээ нэмэлт тайлбартаа:

“Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагад ашигт малтмалын зэрэгцээ Монголбанканд тушааж буй алтны хэмжээг бууруулахгүй, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, татварын суурийг өргөжүүлэх зорилгоор “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулна.” гэж тайлбарласан байдаг.

Гэтэл татварын суурийг өргөжүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй хувь хүн, бичил уурхай, баяжуулах үйлдвэр эрхлэгчдийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх, тайлагнах, бүртгэлжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилготой хуулийн нэмэлт, өөрчлөлт нь нэг бүтээгдэхүүнд өссөн дүнгээр гурван удаагийн төлбөр тооцох бодит нөхцөлийг бүрдүүлсэн байгаа нь Үндсэн хуульд заасан төр нь аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийг хангах эдийн засгийн бодлогыг баримтална гэснийг зөрчиж аж ахуйн үйл ажиллагаанд татварын бодлогоор дарамт учруулсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг хаасан зохицуулалт болсон гэж үзэж байна.

Мөн хууль тогтоогчийн зүгээс Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн үзэл баримтлалдаа энэ хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь төр, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хүсэл сонирхолд бүрэн нийцсэн” гэж худал мэдээлэл оруулж ямар нэг иргэн, аж ахуйн нэгжээс санал аваагүй, хүсэл сонирхлыг нь тусгаагүй, эдийн засгийн тооцоо судалгаагүй асуудлыг оруулсан.

Мөн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилго нь зөвхөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон алтаа хувь

хүн, бичил уурхайн нэр дээр банканд тушааж ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс зайлсхийдэг зөрчлийг арилгах зорилготой гэж тодорхойлж алтны асуудлыг Байнгын хороодын хуралдаан, нэгдсэн хуралдаанаараа ярьсан байдаг хэдий ч эцсийн нэмэлт, өөрчлөлт нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь гурван этгээд байхаар зохицуулж Үндсэн хуулийн, үзэл баримтлалаа зөрчиж шийдвэрлэсэн байдаг.

Ашигт малтмалын тухай хуулийн маргаан бүхий зохицуулалтын өмнө хэрэгжиж байсан агуулгаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөө төлсөн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээс ашигт малтмал худалдан авсан этгээд нь энэ төлбөрийг дахин төлдөггүй байсан бөгөөд шинэ хуулиар ашигт малтмалын нөөц биш бүтээгдэхүүн болсон хэдий ч нөөц ашигласны төлбөр төлөхөөр зохицуулсан нь Үндсэн хуулийг зөрчиж байна.

Хэрэв тухайн бүтээгдэхүүнийг байгалиас нь олборлосон хэвээр буюу түүхий хэвээр нь цааш дамжуулан худалдаж ашиг олж байгаа бол энэхүү хуулийн нэмэлт зохицуулалт нь шударга байх хэдий ч тухайн бүтээгдэхүүнийг боловсруулан нэмүү өртөг шингээж эцсийн бүтээгдэхүүн болгон гаргаж байгаа явдал нь хоёр өөр ойлголт бөгөөд хууль санаачлагч нар үүнийг нарийн ялгаж үзэлгүй эдийн засагт нэмэр болох, татварын суурийг өргөжүүлэх гэсэн санаагаар үйлдвэрлэгчдийг татварын дарамтад оруулахаар хуулийн зохицуулалт хийсэн байна.

Мөн үйлдвэрлэгч нь худалдан авагч болохоос биш тусгай зөвшөөрөлтэй газрын байгалийн баялгийг цааш нь дамжуулан худалддаг газар биш бөгөөд дээр дурдсанчлан хоёр өөр ойлголт юм.

Үйлдвэрлэгчид нь Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашигт малтмалын нөөцийг газрын хэвлийгээс олборлодоггүй учир ашигт малтмалын нөөц ашигласан гэж үзэх боломжгүй юм.

Энэхүү хууль нь цаашид Монгол Улсад байгалийн баялгийг эх орондоо нэмүү өртөг шингээж эцсийн бүтээгдэхүүн болгож олон улсын зэх зээлд гаргах үйлдвэрлэлийг хөгжүүлэхгүй, үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор дарамталсан, үйл ажиллагааг нь боомилсон бөгөөд улмаар энэ салбар цаашид хөгжих боломжгүй болох эрсдэлт нөхцөлийг бүрдүүлж байгалийн баялгаа өөрсдөөсөө харамлаж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг хааж, түүхийгээр нь хямд үнээр гадаадын улс оронд гаргаж их хэмжээний алдагдалд орох маш том эрсдэл, эдийн засгийн хохирол

амсах бодит нөхцөл байдал энэхүү хуулийн зохицуулалтын цаана нуугдаж байна.

Энэ нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь .., аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...” гэснийг зөрчсөн.

Шинээр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэж заасны дагуу нэг бүтээгдэхүүнд улс гурван газраас нэг төрлийн төлбөрийг авч байгаа нь хэт шударга бус болсон ба нэг хуулийн этгээд ашигласан, худалдахаар ачуулсан гэх үндэслэлээр хоёр удаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөхөөр зохицуулагдсан гэж ойлгогдож энэ нь хуулийн үзэл баримтлал болон Монгол Улсын Үндсэн хууль, Татварын ерөнхий хуультай зөрчилдсөн байгаа юм.” гэсэн байна.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад:

Иргэн С.Баярмаа Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн зарим хэсэг, заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “… хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн гэж шаардлагаа ихэсгэж, харин Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “… Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд …” гэсэн заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэсэн шаардлагаасаа татгалзсан болно.

Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ашигт малтмалын тухай хуулийн дээрх зохицуулалтын агуулга мэдээлэл гаргагчийн тайлбарлаж байгаагаас өөр, давхардуулан төлбөр авах агуулгагүй зохицуулалт юм. Гэхдээ амьдрал дээр ийнхүү ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг давхардуулан авч байгаа, мөн дотоодын үйлдвэрлэгч нарт сөрөг үр дагаврыг үүсгэж байгаа бол эргэн харах ёстой асуудал байна гэсэн тайлбарыг хийлээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасан.

Энэ хүрээнд Улсын Их Хурал Монгол Улсын эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, улсын хөгжлийн тогтвортой байдлыг хангахад тодорхой нөлөө үзүүлдэг ашигт малтмал буюу эрдэс баялгийн салбарын бодлогыг тодорхойлон холбогдох хууль тогтоомжийг баталсан бөгөөд 2014 оны 18 дугаар тогтоолоор “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” зэргийг батлан гаргажээ.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 1.2-д “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилго нь ... ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд оршино.” гэж, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтын “Эдийн засгийн тогтвортой хөгжил” гэсэн 2.1-д “... аж үйлдвэр, түүний дотор ... уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч ... хөгжүүлнэ.” гэж заасан байна. Түүнчлэн, дээрх шийдвэрүүдээс гадна Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгч болон холбогдох эрх бүхий этгээдээс баталсан 30 орчим шийдвэрт нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх дотоодын үйлдвэрлэлийг дэмжих талаарх зохицуулалтыг тусгасан байдаг.

Мөн энэ талаарх зохицуулалтыг Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох хуулиудад тусгайлан хуульчилжээ. Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт “Олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр нийлүүлнэ.” гэсэн байна.

2. Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж тус хуулийн “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр” гэсэн 47 дугаар зүйлд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ.

Ингэхдээ Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” хэмээн өөрчлөн найруулсан байна.

Ийнхүү өөрчлөн найруулахдаа өмнө зөвхөн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлдөг байсныг ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд бүр төлдөг байхаар хуульчилжээ. Тодруулбал, ашигт малтмал ашигласны төлбөр гэх нэг төрлийн төлбөрийг тухайн ашигт малтмалыг олборлож, худалдаж байгаа этгээдээс гадна түүнийг худалдан аваад ашигт агуулгыг нэмэгдүүлж, баяжуулан нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэгчээс хүртэл давхардуулан авах боломж бий болгосон байна. Энэ нь дотоодын үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгч иргэдийг дэмжих агуулгагүй, харин улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, түүний тогтвортой байдлыг бий болгох, цаашлаад үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд сөрөг үр дагавар үүсгэх зохицуулалт болсон гэж үзэхээр байна.

Иймд Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх … үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн заалтад нийцээгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Үүнээс үзэхэд уг заалтаас үүдэлтэй Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчих нөхцөл байдлыг үүсгэжээ.

3. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5.11, 47.5.12 дахь заалтад боловсруулаагүй нүүрсийг хүдэртэй, баяжуулсан нүүрсийг хүдрийн баяжмалтай адилтган ашигт малтмалын ангиллыг буруу тусган нэмэлт төлбөр авахаар зохицуулсан нь хууль зүйн зохицуулалтын зорилго, түүний агуулгатай зөрчилдсөн байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалт зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурал нь хууль тогтоогчийн хувьд Үндсэн хуульд заасан өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох зохицуулалтыг сайжруулан өөрчлөх боломжтой юм.

4. Мэдээлэл гаргагч С.Баярмаа хуралдааны явцад Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн гэж мэдээллийн шаардлагаа ихэсгэсэн боловч энэ талаар хангалттай үндэслэл, нотолгоо гаргаагүй байх тул Үндсэн хуулийн дээрх заалт зөрчигдсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн

засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх … үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “… хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчөөгүй байна.

3. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ	Н.ЧИНБАТ
ГИШҮҮД	Ш.ЦОГТОО
	Д.СОЛОНГО
	Ш.СОЛОНГО
	Ц.НАНЗАДДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2019.07.16 Дугаар 70 Төрийн ордон,
Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2019 оны
03 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашиг малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байна” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2019.10.30 Дугаар 04 Улаанбаатар хот

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн зарим хэсэг, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 13.40 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат, Ш.Цогтоо /илтгэгч/, Д.Солонго, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү, Ш.Солонго, Ц.Нанзаддорж, Г.Баясгалан нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн С.Баярмаа болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан эцэслэн шийдвэрлэж, мөн Улсын Их Хурлын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” 70 дугаар тогтоолыг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн С.Баярмаа Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Ашигт малтмалын тухай хуульд 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.”, 47.3 дахь хэсэгт “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дараахь хэмжээтэй байна:” гээд 47.3.1 дэх заалтад “дотоодод борлуулж байгаа нүүрсний нөөц ашигласны төлбөр тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү;”, 47.3.2 дахь заалтад “Энэ хуулийн 47.3.1-т зааснаас бусад төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн доод хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5,0 хувь, Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд тушаасан алтанд ногдох энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү.”, 47.4 дэх хэсэгт “Тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч энэ хуулийн 47.3.2-т заасан хувь дээр мөн хуулийн 47.5-д заасан хувийг нэмсэн дүнгээр тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулна.”, 47.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 47.4-т заасан нэмэлт төлбөрийн хувийг дараахь байдлаар тодорхойлно:” гээд 47.5.11 дэх заалтад “Боловсруулаагүй нүүрсний тонн тутмын зах зээлийн үнийн түвшин /ам.доллараар/ 0-25 хүртэл бол 0 хувь, 25-50 хүртэл бол 1 хувь, 50-75 хүртэл бол 2 хувь, 75-100 хүртэл бол 3 хувь, 100-125 хүртэл бол 4 хувь, 125 ба түүнээс дээш бол 5 хувь,”, 47.5.12 дахь заалтад “Баяжуулсан нүүрс (хуурай болон нойтон аргаар технологийн боловсруулалт хийсэн)-ийн тонн тутмын зах зээлийн үнийн түвшин /ам.доллараар/ 0-100 хүртэл бол 0 хувь, 100-130 хүртэл бол 1 хувиар, 130-160 хүртэл бол 1.5 хувь, 160-190 хүртэл бол 2.0 хувиар, 190-210 хүртэл бол 2.5 хувиар, 210 ба түүнээс дээш бол 3 хувь,”, 47.5.13 дахь заалтад “Эцсийн бүтээгдэхүүн (хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн)-ний тонн тутмын зах зээлийн үнийн түвшин /ам.доллараар/ 0-160 хүртэл бол 0 хувь, 160-190 хүртэл бол 0.5 хувь, 190-210 хүртэл бол 1 хувь, 210-240 хүртэл бол 1.5 хувь, 240-270 хүртэл бол 2 хувь, 270 ба түүнээс дээш бол 2.5 хувь” гэж тус тус өөрчлөн найруулсан байна.

Ашигт малтмалын тухай хуульд орсон дээрх өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцээгүй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын эдийн засагт дарамт учруулсан, давхар татвар ногдуулсан, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг хаасан, нийгмийн эдийн засгийн хөгжилд саад учруулсан зэрэг сөрөг үр дагаврыг бий болгох бодит нөхцөлийг үүсгээд байна. Мөн маргаж буй зүйл нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөд зогсохгүй Татварын ерөнхий хуультай зөрчилдөж байх тул хуулийг нэг мөр, зөв ойлгон хэрэглэх үүднээс Үндсэн хуульд нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргуулж иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг хуулийн төөрөгдөлд орох, давхар татвар төлөх эрсдэлээс сэргийлэх зүй ёсны хэрэгцээ шаардлага үүсч байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж зааснаас үзвэл төр нь нийгмийн хөгжлийг хангах, аж ахуй нэгж байгууллагыг үйл ажиллагаа явуулахад нь эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх бодлого баримталж, эх орондоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бүтээн байгуулалтыг дэмжиж өгөх ёстой гэсэн утга санааг илэрхийлсэн. Гэтэл Ашигт малтмалын тухай хуульд орсон маргаж буй нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн дээрх заалтыг бүхэлд зөрчиж иргэд, аж ахуй нэгжийг давхар татварын дарамтад оруулж, нэг бүтээгдэхүүнд хэд хэдэн татвар ногдуулж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хөгжих боломжийг хааж эдийн засгийн алдагдалд оруулах бодит нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн өмнөх зохицуулалтаар ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй этгээд нь олборлосон бүтээгдэхүүндээ ашигт малтмал ашигласны төлбөр төлдөг байсан бол хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээдүүд бүгд тухайн бүтээгдэхүүний хувьд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байхаар тусгасан нь хуулийн алдаа бий болгосон.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллага нь Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3, 7.3.6 дахь заалтад заасан 2 төрлийн татварыг давхар төлөх бодит нөхцөл байдал бий болоод зогсохгүй, худалдахаар ачуулсан гэсэн үндэслэлээр дахин нэмж татвар төлөхөөр болж, нэг бүтээгдэхүүнээс үндсэндээ дөрвөн татварыг авч байна.

Байгалийн баялгийг олборлосон аж ахуй нэгжээс ашигт малтмал ашигласны төлбөр аваад түүнийг нь боловсруулсан, ашигласан аж ахуй нэгжээс мөн ашигт малтмал ашигласны төлбөр авч, худалдахаар ачуулсан этгээд дахин нэмж ашигт малтмал ашигласны төлбөр төлөхөөр болж байгаа нь нэг бүтээгдэхүүнээс 3 хэлбэрээр төлбөр авч, мөн дээрээс нь нэмэгдсэн өртгийн албан татвар гээд нийт 4 төрлийн татварыг авч байна. Үүнээс үзэхэд, ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан аж ахуйн нэгжүүд нь нэмэгдсэн өртгийн албан татварыг төлөөд зогсохгүй ашигласан, худалдахаар ачуулсан гэсэн 3 төрлийн төлбөрийг төлөх нөхцөлийг бүрдүүлж байгаа нь хэт шударга бус байна.

Тэгэхээр Монгол Улсад байгалийн баялгийг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн бий болгох аж ахуй нэгж байхгүй болж, уул уурхайн салбар хөгжихгүй байгалийн баялаг эх орондоо үлдэхгүй, эдийн засгийн ямар ч үр өгөөжгүйгээр түүхийгээр хямд өртгөөр экспортод гарсан хэвээр байх дүр зураг харагдаж байна. Монгол Улс нь байгалийн баялаг ихтэй, эдийн засаг нь уул уурхайн салбартай салшгүй холбоотой учир дээрх зөрчлийг арилгахгүйгээр уул уурхайн салбарыг хөгжүүлэх, дотооддоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ямар ч боломжгүй гэж үзэж байна.” гэсэн агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Энэ өөрчлөлт нь алтны ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид олборлосон алтаа хувь хүн, бичил уурхайн нэр дээр банканд тушааж ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс зайлсхийдэг зөрчлийг арилгах зорилготой юм. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 220 дугаар тогтоолоор нүүрсэнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг зөвхөн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс авахаар зохицуулсан байгаа.

Мэдээлэл гаргагч мэдээлэлдээ “Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3, 7.3.6 дахь заалтад заасан 2 төрлийн татварыг давхар төлөх бодит нөхцөл байдал бий болсон” тухай дурджээ. Давхар татварын тухай асуудал нь нэг этгээдэд нэг татварыг дахин ногдуулахгүй тухай ойлголт бөгөөд бодит байдал дээр олон улс хооронд үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, хувь хүнд тулгардаг асуудал юм.

Тухайлбал, аль нэг улсад үйл ажиллагаа эрхлэн олсон орлогодоо татвар төлсөн этгээд өөрийн харьяалал бүхий улс оронд дахин тус татварыг төлөх асуудал үүсдэг. Иймээс тухайн этгээдийн эдийн засгийн эрх, эрх чөлөөг хангах, өөрийн улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих зэрэг олон шалтгааны улмаас тодорхой улс орнууд хоорондоо давхар татварын асуудлыг зохицуулах тухай олон улсын гэрээ байгуулдаг.

Харин орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, нэмэгдсэн өртгийн албан татвар зэрэг нь давхар татварын асуудал биш бөгөөд татварын бүтцэд багтдаг төрөл бүрийн төлбөрүүдийн нэг хэсэг юм. Татварыг дотор нь ингэж төрөлжүүлэн салгахын гол ач холбогдол нь төрөөс эдийн засгийн аливаа харилцааг зохицуулах, хянах зорилгоо татварын бодлогоор дамжуулан хэрэгжүүлэх явдал юм. Жишээлбэл, Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.”, 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.” гэж заасан байдаг. Эрдэс баялгийнхаа ашиглалтаас ард түмэндээ хүртээх асуудлыг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэн нийгмийн үйлчилгээнд зарцуулах байдлаар хэрэгжүүлдэг. Харин нэмэгдсэн өртгийн албан татвар бол аливаа бараа, ажил, үйлчилгээний эцсийн хэрэглээнд татвар оноох буюу шууд бус татварын үр ашгийг сайжруулах зорилготой бөгөөд татварын бодлогын хэрэгжилтийг хянах зорилготой төрийн зохицуулалтын нэг арга хэрэгсэл юм.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4, 47.5 дахь хэсэгт заасан ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийн хувь хэмжээ бол тухайн ашигт малтмалд оноож байгаа давхар татвар биш бөгөөд тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг нэмэх буюу бууруулах тухай асуудал юм.” гэжээ.

Гурав. Мэдээлэл гаргагч С.Баярмаа Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээллийнхээ нэмэлт тайлбартаа:

“Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагад ашигт малтмалын зэрэгцээ Монголбанканд тушааж буй алтны хэмжээг бууруулахгүй, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, татварын суурийг өргөжүүлэх зорилгоор Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахаар тусгасан байдаг. Гэтэл татварын суурийг өргөжүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй хувь хүн, бичил уурхай, баяжуулах үйлдвэр эрхлэгчдийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх, тайлагнах, бүртгэлжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилготой хуулийн нэмэлт, өөрчлөлт нь нэг бүтээгдэхүүнд өссөн дүнгээр 3 удаагийн төлбөр тооцох бодит нөхцөлийг бүрдүүлсэн байгаа нь Үндсэн хуульд төр нь аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийг хангах эдийн засгийн бодлогыг баримтална гэж заасныг зөрчиж, аж ахуйн үйл ажиллагаанд татварын бодлогоор дарамт учруулсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг хаасан зохицуулалт болсон гэж үзэж байна.

Мөн хууль тогтоогчийн зүгээс Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн үзэл баримтлалдаа “энэ хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь төр, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хүсэл сонирхолд бүрэн нийцсэн” гэж худал мэдээлэл оруулж ямар нэг иргэн, аж ахуйн нэгжээс санал аваагүй, хүсэл сонирхлыг нь тусгаагүй, эдийн засгийн тооцоо судалгаагүй асуудлыг оруулсан. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилго нь зөвхөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон алтаа хувь хүн, бичил уурхайн нэр дээр банканд тушааж ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс зайлсхийдэг зөрчлийг арилгах зорилготой гэж тодорхойлж алтны асуудлыг байнгын хороодын хуралдаан, нэгдсэн хуралдаанаараа ярьсан байдаг хэдий ч эцсийн нэмэлт, өөрчлөлт нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь 3 этгээд байхаар зохицуулж Үндсэн хуулийг зөрчиж шийдвэрлэсэн байдаг.

Ашигт малтмалын тухай хуулийн маргаан бүхий зохицуулалтын өмнө хэрэгжиж байсан агуулгаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөө төлсөн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээс ашигт малтмал худалдан авсан этгээд нь энэ төлбөрийг дахин төлдөггүй байсан бөгөөд шинэ хуулиар ашигт малтмалын нөөц биш бүтээгдэхүүн болсон хэдий ч нөөц ашигласны төлбөр төлөхөөр зохицуулан Үндсэн

хуулийг зөрчиж байна. Хэрэв тухайн бүтээгдэхүүнийг байгалиас нь олборлосон хэвээр буюу түүхий хэвээр нь цааш дамжуулан худалдаж ашиг олж байгаа бол энэхүү хуулийн нэмэлт зохицуулалт нь шударга байх хэдий ч тухайн бүтээгдэхүүнийг боловсруулан нэмүү өртөг шингээж эцсийн бүтээгдэхүүн болгон гаргаж байгаа явдал нь 2 өөр ойлголт бөгөөд хууль санаачлагч нар үүнийг нарийн ялгаж үзэлгүй эдийн засагт нэмэр болох, татварын суурийг өргөжүүлэх гэсэн санаагаар үйлдвэрлэгчдийг татварын дарамтад оруулахаар хуулийн зохицуулалт хийсэн байна. Мөн үйлдвэрлэгч нь худалдан авагч болохоос биш тусгай зөвшөөрөлтэй газрын байгалийн баялгийг цааш нь дамжуулан худалддаг газар биш бөгөөд дээр дурдсанчлан 2 өөр ойлголт юм. Үйлдвэрлэгчид нь Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашигт малтмалын нөөцийг газрын хэвлийгээс олборлодоггүй учир ашигт малтмалын нөөц ашигласан гэж үзэх боломжгүй юм.

Энэхүү хууль нь цаашид Монгол Улсад байгалийн баялгийг эх орондоо нэмүү өртөг шингээж эцсийн бүтээгдэхүүн болгож олон улсын зах зээлд гаргах үйлдвэрлэлийг хөгжүүлэхгүй, үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор дарамталсан, үйл ажиллагааг нь боомилсон бөгөөд улмаар энэ салбар цаашид хөгжих боломжгүй болох эрсдэлт нөхцөлийг бүрдүүлж, байгалийн баялгаа өөрсдөөсөө харамлаж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг хааж, түүхийгээр нь хямд үнээр гадаадын улс оронд гаргаж, их хэмжээний алдагдалд орох маш том эрсдэл, эдийн засгийн хохирол амсах бодит нөхцөл байдал энэхүү хуулийн зохицуулалтын цаана нуугдаж байна. Энэ нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн ... хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлнэ.” гэснийг зөрчсөн.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэж заасны дагуу 1 хуулийн этгээд ашигласан, худалдахаар ачуулсан гэх үндэслэлээр 2 удаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөхөөр зохицуулсан нь хуулийн үзэл баримтлал болон Монгол

Улсын Үндсэн хууль, Татварын ерөнхий хуультай зөрчилдсөн байгаа юм.” гэжээ.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээрх маргааныг 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаараа хянан хэлэлцэж, 03 дугаар дүгнэлтийг гаргасан болно. Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

1. “Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасан. Энэ хүрээнд Улсын Их Хурал Монгол Улсын эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, улсын хөгжлийн тогтвортой байдлыг хангахад тодорхой нөлөө үзүүлдэг ашигт малтмал буюу эрдэс баялгийн салбарын бодлогыг тодорхойлон холбогдох хууль тогтоомжийг баталсан бөгөөд 2014 оны 18 дугаар тогтоолоор “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” зэргийг батлан гаргажээ.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 1.2-д “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилго нь ... ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд оршино.” гэж, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтын “Эдийн засгийн тогтвортой хөгжил” гэсэн 2.1-д “... аж үйлдвэр, түүний дотор ... уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч ... хөгжүүлнэ.” гэж заасан байна. Түүнчлэн, дээрх шийдвэрүүдээс гадна Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгч болон холбогдох эрх бүхий этгээдээс баталсан 30 орчим шийдвэрт нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх дотоодын үйлдвэрлэлийг дэмжих талаарх зохицуулалтыг тусгасан байдаг.

Мөн энэ талаарх зохицуулалтыг Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох хуулиудад тусгайлан хуульчилжээ. Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт “Олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр нийлүүлнэ.” гэсэн байна.

2. Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж тус хуулийн “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр” гэсэн 47 дугаар зүйлд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ.

Ингэхдээ Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” хэмээн өөрчлөн найруулсан байна. Ийнхүү өөрчлөн найруулахдаа өмнө зөвхөн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлдөг байсныг ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд бүр төлдөг байхаар хуульчилжээ.

Тодруулбал, ашигт малтмал ашигласны төлбөр гэх нэг төрлийн төлбөрийг тухайн ашигт малтмалыг олборлож, худалдаж байгаа этгээдээс гадна түүнийг худалдан аваад ашигт агуулгыг нэмэгдүүлж, баяжуулан нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэгчээс хүртэл давхардуулан авах боломж бий болгосон байна. Энэ нь дотоодын үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгч иргэдийг дэмжих агуулгагүй, харин улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, түүний тогтвортой байдлыг бий болгох, цаашлаад үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд сөрөг үр дагавар үүсгэх зохицуулалт болсон гэж үзэхээр байна.

Иймд Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад

баталгааг бүрдүүлэх … үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн заалтад нийцээгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Үүнээс үзэхэд уг заалтаас үүдэлтэй Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчих нөхцөл байдлыг үүсгэжээ.

3. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5.11, 47.5.12 дахь заалтад боловсруулаагүй нүүрсийг хүдэртэй, баяжуулсан нүүрсийг хүдрийн баяжмалтай адилтган ашигт малтмалын ангиллыг буруу тусган нэмэлт төлбөр авахаар зохицуулсан нь хууль зүйн зохицуулалтын зорилго, түүний агуулгатай зөрчилдсөн байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалт зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурал нь хууль тогтоогчийн хувьд Үндсэн хуульд заасан өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох зохицуулалтыг сайжруулан өөрчлөх боломжтой юм.

4. Мэдээлэл гаргагч С.Баярмаа хуралдааны явцад Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн гэж мэдээллийн шаардлагаа ихэсгэсэн боловч энэ талаар хангалттай үндэслэл, нотолгоо гаргаагүй байх тул Үндсэн хуулийн дээрх заалт зөрчигдсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.” гэсэн.

Дүгнэлтийн тогтоох хэсэгт:

“1. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр

зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх … үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “… хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчөөгүй байна.

3. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.” гэсэн байна.

Тав. Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг Улсын Их Хурал 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцээд 70 дугаар тогтоолыг гаргасан байна. Үүнд:

“1. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд … нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг

худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь … аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх … үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэсэн байна.

Зургаа. Монгол Улсын Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:

“Улсын Их Хурлын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцээд дараах үндэслэлээр хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн:

1. Ашигт малтмал олборлохоос эхлээд нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэгч хүртэл үе шатанд татварыг давхардуулан авах боломжийг бий болгосон гэсэн дүгнэлтийг хүлээн авах боломжгүй байна. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 47.3.1, 47.3.2, 47.4, 47.5-д заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах , тайлагнах, төлөх журмыг Засгийн газар батална.”, 47.7 дахь хэсэгт “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хүдэр, баяжмал, бүтээгдэхүүнд давхардуулахгүйгээр ногдуулна.” гэсэн өөрчлөлтийг оруулсан. Эдгээр өөрчлөлт нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгдсөн аливаа бүтээгдэхүүнд нөөц ашигласны төлбөр дахин ногдуулахгүй тухай зохицуулалт юм.

Иймд Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн

ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэж алтны ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид олборлосон алтаа хувь хүн, бичил уурхайн нэр дээр банканд тушааж ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс зайлсхийдэг зөрчлийг арилгасны зэрэгцээ татвар давхар ногдуулахгүй байх эрх зүйн орчныг тус хуулийн 47 дугаар зүйлийн 47.6, 47.7 дахь хэсэгт бүрдүүлж өгсөн.

2. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5.11, 47.5.12 дахь заалтад боловсруулаагүй нүүрсийг хүдэртэй, баяжуулсан нүүрсийг хүдрийн баяжмалтай адилтган ашигт малтмалын ангиллыг буруу тусган нэмэлт төлбөр авахаар зохицуулсан гэж дүгнэснийг хүлээн авах боломжгүй байна. Төрөөс эдийн засгийн харилцааг зохицуулахдаа орлогын, ашигт малтмалын нөөц ашигласны, нэмэгдсэн өртгийн зэрэг олон төрлийн татварыг ашигладаг. Жишээ нь, Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.” гэж заасан байдаг.

Төрөөс энэхүү заалтын хүрээнд эрдэс баялгийнхаа ашиглалтаас ард түмэндээ хүртээх асуудлыг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэн нийгмийн үйлчилгээнд зарцуулах байдлаар хэрэгжүүлдэг. Харин нэмэгдсэн өртгийн албан татвар бол аливаа бараа, ажил, үйлчилгээний эцсийн хэрэглээнд татвар оноох буюу шууд бус татварын үр ашгийг сайжруулах зорилготой бөгөөд татварын бодлогын хэрэгжилтийг хянах зорилготой төрийн зохицуулалтын нэг арга хэрэгсэл юм. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4, 47.5 дахь хэсэгт заасан ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийн хувь хэмжээ бол тухайн ашигт малтмалд оноож байгаа давхар татвар биш бөгөөд тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг нэмэх буюу бууруулах тухай асуудал юм.

Дээр дурдсаныг үндэслэн Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.3, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй.” гэсэн байна.

Долоо. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд Татварын ерөнхий газраас ирүүлсэн тайлбартаа:

"... Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Татвар ногдох зүйлд орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол хамаарна.", Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад "хуулиар ногдуулсан албан татвар төлөх;" гэж тус тус заасан. Ашигт малтмалын тухай хуульд 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлт нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг өөрчлөөгүй, зөвхөн татварын бааз суурийг нэмэгдүүлэх өөрчлөлт бөгөөд шударгаар татвараа төлж буй этгээдүүдэд нэмэлт татварын ачаалал үүсгээгүй болно.

Ашигт малтмалын тухай хуулийн маргаан бүхий 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн тухайд: Монголд Улсад сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар хурдацтай хөгжиж уул уурхайн бизнесийн олон төрлийн харилцаа бий болсонтой холбоотойгоор ашигт малтмалыг олборлон дотоод, гадаадын зах зээлд борлуулж буй этгээдүүдээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хуульд заасан хувь хэмжээгээр бүрэн хураан авч төсөвт төвлөрүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсч уг салбарт үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ачаалал харилцан адилгүй болж шударгаар өрсөлдөхөд хүндрэлтэй нөхцөл байдал бий болсон. Тухайлбал, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй этгээдийн олборлосон ашигт малтмалыг дотоодын зах зээлээс худалдан авч түүхийгээр болон баяжуулан экспортлох, мөн бичил уурхай эрхлэгчдээс ашигт малтмалыг худалдан авч экспортлох зэрэг бизнесийн харилцаанаас үүдэлтэйгээр тусгай зөвшөөрөлтэй болон тусгай зөвшөөрөлгүй этгээдүүдийн экспортолсон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдуулсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ харилцан адилгүй байна. Ашигт малтмалын тухай хуулийн 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл хугацаанд хүчин төгөлдөр мөрдөж байсан 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн хүрээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхай эдэлбэрээс олборлож худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг татварын алба давхардуулан ногдуулж байсан тохиолдол байхгүй юм.

Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөн найруулсан 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг болон Засгийн газрын 2019 оны 342 дугаар тогтоолоор баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ын хүрээнд цаашид ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг давхардуулан ногдуулахгүй. Засгийн газрын 2019 оны 342 дугаар тогтоолоор баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ын 3 дахь хэсгийн 3.4-д ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг давхардуулан ногдуулахгүй байх заримтлахаар заасан. Өөрөөр хэлбэл, тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалыг дотоодын зах зээлээс тусгай зөвшөөрөлтэй этгээдээс худалдан авч түүхийгээр болон баяжуулан гадаад зах зээлд борлуулсан тохиолдолд тусгай зөвшөөрөлгүй этгээдийн экспортолсон ашигт малтмалд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс тухайн ашигт малтмалын бүтээгдэхүүнд тусгай зөвшөөрөлтэй этгээдийн дотоодын зах зээлд борлуулахад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулан тайлагнасан дүнг хасаж тооцохоор зохицуулсан.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.1 дэх заалт, 47.4 дэх хэсэг болон 47.5 хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалтуудтай холбоотой асуудлаар татвар төлөгчдийн зүгээс санал, гомдол манай байгууллагад гаргаж байгаагүй бөгөөд харин татвар төлөгчийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлагнал, төлөлтийн байдалд татварын хяналт шалгалт хийсэн татварын улсын байцаагчийн акттай холбоотойгоор Татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргаж байсан байна. Уг заалтууд нь 2010, 2011 оноос хойш хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд уг заалтуудыг татвар төлөгчид болон татварын албаны зүгээс нэгдсэн ойлголттойгоор хэрэгжүүлж байна. ...” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.”

гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх … үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “... Улсын Их Хурал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож тогтоол гаргана.” гэж заажээ. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 70 дугаар тогтоолд Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа үндэслэлээ заагаагүй байна.

3. Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “Журам батлах тухай” 342 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтаар “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ыг, 02 дугаар хавсралтаар “Гадаадын зах зээлд борлуулсан нүүрс, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох журам”-ыг баталсан байх бөгөөд Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Татварын ерөнхий газраас тус маргаанд холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа Засгийн газрын дээрх тогтоолд тусгасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг давхардуулан ногдуулахгүй байх зохицуулалтыг тодорхой тусгасан хэмээн дурдсан боловч тус тогтоолыг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлүүлээгүй байх тул хүчин төгөлдөр нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйл, мөн хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх … үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” 70 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ Д.ОДБАЯР

ГИШҮҮД Н.ЧИНБАТ
Ш.ЦОГТОО
Д.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Г.ТУУЛХҮҮ
Ш.СОЛОНГО
Ц.НАНЗАДДОРЖ
Г.БАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2019.09.20 Дугаар 04 Улаанбаатар хот

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 13.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Ш.Цогтоо /илтгэгч/, Д.Солонго, Б.Буяндэлгэр, Ш.Солонго нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Г.Галбаярын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Баялагцэнгэл оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч иргэн Г.Галбаяр Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална.” гэж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалтад “хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх;” гэж баг, хорооны Хурлын бүрэн эрхийг, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлнэ.” гэж сум, дүүргийн Хурлын онцгой бүрэн эрхийг тус тус заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.” гэж заасан байдаг бол дээрх хуулиудад хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд л захиргааны хэм хэмжээний акт гаргахаар заасан байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд тухайлан бие даан шийдвэрлэж болно гэснийг Захиргааны ерөнхий хуульд “тусгайлан эрх олгогдсон тохиолдолд” гэж зааснаар нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээг хязгаарлаж Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1 дэх заалтад “64.1 дэх хэсэгт Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага хамаарахгүй.” гэсэн заалт оруулж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг хүчингүй болгож өгнө үү” гэсэн агуулга бүхий мэдээллийг ирүүлж;

“Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн

зарчим мөн.” гэж заасны дагуу нутгийн өөрөө удирдах байгууллага захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн мэдээллийн санд Захиргааны ерөнхий хуулийн дагуу бүртгүүлэх нь зүйн хэрэг юм.

Улсын хэмжээнд хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгосон захиргааны байгууллага гаргах нь Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хэрэгжиж байна. Гэтэл нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт заагаагүй байхад нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэхэд Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийн заалт нь хязгаарлалт болж байна. Жишээ нь хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тусгаагүй асуудлаар нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан гаргасан “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулахад дагаж мөрдөх журам”-ыг Захиргааны ерөнхий хуулийн 64.1 дэх хэсэгт зааснаар хуулиар тусгайлан эрх олгоогүй тул хүчингүй болгохоор дүгнэсэн байна. Энэ нь Үндсэн хуулиар нутгийн өөрөө удирдах байгууллагад олгосон эрх хэмжээний асуудал юм.

Энэ журмыг бүртгэхгүй байгаа явдал нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын буруу биш. Захиргааны ерөнхий хуулийн дагуу ийнхүү бүртгэх боломжгүй нөхцөл байдал үүсээд байна. Одоогоор Түргэн үйлчилгээний цэг байрлуулах асуудал нь зөвхөн нийслэл Улаанбаатар хотод тулгарч байгаа асуудал бөгөөд бусад суурин газарт тулгараагүй асуудал юм.

Хэм хэмжээний актыг улсын хэмжээнийх, эсвэл тухайн нутаг дэвсгэрийнх гэж ангилж авч үзээгүйгээс Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн нөхцөл байдлыг үүсгээд байна. Зөвхөн тухайн орон нутагт тохиолдох асуудлыг улсын хэмжээнд хэм хэмжээний акт тогтоох, тэр бүр улсын хэмжээнд хуульчлах боломжгүй байдаг тул Үндсэн хуульд энэ заалтыг оруулсан. Жишээ нь Зөвхөн Ховд аймгийн Булган суманд тохиолдох, тэд бие даан шийдвэрлэж болох асуудлыг хуулиар тусгайлан эрх олгоогүй гэх шалтгаанаар шийдвэрлэж чадахгүй байдалд хүрнэ.

Үүнээс гарах арга зам нь Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт нутгийн өөрөө удирдах байгууллага хамаарахгүй байх юм. Ингэснээр Захиргааны ерөнхий хуулийн дагуу хэм хэмжээний акт боловсруулах, хэлэлцэх, батлах, мөрдүүлэх ажиллагаа нь нэгдсэн нэг хяналт, бодлоготой, хэрэгжих нутаг дэвсгэр нь өөр өөр байх боломжтой.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг нь Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн талаар шийдвэр гаргаж өгнө үү.” гэсэн гомдлыг гаргасан байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хариу тайлбартаа:

“1. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “бүрэн эрхт”, Хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “нэгдмэл улс”-ынх нь хувьд, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 7, 8, 12 дахь заалтад заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх, Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлд заасан Засгийн газрын үндсэн бүрэн эрхийн дагуу хууль тогтоомжийн нэг тогтолцоо, Засгийн газрын нэг бодлоготой байлгахад чиглэсэн зохицуулалтын дагуу Захиргааны ерөнхий хуулийг Улсын Их Хурал 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батлан гаргасан.

Захиргааны ерөнхий хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт энэ хуулийн зорилго нь нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэхэд оршино гэж хуулийн зорилгыг тодорхойлсон ба уг хуулиар захиргааны үйл ажиллагаа нийтлэг нэг зохицуулалтад орж, захиргааны хэргийн шүүх эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд баримтлах эрх зүйн үндэслэл буй болж, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд ерөнхий үйл ажиллагааг стандартчилан зохицуулах, хүний эрх, эрх чөлөө, эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх боломжийг бий болгосон.

Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад захиргааны байгууллагыг тодорхойлсон бөгөөд нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага, түүнчлэн Засгийн газрын байгууллагын зарим үүргийг төлөөлөн гүйцэтгэдэг, мөн хууль болон нийтийн эрх

зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага зэрэг нийтийн эрх зүйн субьект болох байгууллагыг хамруулан ойлгоно. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага бол нийтийн эрх зүйн харилцаанд оролцохдоо нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Ардчилсан ёс, ... хууль дээдлэх зарчим", Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "... засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ", Хорьдугаар зүйлд заасан "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална" гэсэн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд чиглэсэн заалтуудаас үзвэл хууль тогтоох эрх мэдлийг Улсын Их Хурал хэрэгжүүлэх ба Улсын Их Хурлаас хуульд тухайлан захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон тохиолдолд л захиргааны байгууллагаас энэхүү эрхийг хэрэгжүүлэх боломжтой. Захиргааны байгууллага нь өөрөө нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг нийтийн эрх зүйн этгээдийн хувьд захиргааны хэм хэмжээний акт гаргахын тулд энэхүү эрхийг хуулиар шилжүүлэн авсан байх зайлшгүй шаардлагатай.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулах талаар тодорхойлж өгсөн байгаа нь "хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй" шийдвэр гаргах эрхтэй тухай бус харин ч хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үүргийг хүлээсэн байна. Мөн зүйлийн 2 дахь хэсгийн хоёрдугаар өгүүлбэрт "Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно" гэж хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрээс гадуур байх эрх мэдлийг тусгайлан тодорхойлсон хэдий ч дээрх заалтаас үзвэл нутгийн өөрөө удирдах байгууллагад хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг зөрчсөн шийдвэр гаргах

эрх мэдэл олгогдоогүй байх бөгөөд энэ асуудлыг хянан шалгаж шийдэх эрх мэдэл нь Улсын Их Хуралд Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн зохих хэсгүүдээр олгогдсон байна.

Өөрөөр хэлбэл, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь нутаг дэвсгэрийнхээ дотоод асуудлыг шийдвэрлэх эрхтэй хэдий ч үүнийг хуулиар хязгаарлаж болох талаар Үндсэн хуулиар хуульчилсан байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар бүлэгт нутгийн өөрөө удирдах байгууллага буюу Хурал, тэргүүлэгчид, Хурлын дарга, тэдгээрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлуудыг нарийвчлан зааж өгсний зэрэгцээ эрх үүргээ хэрэгжүүлэхдээ гаргасан шийдвэр нь Монгол Улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын Засгийн газрын шийдвэрт харшлахгүй байх учиртайг мөн адил хуульчилсан.

Иймээс Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчөөгүй гэж үзэж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан төрийн эрх мэдэл хуваарилах онолын дагуу зөвхөн хууль тогтоогч хууль тогтоох эрхтэй боловч уг эрх мэдлийн зарим хэсгийг шилжүүлсний үндсэн дээр эрх олгосон этгээд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт батлах боломжтой болдог. Энэ нь захиргааны эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд нийтлэг тогтсон ойлголт юм.

Эрх зүйн онолын үүднээс авч үзвэл хууль тогтоогчоос захиргааны байгууллагад хуулиар тусгайлан эрх олгосны үндсэн дээр батлан гаргасан хэм хэмжээний актууд хууль зүйн хүчин чадалтай байдаг. Иймд захиргааны хэм хэмжээний актын үндсэн гол онцлог нь түүнийг батлах эрхийг хуулиар тусгайлан олгосон байх явдал юм. Энэхүү онол, үзэл баримтлалын хүрээнд хууль тогтоогч Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн зохицуулалтыг хуульчилсан байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болохоор заасан. Энэхүү заалт нь нутгийн өөрөө удирдах байгууллагад нутаг дэвсгэрийнхээ хэмжээний асуудлыг шийдвэрлэж, тухайн нутаг дэвсгэртээ үйлчлэх холбогдох шийдвэрийг гаргах эрх, боломжийг Үндсэн хуулийн хүрээнд олгосон зохицуулалт юм.

Иймд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн зохицуулалт нь нутгийн өөрөө удирдах байгууллагын тодорхой бүрэн эрхийг тогтоосон Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийг шууд зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Үндсэн хуулийн нутгийн өөрөө удирдах институтын талаарх үзэл баримтлалтай нь уялдуулан Захиргааны ерөнхий хуульд тусгайлсан зохицуулалтыг тодорхой тусгаагүй байгаа нь энэ зохицуулалтын талаар маргах нөхцөлийг бүрдүүлжээ.

3. Иргэн Г.Галбаяр нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд анх гаргасан мэдээлэлдээ Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийн зохицуулалт Үндсэн хуулийг зөрчсөн талаар бус харин түүнийг боловсронгуй болгох асуудлаар шаардлагаа тодорхойлсон байх тул Үндсэн хуулийн цэцийн энэхүү хуралдаанаар уг асуудлаар дүгнэлт гаргах үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалтад “хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх;”, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Хуулиар

тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.” гэснийг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ Н.ЧИНБАТ
ГИШҮҮД Д.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Ш.СОЛОНГО
Ш.ЦОГТОО